

LAW ENFORCEMENT UNIVERSITY  
MONGOLIA



# LAW ENFORCEMENT

---

THEORETICAL AND METHODOLOGICAL  
QUARTERLY JOURNAL

2018  
№01 (15)

Ulaanbaatar, Mongolia

## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

### Зөвлөлийн дарга:

**Энхтөр Ө.** Хууль сахиулахын их сургуулийн захирал, профессор, цагдаагийн хурандаа

### Зөвлөлийн орлогч дарга:

**Бат-Эрдэнэ Б.** ХСИС-ийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн тэргүүн дэд захирал, хууль зүйн доктор, профессор, цагдаагийн хурандаа

### Гишүүд:

**Амарсанаа Ж.** Академич

**Амгаланбаяр Ц.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хууль зүйн доктор, бригадын генерал

**Баатаржав С.** Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа

**Бадрал Т.** Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал

**Батжаргал Д.** Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, бригадын генерал

**Бернд Шюенеманн** ХБНГУ-ын Людвиг Максимилианы нэрэмжит Мюнхений их сургуулийн Өмгөөллийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, профессор, доктор h.c.mult

**Болд Л.** Шинжлэх Ухааны Академийн хэл зохиолын хүрээлэнгийн захирал, Академич

**Болдбаатар Б.** ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн захирал, хууль зүйн доктор, профессор, цагдаагийн хурандаа

**Ганбаатар Г.** ХСИС-ийн Ахлагчийн сургуулийн захирал, хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа

**Гантөмөр Г.** Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

**Гантулга Н.** ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн захирал, хууль зүйн доктор, профессор, хурандаа

**Жавхланцогт В.** ХСИС-ийн Хилийн сургуулийн захирал, цэргийн ухааны доктор, дэд профессор, хурандаа

**Жигалов Н.Ю.** ОХУ-ын Дотоод явдлын яамны Дорнод Сибирийн их сургуулийн дэд захирал, хууль зүйн доктор, профессор

**Ил Сү Ким** БНСУ-ын Криминологийн институтын ерөнхийлөгч, хууль зүйн доктор, профессор

**Лхавгасүрэн Б.** Шинжлэн магадлахуйн институтийн захирал, хууль зүйн доктор, цагдаагийн дэд хурандаа

**Мөнхболд Ж.** ХСИС-ийн Ахисан шатны боловсролын сургуулийн захирал, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

**Нарангэрэл С.** Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Академич

**Сэргэлэн Ц.** Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал

**Чулуунбаатар Г.** Академич

**Эрдэнэбаатар Д.** ХСИС-ийн Сургалт эрхэлсэн дэд захирал, хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа

## JOURNAL BOARD

### Chief of the Board:

**Enkhtur U.** President of Law Enforcement University, police colonel

### Deputy Chief of the Board:

**Bat-Erdene B.** First Vice President of Law Enforcement University, Ph.D, Professor, police colonel

### Members:

**Amarsanaa J.** Academician

**Amgalanbayar Ts.** Chief of Court Decision Execution Agency, Ph.D in Law, Brigadier General

**Baatarjav S.** Chief of National Police Agency, Police Colonel

**Badral T.** Chief of National Emergency Management Agency, Major General

**Batjargal D.** Chief of National Institute of Forensic Science, Brigadier General

**Bernd Schuenemann** Prof.Dr.Dr.h.c.mult. Professor Emeritus at the University of Munich, Executive Director of the Institute for Lawyers' Law at the University

**Bold L.** Director of Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences, Academician

**Boldbaatar B.** Director of Police Institute, Law Enforcement University, Ph.D in Law, Professor, Police Colonel

**Ganbaatar G.** Director of Non-Commissioned school, Law Enforcement University, Ph.D in Law, Police Colonel

**Gantumur G.** Scientific Secretary of Law Enforcement University, Ph.D in Law, Associate Professor, Police Colonel

**Gantulga N.** Director of Institute of Execution of Court Decisions, Law Enforcement University, Ph.D in Law, Professor, Colonel

**Javkhantsogt V.** Director of Border Institute, Law Enforcement University, Ph.D in Military Science, Associate Professor, Colonel

**Jigalov N.Yu.** Deputy Director of Eastern-Siberian Institute of Ministry of Internal Affairs, Russia, Ph.D in Law, Professor

**Il Sou Kim** President of Korean Institute of Criminology, Ph.D in Law, Professor

**Lkhagvasuren B.** Director of Forensic Science Institute, Ph.D in Law, Police lieutenant colonel

**Munkhbold J.** Director of Graduate school, Law Enforcement University, Ph.D in Law, Associate Professor, Police Lieutenant Colonel

**Narangerel S.** Honored Science Worker of Mongolia, Academician

**Sergelen Ts.** Chief of the Border Protection Authority, Border Troops Commander, Major General

**Chuluunbaatar G.** Academician

**Erdenebaatar D.** Vice President of Law Enforcement University, Ph.D in Law, Police Colonel

## СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

### Сэтгүүлийн эрхлэгч:

**Бат-Эрдэнэ Б.** Эрдэм шинжилгээ эрхэлсэн тэргүүн дэд захирал, хууль зүйн доктор, профессор, цагдаагийн хурандаа

### Хариуцлагатай нарийн бичгийн дарга:

**Эрдэнэбаяр М.** Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн захирал, хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа

### Нарийн бичгийн дарга:

**Мөнхдорж Б.** Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, цагдаагийн хошууч

### Гишүүд:

**Алтангэрэл Б.** Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн ухааны доктор, хурандаа

**Ариунбилэг Ш.** Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Эрх зүйн онолын тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа

**Батсайхан Н.** Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гамшиг судлалын төвийн эрхлэгч, биологийн ухааны доктор, дэд профессор, хошууч

**Ганбадрал Н.** Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа

**Гантулга С.** Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн дэд профессор, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн хошууч

**Даваа Б.** Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Шинжлэн магадлахуй судлалын төвийн эрхлэгч, биологийн ухааны доктор, цагдаагийн дэд хурандаа

**Муратхан Т.** Хэвлэл, редакцийн албаны ахлах редактор, цэргийн ухааны доктор, профессор, хурандаа

**Мягмарцэрэн Д.** Цагдаагийн сургуулийн Гүйцэтгэх ажлын тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

**Нармандах С.** Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Гадаад хэлний тэнхимийн эрхлэгч, цагдаагийн хурандаа

**Нямсүрэн Ч.** Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа

**Одбаатар Б.** Хууль сахиулахын удирдлагын академийн Цагдаагийн стратеги, удирдлагын профессорын багийн профессор, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

**Өвгөнбүргэд Ж.** Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Хил судлалын төвийн эрхлэгч, цэргийн ухааны доктор, дэд профессор, хурандаа

**Цолмон Б.** Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Шинжлэн магадлахуй судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хууль зүйн доктор, цагдаагийн дэд хурандаа

**Энхболд Б.** Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор, цагдаагийн хошууч

**Энхжаргал Д.** Ахисан шатын боловсролын сургуулийн Гадаад хэлний сургалтын багийн ахлагч, хэл шинжлэлийн ухааны доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

## JOURNAL EDITORIAL BOARD

### Editor of the journal:

**Bat-Erdene B.** First Vice President of Law Enforcement University, Ph.D in Law, Professor, Police Colonel

### First Secretary:

**Erdenebayar M.** Director, Scientific Research Institute, Ph.D in Law, Police Colonel

### Secretary:

**Munkhdorj B.** Senior Researcher, Police Studies Center, Scientific Research Institute, Police Major

### Members:

**Altangerel B.** Dean, Court Decision Execution Studies Center, Scientific Research Institute, Ph.D in Law, Colonel

**Ariunbileg Sh.** Dean, Department of of Law Theory, Law and Social Science Institute, Ph.D in law, Police Colonel

**Batsaikhan N.** Dean, Disaster Studies Center, Scientific Research Institute, Ph.D in Biology, Associate Professor, Major

**Ganbadral N.** Dean, Department of Police Law, Police Institute, Ph.D in Law, Police Colonel

**Gantulga S.** Associate Professor, Department of Criminology and Criminal Law, Police Institute, Ph.D in Law, Police Major

**Davaa B.** Dean, Forensic Studies Center, Scientific Research Institute, Ph.D in Biology, Police Lieutenant Colonel

**Muratkhan T.** Senior Editor of Publication and editorial offices, Ph.D in Military Science, Professor, Colonel

**Myagmartseren D.** Dean, Department of Intelligence work, Police Institute, Ph.D in Law, Associate Professor, Police Colonel

**Narmandakh S.** Dean, Department of Foreign Language, Institute of Law and Social Science, Police Colonel

**Nyamsuren Ch.** Dean, Police Studies Center, Research and Development Institute, Ph.D in Law, Police Colonel

**Odbaatar B.** Professor, Professor's Team of Police Management, Executive Leadership Academy of Law Enforcement, Ph.D in Law, Associate Professor, Police Colonel

**Uvgunburgud J.** Dean, Border Studies Center, Scientific Research Institute, Ph.D in Military Science, Associate Professor, Colonel

**Tsolmon B.** Senior Researcher, Forensic Studies Center, Scientific Research Institute, Ph.D in Law, Police Lieutenant Colonel

**Enkhbold B.** Dean, Department of Criminology and Criminal Law, Police Institute, Ph.D in Law, Police Major

**Enkhjargal D.** Dean, Training Team of Foreign Language, Graduate School, Ph.D in Linguistics, Associate Professor, Police Lieutenant Colonel

## ГАРЧИГ-TITLE

АЮУЛГҮЙ БАЙДАЛ СУДЛАЛ  
SECURITY STUDIESТЕРРОРИСТ БАЙГУУЛЛАГЫН "ЖИНХЭНЭ ГИШҮҮН"-ИЙГ "ГАНЦААРДСАН ЧОНО"  
ТЕРРОРИСТОЙ ХАРЬЦУУЛАН ШИНЖИХҮЙ

A COMPARATIVE STUDY ON "ACTIVE CADRE" OF TERRORIST ORGANIZATIONS AND "LONE WOLF TERRORISTS"

**Ш.ЧУЛУУНБАТ**

ХСИС-ийн Хилийн сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдлын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд хурандаа

**CHULUUNBAT SH. (PhD)**

Lieutenant Colonel, Head, Faculty of Security for Border Checkpoints, Border Institute, LEU

8

**ЖЕЙМС БРАЙН ПАТТИСОН**

БНСУ-ын Кеймюнг их сургуулийн Цагдаа судлалын тэнхим, доктор, профессор

**JAMES BRYAN PATTISON (PhD, Prof.)**

Faculty of Police Sciences, Department of Police Administration, Keimyung University, Korea

**Ц.БАТБАЯР**

ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн дэд профессор, доктор, хошууч

**BATBAYAR TS. (PhD, Assoc.Prof.)**

Faculty of Social Sciences, Institute of Law and Social Sciences, LEU

МОНГОЛ УЛСЫН ДОТООД АЮУЛГҮЙ БАЙДАЛД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БҮЙ ЗАРИМ  
ХҮЧИН ЗҮЙЛ, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

POSSIBLE APPROACHES TO OVERCOMING SOME OF THE NEGATIVE FACTORS AFFECTING MONGOLIA'S INTERNAL SECURITY

15

**С.СҮХЧУЛУУН**

Хууль сахиулахын их сургуулийн докторант

**SUKHCHULUUN S.**

PhD Student of Law enforcement university

ГЭМТ ЯВДАЛ СУДЛАЛ  
CRIMINOLOGYРЕАБИЛИТИРУЮЩИЕ ОСНОВАНИЯ ПРЕКРАЩЕНИЯ УГОЛОВНОГО ДЕЛА ПО УГОЛОВНО-  
ПРОЦЕССУАЛЬНОМУ КОДЕКСУ РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ RENABILITATIVE

BASES OF TERMINATION OF THE CRIMINAL CASE ON THE CRIMINAL PROCEDURAL CODE OF THE RUSSIAN FEDERATION

ОХУ-ЫН ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД ТУСГАГДСАН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОХ ЦАГААТГАХ ҮНДЭСЛЭЛҮҮД

22

**ГАНБОЛД Р.**

Адъюнкт Омской академии МВД России, подполковник полиции

**GANBOLD R.**

Police Lieutenant Colonel, Postgraduate student of the Omsk Academy, Ministry of Internal Affairs of Russia

**Р.ГАНБОЛД**

ОХУ-ын ДХЯ-ны Омский академийн адъюнкт, цагдаагийн дэд хурандаа

## ОБЪЕКТ МЕЛКОГО КОММЕРЧЕСКОГО ПОДКУПА

OBJECT OF SMALL COMMERCIAL BRIBERY

ХУДАЛДААНЫ БАГА ХЭМЖЭЭНИЙ ХАХУУЛЬ ӨГӨХ ГЭМТ ХЭРГИЙН ОБЪЕКТИН ШИНЖ

28

**МИРОНОВА Г.Н.**

Адъюнкт Омской академии МВД России

**MIRONOVA G.N.**

Postgraduate student of the Omsk Academy, Ministry of Internal Affairs of Russia

**Г.Н.МИРОНОВА**

ОХУ-ын ДХЯ-ны Омский академийн адъюнкт





**ОБЩЕСТВЕННАЯ ОПАСНОСТЬ ПОСЯГАТЕЛЬСТВА НА ЖИЗНЬ СОТРУДНИКА ПРАВООХРАНИТЕЛЬНОГО ОРГАНА ПО УГОЛОВНОМУ ЗАКОНОДАТЕЛЬСТВУ РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ**

PUBLIC DANGER OF ENCROACHMENT ON LIFE OF LAW ENFORCEMENT OFFICER IN THE CRIMINAL LEGISLATION OF THE RUSSIAN FEDERATION

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН АМЬ БИЕД ХАЛДАХ ГЭМТ ХЭРГИЙН НИЙГМИЙН АЮУЛ

33

**АМАРСАНАА В.**

Адъюнкт Омской академии МВД России, старший лейтенант полиции Монголии

**AMARSANAA V.**

Post-graduate student of the Chair of Criminal Law of the Omsk Academy of the Ministry of Internal Affairs of Russia

**В.АМАРСАНАА**

ОХУ-ын ДХЯ-ны Омский академийн адъюнкт, цагдаагийн ахлах дэслэгч

**ЮРИДИЧЕСКИЙ АНАЛИЗ ПРЕДМЕТА ПРЕСТУПЛЕНИЯ, ПРЕДУСМОТРЕННОГО СТ. 174.1 УК РФ.**

THE LEGAL ANALYSIS OF THE CRIME SUBJECT, STIPULATED BY ART. 174.1 OF THE CRIMINAL CODE

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ТУСГАЙ АНГИЙН 174.1 ДҮГЭЭР ЗҮЙЛД ЗААГДСАН ГЭМТ ХЭРГИЙН ХАЛДЛАГЫН ЗҮЙЛИЙН ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН ТАЙЛБАР

36

**ЛУПЫРЬ М.В.**

Адъюнкт Омской академии МВД России

**LUPYR M.V.**

Postgraduate student of the Omsk Academy, Ministry of Internal Affairs of Russia

**М.В.ЛУПЫРЬ**

ОХУ-ын ДХЯ-ны Омский академийн адъюнкт

**ХУУЛЬ САХИУЛАХУЙН ИННОВАЦИ**  
LAW ENFORCEMENT INNOVATION

**ОХУ БОЛОН МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, НИЙГМИЙН ХЭВ ЖУРМЫГ ХАМГААЛАХ АЖИЛЛАГААНД ОРЧИН ҮЕИЙН ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙГ АШИГЛАХ АСУУДЛЫГ ХАРЬЦУУЛАН СУДЛАХ НЬ**

COMPARATIVE STUDY REGARDING THE ISSUE ON THE USE OF MODERN TECHNIQUES AND TECHNOLOGIES FOR THE PREVENTION OF CRIME AND PUBLIC ORDER IN RUSSIA AND MONGOLIA

39

**Б.МЭНДБАЯР**

ОХУ-ын ДХЯ-ны харьяа Удирдлагын академийн сонсогч, цагдаагийн хошууч

**MENDBAYAR B.**

Police Major, Student of the Academy of Management, Ministry of Internal Affairs of Russia

**МАЛЫН ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛД ЧИП АШИГЛАХ БОЛОМЖ**

OPPORTUNITIES TO USE CHIP FOR FIGHTING CRIME AND PREVENT OF THEFT LIVESTOCK

**Б.ДАЯДАН-ЭРМЭД**

ХСИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хил судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, дэслэгч

**DAYDAN-ERMED B.**

Lieutenant, Researcher at the Border Studies Center, Research Institute, LEU

47

**Б.ГАНЗАГАС**

ХСИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хууль сахиулахуйн инновацийн төвийн эрдэм шинжилгээний ажилтан, дэд ахлагч

**GANZAGAS B.**

Junior sergeant, Researcher at the Law Enforcement innovation Center, Research institute, LEU





## ХУУЛЬ САХИУЛАХУЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛ LAW ENFORCEMENT EDUCATION STUDIES

### МОНГОЛЫН ЗАРИМ ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН ОЮУТНУУДЫН СУРАЛЦАХ ХЭВ МАЯГИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА (ХСИС-ИЙН СУРАЛЦАХ ХЭВ МАЯГИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

THE COMPARISON STUDY OF LEARNING STYLE AMONG STUDENTS OF MONGOLIAN UNIVERSITIES  
(BASED ON LAW ENFORCEMENT UNIVERSITY)

51

#### Л.ЭНХТҮШИГ

ХСИС-ийн Эрх зүй Нийгмийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн багш, сэтгэл судлалын магистр

#### ENKHTUSHIG L. (MA of Psychology)

Psychology lecturer at Faculty of Social Science, Institute of Law and Social Science, LEU

## ЦАГДАА СУДЛАЛ POLICE STUDIES

### ЦАГДААГИЙН СОЁЛ, ТҮҮНИЙГ ТОДОРХОЙЛОХ ХҮЧИН ЗҮЙЛ

POLICE CULTURE AND ITS DEFINING FACTORS

61

#### Л.НЯМДАВАА

Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа

#### NYAMDAAVA L.

Police Colonel, Head of Legal Division, Headquarter of National Police Agency of Mongolia

### БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ҮНДЭСНИЙ ЖЕНДАРМЫН БОЛОН ҮНДЭСНИЙ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

ORIGIN AND DEVELOPMENT OF THE NATIONAL POLICE AND THE NATIONAL GENDARMERIE OF  
THE FRENCH REPUBLIC

64

#### Ш.БААСАНДОРЖ

ХСИС-ийн докторант, хуульч, прокурор

#### BAASANDORJ SH.

Public prosecutor, lawyer, PhD student of the LEU

## ХИЛ СУДЛАЛ BORDER STUDIES

### ХИЛИЙН МАНАА БИЕИЙН ХҮЧ, ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ, ГАЛТ ЗЭВСЭГ ХЭРЭГЛЭХ ҮЕД ГАРЧ БОЛЗОШГҮЙ АЛДАА, ЗӨРЧЛӨӨС СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

ISSUES AND WAYS TO PREVENT VIOLATIONS DURING THE USAGE OF PHYSICAL EXERTION,  
SPECIAL EQUIPMENT AND FIREARMS

74

#### Б.ЗУЛБАДРАХ

ХСИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хил судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант, дэд хурандаа

#### ZULBADRAKH B.

Lieutenant Colonel, Ph.D student, Researcher of Border Studies Center, Research Institute, LEU

## ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙ СУДЛАЛ FORENSIC STUDIES

### ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙН ХЭЛ: ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

LANGUAGE OF FORENSIC EXAMINATION:  
PROBLEM ASPECTS AND WAYS TO SOLVE THEM

84

#### Б.ЦОЛМОН

ХСИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Шинжлэн магадлахуй судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хууль зүйн ухааны доктор, цагдаагийн дэд хурандаа

#### TSOLMON B. (Ph.D in Law)

Police Lieutenant Colonel, Senior Researcher of Forensic studies center, Research Institute, LEU

### ГАРЫН МӨРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

CURRENT CONDITION AND FUTURE TREND OF IDENTIFICATION OF FINGERPRINT

90

#### Б.НОМИН

ХСИС-ийн Шинжлэн магадлахуйн институтийн багш, докторант, цагдаагийн хошууч

#### NOMIN B.

Police major, teacher of Institute of Forensic Science, LEU

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ**  
**COURT DECISION EXECUTION STUDIES**

**НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ: УЛАМЖЛАЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ**

EFFECTIVE COMMUNITY SENTENCES: TRADITION, LEGAL REGULATION, IMPLEMENTATION

97

**Б.АЛТАНГЭРЭЛ**

ХСИС-ийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн ухааны доктор, дэд профессор, хурандаа

**ALTANGEREL B. (Ph.D in Law, Assoc.Prof.)**

Colonel, Head of Court Decision Execution center, Research Institute, LEU

**ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АСУУДАЛД**

MANAGEMENT ISSUES RELATED TO PRISON REHABILITATION PROGRAMS

**Ц.ОЧГЭРЭЛ**

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн профессорын багийн профессор, хууль зүйн ухааны доктор, хурандаа

**OCHGEREL TS. (Ph.D in Law)**

Colonel, Professor of the panel for Court decision executions management and strategy, Law Enforcement Management Academy, LEU

105

**ХОРИХ БАЙГУУЛЛАГА ДАХЬ НИЙГЭМ, СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ**

FOCUSING ON THE IMPLEMENTATION PROCESS OF SOCIAL AND PSYCHOLOGICAL SERVICE PROGRAM IN PENAL INSTITUTIONS

110

**О.БАЯРЖАРГАЛ**

ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш, ахмад

**БAYARJARGAL O.**

Captain, Senior lecturer of Social work faculty, Institute of Court Decisions Execution, LEU

**ЭРДЭМТЭН, СУДЛААЧДЫН ҮЗЭЛ БОДОЛ**  
**POINTS OF VIEWS OF SCIENTISTS AND RESEARCHERS**

**АРБИТРТ ОЛОН УЛСЫН АРИЛЖААНЫ МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭД ХЭРЭГЛЭГДЭХ ЭРХ ЗҮЙГ СОНГОХ ТАЛААР ОНОЛЫН ЗАРИМ АСУУДАЛ**

CHOICE OF LAW IN INTERNATIONAL COMMERCIAL ARBITRATION

115

**С.ОЮУНЧИМЭГ**

ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Эрх зүйн онолын тэнхимийн ахлах багш, ахмад

**OYUNCHIMEG S.**

Captian, Senior lecturer, Faculty of Law Theory, Law and Social Science Institute, LEU

**УЛС ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН АСУУДАЛ**

ETHICAL ISSUES OF POLITICAL PUBLIC SERVANT

**М.ДОЛГОРСҮРЭН**

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрдэм шинжилгээний дэд ажилтан, хууль зүйн магистр

**DOLGORSUREN M. (LL.M)**

Researcher at the Department of Legal and Political studies, Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences

123



## ТЕРРОРИСТ БАЙГУУЛЛАГЫН “ЖИНХЭНЭ ГИШҮҮН”-ИЙГ “ГАНЦААРДСАН ЧОНО” ТЕРРОРИСТТОЙ ХАРЬЦУУЛАН ШИНЖИХҮЙ

### A COMPARATIVE STUDY ON “ACTIVE CADRE” OF TERRORIST ORGANIZATIONS AND “LONE WOLF TERRORISTS”

#### Ш.ЧУЛУУНБАТ

ХСИС-ийн Хилийн сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдлын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд хурандаа

#### CHULUUNBAT SH. (PhD)

Lieutenant Colonel, Head, Faculty of Security for Border Checkpoints, Border Institute, LEU

#### ЖЕЙМС БРАЙН ПАТТИСОН

БНСУ-ын Кеймюнг их сургуулийн Цагдаа судлалын тэнхим, доктор, профессор

#### JAMES BRYAN PATTISON (PhD, Prof.)

Faculty of Police Sciences, Department of Police Administration, Keimyung University, Korea

#### Ц.БАТБАЯР

ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн дэд профессор, доктор, хошууч

#### BATBAYAR TS. (PhD, Assoc.Prof.)

Faculty of Social Sciences, Institute of Law and Social Sciences, LEU

✉ [chuluunbat.sh@leu.gov.mn](mailto:chuluunbat.sh@leu.gov.mn)

**Товч агуулга:** Ирак Сири дахь Исламын улс (Isis) бүлэглэлийн нэгэн нууц ажилтан Европ руу дүрвэн гарч террорист байгууллагын удирдлага зохион байгуулалт, дотоод үйл ажиллагаа, гишүүнчлэл, хөдөлмөрийн гэрээний тухай зарим нэг чухал мэдээллийг илчилсэн байдаг. Энэхүү мэдээлэл нь хязгаарлагдмал хэдий ч, террорист бүлэглэлийн гишүүдийг чухам ямар хүчин зүйл хүчирхийлэл хийхэд хүргэдэг талаарх ойлголтыг авах боломжийг бүрдүүлсэн. Террористууд яагаад гэм буруугүй, энгийн иргэдийн эсрэг хүчирхийлэл үйлддэг болохыг сэтгэл зүйн үүднээс, эсвэл хувь хүний зан араншин, төлөвшилтэй холбон тайлбарлах нь учир дутагдалтай юм. Учир нь дурын хүн өөрийгөө хянах бүрэн чадвартай байдаг бөгөөд энэ чадвар нь дотоод талаасаа гадагшаа эсвэл гадна талаасаа дотогшоо чиглэсэн урсгалтай байдаг. Терроризм судлаач Борум “Террорист бүлэглэл”-ийн гишүүдийн өөрийгөө хянах чадвар нь гаднаасаа дотогш чиглэсэн, харин “Ганцаардсан чоно” террористынх дотроосоо гадагшаа чиглэсэн урсгалтай болохыг өөрийн хийсэн судалгаагаар олж тогтоожээ. Тэгвэл терроризмыг онолын ямар үзэл баримтлалаар тайлбарлах нь социологичдын дунд ихээхэн маргаантай асуудал үүсгэдэг төдийгүй криминологийн онолоор тайлбарлаж болох уу гэсэн асуудал гарч ирж байна.

Уг өгүүлэлд бид энэхүү феномен, түүний амин сүнс, зангилаа асуудал нь юу болохыг микро социологийн хандлагаар тайлбарлахыг хичээлээ. Мөн нийгмийн энэхүү содон үзэгдлийг танин мэдэх, түүний хамгийн эцсийн эд эс, цаашид үл задрах бодгаль хүний ертөнцийг хэрхэн ойлгож буйгаар террорист байгууллагын “жинхэнэ гишүүн” болон “ганцаардсан чоно” террористын талаар судлах боломж нээгдэх юм.

**Abstract:** The release of a trove of “employment applications” by a disgruntled former Islamic State operative has given some insight into the relationship between fighters (what we call the “active cadre”) and their employing organization. Extrapolating from the tenor of these documents gives some limited understanding about what attracts, drives, and maintains the attention and loyalty of those that do the violent “work” of the organization. This information proves less useful for analyzing “home-grown” or unaffiliated terrorists. While no personality or psychological “profiles” can be constructed to identify terrorists to any degree of usefulness, approaching the task from an integrated criminology theory holds some promise at least for explanations as to what allows individuals to leap from a theoretical acceptance of violent behavior against innocent civilians to actually undertaking the violent action. Borum’s analysis of external and internal controls upon the individual perpetrators is useful for differentiating between organized and lone wolf terrorists. Outside-in control mechanisms apply to terrorist organization members while so-called “lone wolf” terrorists nurture violent behavior with inside-out cognition.

**Түлхүүр үгс:** Жинхэнэ гишүүн, ганцаардсан чоно террорист, криминологийн нэгдмэл онол, нийгмийн хяналт.

**Keywords:** Active Cadre, Lone Wolf Terrorists, Integrated Criminology Theory, Social Control.





Хууль сахиулахуй

### Оршил

М.Креншоу, Р.Борум, Д.Тейлор, В.Луис, А.Силке, Ф.М.Могаддам зэрэг олон эрдэмтэд энэ чиглэлээр тодорхой судалгаа хийж өөр өөрийн байр суурийг илэрхийлсэн байдаг. Судалгааны үндсэн ойлголт болох террорист байгууллагын “жинхэнэ гишүүн” болон “ганцаардсан чоно” террористын ялгааг танин мэдэхийн тулд ерөөс терроризм, түүний мөн чанар, олон хувилбарт дүрсүүдийг тайлбарлах шаардлага тулгарч байна.

Тэгш бус байдал, шударга бус сөргөлдөөн нь террорист хадлага үйлдэх үндсэн шалтгаан болдог. Террорист байгууллагууд нь албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага биш юм. Тэдэнд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нутаг дэвсгэр, хил, үндэсний харьяалал байдаггүй талаар ч зарим эх сурвалж дурдсан байдаг. Товчоор хэлбэл, террорист байгууллагууд нь бусад улс, үндэстний эсрэг алан хядах үйл ажиллагааг явуулдаг бөгөөд хэт даврах үзэл баримтлалыг бий болгож, аливаа нийгэм, нийгмийн бүлгүүдийг эмзэг байдалд оруулах зорилгоор хүн ам ихтэй хот, суурин, байрлалд алан хядах, хорлон сүйтгэх үйл ажиллагааг маш хурдацтай зохион байгуулах чадамжтай сайтар бэлтгэгдсэн бүлэглэл юм. Тэдний болзошгүй ажиллагааны талаар бодит мэдээлэл олох, түүнээс урьдчилан сэргийлэхэд маш хэцүү байдаг. Тэгвэл ямар нэг террорист байгууллагад харьяалагддаггүй, бие даан үйл ажиллагаа явуулдаг террористууд бий. Тэднийг ганцаардсан чоно террорист гэх бөгөөд тэдгээр нь ямар ч хамаагүй аргаар олны анхаарлыг татах зорилгоор экстрим буюу хэт аюултай ажиллагааг олон нийтийн эсрэг явуулах эрсдэлийг тээж явдаг.

Арга зүйн хувьд терроризмыг хүчирхийллээр заналхийлэх; олон нийтийн дунд айдас бий болгох; дахин аюул нүүрлэн хэмээн итгүүлэх; улс төр, шашны үнэт зүйл, хувь хүний мөн чанарт нөлөөх; олон давхар сүлжээний өргөн бүтэцтэй ч террорист нь дүрэмт хувцас, ялгаж тэмдэггүй, тиймээс энгийн иргэдээс үл ялгарах; хүчирхийллийн хэлбэр нь ерөнхий шинж чанартай; хаалттай, хязгаарлагдсан бүсэд биш дэлхийн аль ч хэсэгт үйл ажиллагаа явуулах магадлалтай зэргээр ойлгож болох юм.

Ганцаардсан чоно террорист, террорист байгууллагын гишүүдийн аль аль нь бодгаль үнэт зүйл, аливаа зорилгын үндсэн хэсэг болж байдаг хэдий ч ганцаардсан чоно террорист гэгдэх этгээд нь цэвэр террорист этгээд байдаггүй байна.

Энэхүү өгүүлэлд бид террорист байгууллагын “жинхэнэ гишүүн” болон

“ганцаардсан чоно” террористын хэв шинж, үйл ажиллагааг нарийвчлан танин мэдэх боломжийг эрэлхийлэх үүднээс доорх дэд сэдвүүдэд хуваан харьцуулан судлах зорилтыг тавьсан болно.

### Үндсэн хэсэг

#### “Террористыг таньж мэдэх” аргыг хайсан ч юу ч олоогүй нь

Марта Креншоу террористуудыг 35 жил гаруй хугацаанд судалжээ. Тэрээр хувь хүн террористуудтай холбогдох хүслийн хувьд: (1) хүчирхийлэл хийх боломж эрэлхийлэх; (2) өөрсдөөсөө илүү дээд шатны хүрээлэлд харьяалагдах хүсэл; (3) нийгмийн статуст харьяалагдах хүсэл; (4) материаллаг ашиг сонирхол олж авах зорилгодоо татагдах<sup>1</sup> гэсэн хэд хэдэн шалтгаантай гэж тодорхойлсон байна. Харин Борум Креншоугийн дэвшүүлсэн сэдлүүдтэй утга нэг боловч илүү нээлттэй өнцгөөс нь харж арай хураангуй байдлаар томьёолжээ. Үүнд: (1) шударга бус байдал; (2) хувийн шинж байдал, хандлага, итгэл үнэмшлийг илэрхийлэх боломжийг эрэлхийлэх; (3) ямар нэг харьяалалд хамаарах зорилго гэсэн байна<sup>2</sup>. Креншоугийн жагсаалтыг Борумын жагсаалттай дүйцүүлэн шинжилбэл: террористууд алив нийгмийн харилцааг шударга бус, нэг нь нөгөөгөө эдийн засаг, үндэс угсаа, улс төр, шашин болон нийгмийн гарал үүслээр ялгаварладаг гэж итгэдэг, итгүүлэх арга замаар нийгэм, олон нийтийн эсрэг үйл ажиллагаа явуулах боломжийг эрэлхийлдэг, явуулдаг гэж үзэхээр байна. Креншоугийн хоёр дахь сэдэл “харьяалагдах хүсэл”, Борумын гурав дахь сэдэл “харьяалал хайх” гэдэг нь хоёулаа итгэгчдийн нийгэмлэг буюу бүлэглэлд багтах гэсэн утга, зорилго, үндсэн чанар байхаар байна. Харин Креншоугийн жагсаалтын нийгмийн статус гэдгийг Борумын хувийн шинж байдал, хандлага, итгэл үнэмшлийг илэрхийлэх боломжийг эрэлхийлэх гэсэн санаатай язгуур холбоотой гэж ойлгож болох юм.

Тейлор, Луис (2004) нар террорист байгууллагууд гишүүнээ элсүүлэхдээ эмзэг байдлыг нь ашигладаг талаар маш энгийн тодорхойлолт, бодит тайлбарыг хийсэн байдаг: “Залуучуудад ирээдүйгээ эрэлхийлж, цааш сэтгэл ханамжтай амьдрахад дэм болох утга учиртай зүйл хийхийг хүссэн цаг үе гэж байдаг. Тийм үедээ тэд хэт эмзэг болж нийгэм тэднийг хөсөр хаясан мэт санагдах, өөрсдөө үнэ цэнэгүй болсон мэт ойлгох, алив шашны номлол, удирдлага тэдний хийсвэрлэн сэтгэсэнтэй адил өрнөж буй мэт ойлгодог”<sup>3</sup> гэжээ. Зохион



байгуулалттай террорист бүлгийн гишүүн нь хувь хүний мөн чанар, амьдралын зорилго, утга учрыг олох гэх мэт бусадтай л адил ажиглагддаг. Мэдээж ямар ч ухаалаг нийгэм ирээдүйн аюул, заналхийллийг урьдчилан тодорхойлж, сэргийлэх чадамж сул байдаг билээ.

Жоржтауны Аюулгүй байдал судлалын төвийн судлаачдын тэмдэглэснээр ганцаардсан чоно террористыг багаар ажилладаг террорист бүлгийн гишүүдтэй харьцуулахад сэтгэл зүйн эмгэг асуудалтай, террорист халдлагаас омогшин урамшдаг, тиймээс зохион байгуулалттай бүлэг тэднийг гишүүнээр хүлээн авдаггүй байх магадлалтай<sup>1</sup> гэжээ.

Судлаач Борум террорист болох процессын талаар дурдахдаа: терроризм үйлдэх гэсэн хүсэл эрмэлзэл нь хувь хүний өөрийн мэдэрч буй зөв буруугийн мэдрэмж, “хүний аливаа орчин нөхцөлийг хязгаарласан эсвэл эрхийг нь зөрсөн гэсэн ухамсар”-аас үүдэн бий болсон “Энэ бол буруу” гэсэн ойлголт, хандлага юм. Энэ нь тухайн этгээдийн хүлээлт биелээгүйд төрсөн эгдүүцэл, шударга биш байдлыг эсэргүүцэх гэсэн ухамсарт хүргэж<sup>2</sup>, хувь хүний сэтгэл хөдлөл, өөрийгөө хянах чадварт нөлөөлөх хөдөлгөгч хүч нь болж өгдөг. Харин терроризм үйлдэх үндсэн шалтгаан нь сэтгэл мэдрэлийн эмгэгээс үүдэж байгаа гэж үзэж болохгүй бөгөөд террористууд аймшигтай үйлдэл хийдэг ч тэднийг “сонгодог сэтгэл мэдрэлийн өвчтөн” гэж тодорхойлж болохгүй юм<sup>2</sup>.

Эдлэх ёстой эрх, эрх нь хангагдахгүй байх хоёрын тэнцвэртэй бус харьцаа нь алив зүйлийг буруутгах буюу Борумын нэрлэснээр “энэ чиний буруу” гэсэн ойлголтод хүргэх, энэхүү эсэргүүцлээ тодорхой бүлэг, олон нийтийн эсрэг чиглүүлэхэд хүргэдэг байна<sup>3</sup>. Түүний томьёолсноор зарим хүмүүс өөрсдийгөө хамгаалах зорилгоор эсэргүүцлээ илэрхийлдэг бол нөгөө хэсэг нь экстрим буюу эрс шийдэмгий хүчирхийллийн арга хэрэглэж өөрсдийг нь үгүйсгэж буй хэсгийг шийтгэдэг ажээ<sup>3</sup>.

Рассел, Миллер (2008) нар терроризм үйлдэгчдийг хүн ам зүйн талаас нь судалж дараах нийтлэг үзүүлэлтийг гаргасан байна:

1. Нас: Террорист бүлгийн гишүүдийн дундаж нас 22-25. Криминологийн онолын үүднээс нас нь гэмт явдлын учир шалтгаантай шууд хамааралтай гэж үздэг. Өөрөөр хэлбэл залуу хүний гэмт хэрэг үйлдэх магадлал нь ахимаг настай хүнийхээс хэд дахин илүү

<sup>1</sup> M. Crenshaw: “An organizational approach to the analysis of political terrorism”, Orbis, Vol.29, No.3, pp. 465-489 (1985)

<sup>2</sup> R. Borum: “Psychology of terrorism”, Tampa: University of South Florida (2004)

байдаг;

2. Хүйс: Хүйсийн хувьд мөн л ялгаагүй, эрэгтэй хүний гэмт хэрэг үйлдэх магадлал эмэгтэй хүнийхээс өндөр гэж криминологийн онол тайлбарладаг. Уг судлаачдын судалгаанаас үзэхэд террорист халдлага үйлдэгчдийн 80 гаруй хувийг эрэгтэйчүүд эзэлдэг гэсэн нь онолын үүднээс тайлбарлагдахаар байна;

3. Гэрлэлтийн байдал: Дийлэнх нь гэрлээгүй;

4. Хот/Хөдөө: Дийлэнх нь хотод төрж өссөн эсвэл удаан хугацаанд оршин суусан;

5. Нийгэм, эдийн засгийн байдал: Гишүүд болон удирдагчид нь ихэвчлэн дунд болон дээд ангиллынхан;

6. Боловсрол: Гуравны хоёр нь тодорхой хэмжээнд их сургуульд сурч боловсорсон;

7. Улс төрийн үзэл баримтлал: Анархист, Марксист-Ленинизм, үндсэрхэг үзэл гэжээ. Харин террорист бүлэгт гишүүн элсүүлэх хамгийн тохиромжтой газрыг томоохон их сургуулиуд гэжээ<sup>4</sup>.

Дээрх үзүүлэлтүүдээс террорист, террорист бүлгийн гишүүн болох магадлал, элемент, эмзэг байдал, сэдэл зэрэг ойлголтуудыг харж болох боловч тухайлсан онол хараахан гараагүй байна. Түүнчлэн Креншоу, Борумын өгсөн тодорхойлолтуудыг хүлээн зөвшөөрөх эсэх нь ч эргэлзээтэй юм.

Хэдийгээр хувь хүний мөн чанар, сэтгэл зүйн өөрчлөлт нь хүчирхийлэл үйлдэх шийдвэр гаргахад нөлөөлж буй хөдөлгөгч хүчин зүйл мөн боловч терроризм үйлдэгчийн хандлагыг дан ганц сэтгэл зүйн үүднээс холбон тайлбарлах боломжгүй<sup>3</sup>. Борум террорист бүлгийн хэд хэдэн гишүүдийн хувийн түүхийг судалсны дараа террористууд бусад хүмүүсээс ялгарах амьдралын онцлог хэв маягийг, бүгд өөр өөр хэв шинжтэй, хүүхэд насандаа сэтгэл зүйн дарамт, хямрал, шударга бус байдал, доромжлолыг мэдэрч өссөн зэрэг нийтлэг шинжтэй болохыг тогтоосон байна. Үүгээр терроризмыг тайлбарлах нь өрөөсгөл хэдий ч энэ нь шударга бус байдлын эсрэг өөр өөрийн аргаар тэмцэх гэсэн хувь хүний сэтгэл зүйн эмзэг байдал, аливаад автах сэдэл, радикал үзэл суух үндсийг бий болгож өгсөн байх боломжтой юм.

Палутциан, Могатдам нар аймшигт терроризм үйлдэхэд хүргэдэг сэтгэл зүйн хөгжлийн үе шатыг энгийн шатаар зүйрлэсэн “метафор” загварчлалаар тайлбарласан байдаг<sup>4</sup>.

<sup>3</sup> D. Taylor and W. Louis: “Terrorism and the quest for identity”, in ‘Understanding terrorism: Psychosocial roots, consequences, and interventions’, Edited F.M. Moghaddam and Marsella, Washington DC: American Psychological Association, pp. 169-185 (2004)

<sup>4</sup> Security Studies Program of National Security Critical Issue



ХУУЛЬ САХИУЛАХУЙ  
 LEGAL STUDIES

Газрын давхар-материаллаг нөхцөлийн шударга бус байдлыг сэтгэл зүйн хувьд мэдрэх;

Нэгдүгээр давхар-нийгэм аливаа сөрөг шалтгааны улмаас (улс орны эдийн засгийн хямрал, нийгмийн эмзэг байдал) эергээр өөрчлөгдөж, хувьсаж чадахгүй байгааг мэдрэх;

Хоёрдугаар давхар-өөрийн уур хилэнг системийн эсрэг чиглүүлэх (гэр бүл, ажлын хамт олон хамаарахгүй);

Гуравдугаар давхар-нийтлэг ёс суртахуунаас өөрийгөө тусгаарлан цөхрөлийг нь өдөөгч философийн өвөрмөц системийг олох;

Дөрөвдүгээр давхар-тухайлсан хүмүүс авлигад идэгдсэн нийгмийн эсрэг “бид тэмцэнэ” гэж бусдад итгүүлэн “тэдний” эсрэг гэсэн үзэл суртлыг хөгжүүлэх;

Тавдугаар давхар-хүний төрөлхийн араатан араншинг сэдрээх буюу энэ давхарт гарахад сэтгэл зүйн хувьд хүн алахад бэлэн болсон байдаг.

Тэгвэл террорист байгууллагын бүх гишүүд тавдугаар давхарт гардаг уу? Террорист байгууллагын хувьд бүх гишүүд нь тавдугаар давхарт гарах шаардлагагүй байдаг. Жишээлбэл: Гуравдугаар давхарт удирдагчид, стратеги төлөвлөгчид, элсүүлэгчид, дэмжигчид байх ба тэд харгис хэрцгий үйл ажиллагаанд биечлэн оролцдоггүй.

Энэхүү загварчлал нь террорист бүлгийн гишүүн болон ганцаардсан чоно террористуудын аль алинд хамааралтай байж болох ч хүссэнээрээ хүчирхийлэл үйлдэх эрх мэдэлтэй болгох тавдугаар шатанд бүх террористууд ямар нэгэн байдлаар хүрэх шаардлагатай болно. Тэгэхээр террорист байгууллагын гишүүн болон ганцаардсан чоно террористуудын хооронд ямар ялгаа байна вэ?

### **Террорист байгууллагын жинхэнэ гишүүн болон ганцаардсан чоно террористыг харьцуулан шинжихүй**

Террорист байгууллага нь олон төрлийн гишүүдтэй, тэдгээрийн оролцоо нь харилцан адилгүй байдаг. Зарим гишүүд нь стратеги төлөвлөгчид байхад зарим нь гишүүн элсүүлэгчээр мэргэшсэн, эсвэл тухайн байгууллагыг биет болон биет бус хэлбэрээр дэмждэг (мөнгө, хөрөнгө, байр байгууламж, аж ахуй, хангалт, сургалт, эсвэл шашны зан үйлтэй холбоотой амлалтууд өгөх гэх мэт) гишүүд ч байдаг. Мэдээж зарим нь алан хядах ажиллагааг гардаж гүйцэтгэдэг. Могаддам хэрцгий этгээдүүдийг нэрлэхдээ

Task Force: “Report: lone wolf terrorism”, Washington DC: Georgetown University (2015)

“тэжээл”<sup>5</sup> гэдэг үгийг ашигласан бол бид энэ өгүүлэлд тэднийг “жинхэнэ гишүүн” гэж нэрлэсэн.

Тодорхой үе шат бүрийг туулж байж жинхэнэ гишүүн буюу алан хядагч болдог гэх түгээмэл ойлголтын хүрээнд авч үзвэл, жинхэнэ гишүүн гэдэг нь шударга бус байдлыг яс махандаа тултал мэдрэсэн; нийгэм, эдийн засгийн хувьд амжилтад хүрэхээр чармайсан хэдий ч ахиц дэвшилд хүрээгүй; уур бухимдалдаа автсан; өөрийнхөө бүтэлгүйтлийн шалтгаанд бусдыг буруутгаж, түүндээ гүн бат итгэсэн; хүрээлэн буй орчин, нийгмийн ёс зүйгээс хөндийрсөн (зөвхөн харьяалагддаг бүлэгт нь үйлчилдэг ёс суртахуунд үнэнч); ертөнцийг үзэх үзэл нь “тэд”-ний эсрэг “бид” гэх харьцаагаар тодорхойлогддог; бүлгийнхээ явцуу зарчимтай хүчирхийллийг жигшсэн бусдын жигшилтийг “амжилт” хэмээн бахархдаг этгээд юм. Энэхүү сөрөг үзэгдлийг криминологийн дэд соёлын онол, социологийн гудамжны хуулийн онолоор тайлбарлан ойлгож болно.

Ганцаардсан чоно террористын хувьд “метафор” загварчлалын тодорхой үе шатыг бие даан туулж алан хядах ажиллагааг өөрийн шийдвэрээр үйлддэг. Тэд тодорхой зааварчилгаа юм уу, гэмт үйлдлийн санаагаа ихэвчлэн олон нийтийн сүлжээ, харгислалыг сурталчилсан мэдээллийн хэрэгслээс, зарим тохиолдолд найз нөхөд, хамт ажилладаг хүмүүсээсээ олж авдаг ажээ<sup>6</sup>.

Ганцаардсан чоно террорист ба террорист байгууллагын жинхэнэ гишүүн хоёрыг ялгаж судлахын өмнө аливаа бүлгийн гишүүд болоод тухайн бүлэгт харьяалагддаг ч гэмт үйлдэлд шууд оролцдоггүй бусад гишүүд хоорондын ялгааг судлах хэрэгтэй. Террорист байгууллагын ихэнх гишүүд “метафор” загварчлалын таван үе шатыг гүйцээгүй байдаг байна. Зөвхөн “жинхэнэ гишүүд” гэх тусгай бэлтгэгдсэн гишүүд л энэ таван үе шатыг бүрэн төгс туулж гарсан байдаг. Мөн тэдний ёс суртахуун, үзэл суртал, харилцаа холбоо, хөдөлгөөн бүр хатуу хараа хяналтан дор байдаг байна (2).

Харин ганцаардсан чоно террористын хувьд бүх зүйл эсрэгээрээ. Тэд зөвхөн өөрөө өөрийгөө л удирддаг<sup>7</sup>. Ганцаардсан чононуудын хувьд терроризм нь бүхий л амьдралынх нь утга учир гэхээсээ илүү хувийн амьдралынх нь бүтэлгүйтэл, бухимдал, хорслоос нь үүдэлтэй байх нь

<sup>5</sup> R. Borum: “Understanding the terrorist mindset”, FBI Law Enforcement Bulletin, Vol.72, No.7, pp.7-10 (2003)

<sup>6</sup> R. Borum: “Psychology of terrorism”, Tampa: University of South Florida (2004)

<sup>7</sup> Security Studies Program of National Security Critical Issue Task Force: “Report: lone wolf terrorism”, Washington DC: Georgetown University (2015)



элбэг ба шашны ухуулга юм уу цахим ертөнцөөс зарим нэг албан бус сургалтыг олж авсан байх талтай<sup>8</sup>. Өөрөөр хэлбэл ганцаардсан чононууд нь хүчирхийлэлд бэлдэхийн тулд нийгэм дэх бүтэлгүйтэл, үзэл суртлын гажуудлаа ашигладаг. Тэд эцсийн эсвэл цорын ганц үйлдлээр өөрийн өнгөрсөн амьдралын бүхий л бүтэлгүйтлийг арчиж чадна гэж бат итгэдэг. Тиймээс ч дээд шатны үзэл санааны төлөө өөрийгөө золиосолж, өнгөрсөн амьдралынхаа гэм нүглийг цагаатгана гэж үздэг. Ихэнх ганцаардсан чононууд нь хувийн хорслоо ямар нэг үзэл суртлын урсгалтай холих замаар террорист үйлдлээ зөвтгөн үздэг байна. Пантуччи (2011) ганцаардсан чоно террористуудыг хэв шинжээр нь том хэмжээний бүлэглэл, сүлжээнд автаагүй идеалистууд; том хэмжээний бүлэглэл, сүлжээнд албан ёсоор элсээгүй боловч тодорхой хэмжээгээр холбоо тогтоосон; гэмт хэргийн ямар нэг бүлэгт хамаардаг ч төдийлөн нягт ажилладаггүй ганцаардсан чоно; бүлэглэл, сүлжээний хяналт, удирдлагад орох хүсэл, зоригтой ганцаардсан чоно террорист гэж дөрөв ангилан авч үзсэн<sup>9</sup>. Пантуччигийн эдгээр хэв шинжүүдээр ганцаардсан чоно террористыг тодорхойлж болох боловч онолын загвараар ашиглахад учир дутагдалтай юм. Тиймээс ганцаардсан чоно террористыг илүү сайн олгох, террорист бүлгийн жинхэнэ гишүүдээс юугаар ялгаатай болохыг тайлбарлахын тулд криминологийн онол, аргачлалыг ашиглах нь зүйтэй байж болох талтай.

**Терроризмыг тайлбарлах криминологийн тухайлсан онол байхгүй ч эл ойлголтыг хөгжүүлэхэд криминологийн ухаан бусад боломжуудыг нээж өгч болох юм**

Криминологийн нийгмийн харилцан уялдааны онол (social bonding), нийтийн хяналтын онолууд (social control theories) нь бүгд террорист сэтгэл зүйн талаар зарим нөхцөлийг илэрхийлэх давуу талтай хэдий ч аль нь ч бүрэн тайлбарыг өгөхөөр төгс биш байна. Магадгүй зөвхөн гэмт явдлын талаарх нийтлэг дүгнэлт төдий боловч онолын хувьд бүх нөхцөлд тохирох хариулт биш юм. Мөн терроризм гэдгийг үндсэн шинжээр нь гэмт хэрэгтний сэтгэл зүйн хандлага гэж тодорхойлоход хүндрэлтэй. Учир нь гэмт явдал бол ерөнхийдөө хувиа бодсон, хувь хүний эрх ашгийн төлөө байдаг бол терроризм бол тийм байдаггүй. Хирши,

<sup>8</sup> R. Borum: "Understanding the terrorist mindset", FBI Law Enforcement Bulletin, Vol.72, No.7, pp.7-10 (2003)

<sup>9</sup> F.M. Moghaddam: "The staircase to terrorism: A psychology exploration", American Psychologist, Vol.60, No.2, pp.161-169 (2005)

Реклес, Сайкс, Сутерланд, Бургесс, Мертон, Кохен, Дуркхейм, Акерс зэрэг криминологи судлаачдын баталсан онолыг нарийвчлан судлахаас илүүтэйгээр Борумын дэвшүүлсэн санааг нийгмийн харилцан уялдааны онол, нийтийн хяналтын онолуудаар баяжуулан судлах нь зүйтэй. Тэрээр нийтээс суралцах онол (social learning theory)-д онцгойлон тусгагдаагүй өөрийгөө хянах чадварын дотоод, гадаад урсгалын талаарх санааг хөндөн дэвшүүлсэн. Өөрөөр хэлбэл, "Террорист бүлэглэл"-ийн гишүүдийн өөрийгөө хянах чадвар нь гаднаасаа дотогш чиглэсэн, харин "Ганцаардсан чоно" террористынх дотроосоо гадагшаа чиглэсэн урсгалтай гэж ойлгож болно.

Гаднаасаа дотогш чиглэсэн урсгалд дараах хүчин зүйлсийг хамруулан ойлгож болох юм. Үүнд: хүчирхийлэл үйлдэгчдийн үүрэг хариуцлагын хуваарилалт; өөрийн бүлэглэл, байгууллагын нэрийн өмнөөс ганцаар эсвэл хамтарч хийж буй хүчирхийлэл; бүлгийн гишүүний амьдралын бүх үйл явц нарийн хараа, хяналт дор байдаг тул удирдагч байгууллагын үйл ажиллагааны зорилго, чиглэлийг дуулгавартай мөрдөх ухамсар; тухайн бүлэглэл, байгууллагаас өгч буй нэр хүндийн баталгаа, амьжиргааны хангалт, хангамж.

Тэгвэл дотроосоо гадагшаа чиглэсэн урсгалд дараах хүчин зүйлсийг багтаан үздэг. Үүнд: өөрийн хийж буй террорист үйлдлийг зөв хэмээн итгэх далд ухамсар; цаг ямагт зүй бус үйлдэл хийхээр хийсвэрлэн төсөөлөх, төлөвлөх; хувь хүний сэтгэлгээний гаж мэдрэмж, түүний өөрчлөлт, хувирал, тогтворгүй байдал; хүчирхийллийн улмаас учирч буй хор хөнөөлийг үл тоомсорлох байдал, зүй ёсны мэт бодох, итгэх; хохирогчдыг буруутгах үзэл, (жишээлбэл: АНУ-ын засгийн газрын буруутай үйл ажиллагааны улмаас иргэд нь хохирох ёстой, учир нь тэд өөрсдөө засгийн газраа сонгосон); хохирогчдыг хүн биш „амьтан“ эсвэл „шавьж“ хэмээн үл тоомсорлох үзэл зэргийг дурдаж болох юм.

Эдгээрээс дүгнэн үзвэл, идэвхгүй хэв шинжээс хүчирхийлэл үйлдэхийг өдөөгч хүчин зүйл буюу өөрийгөө хянах чадвар нь ганцаардсан чоно террористын хувьд нь дотроосоо гадагш чиглэсэн, харин террорист байгууллагын гишүүнийх гаднаас дотогш чиглэсэн урсгалтай байдаг байна.

**Ирак Сири дахь Исламын улс (ISIS) бүлэглэлийн хөдөлмөрийн гэрээ тухайн байгууллагын жинхэнэ гишүүдийг ил болгосон нь**

2016 оны 3 дугаар сард Isis-ийн нэгэн дайчин байгууллага орхин Европ руу дүрвэсэн байдаг. Тэрээр өөрийн



байгууллагын 2 жилийн туршид шинээр элсүүлсэн гишүүдийн баримт болох 22,000 хувийн хэрэг, холбогдох мэдээллийг ил болгожээ. Уг баримтад өргөдөл өгсөн 22,000 иргэн Исламын улс бүлэглэлийн гишүүн болбол өөрийн биеийг бүрэн зориулахаа илэрхийлсэн байна. Хамгийн аймшигтай нь өөрийн амь насыг харамгүй зориулахаа илэрхийлсэн өргөдөл гаргагчид шашны талаар өнгөцхөн, буруу, хязгаарлагдмал ойлголттой байжээ.

Хувийн өргөдөлд жинхэнэ нэр, “тулааны” нэр, нас, боловсрол, жихадын туршлага, яс үндэс болон бусад мэдээллийг баримтжуулан багтаасан байв. Isis-д элсэж буй элсэгчдийн ам зүйн дундаж үзүүлэлт нь “эрэгтэй, 26 настай, ганц бие, маш сайн боловсрол эзэмшсэн, Куран судрыг сайтар судлаагүй” байсныг ил болсон 22,000 баримт бичгээс тусгай байгууллага судлан тогтоожээ. Мөн өргөдөл гаргагчдыг тусгай чадвар, хобби, ажлын туршлагын талаар дэлгэрэнгүй бичихийг шаардсан байжээ<sup>2</sup>.

Өргөдөл гаргагчид ажлын туршлагын хувьд харилцан адилгүй, дийлэнх нь тусгай ур чадвар эзэмшээгүй хар ажилчин, хувиараа худалдаа эрхлэгч, оюутан, ажилгүй иргэд байсан хэдий ч нарийн мэргэжил эзэмшсэн, өндөр цалин, ур чадвартай ажилтнууд бас (газрын тосны техникч, бэлтгэл цэргийн үүрэгтэн, IT инженер, нисгэгч, нисэх механик, Саудын дотоод хэргийн яамны харьяа онгоцны аюулгүй байдлын албаны ажилтан) хамрагджээ. Мөн ихэнх залуучууд нь барууны улсуудаас мэдүүлсэн бол ахимаг настайчууд нь дэлхийн халуун цэг, тулалдаан, мөргөлдөөнтэй улс, орны байлдах ур чадвар, мэдлэг туршлагатай иргэд байв.

Тухайн баримт бичгүүдийг АНУ-ын Цэргийн академийн Терроризмтой тэмцэх төв (СТС), тусгай албад нарийвчлан судлаад “Isis-ийн гишүүд өөрсдийн улсдаа эдийн засгийн хувьд тогтворгүй, боловсрол эзэмшсэн боловч дүйцэх ажлын байргүй, хамаатан садан, ойрын хүмүүс нь амь үрэгдсэн зэрэг шалтгаанаас болж террорист байгууллагад элсдэг” гэсэн дүгнэлтийг хийжээ.

Үүнээс дүгнэн үзэхэд Исламын улс бүлэглэлийн хүний нөөцийн үндсэн бодлого нь терроризмын үзэл санаа, идеологийг гишүүддээ бат суулгаж өгдөг, өөрсдийн ашиг сонирхлын төлөө бусдыг ашиглах, тэдний сэтгэл зүйд нөлөөлөх мэргэжлийн өндөр түвшинд очсоныг харуулж байна.

### Цаашдын судалгааны чиглэл

Энэхүү өгүүлэлд дурдаагүй боловч терроризмын талаар илүү чухал ач

холбогдолтой, судлах шаардлагатай зарим асуудлууд байна. Үүнд: 1) террорист ажиллагаанд нийгмийн тодорхой бүлэг татагдах нөхцөл байдал; 2) ёс зүйтэй, хуулийг сайн дагаж мөрддөг хүмүүсийг зүйрлэшгүй аюултай үйлдэл хийхэд хүргэдэг ёс суртахуун, ухамсрын өөрчлөлтийн үйл явц; 3) террористууд өөрсдийн байгууллагынхаа нэгдлийг хэрхэн хангадаг, орон нутгийн тэмцэгчдийг тэтгэнээр маш сайн дайсанг бий болгодог уу; 4) нийгмээс терроризмын нөлөөг бүрэн үгүй хийснээр террорист байгууламжийг зорилгогүй, үр дүнгүй болгож чадах уу зэрэг болно.

### Төрсгөл

Террорист байгууллага нь төрөл бүрийн үүрэг, хариуцлага бүхий гишүүдээс бүрдэх ба тэдгээрийн дотор хэзээ ч буу барьж, бөмбөг тэсэлж үзээгүй гишүүд ч байдаг талаар дээр өгүүлсэн билээ. Шашны номлогч, харилцаа холбоо, ар тал, хангалтын мэргэжилтэн, ёс суртахууны ажилтан, сэтгэл зүйч, тэсэрч дэлбэрэх бодис, бөмбөг үйлдвэрлэгч, бэлтгэгч зэрэг олон төрөл мэргэжлийн гишүүд террорист байгууллагыг бүрдүүлдэг. Тэд сэтгэл зүйн дээд түвшний буюу “метафор” загварчлалын гуравдугаар шатны сургалтад хамрагдаж, тухайн байгууллагын эрх, ашиг сонирхол, зорилгын төлөө нийгмийн хэвшмэл ёс суртахуунаас гажуу үзэл баримтлал, чадварыг олж авдаг. Харин зэвсэгт тэмцэгчид, бөмбөг тэслэгчид нь “метафор” загварчлалын тавдугаар шатны жинхэнэ гишүүд юм. Тэд нийгмийн хэвшмэл ёс суртахуун, энгийн амьдралаас гадуурхагдсан гэх, дэлхийн эсрэг “бид” хүмүүсийг алж устгах нь бидний зөв хэмээх үзэлд автсан харгис этгээдүүд байдаг.

Террорист байгууллагууд тэднийг итгүүлэн элсүүлэхдээ: өндөр боловсрол эзэмшсэн ч өнөөгийн нийгэмд чамд орон зай байхгүй учраас чи гадуурхагдсан, чамтай ижил хүмүүсийн төлөө чи ямар нэгэн утга учиртай зүйл хийх, тэмцэх боломж байгаа гэж өдөөдөг ба энэ нь хүний өөрийгөө удирдах чадварыг гаднаас нь дотогш чиглүүлж буй үйл явц юм. Isis гаднаас нь дотогш чиглүүлэх үйл явцыг тасралтгүй зэрэгцээ байдлаар явуулж, байгууллагынхаа төлөө ямар ч алан хядах ажиллагаа явуулахад бэлэн болгоход бэлтгэдэг. Шинээр элссэн гишүүдийн ихэнх нь юуны төлөө тэмцэх гэж байгаагаа мэдэхгүй, үзэл сурталд төөрөгдсөн этгээдүүд байдаг.

Харин ганцаардсан чоно террорист нь (жинхэнэ гишүүдтэй харьцуулахад) ихэвчлэн сэтгэл зүйн хувьд тогтворгүй, идеологийн хувьд тодорхойлох зүйлгүй, нийгэмд дасан зохицох чадавх сул,



тогтворгүй зан суртахуунтай хүмүүс байдаг. Ганцаардсан чоно террорист нь ерөнхийдөө ганцаараа, сэтгэлээ мэдрч итгэдэг, зорилго нь байгууллагын төлөө бус өөрийн үзэмжээр террорист үйл ажиллагааг үйлддэг. Борумын хувь хүний гадаад ба дотоод хяналтын механизмын үр дүн энд ихээхэн ач холбогдолтой. Гадаад хяналтын механизм нь террорист байгууллагуудын гишүүдэд хамаарах бол ганцаардсан чоно террористууд зөвхөн дотоод хяналтын механизмдаа захирагддаг ба өөрсдийн итгэж үнэмшсэн, эмх цэгцгүй байдалд гаргасан санаагаа хэрэгжүүлдэг. Ганцаардсан чоно террористын интерсубъектив ертөнц бүрэлдэх явц, нийгэм соёлын орчин, ёс суртахууны үнэт зүйлс, үнэлэмж, үзэл суртал зэрэг олон хүчин зүйлс нь бодит байдалтай хэрхэн холбоотой, тэд өөрсдийгөө болон бусдыг хэрхэн үнэлж, дүгнэдэг, шударга ёс, зөв буруугийн мэдрэмж хэрхэн бүрэлдэн тогтдог нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Дээрх мэдрэмж нь ганцаардсан чоно террористын сэтгэл зүйд алгуурхан нөлөөлсөөр тэсрэлттэй үйлдэл хийх шалтгаан нөхцөл нь болдог ба илрэх хэлбэр нь олон янз байдаг. Тухайлбал, тухайн ганцаардсан чоно террористын бодгаль шинжээс түүний ухамсарлагдсан зорилгот үйлдэл нь шалтгаалах ба ихэвчлэн хүчирхийллээр илэрдэг. Энэ нь өргөн утгаараа ёс суртахууны үнэлэмжийн плюраль систем ганцаардсан чоно террористын үнэт зүйлтэй зөрчилдсөнөөр тайлбарлагдах юм. Ганцаардсан чоно террористын санаа бодол бүрэлдэх механизмыг нээх нь ирээдүйд элсний ширхэг шиг олшрох нийгэм-сэтгэл зүйлн нөхцөлийг танин мэдэхэд чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн Рассел, Миллер (2008) нарын үзүүлэлтэд чанарын шинжилгээ хийж, бодгаль хүний ертөнц бүрэлдэх үйл явцыг танин мэдэх шаардлага тулгарч байна. Мөн Креншоу, Борум нарын аргачлалыг хөгжүүлж, психик хүчин зүйлсийг тодорхойлох технологийг боловсруулах нь микро социологи, сэтгэл судлал, криминологийн тулгамдсан асуудал болж байна.

Эдгээр асуудал нь яагаад чухал вэ? Учир нь аливаа аюул заналын эсрэг арга хэмжээ авна гэдэг нь тухайн аюул заналыг зөв тодорхойлохоос эхэлнэ. Харин аюул заналыг зөв тодорхойлсноор ямар аюул занал байж болохыг урьдчилан зөв харна. Тиймээс өөрсдийгөө хэрхэн хамгаалах, тэдний сэтгэл зүйг хэрхэн засаж өөрчлөх, нийгэмшүүлэх бодлого нь тэднийг зөв ойлгосны үндсэн дээр бий болох юм.

### Эх сурвалжийн жагсаалт

1. M. Crenshaw: "An organizational approach to the analysis of political terrorism", *Orbis*, Vol.29, No.3, pp. 465-489 (1985)
2. R. Borum: "Psychology of terrorism", Tampa: University of South Florida (2004)
3. D. Taylor and W. Louis: "Terrorism and the quest for identity", in 'Understanding terrorism: Psychosocial roots, consequences, and interventions', Edited F.M. Moghaddam and Marsella, Washington DC: American Psychological Association, pp. 169-185 (2004)
4. Security Studies Program of National Security Critical Issue Task Force: "Report: lone wolf terrorism", Washington DC: Georgetown University (2015)
5. R. Borum: "Understanding the terrorist mindset", *FBI Law Enforcement Bulletin*, Vol.72, No.7, pp.7-10 (2003)
6. A. Silke: "Profiling terror", *Police Review*, Vol. 111, No.5737, pp.18-20 (2003)
7. G.H. McCormick: "Terrorist Decision Making", *Annual Review of Political Science*, Vol.6, No.1, pp.473-506 (2003)
8. F.M. Moghaddam: "The staircase to terrorism: A psychology exploration", *American Psychologist*, Vol.60, No.2, pp.161-169 (2005)
9. R.A. Bates: "Dancing with wolves: today's lone wolf terrorists," *The Journal of Public and Professional Sociology*, Vol.4, No.1, Online at <http://digitalcommons.kennesaw.edu/jpps/fo14/iss1/1> (2012)
10. P. Raffaello: "A typology of lone wolves: preliminary analysis of lone Islamist terrorists," *The International Centre for the Study of Radicalization and Political Violence*, King's College of London (2011)
11. R. L. Akers and C. S. Sellers: "Criminological theories: introduction, evaluation, and application", Oxford University Press (2013).
12. L. Dearden: "Isis documents leak reveals profile of average militant as young, well-educated but with only 'basic' knowledge of Islamic law", Online at <http://www.independent.co.uk/news/world/middle-east/Isisdocuments-leak-reveals-profile-of-average-militant-as-young-well-educated-but-with-only-basic-a6995111.html> (2016)



## МОНГОЛ УЛСЫН ДОТООД АЮУЛГҮЙ БАЙДАЛД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БУЙ ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛ, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

POSSIBLE APPROACHES TO OVERCOMING SOME OF THE NEGATIVE FACTORS AFFECTING MONGOLIA'S INTERNAL SECURITY

### С.СҮХЧУЛУУН

Хууль сахиулахын их сургуулийн докторант

### SUKHCHULUUN S.

PhD Student of Law enforcement university

✉ [sukhchuluun0503@gmail.com](mailto:sukhchuluun0503@gmail.com)

**Товч агуулга:** Эрдэм шинжилгээний өгүүлэлд Монгол Улсын дотоод аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг нийгэм, улс төрийн, соёл иргэншил, шинжлэх ухаан, боловсролын болон мэдээллийн зэрэг салбарт тодорхойлохыг зорьсон болно. Аюулын эх сурвалж болж буй төр, улс төрийн хүчин, хуулийн этгээд, иргэн, гадаадын тусгай албад зэргийг тус бүрээр авч үзэж, тулгамдаж буй асуудлыг илрүүлэн шийдвэрлэх арга замын талаар санал дэвшүүлэх болно.

**Abstract:** This research article is aimed at identifying some of the negative factors that are affecting Mongolia's internal security based upon the concepts of socio-economics, politics, culture, science, education and information technology. Sources of national security risks such as governance, politics, legal entities, citizens and foreign secret services were examined to determine the issues brought forward case by case and some suggestions to overcome these difficulties were presented.

**Түлхүүр үгс:** Аюулгүй байдал, дотоод аюулгүй байдал, аюул, аюулын эх сурвалж.

**Keywords:** Security, internal security, risks, sources of national security risks.

Монгол Улсын дотоод аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс нь улс төр, эдийн засаг, цэрэг, соёл, шинжлэх ухаан технологийн, мэдээлэл зэрэг нийгмийн төрөл бүрийн харилцаа, хүрээлэн байгаа орчин болон техно салбар (хиймэл буюу хүний хүчээр бүтээгдсэн орчин)-тай харилцах диалектик холбоонд оршдог. Сөрөг өөрчлөлтийн нөлөөнд орсноор үндэсний ашиг сонирхолд ноцтой нөлөөлж болох элементийг аюулгүй байдлын объект гэдэг. Аливаа аюулгүй байдлын объект бие хүн (иргэн), түүний эрх, эрх чөлөө, үүрэг, нийгэм, түүний материаллаг ба оюуны үнэт зүйлс, төр, түүний үндсэн хуульт төрийн байгуулалт, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлаар илэрнэ<sup>1</sup> гэж судлаачид үздэг байна.

Дэлхийн улс орнуудын гадаад харилцаа, хамтын ажиллагаа хурдацтай өргөжин тэлж, харилцан хамаарал нэмэгдсэн явдал нь нийгэм, улс төр, эдийн засгийн хөгжил дэвшлийг хурдасгагч хүчин зүйл болж буй боловч, нөгөө талаас үндэсний аюулгүй байдалтай холбоотой олон сөрөг асуудлыг үүсгэх болов.

Олон улсын харилцааны (XXI зууны)

өнөөгийн байдлыг авч үзвэл, дэлхийн хүчирхэг улс орнууд бусад улс орныг гадаад орчны нөлөө, дотоодын хүчнээс эрхшээлдээ оруулахын тулд үндсэн хуульт байгууллыг нь сулруулах, өөрийн нөлөө ашиг сонирхлоо тулгах, тусгай албадаараа дамжуулан нөлөөлөх оролдлогыг хэрэгжүүлсээр байна.

Энэ талаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганы индрээс ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин "... Ардчилсан хувьсгал гэгчийг экспортолсоор байна. Үүнийг ойрхи Дорнод, хойд Африкийн нөхцөл байдлаас харахад хангалттай. Гадны түрэмгийллийн улмаас төрийн бүтэц, ердийн амьдралын хэв маяг бусармаг байдлаар мөхөж байна. Ардчилал, хөгжил цэцэглэлтийн оронд хүчирхийлэл, ядуурал гуйланчлал, нийгмийн сүйрэлд хөтөлж байна. Хүний эрх, түүний дотор амьд явах эрхийг хүндэтгэхээ нэгэнт больжээ ...", "Ийм нөхцөл байдлыг бий болгосон хүмүүсээс "Та нар юу хийснээ ойлгож байна уу?" гэж асуумаар байна..." илэрхийлсэн юм.

Эдүгээ цэрэг зэвсэг ашиглахын өмнө, улс үндэстнийг дотоодын зөрчил тэмцлээр өдөөж удирдлага, залуургүй болгоход чиглэх, энэхүү шинэ түрэмгийллээс хамгаалах гол баталгаа болсон Үндсэн хуульт байгууллаа бэхжүүлэх, хамгаалах асуудлыг бага буурай улс орны хувьд эн тэргүүнд тавихад хүрч

<sup>1</sup> Н.И.Карпов., Д.Б.Павлов. "Основы теории обеспечения безопасности личности, общества и государства" учебное пособие. М., 2000. С.30.





байна. 2008 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хэрэг явдал буюу УИХ-ын сонгуулийг тойрсон будиалаан, эмх замбараагүй байдал бидэнд томоохон сургамж, дохио өгсөн юм. Үндэсний аюулгүй байдлыг хангахад аюул, эрсдэлийг бодитоор мэдрэх, түүнийг зөв үнэлэх асуудал нэн чухал. Улс орны дотоод аюулгүй байдалд заналхийлж буй аюул, эрсдэлийг тодорхойлсноор түүнийг зайлуулах, саармагжуулах хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой.

#### **Аюулын эх сурвалжийг тодорхойлох нь**

Монгол Улсын дотоод аюулгүй байдал, түүнд нөлөөлөх аюулын эх сурвалжуудыг дараах байдлаар авч үзэж болно. Үүнд:

**Нийгэм-улс төрийн салбарт:** Аюулын эх сурвалж төр өөрөө буюу төрийн дээд эрх барих байгууллага (хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх болон төрийн бүтцэд ордог бусад байгууллага: яам, тусгай газар (болон бусад институт) байх бөгөөд тэдний ашиг сонирхол нийгмийн ашиг сонирхолтой зөрчилдөх, засаглалын салаа мөчир хоорондын тэнцвэрт байдал алдагдсанаар аюул үүсэх магадлал бий.

Үүний зэрэгцээ аливаа улс төрийн хүчин, иргэний нийгмийн байгууллагууд, (төрийн бус байгууллага) үйлдвэрчний эвлэл болон хувь хүн аюулын эх сурвалж болно. Төр засгийн бодлого, шийдвэрт нөлөө үзүүлэх зорилго тавьсан гадаадын тусгай албад, алан хядагчид, хэт даврагчид, үндэсний үзэлтнүүд болон бусад байгууллагын үйл ажиллагаа ч мөн улс төрийн салбар дахь аюулын дотроос ноцтойд тооцогддог аж.

**Соёл иргэншлийн салбарт:** Үндэсний уламжлалаас хөндийрч, түүнийг устгах, иргэдийн оюун санаа, ёс зүйн орон зайд үндэсний уламжлалт үзэлд харш, ертөнцийг үзэх тэрс үзэл төлөвшүүлэхийг чармайж байгаа иргэний нийгмийн байгууллага, зарим иргэний үйл ажиллагаанаас аюул үүсэх боломжтой. Үндэстэн болон шашин хоорондын зөрчилдөөн хүчирхийлэл, үймээн самуун, тогтворгүй байдал, шашин болон үндэстэн хоорондын хямралд уриалан дуудаж буй элдэв сургаал, номлол нь нийгмийн материаллаг болон оюун санааны үнэт зүйлтэй харшилж, аюул учруулах боломжтой аж.

**Шинжлэх ухаан, боловсролын салбарт:** Шинжлэх ухаан, техникийн болон оюун ухааны хөгжлийн үндсэн тулгуур дэвсгэр болдог суурь шинжлэх ухааны хөгжил, боловсролын тогтолцооны боловсронгуй байдал нь улс орны хөгжлийг урагшлуулах ач холбогдолтой. Улс төрийн засаглалын зүгээс үүнийг үл тоомсорлон үзэх нь эх орны шинжлэх ухаан техникийн

дэвшил саатаж, хоцрогдох аюулд хүргэдэг. Боловсролын тогтолцооны хоцрогдол, бусад улсын боловсролын арга, механизмыг даган дуурайх нь хор аюултай байдаг. Дурдсан асуудлыг шийдвэрлэх үүрэг зорилт бүхий төрийн байгууллага, засаглал нь энэ тохиолдолд холбогдох аюулын эх сурвалж болж хувирдаг. Шинжлэх ухаан, боловсролыг хөгжүүлэх нь төр, нийгмийн үйл ажиллагаанд тэргүүлэх чиглэлийн нэг зайлшгүй байх ёстой зүйл мөн бөгөөд учир нь шинжлэх ухааны чадавх, боловсролын түвшнээс улс төр, эдийн засаг, төрийн бусад үйл хэргийн цаашдын хөгжил шууд шалтгаалж, бодит болон болзолт аюулыг сөрөн зогсох, түүнээс урьдчилан сэргийлэх чадвар боломж хангагдана.

**Мэдээллийн салбарт:** Өөрийн орны иргэд, худалдааны болон бусад байгууллагууд төрийн нууцыг задрүүлж, дамжуулснаар, гадаадын тагнуул, тусгай албад манай орны улс төр, эдийн засаг болон бусад хаалттай нууц мэдээллийг хулгайлах, цуглуулах зэрэг үйлдлээс үүсдэг. Түүнчлэн манай ард түмний ёс суртахууны эв нэгдлийг задлах, улс төр, эрх зүйн ухамсарт нь харш нөлөө үзүүлэхэд чиглэсэн суртал ухуулга бие хүний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх аюулын нэг эх сурвалж болдог.

Монгол Улсын хувьд дээр дурдсан аюул заналын эх сурвалжууд бүгд оршиж байна гэхэд хилсдэхгүй бөгөөд өнөөдөр ямар түвшинд аюул, заналын эх сурвалжууд байж болохыг тодорхойлж үзье.

#### **Төр аюулын эх сурвалж болох нь**

Төрийн засаглах чадавх суларснаас нийгэмд төрийн албаны нэр хүнд унаж, төрийн байгууллагуудын бүтэц үр өгөөж муутайгаар өргөжин, төсөв зардал нэмэгдэх, улс төрийн томилгоо хүрээгээ хальж, хүний нөөцийн бодлого үгүй болсноос төрийн мэргэшсэн, чадварлаг алба хаагчдын хүрээ хумигдаж, төрийн алба хаагчдын ёс зүй, ажил гүйцэтгэх чадамж доройтсон зэргээс иргэдийн төр, хууль ёсоо дээдлэх үзэл алдагдахад хүрч байна.

Төрийн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнууд хүнд суртал, хээл хахуульд автаж, төр, нийгмийн эрх ашгаас илүү хувийн болон цөөн хэсэг бүлэг хүмүүс, хүрээллийн ашиг, сонирхолд үйлчлэх болсон талаар олон нийтийн хэвлэл мэдээлэл, ард иргэдийн дунд байнга яригдаж байна.

Тухайлбал, "Сант марал" сангаас 2015 онд явуулсан "Монголын нийгэм, улс төр, эдийн засгийн байдлын талаарх олон нийтийн санал бодол" судалгаанд хамрагсдын дийлэнх нь "төр засаг иргэдийн төлөө зөв зүйтэй"



Хууль сахиулахуй

юм хийж байна гэдэгтэй санал нийлэхгүй байна”<sup>2</sup>. Үндэсний тагнуулын академийн Тагнуул судлалын төвөөс 2013 онд явуулсан “Монголын улс төр, нийгмийн өнөөгийн байдал” сэдэвт социологийн судалгаагаар “төрийн тогтолцоог шинэчилснээр нийгэмд шударга ёс бэхэжнэ” гэж судалгаанд оролцогсдын дийлэнх хувь нь үзжээ.<sup>3</sup>

Мөн авлигын төсөөллийн индекс Монгол Улс 2004 оноос хамрагдаж, 2004 онд 146 орноос 85-д орж байсан бол 2010 онд 178 орноос 116-д орж, жил бүр 2,7-3,0 гэсэн оноо авч “дампуурсан төр” гэсэн үнэлгээнд багтсан байна.<sup>4</sup> “Транспаренси Интернэшнл” байгууллагаас явуулсан олон улсын авлигын индексийн 2012, 2013 оны судалгаагаар Монгол улс 175 орноос 94-т, 2014 онд 39 оноотойгоор 80-д бичигдсэн бөгөөд авлигын улмаас Монгол Улсын нэгдсэн төсвийн жилийн зарлагын 2,7 хувьтай тэнцэх хэмжээний хохирол учирч байгаа талаар судалгаанд дурджээ.<sup>5</sup>

Иргэдийн ядуурал, ажилгүйдэл ихсэж, баян, хоосны ялгаа нэмэгдэж байна. Төр, засгаас эдийн засгийн салбарт дорвитой арга хэмжээ авахгүй, цөөн тооны олигархуудын ашиг сонирхолд үйлчлэх, төрийн албан тушаалтнууд нь ашиг сонирхлын бүлэглэлүүдэд хуваагдсанаар эдийн засгийн цогц бодлого үгүй болж хямралд өртөж байна. Ядуурлын шалтгааныг ажилгүйдэл ихэссэн, цалин бага, үнийн хөөргөдөл, эдийн засгийн хөгжил сул, нийгмийн халамж хавтгайрсан<sup>6</sup> зэрэгтэй холбоотой болохыг зарим судалгаа харуулдаг.

Төрийн байгууллага, тэр дундаа үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа, болзошгүй аюул, хямралт байдлын үед үүрэг гүйцэтгэх чадавх сул байгаа зэрэг нөхцөл байдлууд нь эмзэг, хямралтай аюул бүхий цаг дор байгааг харуулж байна. Тухайлбал, Улс орны өнөөгийн нөхцөл байдлын талаарх зарим судалгааны дүнгээс харахад, 2001 онд “тааламжтай, хэвийн” гэж үзэгсэд 3 хүн тутмын нэг нь байсан бол 2014 онд

бараг 2 дахин буурч, 5 хүн тутмын нэг нь “тааламжтай, хэвийн” буюу “хямралтай, аюултай” гэж үзэгсэд огцом өсөж, 3 хүн тутмын нэг нь “хямралтай байна”<sup>7</sup> гэж үзэх болжээ.

### Улс төрийн хүчнүүд аюулын эх сурвалж болох нь

Иргэдийг нам, хөдөлгөөнөөр ангилж, талцуулан тэмцэлдүүлж буй улс төрчдийн үйлдлийг үндэсний эв нэгдэл, нийгмийн тогтвортой байдалд аюул, занал үүсгэж байгааг ялгаж салгаж ойлгох нь зөв байна. Олон түмний эвдрэлцээн дундаас цөөн хэдэн хүн ашиг хүртэж, монголчууд тусгаар тогтнол, газар нутаг, үндэс угсаагаараа хохирч үлддэг түүхэн сургамж холгүй байна.

Улс төрийн нам, хүчнүүд олон түмний санал бодлыг илэрхийлэхээсээ илүүтэйгээр зөвхөн өөрсдийн эрх ашгийг хамгаалах, ямар ч замаар хамаагүй засгийн эрхийг авахын төлөө тэмцэлдэж байгаа<sup>8</sup> нь улс орны тогтвортой байдалд хор учруулж болзошгүй юм. Нийгэм, улс төр, эдийн засгийн бэрхшээл, улс төрийн сонгуулийг ашиглан улс төрийн нам, хүчин, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн зүгээс Үндсэн хууль, хууль ёсыг зөрчсөн хэлбэрээр үйл ажиллагаа явуулах нь даамжирч байна.

Улс төрийн зарим хүчин, иргэний хөдөлгөөнийхөн төр, засгаас явуулж буй зарим алдаатай бодлого, иргэдийн бүхимдлыг ашиглан ард түмнийг бослого, үймээн самуун, хувьсгалд уриалан дуудах болсон нь ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй байна. Улс төрийн нам, засаглалын төлөөх тэмцэл, өрсөлдөөн, эдийн засгийн ашиг сонирхлоос цаашхыг олж харахгүй болтлоо явцуурчээ гэх болгоомжлол төрийн алба хаагчдын дунд түгээмэл ажиглагдах болсон нь анхаарах ёстой асуудал юм. Өөрөөр хэлбэл үндэсний ашиг сонирхлоос илүү хувийн ашиг сонирхолтой улс төрч, бүлэглэл олширч байгаад онцгой анхаарах цаг болжээ.

### Бусад хуулийн этгээдүүд аюулын эх сурвалж болох нь

Хүн төрөлхтөн өнөөг хүртэл, нийгмийн амьдралаа удирдах олон арга, ухаан сэдсэнээс одоогоор хамгийн оновчтой нь Үндсэн хуультай байгуулал болно. Монгол Улсын Үндсэн хуулиар ард түмэн чөлөөт сонгуулиар сонгосон төлөөлөгчөөрөө

<sup>7</sup> Прогноз хүрээлэн, Социум агентлаг, Танадалт судалгааны төвөөс хийсэн “Нийгэм, улс орны нөхцөл байдал, олон түмний санаа бодол” сэдэвт судалгаа. УБ., 2014.

<sup>8</sup> “Сант марал” сангаас хийсэн “Монголын нийгэм, улс төр, эдийн засгийн байдлын талаар олон нийтийн санал бодол”-ын судалгаа. УБ., 2015.

<sup>2</sup> “Сант марал” сангаас хийсэн “Монголын нийгэм, улс төр, эдийн засгийн байдлын талаар олон нийтийн санал бодол”-ын судалгаа. УБ., 2015.

<sup>3</sup> УТА-ийн Тагнуул судлалын төвөөс хийсэн “Монголын улс төр, нийгмийн өнөөгийн байдал” сэдэвт социологийн судалгаа. УБ., 2013.

<sup>4</sup> “Тусгаар тогтнол” сэтгүүл. С.Гомбо., Монгол улсын дотоод ба хүний аюулгүй байдлыг хангахад сөрөх тагнуулын шугамаар анхаарах асуудал өгүүлэл. УБ., 2010. 3/13/ т б.

<sup>5</sup> “Тусгаар тогтнол” сэтгүүл. Г.Гэрэлчулуун. “Авлига зэрэг тулгамдсан асуудал” өгүүлэл. УБ., 2013. т 43

<sup>6</sup> УТА-ийн Тагнуул судлалын төвөөс хийсэн “Монголын улс төр, нийгмийн өнөөгийн байдал” сэдэвт социологийн судалгаа. УБ., 2013.

дамжуулан улс орныг удирдах эрх, арга замыг тодорхойлсон.

Үндэсний аюулгүй байдал тэр дундаа нийгэм төрийн байгууллын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох эрсдэлийг тодорхойлох шаардлага урган гарч байна. Тухайлбал:

#### **Иргэний нийгмийн байгууллага:**

Нийгэм, улс төр, эдийн засагт үүсээд буй бэрхшээлтэй холбоотойгоор ард иргэдийн бухимдал гүнзгийрч, төрд итгэх олон нийтийн итгэл суларч, нийгмийн салбар бүрд эрх ашгаа хамгаалуулсан хөдөлгөөн, төрийн бус байгууллага үүсэж төрийн бодлого шийдвэрийг эсэргүүцэх, шүүмжлэх, газар нутгаа болон тодорхой бүлэг хүмүүсийн эрх ашгийг хамгаалах зэргээр улс төрийн зорилготой үйл ажиллагаа явуулж байна.

Мөн албан тушаалтан, улс төрчидтэй холбоотой олон гэмт хэрэг шийдвэрлэгдэхгүй замхрах, төрийн албан тушаалтнууд өөрсдөө хууль зөрчин, улс үндэсний эрх ашигт хор хохиролтой шийдвэр гаргах, нийгэм, эдийн засагт тулгамдаад буй олон асуудлууд шийдвэрлэгдэхгүй цаг алдах зэрэгт иргэний нийгэм туйлын бухимдах болж, эсэргүүцлээ хурцаар илэрхийлэх болжээ.

Тухайлбал, “Онги гол хөдөлгөөн”, “Монголын гол нууруудын нэгдсэн холбоо”, “Даяар Монгол”, “Хөх Монгол”, “Босоо хөх Монгол”, “Гал үндэстэн”, “Хөх бүлгэм” зэргээс өнөөгийн нийгэм, улс төр, эдийн засагт тулгамдсан асуудал болон уул уурхайн зүй бус, хууль бус ашиглалтын эсрэг, байгаль орчноо хамгаалах зорилгоор хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь нийгмийн сэтгэл зүйд хүчтэй нөлөөлж, түүнд тулгуурлан хүч түрэмгийлсэн, зарим талаар хэт даварсан үйлдэл хийх үндэс тавигдсан гэж үзэж болно.

Нийгэмд асуудлыг хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэхээс илүүтэйгээр авлига, дарамт шахалт, хүчирхийллээр зохицуулах нь үр дүнтэй хандлага хүрээгээ тэлж байна. Энэ байдлыг даруй шийдвэртэй өөрчлөхгүй бол, нөхцөл байдал даамжирч нийгэмд хүчирхийлэл дэлгэрч, дарамт шахалт, захиалгат аллага, хэрэг зөрчлийг хувиараа шийтгэж “өшөө, хариу авах” мэтээр асуудлыг шийдэх, “үнэнийг тогтоох” давалгаа үүсч үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхөд ойрхон болжээ.

Бослого тэмцэлд илтээр уриалах, төрийн төлөөлөгчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, төрийн албан хаагчийн амь биед халдах, төрийн өндөр албан тушаалтнуудыг гутаан доромжлох, заналхийлэх, өлсгөлөн, суулт, жагсаал хийх зэрэг үйлдэл нь иргэдийн бухимдал дээд цэгтээ хүрч байгааг харуулж, улмаар нийтийг хамарсан эмх замбараагүй

байдал, дотоодын үймээн самуунд хүргэж болзошгүй<sup>9</sup> нөхцөл байдлыг бий болгож байна.

2008 оны долдугаар сарын 1-ний хэрэг явдалд “Улс төрийн сонгуулийн үр дүнд сэтгэл дундуур үлдэгсдийн хууль бусаар зохион байгуулсан жагсаал цуглаан нь ажилгүйдэл, ядуурал зэрэг нийгмийн бухимдалд үндэслэсэн иргэдийн сэтгэл зүйд нөлөөлж, нийтийг хамарсан эмх замбараагүй байдалд хүргэхэд нөлөөлсөн” гэдэг урьдчилсан дүгнэлтийг мэргэжлийн байгууллагууд хийсэн байдаг.

Монгол Улсын хэмжээнд Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газраас АНУ-30, БНСУ-16, ХБНГУ-8, БНФУ-6, Итали-4, ИБУИНВУ-4, БНХАУ-3, Япон-3, Швейцар-3, Канад-3, БНЧУ-2, Тайван-2, Норвеги-1, Финлянд-1, Шинэ Зеланд-1, Голланд-1, Австрали-2, Ватикан-1, Испани-1, ОХУ-1, ОУ-ын-7 нийт 102 төрийн бус байгууллага, салбар төлөөлөгчийн газар байгаль орчин, хүмүүнлэг, засаглалын ил тод байдлыг бэхжүүлэх, хөдөө аж ахуй, иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулах зэрэг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр албан ёсны зөвшөөрөл авч, үйл ажиллагаа явуулж байна.

Эдгээр ТББ-ын дунд гадаад улс оронд “Өнгөт хувьсгал”-ыг зохион байгуулахад гол үүрэгтэй оролцож байсан “Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн”, “Мерси Кор Интернэшнл”, “Fact” зэрэг байгууллага манай улсад иргэний нийгмийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээлэл, улс төрийн нам, УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгчийн тамгын газар зэрэг байгууллагуудтай өргөн хүрээнд идэвхтэй хамтран ажиллаж байгаа нь анхаарал татаж байна.

#### **Зохион байгуулалттай гэмт бүтэц:**

Хууль зөрчих ердийн үзэгдэл болох, гэмт хэргийн гаралт өсөж, нэг санаа зорилготой хүмүүс нэгдэн зохион байгуулалтад орж, төр засгийн эрх мэдэл, хяналтыг бүрэн эсэргүүцэх хэмжээнд идэвхжиж, өөрсдийн зөв гэж үзсэн үйлдлийг хүч түрэмгийлэн хэрэгжүүлэх, нийгмийн дэг журмыг зохион байгуулалттайгаар зөрчих хандлагатай боллоо.

Авлигатай хийх тэмцлийг эрчимжүүлэхэд засгийн эрх баригчдаас улс төрийн идэвх гаргахгүй, улс төрийн нам, хүчний бодлого тодорхойлох болон идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг нэгжид олигархууд хүчтэй болсон, хууль сахиулах, шүүхийн байгууллагын шинэчлэл зогсонги байдалд

<sup>9</sup> УТА-ийн ГА-ын тэнхимээс хийсэн “Нийгэм төрийн аюулгүй байдлыг хангах чиглэлийн өнөөгийн байдал” сэдэвт санал асуулга. УБ., 2015.



Хууль сахиулахуй

орж, “цус ойртсон”, төрийн хариуцлагатай албан тушаалтнаас санаатай, санамсаргүй байдлаар улс, үндэсний эрх ашигт харшилсан шийдвэр гаргах, төсвийн хөрөнгийг хуваарилах, зарцуулах, томоохон тендер шалгаруулах нэрээр хуйвалдан завших, тэдэнтэй холбоотой “дуулиантай хэрэг”-үүд шийдвэрлэгдэлгүй яльгүй үндэслэлээр түдгэлзэх, хэрэгсэхгүй болох зэрэг шинж тэмдэг Монгол Улсад эдийн засгийн ашиг сонирхлоор нэгдэж, улс төрөөр хамгаалагдсан зохион байгуулалттай гэмт бүтцүүд нэгэнт бий болсныг харуулж байна.

**Хэвлэл мэдээллийн хэрэгсэл:** Олон нийтийн зарим хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь улс төрийн нам, улс төрчид, бизнес бүлэглэлийнхний харьяалалд орж, тэдний талд захиалгаар үйлчлэх, энэ хэрээр нийгэмд үнэнийг өгүүлэх, бодит мэдээлэл түгээхэд өөрсдөө саад учруулан, нийгэм, олон нийтийг хэт улс төржүүлэхэд нөлөөлж байна. Энэ байдал улс төрийн сонгуулийн үеэр хурцаар илэрч, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөхөд чиглэсэн зохиомол үйл ажиллагааг явуулж хэвших хандлагатай болжээ. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр цацаж буй цаг үеийн мэдээллийн дийлэнх нийгэмд бухимдал, гутрал төрүүлэх эх сурвалж болсоор байна. Тухайлбал, “Нийгэм төрийн аюулгүй байдлыг хангах чиглэлийн өнөөгийн байдал” сэдвээр ТЕГ-ын СТГ-ын ажилтнуудын дунд санал асуулга явуулахад: “Нийгмийн бухимдлыг дэвэргэж буй хүчин, хүчин зүйлийг Та юу гэж бодож байна вэ?” гэсэн асуултад нийт санал асуулгад оролцогчдын 25,0 хувь, “Нийгмийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж болох зам сувгуудыг та хэрхэн тодорхойлох вэ?” гэсэн асуултад 87,5 хувь нь “хэвлэл мэдээллийн хэрэгслүүд” гэсэн хариулыг өгчээ<sup>10</sup>.

Ардчилсан нийгэмд сэтгүүлчид эрх баригчдад бус харин олон нийтэд үйлчилж, үнэн бодит, шуурхай мэдээллээр хангах ёстой. Үндсэн хуулиас харахад манай улс дэлхийн жишигт нийцсэн хэвлэлийн эрх чөлөөгөөр хангагдсан. Гэтэл манай сэтгүүлзүйн салбар үнэнийг тэр бүр илэрхийлдэггүй, шударга бус, мөнгөний төлөө ашиг харж, олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангахаас илүүтэйгээр ямар нэг шуугиан тарьж ашиг олохыг эрмэлздэг байдал давамгайлж байна. Үүнийг мэдэрсэн өрнөдийн зарим тусгай албад (Чехийн тусгай алба) ил эх сурвалжийн мэдээ боловсруулахдаа арилжааны сонин, сэтгүүл, телевизийн мэдээллүүдийг “найдвартай” гэж үнэлдэг болжээ.

**Уламжлал болон уламжлалт**

**бус шашны урсгал:** Монгол Улсад зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй гадны янз бүрийн шашны байгууллага, сүм хийд, тэднээс нийгмийн сэтгэл зүйд үзүүлэх сөрөг нөлөөлөл хяналтгүй шахам байна. Монголд Буддын шашны 4 урсгалын 2 /Улааны, Шарын/ түгэн дэлгэрсэн байдаг. Өмнөд хөрш Хятадын хувьд Бурхны шашнаар дамжуулан Төвдийн үймээн болоод Далай ламыг буулган авах гэсэн бодлого нь амжилттай хэрэгжиж, тэрхүү явуулга нь Монголын уламжлалт бурхны шашинд нөлөөлөх хандлагатай байна.

Мөн уламжлалт бус шашны урсгалууд Монгол Улсад ихээр нэвтэрч байгаа явдал үндэсний эв нэгдлийг сулруулах хүчин зүйл болж болзошгүй юм. Ард иргэдийн өлөн зэлмэн, ядуу байдлыг ашиглан эд зүйл, хоол хүнс, сайхан амьдруулах амлалтаар ард иргэд, түүн дотор залуус идэвхтэйгээр татах болсон нь үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй юм. Монгол Улсад зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй гадаадын янз бүрийн шашны байгууллага, сүм хийд, тэднээс үндэсний аюулгүй байдалд үзүүлэх сөрөг нөлөөлөл хяналтгүй шахуу байна. Үндэсний тагнуулын академиас хийсэн социологийн судалгаанд оролцогчдын 80 гаруй хувь нь гаднын шашин хүчтэй болж буй нь ард түмний эв нэгдэлд нөлөөлөх хандлагатай болсон гэж хариулсан байна. □

Шашин шүтэх эсэх эрх нь хувь хүний асуудал боловч шашин хоорондын зөрчил, шашны харгис урсгалыг дэлгэрүүлэхгүй байх, шашны итгэл үнэмшлээр далимдуулж нийгмийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж, нийгмийн тогтворгүй байдал бий болох зэргээс урьдчилан сэргийлэх нь төрийн үүрэг юм. Шашин сүмийн асуудал нь тухайн улсын үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулаад байгаа бусад улс орнуудын нөхцөл байдлаас үзэхэд шашны асуудлыг урсгалд нь орхих нь хэтдээ залруулж болшгүй аюул, заналын эх үндэс болдог гашуун сургамжийг судалж, цаг алдалгүй шийдвэртэй алхам, зохицуулалт хийх шаардлагатай болохыг харуулж байна.

**Үндэсний эв нэгдэл:** Үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулдаг хамгийн бодитой, хамгийн том аюул бол үндэсний эв нэгдэл алдрах явдал гэдгийг түүх гэрчилдэг. Дотоод дахь улс төр, эдийн засаг, шашны хуваагдал, бүлэглэлүүдийн өрсөлдөөн, баян ядуугийн ялгаа газар авч, үндэсний нийтлэг эрх ашгийг хөсөрдүүлэх, эв нэгдлийг сарниулах улмаар нийгмийн тогтвортой байдалд заналхийлэх түвшинд хүрч байна. Энэ нь үндэсний аюулгүй байдал, түүний

<sup>10</sup> “Тусгаар тогтнол”. УБ., 2010. 3/13/ х-96.





дотор Монгол Улсын нэгдмэл байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд ч заналхийлэл учруулж болзошгүй. Дотооддоо өөр зуураа эв нэгдэлгүй байх нь улс үндэстэн сүйрлийн ирмэгт ирж, үндэс угсаагаараа аюулд учирч байгаагийн ойрын жишээ бол Ирак, Афганистанд болсон хэрэг явдал болно.

### Иргэн аюулын эх сурвалж болох нь

Иргэн /бие хүн/-ий үйл ажиллагаатай холбоотой, үндэсний эрх ашигт харшилж буй бүхий л үзэгдэл, үйл явцыг энэ хэсэгт хамааруулж болох юм. Үүнд:

- ❖ Экологийн тэнцвэр алдагдаж, цөлжих явц хурдсаж, гол мөрөн, усны нөөц багасаж, цаг агаарт өөрчлөлт гарч байна. Энэ чиглэлд ажиллаж буй иргэний хөдөлгөөн, төрийн бус байгууллагууд олноор байгуулагдаж, мөхөл рүүгээ явж буй дохиог байнга өгөх боллоо.

- ❖ Удмын сан бохирдож, монгол хүний хүний намба, төрх алдагдаж байна.

- ❖ Монгол ёс заншил, уламжлал аажмаар алга болж байна.

- ❖ Хүнсний бүтээгдэхүүн импортлолж буй аж ахуйн нэгж, хувь хүмүүс монгол иргэдийн амьжиргааны түвшин муу байгаагаас шалтгаалж, хувийн ашиг орлогоо бодон хамгийн хямд, баталгаагүй, шинжилгээгүй, хортой хүнсийг оруулж ирж байгаа нь хүн амын эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж байна. Архи, тамхи, улмаар мансууруулах бодисын хэрэглээ хяналтаас гарч байгаа нь үндэсний нэг эмгэнэл болж байгаа бөгөөд хор хохирлын талаар тайлбарлалтгүй бүхэнд тодорхой болоод удлаа.

### Гадаадын тусгай албад аюулын эх сурвалж болох нь

Нийгэм төрийн байгууллын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох хүчин зүйлд Гадаадын тусгай албадын тагнан турших, хорлон бусниулах үйл ажиллагаа ордог бөгөөд аюулгүй байдлын аюул заналын эх сурвалж яах аргагүй мөн.

Гадаад улс орнуудын тусгай албад өөрийн орны төр засгийн удирдлагыг гадаад орнуудтай харилцах асуудлаар оновчтой шийдвэр гаргахад нь шаардлагатай мэдээ мэдээллээр хангах зорилгоор сонирхож буй улс орныхоо төр засгийн удирдлага, төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтэрч нөлөөлөх, бодлогод саад болох, эсэргүүцсэн, тааламжгүй гэж үзсэн улс орны удирдлага, төрийн байгууллагын талаар материал цуглуулж, нэр хүндийг нь унагах, онцгой тохиолдолд амь насанд нь халдах, сөрөг хүчнийг нь дэмжиж санхүүгийн дэмжлэг үзүүлэх сонирхол, эрмэлзэл

санаархлаа тусгай технологиор гүйцэлдүүлж байсан арга ажиллагаа “Хүйтэн дайны үед” байсан одоо ч оршоор байна.

Тухайлбал, гадаадын зарим тусгай албад гоц мэдрэхүйтэй онцгой чадвартай хүмүүсийг судлан, хүний бие организм, ухамсар, сэтгэцэд нөлөөлж чадах тусгай техник, арга ажиллагааны чиглэлээр ажилладаг хүрээлэн, байгууллагуудыг онцгойлон анхаарч санхүүжүүлдэг, тэр ч байтугай тодорхой зорилгод чиглэсэн сэтгэцэд нөлөөлөх /психотроникийн, психофизикийн, психотропын бэлдмэл гэх мэт/ төхөөрөмж, эм бэлдмэл бүтээсэн, түүнийг ашигладаг талаар баримт материал ил болсоор байна.

АНУ, ОХУ, БНХАУ зэрэг дэлхийн хүчирхэг улс өөрийн нөлөө ашиг сонирхлоо шаардлагатай гэж үзсэн улс орон, бүс нутагт бий болгох, тусгай албадаараа дамжуулан нөлөөлөх оролдлогоо хэрэгжүүлсээр байна. Нэгэн цагт асар их хүч нөлөөтэй байсан Зөвлөлт холбоот улс болон Югослав улс гаднын болон дотоодын нөлөөтэй задарч бутарсныг бүгд мэднэ.

Гүрж, Украин, Тунис, Ливи, Египет, Сири, Ирак, Афганистанд болсон олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, иргэний дайн, “Өнгөт” хувьсгал зэрэг гаднын улс орон тэдний тусгай албадын оролцоо дэмжлэгтэйгээр хийгдсэн талаарх баримт мэдээллүүд ил тод болсоор байна.

Манай орны хувьд ч гэсэн дэлхийн хоёр том гүрний дунд оршдог. Нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдлын хувьд шууд болон шууд бусаар тэдний нөлөөлөлд автах бүрэн боломжтой.

Иймээс Тусгаар тогтнол, Үндэсний аюулгүй байдал болон дотоод аюулгүй байдлыг гадна дотнын аюул занал, нөлөөллөөс хамгаалах асуудал Монгол Улс шиг геополитикийн өвөрмөц байрлалтай оронд нэн чухал болно.

### Дүгнэлт

Ардчиллын замыг буцалтгүй сонгосон Монгол Улсын хувьд, Үндсэн хуульт байгууллаа эн тэргүүнд бататган бэхжүүлэх нь ард түмний дийлэнхийн хүсэл эрмэлзлэлээс урган гарсан асуудал мөн. Үндсэн хуульт байгуулал нь сул, үйл ажиллагаа нь тодорхойгүй, төлөвшин тогтоогүй байх зэрэг нь улс орны дотоодод хямралт байдал, зөрчил тэмцлийг бий болгодог аж.

Улс үндэстнийг хэрхэн зөв, аюул эрсдэлгүй хөгжүүлэн авч явах арга ухааны тогтолцоог Үндсэн хуульт байгуулал илэрхийлдэг. Олон улсын амьдралд, аливаа улс орныг гадаад, дотоодын хүчнээс эрхшээлдээ оруулахын тулд үндсэн хуульт байгууллыг нь сулруулах,





Хууль сахиулахуй

сонгуулийн бус аргаар төрийн эрхийг олж авах арга замыг сүүлийн үед сонгох болжээ. Өөрөөр хэлбэл, цэрэг зэвсгийн хүчээр дайн тулаанаар эзлэн түрэмгийлдэг жишиг хуучирсан байна. Улс үндэстнийг дотоодын зөрчил тэмцлээр өдөөж удирдлага, залуургүй болгох шинэ түрэмгийллээс хамгаалах гол баталгаа болсон Үндсэн хуульт байгууллаа бэхжүүлэх, хамгаалах асуудал тэргүүн зэргийн ач холбогдолтой болоод байна.

2008 оны УИХ-ын сонгууль тойрсон будилаан, эмх замбараагүй байдал монголчууд бидэнд томоохон сургамж, дохио өгсөн. Үндэсний аюулгүй байдлыг хангахад аюул, эрсдэлийн мэдрэх, түүнийг зөв үнэлэх асуудал хамгийн чухал. Улс орны аюулгүй байдалд заналхийлж буй аюул, эрсдэлийг тодорхойлсноор түүнийг зайлуулах, саармагжуулах сөрөг хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой. Нийгэм, улс төр, эдийн засгийн бэрхшээлүүд, улс төрийн сонгуулийг ашиглан улс төрийн нам, хүчин, иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн зүгээс Үндсэн хууль, хууль ёсыг зөрчсөн хэлбэрээр үйл ажиллагаа явуулах нь идэвхжих хандлагатай байна. Иргэдийн бухимдал гүнзгийрч, төрд итгэх олон нийтийн итгэл ихээхэн алдарч, нийгмийн салбар бүрд шахуу эрх ашгаа хамгаалуулсан хөдөлгөөн, төрийн бус байгууллагууд үүсэн бий болж, төрийн бодлого шийдвэрийг эсэргүүцэх, шүүмжлэх, газар нутгаа болон тодорхой бүлэг хүмүүсийн эрх ашгийг хамгаалах зэргээр улс төрийн зорилготой үйл ажиллагаа идэвхжих болов. Улс-үндэсний хөгжлийн явцад, хүний нийгмийн хөгжлийн хуулиар зайлшгүй тохиолдох бэрхшээлтэй асуудлыг хэт дөвийлгөж, нийгмийн сэтгэл зүйг тогтворгүй болгох, улмаар улс төрийн тэмцлийн арга хэрэгсэл болгох бохир технологи буй болсон нь улс орны аюулгүй байдалд ноцтой, залруулж болшгүй хор уршиг тарих нөхцөл буй болгоод байна.

### Санал

1. Бослого тэмцэлд илтээр уриалах, төрийн төлөөлөгчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, төрийн албан хаагчийн амь биед халдах, төрийн өндөр албан тушаалтнуудыг гутаан доромжлох, заналхийлэх, өлсгөлөн, суулт, жагсаал хийх зэрэг үйлдэл нь иргэдийн бухимдал дээд цэгтээ хүрч байгааг харуулж, улмаар нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, дотоодын үймээн самуунд хүргэж болзошгүй нөхцөл байдлыг бий болгож байна. Иймд Үндсэн хуульт байгууллын аюулгүй байдлыг сөрөх тагнуулын аргаар хангах ажилд тулгамдаж буй асуудлыг зөв тодорхойлох, түүнийг боловсронгуй болгох шаардлага зүй

ёсоор тавигдаж байна. Тухайлбал, Монгол Улсын өнөөгийн нийгэм, улс төр, эдийн засагт үүсээд буй хүндрэл бэрхшээл, гадаад орнуудын тусгай албадын шинэчлэлт, өөрчлөлтийн чиг хандлага, цаг үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн холбогдох хууль тогтоомжуудад үзэл баримтлалын шинжтэй өөрчлөлтийг хийх нь зөв.

2. Тусгай алба болон хууль сахиулах байгууллагуудын зүгээс хэрэгжүүлж буй дотоод аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт тал дээр бодлогын чанартай зохицуулалт хийх.

3. Дотоод аюулгүй байдал, нийгмийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж болох зам сувгуудыг шинээр тодорхойлж, чиглэлүүдийн давхцалыг арилгах, үйл ажиллагааг боловсронгуй болгон, идэвхжүүлэх.

Үндэсний аюулгүй байдал тэр дундаа дотоод аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс бодитоор оршин тогтнож, түүнийг гүйцэтгэх ажлын аргаар хангах ажил боловсронгуй бус байгаа зэрэг нь өнөөгийн Үндсэн хуульт байгууллын аюулгүй байдалд аюул, занал учирч болзошгүй нөхцөл үүсжээ гэж нэгтгэн дүгнэж болохоор байна.

### Эх сурвалжийн жагсаалт

1. Н.И.Карпов, Д.Б.Павлов. "Основы теории обеспечения безопасности личности, общества и государства" учебное пособие. М., 2000.
2. "Сант марал" сан. "Монголын нийгэм, улс төр, эдийн засгийн байдлын талаар олон нийтийн санал бодол" судалгаа. УБ., 2015.
3. Үндэсний тагнуулын академийн Тагнуул судлалын төв. "Монголын улс төр, нийгмийн өнөөгийн байдал" социологийн судалгаа. УБ., 2013.
4. С.Гомбо. "Монгол Улсын дотоод ба хүний аюулгүй байдлыг хангахад сөрөх тагнуулын шугамаар анхаарах асуудал" өгүүлэл. "Тусгаар тогтнол" сэтгүүл. УБ, 2010.
5. Г.Гэрэлчулуун. "Авлига зэрэг тулгамдсан асуудал" өгүүлэл. "Тусгаар тогтнол" сэтгүүл. УБ., 2013.
6. Прогноз хүрээлэн, Социум агентлаг, Тандалт судалгааны төв. "Нийгэм, улс орны нөхцөл байдал, олон түмний санаа бодол" судалгаа. УБ., 2014.
7. Үндэсний тагнуулын академийн Гүйцэтгэх ажлын тэнхим. "Нийгэм төрийн аюулгүй байдлыг хангах чиглэлийн өнөөгийн байдал" санал асуулга. УБ., 2015.

## РЕАБИЛИТИРУЮЩИЕ ОСНОВАНИЯ ПРЕКРАЩЕНИЯ УГОЛОВНОГО ДЕЛА ПО УГОЛОВНО- ПРОЦЕССУАЛЬНОМУ КОДЕКСУ РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ

REHABILITATIVE BASES OF TERMINATION OF THE CRIMINAL CASE ON THE CRIMINAL PROCEDURAL CODE OF THE RUSSIAN FEDERATION

ОХУ-ЫН ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД ТУСГАГДСАН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОХ ЦАГААТГАХ ҮНДЭСЛЭЛҮҮД

### Научный руководитель: АРТАМОНОВ А.Н.

Начальник кафедры уголовного процесса Омской академии МВД России

Кандидат юридических наук, доцент, полковник полиции

### Scientific adviser: ARTAMONOV A.N. (Ph.D in Law, Assoc.Prof.)

Police Colonel, Head of the Criminal Procedure Department, Omsk Academy of the Ministry of Internal Affairs of Russia

### Эрдэм шинжилгээний удирдагч: АРТАМОНОВ А.Н.

ОХУ-ын ДХЯ-ны Омский академийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

### ГАНБОЛД Р.

Адъюнкт Омской академии МВД России, подполковник полиции

### GANBOLD R.

Police Lieutenant Colonel, Postgraduate student of the Omsk Academy, Ministry of Internal Affairs of Russia

### Р.ГАНБОЛД

ОХУ-ын ДХЯ-ны Омский академийн адъюнкт, цагдаагийн дэд хурандаа

✉ [rganbold2010@yahoo.com](mailto:rganbold2010@yahoo.com)

**Аннотация:** В статье дана характеристика сущности реабилитирующих оснований прекращения уголовного дела и их правовых последствий. Рассмотрено содержание таких оснований прекращения уголовного дела (уголовного преследования) как: отсутствие события преступления, отсутствие в деянии состава преступления, непричастность подозреваемого или обвиняемого к совершению преступления. Рассмотрены вопросы соотношения данных оснований, их разграничение в применении к конкретным ситуациям.

**Abstract:** The termination of the criminal case (prosecution) in the absence of evidence of a crime, the absence in act of structure of a crime, the innocence of the suspect or the accused to commit the crime

In the article the characteristics of such grounds for termination of criminal proceedings (criminal prosecution) as the absence of evidence of a crime, the absence in the act of a crime, the innocence of the suspect or the accused to commit the crime. Examines the correlation between data bases, their distinction as applied to specific situations.

**Товч агуулга:** ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн онолд эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэлүүдийг: нэгд, эрүүгийн хэргийг цагаатгах үндэслэл, хоёрт, эрүүгийн хэргийг цагаатгахгүй үндэслэлүүд гэж ангилсан байдаг.

Энэхүү өгүүлэлд эрүүгийн хэргийг цагаатгах үндэслэлүүд болох гэмт хэрэг үйлдэгдээгүй байх, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байх, сэжигтэн яллагдагч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдохгүй байх гэсэн үндэслэлүүд, тэдгээрийн харилцан хамаарал ялгагдах нөхцөлүүдийн талаар дурдсан болно.

Мөн цагаатгах үндэслэлийн эрх зүйн үр дагавар болон ач холбогдлын талаар дурдсан болно.

**Ключевые слова:** реабилитация, прекращение уголовного дела, прекращение уголовного преследования, отсутствие события преступления, отсутствие состава преступления, непричастность, недоказанность.

**Keywords:** rehabilitation, termination of criminal proceedings, termination of criminal prosecution, absence of crime, the lack of evidence, the innocence, the lack of evidence.

**Түлхүүр үгс:** цагаатгах, эрх нөхөн сэргээх, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, эрүүгийн мөрдөн байцаалтыг хэрэгсэхгүй болгох, гэмт хэрэг гараагүй байх, гэмт хэргийг бүрэлдэхүүнгүй байх, гэмт хэрэгт хамааралгүй, нотлогдохгүй байх.

Система правовых норм должна обеспечивать восстановление нарушенных прав. Поэтому одной из важнейших проблем современной юридической науки и право применения является задача построения и функционирования правового государства. В связи с этим необходимо закрепление в действующем законодательстве разных институтов, гарантирующих соблюдение прав человека. Одним из важнейших такого рода институтов является институт реабилитации.

Реабилитация (лат. Rehabilitation, от re - опять, вновь, снова + habilitas/habilitatis/ - пригодность, способность, англ. rehabilitation) - 1) восстановление гражданина (в судебном или административном порядке) в правах; 2) в широком смысле восстановления доброго имени, прежней репутации<sup>1</sup>. Большая советская энциклопедия содержит понятие «реабилитация», происходящее от латинского «rehabilitation», как восстановление способности.

В действующем Уголовно-процессуальный кодекс Российской Федерации (далее - УПК РФ) *реабилитация* определяется как «порядок восстановления прав и свобод лица, незаконно или необоснованно подвергнутого уголовному преследованию, и возмещения причиненного ему вреда» (п. 34 ст. 5).

В науке уголовного процесса существует множество классификаций оснований прекращения уголовного дела. Наибольший интерес в свете рассмотрения вопроса о прекращении уголовного дела представляет разделение на реабилитирующие и нереабилитирующие основания. Прекращение уголовного преследования по реабилитирующим основаниям влечет за собой полное восстановление в правах и возмещение причиненного незаконным и необоснованным уголовным преследованием морального и материального вреда (гл.18 УПК РФ).

Рассмотрим закреплённые УПК РФ реабилитирующие основания прекращения уголовного дела.

Отсутствие события преступления (п. 1 ч. 1 ст. 24 УПК РФ), отсутствие в деянии состава преступления (п. 2 ч. 1 ст. 24 УПК РФ), непричастность подозреваемого или обвиняемого к совершению преступления (п. 1 ч. 1 ст. 27 УПК РФ) являются классическими «реабилитирующими» основаниями прекращения уголовного дела (уголовного преследования), имеющими место при установлении (или констатации) факта отсутствия преступления или несовершенства

его конкретным лицом.

*Отсутствие события преступления* (п. 1 ч. 1 ст. 24 УПК РФ). В качестве самостоятельного основания к прекращению уголовного дела отсутствие события преступления было сформулировано в п. 1 ст. 5 Основ уголовного судопроизводства Союза ССР и союзных республик 1958 г. До этого момента указанное основание охватывалось понятием отсутствия состава преступления<sup>2</sup>. В связи с этим возник актуальный до настоящего времени вопрос о разграничении этих близких по содержанию оснований прекращения уголовного дела<sup>3</sup>, поскольку в обоих случаях уголовное дело прекращается ввиду отсутствия преступления.

Как отмечает Г.П. Химичева, в уголовно-правовом смысле «событие преступления» по существу тождественно понятию «состав преступления», поскольку преступное событие не может существовать вне хотя бы одного из четырех элементов состава преступления: объекта, объективной стороны, субъекта, субъективной стороны<sup>4</sup>. К ситуациям, когда уголовное дело подлежит прекращению в связи с отсутствием события преступления, в юридической литературе в первую очередь относятся такие, в которых предполагается отсутствие *деяния*, по поводу которого велось уголовное судопроизводство<sup>5</sup>.

В судебной практике и литературе как отсутствие события преступления рассматриваются также случаи, когда произошедшее явилось результатом действий самого потерпевшего (самоубийство, несчастный случай на производстве при отсутствии вины иных лиц, автотранспортные происшествия вследствие неосторожности самого потерпевшего

<sup>2</sup> Дубинский А. Я. Основания к прекращению уголовного дела в стадии предварительного расследования: учебное пособие. Киев, 1973. С. 7.

<sup>3</sup> См., напр.: Васильева Е. Г. Правовые и теоретические проблемы прекращения уголовного преследования и производства по уголовному делу. М., 2006. С. 96-104; Сафронов Д. М. Обстоятельства, исключающие уголовное преследование: учебное пособие. Омск, 2007. С. 8-12 и др.

<sup>4</sup> Химичева Г. П. Досудебное производство по уголовным делам: концепция совершенствования уголовно-процессуальной деятельности: монография. М., 2003. С. 245.

<sup>5</sup> См., напр.: Дубинский А. Я. Основания к прекращению уголовного дела в стадии предварительного расследования. С. 11-12; Васильева Е. Г. Указ. соч. С. 97; Комментарий к Уголовно-процессуальному кодексу Российской Федерации / науч. ред. В. Т. Томин, М. П. Поляков. М., 2010. С. 87; Уголовно-процессуальное право Российской Федерации: учебник. 3-е изд., отв. ред. И.Л. Петрухин, И.Б. Михайловская. Москва, 2012. С. 426.

<sup>1</sup> Словарь русского языка. М., 1998. С.586



ХУУЛЬ САХИУЛАХУЙ

и т.п.)<sup>6</sup>. В приведенных нами ситуациях предполагается достоверное установление отсутствия преступного события. Однако уголовное дело прекращается по данному основанию и тогда, когда наличие или отсутствие расследуемого события не удалось с необходимой определенностью установить, а возможности доказывания при этом исчерпаны<sup>7</sup>.

*Отсутствие в деянии состава преступления (п. 1 ч. 1 ст. 24 УПК РФ).* Данное основание охватывает значительно более широкий спектр ситуаций. В отличие от отсутствия события преступления, данное основание предполагает наличие конкретного деяния, совершенного каким-либо лицом. Однако в силу тех или иных обстоятельств совершенное лицом деяние не может быть оценено как преступное.

Раскрывая данное основание, в первую очередь необходимо обратить внимание на положения ст. 8 УК РФ, согласно которой основанием уголовной ответственности является совершение деяния, содержащего все признаки состава преступления, предусмотренного данным Кодексом. Если хотя бы один признак состава конкретного преступления (объект, объективная сторона, субъект, субъективная сторона) отсутствует, то нет и основания уголовной ответственности.

Так, отсутствие субъективной стороны преступления будет иметь место при невиновном причинении вреда (ст. 28 УК РФ), несоответствии конкретному составу преступления формы вины, а также мотива и цели, если последние указаны в диспозиции определенной статьи Особенной части УК РФ<sup>8</sup>.

Во многих случаях для признания определенного деяния преступным имеют значение установленные уголовным законом условия или последствия (крупный размер, тяжкие последствия, причинение вреда здоровью человека, причинение значительного ущерба и др.).

Например, обязательным признаком объективной стороны уголовно наказуемого самоуправства (ст. 330 УК РФ) является

<sup>6</sup> Дубинский А. Я. Основания к прекращению уголовного дела в стадии предварительного расследования. С. 12; Химичева Г. П. Указ. соч. С. 247; Комментарий к Уголовно-процессуальному кодексу Российской Федерации / науч. ред. В. Т. Томин, М. П. Поляков. М., 2010. С. 87; Уголовно-процессуальное право: учебник для вузов / под. общ. ред. В. М. Лебедева. М., 2013. С. 587.

<sup>7</sup> Химичева Г. П. Указ. соч. С. 247; Комментарий к Уголовно-процессуальному кодексу Российской Федерации / науч. ред. В. Т. Томин, М. П. Поляков. М., 2010. С. 87-88.

<sup>8</sup> Васильева Е. Г. Указ. соч. С. 128-129.

причинение потерпевшему существенного вреда.

Отсутствие субъекта преступления имеет место в тех случаях, когда лицо, совершившее запрещенное уголовным законом деяние, не соответствует признакам, указанным в нормах Особенной части УК РФ. Так, особенностью должностных преступлений, предусмотренных гл. 30 УК РФ «Преступления против государственной власти, интересов государственной службы и службы в органах местного самоуправления», является то, что их совершение становится возможным лишь благодаря занимаемой должности или путем использования лицом предоставленных ему служебных полномочий<sup>9</sup>. Поэтому уголовный закон специально предусматривает признаки, которым должно соответствовать лицо, подлежащее уголовной ответственности за данные преступления. Они раскрываются в примечаниях к ст. 285 УК РФ.

Отсутствует субъект преступления и в случае если лицо, совершившее предусмотренное уголовным законом деяние, не достигло возраста, с которого наступает уголовная ответственность. По общему правилу уголовной ответственности подлежит лицо, достигшее ко времени совершения преступления шестнадцатилетнего возраста (ч. 1 ст. 20 УК РФ). Часть 3 ст. 27 УПК РФ прямо оговаривает, что уголовное преследование в отношении лица, не достигшего возраста уголовной ответственности, подлежит прекращению именно в связи с отсутствием в деянии состава преступления. Для правильного прекращения уголовного дела в отношении лица, не достигшего возраста уголовной ответственности, существенное значение имеет полнота установления обстоятельств дела и точность квалификации содеянного, поскольку ч. 2 ст. 20 УК РФ устанавливает перечень преступлений, при совершении которых ответственность наступает с 14-летнего возраста.

В соответствии с ч. 3 ст. 27 УПК РФ в связи с отсутствием состава преступления подлежит прекращению уголовное преследование и в отношении несовершеннолетнего, который хотя и достиг возраста, с которого наступает уголовная ответственность, но вследствие отставания в психическом развитии, не связанного с психическим расстройством, не мог в полной мере осознавать фактический характер и общественную опасность своих действий (бездействия) и руководить ими в момент совершения деяния,

<sup>9</sup> Комментарий к Уголовному кодексу Российской Федерации / отв. ред. В. М. Лебедев. М., 2012. С. 1054.

предусмотренного уголовным законом.

Уголовное дело также подлежит прекращению в связи с отсутствием в деянии состава преступления в случае, когда до вступления приговора в законную силу преступность и наказуемость деяния устранены новым уголовным законом (ч. 2 ст. 24 УПК РФ).

По рассматриваемому основанию уголовное дело прекращается и тогда, когда имеют место указанные в нормах Общей части УК РФ обстоятельства, в силу которых расследуемое деяние не может быть признано преступлением.

Так, не является преступлением действие (бездействие), хотя формально и содержащее признаки какого-либо деяния, предусмотренного уголовным законом, но в силу малозначительности не представляющее общественной опасности (ч. 2 ст. 14 УК РФ). Не является преступлением причинение вреда охраняемым уголовным законом интересам в силу указанных в гл. 8 УК РФ обстоятельств, если деяние совершено в состоянии необходимой обороны (ст. 37 УК РФ) или крайней необходимости (ст. 39 УК РФ); при задержании лица, совершившего преступление (ст. 38 УК РФ); в результате физического или психического принуждения (ст. 40 УК РФ); при обоснованном риске (ст. 41 УК РФ), во исполнение обязательного приказа или распоряжения (ст. 42 УК РФ).

Уголовное дело по рассматриваемому основанию, (в зависимости от конкретной ситуации) может быть прекращено как в отношении подозреваемого (обвиняемого) по делу, так и в отношении лица, не поставленного в данный процессуальный статус. Также возможно принятие данного решения и без установления конкретного лица, действиям которого должна быть дана уголовно-правовая оценка. Например, если по расследуемому уголовному делу о краже вследствие уточнения стоимости похищенного установлены признаки административного правонарушения — мелкого хищения (ст. 7.27 Кодекса РФ об административных правонарушениях).

Вместе с тем, особенностью прекращения уголовного дела ввиду отсутствия в деянии состава преступления (в отличие от ситуаций отсутствия события преступления) является возможность привлечения лица, в отношении которого принято такое решение, к иной, установленной законом ответственности, либо возмещение причиненного им вреда в порядке гражданского судопроизводства.

В случае признания постановления о прекращении уголовного дела или уголовного преследования незаконным,

судья разрешает и вопрос о наличии оснований для применения процедуры реабилитации.

*Непричастность подозреваемого или обвиняемого к совершению преступления (п. 1 ч. 1 ст. 27 УПК РФ).* Данное основание вошло в практику российского судопроизводства с принятием УПК РФ. В соответствии с п. 20 ст. 5 УПК РФ под «непричастностью» понимается неустановленная причастность либо установленная непричастность лица к совершению преступления. Такой подход законодателя обусловлен действием принципа презумпции невиновности, одним из следствий которого является правило о том, что «недоказанная виновность равнозначна доказанной невиновности». Ранее действующий УПК РСФСР в качестве сходного по содержанию основания прекращения уголовного дела предусматривал «недоказанность участия обвиняемого в совершении преступления» (п. 2 ч. 1 ст. 208 УПК РСФСР). Это ставило проблему как реализации принципа презумпции невиновности при прекращении уголовного дела по данному основанию, так и определения подлежащего применению основания прекращения уголовного дела в случаях, когда имела место доказанная непричастность лица к совершению преступления<sup>10</sup>. В действующем законе данные проблемы возможно признать разрешенными, однако применение данного основания в конкретных ситуациях может представлять сложность в связи с неоднородностью возникающих при этом ситуаций и наличием конкуренции с иными уголовно-процессуальными решениями. Ведь неустановленными в силу недостаточности доказательств могут быть различные обстоятельства дела, касающиеся как собственно участия лица в тех или иных событиях, так и наличия или отсутствия отдельных признаков, имеющих значение для определения преступности расследуемого деяния. Важным условием для применения в качестве основания прекращения уголовного преследования непричастности к совершению преступления и его разграничения с иными основаниями является доказанность по делу события и состава преступления. Таким образом, «непричастность» может иметь место только тогда, когда установлено событие преступления, имеют место все обязательные признаки состава преступления, в том числе и субъект преступления, но привлекаемое

<sup>10</sup> См., напр.: Стойко Н. Г. Недоказанность обстоятельств уголовного дела. Красноярск, 1984. С. 85-86; Химичева Г. П. Указ. соч. С. 250-251.



Институт  
законодательства  
и  
судоведения  
РАН  
и  
МВД  
РФ



к ответственности лицо им не является, так как установлено, что оно данного деяния не совершало, либо не установлено, что данное деяние совершено именно им<sup>11</sup>. Рассмотрим основные ситуации применения указанного основания прекращения уголовного преследования.

Установленная непричастность подозреваемого (обвиняемого) предполагает, что собранными по делу доказательствами достоверно установлено, что он не совершал инкриминируемого ему деяния. При этом уголовной ответственности за данное деяние подлежит иное лицо. Именно данное обстоятельство подчеркивает законодатель в ч. 4 ст. 24 УПК РФ, определяя, что при прекращении уголовного преследования по данному основанию в отношении всех подозреваемых или обвиняемых уголовное дело прекращению не подлежит. Цель дальнейшего производства — установление иных лиц, подлежащих привлечению к уголовной ответственности за данное преступление.

Неустановленная причастность подозреваемого (обвиняемого) к совершению преступления может быть констатирована в случае, когда по делу имеются отдельные доказательства, свидетельствующие о возможном совершении преступления данным лицом, но их совокупности недостаточно для привлечения его к уголовной ответственности.

Например, если после привлечения лица в качестве обвиняемого имеющийся объем доказательств о его причастности к совершению преступления уменьшился в силу признания отдельных доказательств недопустимыми или изменения участниками судопроизводства ранее данных ими показаний. Возможна и ситуация, когда объем доказательств не изменился, но их совокупность, достаточная для принятия решения, повлекшего возникновение у лица процессуального статуса подозреваемого (возбуждение уголовного дела в отношении лица, задержание подозреваемого и др.), позднее не могла быть положена в основу решения о привлечении его в качестве обвиняемого. В соответствии с принципом презумпции невиновности, все сомнения в виновности обвиняемого, которые не могут быть устранены, толкуются в его пользу (ч. 3 ст. 14 УПК РФ), и при прекращении

уголовного преследования юридически констатируется его невиновность в совершении преступления.

Важнейшим условием для прекращения уголовного преследования ввиду неустановленной причастности лица к совершению преступления, является то, что возможности доказывания по уголовному делу должны быть исчерпаны. Т.е. должны быть выполнены все возможные следственные и иные действия, направленные на устранение имеющихся по делу противоречий или восполнение неполноты доказательств, изобличающих в совершении преступления конкретное лицо.

В соответствии с п. 3 ч. 2 ст. 133 УПК РФ право на реабилитацию, в том числе право на возмещение вреда, связанного с уголовным преследованием, имеют подозреваемый или обвиняемый, уголовное преследование в отношении которых прекращено по основаниям, предусмотренным также пп. 5 и 6 ч. 1 ст. 24 УПК РФ и пп. 4–6 ч. 1 ст. 27 УПК РФ. В частности, это такие основания как: отсутствие заявления потерпевшего, если уголовное дело может быть возбуждено не иначе как по его заявлению; отсутствие заключения суда о наличии признаков преступления в действиях одного из лиц, в отношении которых применяется особый порядок производства по уголовным делам; отсутствие согласия Совета Федерации, Государственной Думы, Конституционного Суда РФ, квалификационной коллегии судей на возбуждение уголовного дела или привлечение в качестве обвиняемого отдельных категорий лиц.

Таким образом, УПК РФ расширяет традиционный перечень реабилитирующих оснований прекращения уголовного дела (уголовного преследования), относя к ним такие, которые не связаны непосредственно с выводом о невиновности лица, либо отсутствии преступления

<sup>11</sup> Лифанова Л. Г. Прекращение уголовного преследования за непричастностью подозреваемого и обвиняемого к совершению преступления. Автореф. Дисс. ... канд. юрид. Наук. М., 2005. С. 23.





Хууль сахиулахуй

### Список использованной литературы

1. Уголовно-процессуальный кодекс Российской Федерации. М., 2016. С. 8.
2. Философская энциклопедия. М., 1967. Т. 4. С. 170.
3. Словарь русского языка. М., 1998. С. 586.
4. Дубинский А. Я. Основания к прекращению уголовного дела в стадии предварительного расследования: учебное пособие. Киев, 1973. С. 7.
5. Васильева Е. Г. Правовые и теоретические проблемы прекращения уголовного преследования и производства по уголовному делу. М., 2006. С. 96-104.
6. Сафронов Д. М. Обстоятельства, исключающие уголовное преследование: учебное пособие. Омск, 2007. С. 8-12 и др.
7. Химичева Г. П. Досудебное производство по уголовным делам: концепция совершенствования уголовно-процессуальной деятельности: монография. М., 2003. С. 245.
8. Лифанова Л. Г. Прекращение уголовного преследования за непричастностью подозреваемого и обвиняемого к совершению преступления. Автореф. дисс. ... канд. юрид. Наук. М., 2005. С. 23.
9. Стойко Н. Г. Недоказанность обстоятельств уголовного дела. Красноярск, 1984. С. 85-86.
10. Комментарий к Уголовно-процессуальному кодексу Российской Федерации / науч. ред. В. Т. Томин, М. П. Поляков. М., 2010. С. 87.
11. Уголовно-процессуальное право: учебник для вузов / под. общ. ред. В. М. Лебедева. М., 2013. С. 587.
12. Комментарий к Уголовному кодексу Российской Федерации / отв. ред. В. М. Лебедев. М., 2012. С. 1054.

## ОБЪЕКТ МЕЛКОГО КОММЕРЧЕСКОГО ПОДКУПА

## OBJECT OF SMALL COMMERCIAL BRIBERY

ХУДАЛДААНЫ БАГА ХЭМЖЭЭНИЙ ХАХУУЛЬ ӨГӨХ  
ГЭМТ ХЭРГИЙН ОБЪЕКТЫН ШИНЖ**МИРОНОВА Г.Н.**

Адъюнкт Омской академии МВД России

**MIRONOVA G.N.**

Postgraduate student of the Omsk Academy, Ministry of Internal Affairs of Russia

**Г.Н.МИРОНОВА**

ОХУ-ын ДХЯ-ны Омскийн академийн адъюнкт

✉ [mgn2007@mail.ru](mailto:mgn2007@mail.ru)

**Аннотация:** Проанализированы подходы к определению объекта преступления, объекта коммерческого подкупа разными учеными в области уголовного права, проведенный анализ позволил сделать выводы относительно содержания родового, видового и непосредственного объекта мелкого коммерческого подкупа.

**Abstract:** The approaches to the definition of the object of crime, the object of commercial bribery by various scientists in the field of criminal law are analyzed, the analysis made allowed to draw conclusions regarding the content of the generic, specific and direct object of small commercial bribery.

**Товч агуулга:** Өгүүлэлд худалдааны бага хэмжээний хахууль өгөх гэмт хэргийн объектыг Оросын эрүүгийн эрх зүйд тодорхойлсон байдал болон эрдэмтдийн үзэл санааг шинжлэн судлаад уг гэмт хэргийн ерөнхий, төрлийн ба шууд объектуудын агуулгын талаарх дүгнэлт гаргасан болно.

**Ключевые слова:** коммерческий подкуп, мелкий коммерческий подкуп, объект преступления, объект коммерческого подкупа, родовой, видовой, непосредственный объекты мелкого коммерческого подкупа.

**Keywords:** commercial bribery, small commercial bribery, object of crime, object of commercial bribery, patrimonial, species, direct objects of small commercial bribery.

**Түлхүүр үгс:** худалдааны хахууль, худалдааны бага хэмжээний хахууль, гэмт хэргийн объект, худалдааны хахууль өгөх гэмт хэргийн объект, худалдааны бага хэмжээний хахууль өгөх гэмт хэргийн ерөнхий, төрлийн, шууд объектууд.

В науке уголовного права не сложилось единого мнения об объекте преступления в целом, и объекте коммерческого подкупа, в частности. Большинство ученых традиционно под объектом преступления понимают охраняемые уголовным законом общественные отношения<sup>1</sup>. Существует и несколько альтернативных позиций относительно объекта преступления. Под объектом преступления понимают: субъективные права личности, интерес<sup>2</sup> и

человека (совокупность людей)<sup>3</sup>.

Именно совокупность общественных отношений, которые поставлены под защиту уголовного закона, на наш взгляд, следует определять в качестве объекта преступления. Все названные выше категории – «права личности», «свободы», «интерес», «человек как личность, как физическое лицо» – проявляют свои сущностные качества и характеристики посредством взаимодействия людей между собой, в

<sup>1</sup> Начало такого понимания объекта преступления в науке уголовного права положил советский ученый А.А. Пионтковский. Этой позиции придерживались такие советские и российские ученые, как Б.С. Никифоров, В.К. Глистин, В.Я. Тацкий, Н.И. Загородников, Н.И. Коржанский, В.Н. Кудрявцев и др.

<sup>2</sup> См., например: Курс уголовного права / под ред. Н.Ф. Кузнецовой, И.М. Тяжковой, Г.Н. Борзенкова, В.С.

Комиссарова. М., 1999. Т. 1 : Общая часть. Учение о преступлении. С. 202; Наумов А.В. Российское уголовное право : курс лекций. М., 1999. Т. 1 :Общая часть. С. 157.

<sup>3</sup> См., например: Козаченко И.Я. Уголовное право. Общая часть : учебник. 4-е изд., переработ. и доп. М. : Норма, 2008; Новоселов Г.П. Учение об объекте преступления. Методологические аспекты. М., 2001. С. 60.

рамках складывающихся между ними общественных отношений. Отделенные от общественных отношений они теряют свою ценность как объекта уголовно-правовой охраны.

В основе общественных отношений как объекте уголовно-правовой охраны лежит какая-либо ценность. Именно ценность общественных отношений и определяет, будет ли государство посредством уголовного закона охранять эти общественные отношения. В качестве таких ценностей и могут выступать субъективные права личности, его свободы, интересы или сам человек, его жизнь и здоровье.

Мелкий коммерческий подкуп (ст. 204<sup>2</sup> УК РФ) включен законодателем в раздел VIII «Преступления в сфере экономики» УК РФ. В связи с чем, следовало бы считать, что родовым объектом рассматриваемого преступления выступают отношения экономики в целом. Тем не менее, по данному вопросу в научной среде по данному вопросу имеются различные мнения.

С.Д. Макаров утверждает, что «далеко не всегда коммерческий подкуп имеет экономическую направленность, поэтому экономические интересы субъектов могут выступать лишь в качестве дополнительного либо факультативного объекта преступления... Родовым объектом изучаемого преступления следует рассматривать нормальное исполнение служебных обязанностей, независимо от того, в какой бы сфере (социальной, экономической, политической) эта деятельность не осуществлялась»<sup>4</sup>. Таким образом, автор относит коммерческий подкуп к «роду» служебных преступлений, содержащихся в главе 30 и некоторых других статьях Особенной части УК РФ<sup>5</sup>.

Против выделения в качестве родового объекта коммерческого подкупа экономических отношений выступает И.А. Кузнецова, которая обосновывает

<sup>4</sup> Макаров С.Д. Уголовная ответственность за коммерческий подкуп: учебное пособие. Иркутск : ИЮИ ГП РФ, 2001. С. 12-13.

<sup>5</sup> К роду служебных преступлений коммерческий подкуп, наряду с другими преступлениями гл. 23 УК РФ, относят также такие ученые, как: Шнитенков А.В. Ответственность за преступления против интересов службы. Автореф. дис. ... докт. юрид. наук. Омск, 2006; Егорова Н.А. Теоретические проблемы уголовной ответственности лиц, выполняющих управленческие функции. Автореф. дис. ... докт. юрид. наук. Саратов, 2006; Асанов Р.Ф. Преступления против интересов службы в коммерческих и иных организациях (Квалификация и ответственность). Автореф. дис. ... канд. юрид. наук. Н.Новгород, 1999.

точку зрения, что родовым объектом анализируемого преступления должны признаваться интересы службы в коммерческих и иных организациях, поскольку интересы этих субъектов отношений не всегда сводятся лишь к экономическим<sup>6</sup>. Схожее мнение высказывает Д.А. Гришин, который родовым объектом преступлений главы 23 называет «служебные интересы» и предлагает исключить эту главу из УК РФ, а соответствующие преступления перенести в главу 30 УК РФ, изменив ее название – «Преступления против интересов службы»<sup>7</sup>.

Придерживаясь пятизвенного родовидового деления объекта преступления, Н.Н. Цугленок выделяет два уровня родового объекта: «родовым объектом первого уровня... следует признавать отношения экономики, в этом плане годятся здесь и обеспечение конкуренции, и борьба с монополизмом. Родовым объектом второго уровня являются отношения непубличной службы»<sup>8</sup>.

Анализ понятий «сфера экономики (экономические отношения)», «интересы организации» и «интересы службы» в контексте уголовно-правовой охраны коммерческого подкупа, в том числе и его привилегированного состава – мелкого коммерческого подкупа позволяет прийти к следующим выводам. Основываясь на имеющихся в определениях понятия «экономики»<sup>9</sup>, эту категорию можно рассматривать, как в широком, так и в узком смысле. В широком смысле экономикой является базис существования государства и общества в целом, это их материальная жизнеспособность. В узком смысле экономика – совокупность отношений по производству, распределению и обмену продукции в различных секторах, в том числе и домашнего хозяйства, т.е. отношения права собственности на конкретный предмет.

Согласимся с мнением Ю.А. Ежова, который исследуя родовой

<sup>6</sup> Кузнецова И.А. Ответственность за коммерческий подкуп. Автореф. дис. ... канд. юрид. наук. М., 2003. С. 14-15.

<sup>7</sup> Гришин Д.А. Уголовная ответственность за преступления в сфере интересов службы в коммерческих и иных организациях. Автореф. дис. ... канд. юрид. наук. Тюмень, 2008. С. 18-19.

<sup>8</sup> Цугленок Н.Н. Получение предмета коммерческого подкупа. Автореф. дис...канд. юрид. наук. Красноярск, 2006. С.12.

<sup>9</sup> См: <https://ru.wikipedia.org/wiki/Экономика>; Словарь иностранных слов. 18-е изд., стер. М. : Рус. яз., 1989. С. 587.



Сибирский  
Федеральный  
Университет

объект преступлений в сфере предпринимательства, отмечает, что родовый объект всех преступлений раздела 8 УК РФ — это «совокупность общественных отношений, обеспечивающих нормальное функционирование и развитие экономики России как единого народно-хозяйственного организма»<sup>10</sup>.

Такое понимание родового объекта коммерческого подкупа согласуется с позицией, что коммерческий подкуп в целом, и мелкий коммерческий подкуп, в частности, это преступные коррупционные проявления, которые влияют на способность и привлекательность отечественной экономики для инвестирования, как внутреннего, так и международного<sup>11</sup>.

На объект уголовно-правовой охраны коммерческого подкупа опосредованно указывает Пленум Верховного Суда Российской Федерации в постановлении от 9 июля 2013 года № 24 «О судебной практике по делам о взяточничестве и об иных коррупционных преступлениях»<sup>12</sup>. Так, во вводной части постановления говорится, что коррупционные преступления (к которым мы относим мелкий коммерческий подкуп — зам. наше) препятствуют конкуренции, затрудняют экономическое развитие.

Мелкий коммерческий подкуп, как бланкетная норма отсылает к диспозиции ст. 204 УК РФ, в которой названы такие субъекты, как коммерческие и иные организации. Они, в свою очередь, составляют частный сектор экономики государства. «Всякое предприятие не существует само по себе, а связано с экономикой в целом, с одной стороны, через рынок производственных факторов, с другой — через рынок сбыта. Предприятие функционирует в определенной предпринимательской среде, которая оказывает влияние на всю его деятельность»<sup>13</sup>. Нарушение функционирования коммерческих и иных организаций через подкуп лиц, управляющих ими, влечет, по нашему мнению, нарушение

экономических основ государства в целом.

Анализируя понимание категорий «интерес», согласимся с мнением Д.А. Кононова, что «интересы организации — это вовсе не интересы службы, это сложный комплекс частных и общественных интересов, в основе которого преимущественно лежат частные интересы ее инвесторов. Тем не менее, к интересам инвесторов этот комплекс не сводится, поскольку организация является самостоятельным субъектом права, наделенным собственными правами и обязанностями, отличным от прав и обязанностей инвесторов. В структуру интересов организации входят общественные интересы (что позволяет организации, напр., заниматься благотворительностью) и интересы ее работников (что позволяет реализовать социальное партнерство)»<sup>14</sup>. В своем исследовании автор предлагает изменить наименование главы 23 УК РФ, изложив ее в следующей редакции: «Преступления в сфере управления организациями, частной охранной детективной деятельности, деятельности частных нотариусов и аудиторов». Он выступает против использования в наименовании главы, а соответственно, и в качестве видового объекта коммерческого подкупа термина «интересы службы»<sup>15</sup>.

Следует согласиться с мнением Д.А. Кононова, что термин «служба» применительно к составам преступлений, предусмотренным в главе 23 УК РФ, использовать некорректно. Исторически термин «служба» связан на русском языке с государством, его учреждениями и органами. Безусловно, если говорить о преступлениях, которые посягают на государственные интересы, то термин «служба» как нельзя точно отражает суть взаимоотношений субъектов. Невозможно «привязать» слово «служба» к таким субъектам, как частный нотариус или аудитор, которые являются субъектами преступления, предусмотренного ст. 202 УК РФ. Буквальный анализ статей главы 23 УК РФ демонстрирует нелогичность законодателя, который слова «служебные» полномочия и «служебное» положение использовал лишь в ст. 204 УК РФ «Коммерческий подкуп». В других же нормах исследуемой главы таких словосочетаний нет, и законодатель

<sup>10</sup> Ежов Ю.А. Преступления в сфере предпринимательства: учебное пособие. М.: Маркетинг, 2001. С. 89.

<sup>11</sup> О влиянии коммерческого подкупа на развитие экономики государства см., например: Красноусов С.Д. Коммерческий подкуп как форма коррупции в частном секторе: понятие и противодействие. Автореф. дис. ... канд. юрид. наук. Владивосток, 2012; Кононов Д.А. Злоупотребление полномочиями и коммерческий подкуп: уголовно-правовая характеристика. Автореф. дис. ... канд. юрид. наук. М., 2016.

<sup>12</sup> Доступ из справ.-правовой системы КонсультантПлюс.

<sup>13</sup> Сафронов Н.А. Экономика организации (предприятия) : учеб. для ср. спец. учеб. заведений. М. : Экономика, 2006. С. 13-14.

<sup>14</sup> Кононов Д.А. Злоупотребление полномочиями и коммерческий подкуп: уголовно-правовая характеристика. Дис. ... канд. юрид. наук. М., 2016. С. 70.

<sup>15</sup> Кононов Д.А. Указ. соч. С. 69-70.

ограничился упоминанием термина «полномочия».

Против использования в уголовном законе применительно к коммерческим организациям понятия «служба» выступает В.Н. Борков. Аргументируя нелогичность законодателя, В.Н. Борков отмечает, что в нормативных актах, регулирующих предпринимательскую деятельность понятие «служба» не применяется<sup>16</sup>.

Следовательно, для упорядочивания и логичной стройности норм главы 23 УК РФ, предлагаем исключить термины «служба», «служебные» и «служебное» из названия главы, и из диспозиции коммерческого подкупа.

Относительно видового и непосредственного объектов коммерческого подкупа в науке уголовного права также имеются разные точки зрения. Видовым объектом преступления, предусмотренного ст. 204 УК РФ, предлагается понимать: управление коммерческими или иными организациями<sup>17</sup>; интересы службы<sup>18</sup>. Другие авторы отстаивают точку зрения, что интересы службы или служебные отношения должны быть признаны непосредственным объектом коммерческого подкупа<sup>19</sup>.

А.В. Шнитенков, анализируя понятие «служба» и определяя ее место в системе управления, отмечает, что «под службой следует понимать основанную на правовом отношении деятельность служащего, для осуществления которой он наделяется полномочиями по выполнению функций управленческого и (или) профессионального характера. Служба является необходимой составляющей частью управления»<sup>20</sup>. Как и слово «управление», термин «служба» производно от соответствующего глагола в русском языке. Системное толкование дефиниций глаголов «управлять» и

«служить» показывает их связь. «Служить – делать что-нибудь для кого-чего-нибудь, выполняя чью-нибудь волю, приказание»<sup>21</sup>. «Управлять – руководить, направлять деятельность, действия кого-чего-нибудь»<sup>22</sup>. Переноса такую трактовку в правовое поле, следует заключить, что управление включает в себя не только руководство людьми, но и деятельностью в целом, в частности деятельностью коммерческой и иной организации. При этом служебные отношения, отношения подчинения могут отсутствовать. Также следует учитывать, что характер отношений между работником и лицом, его нанявшим, не публично-правовой, а гражданско-правовой. Это подчеркивает позицию о нецелесообразности употребления слова «служба» в нормах главы 23 УК РФ, и тем более, отнесение интересов службы к видовому или непосредственному объекту мелкого коммерческого подкупа.

Для достижения поставленных целей коммерческие и некоммерческие организации создают органы управления, как коллегиальные, так и единоличные. Следовательно, деяния, которые запрещены гл. 23 УК РФ, посягают на порядок управления деятельностью коммерческих и некоммерческих организаций. Эти противоправные деяния должны влиять на принятие управленческих решений и, тем самым, препятствовать достижению целей организации, в которой лицо, выполняющее управленческие функции, получило предмет коммерческого подкупа или совершило иное запрещенное нормами гл. 23 УК РФ деяние.

Непосредственным объектом мелкого коммерческого подкупа, на мой взгляд, выступает функционирование как организованная деятельность системы, которой выступает коммерческая или иная организация. Управление же этой системой, порядок нормального эффективного управления деятельностью организации или иного лица (в качестве такового выступают частные нотариусы, аудиторы, частные детективы и работники частных охранных организаций), должно быть признано видовым объектом преступлений, предусмотренных гл. 23 УК РФ. Эффективное управление деятельностью, по нашему мнению, приводит к функционированию организации, и ее существованию как субъекта экономических отношений в

<sup>16</sup> Борков В.Н. Уголовно-правовое предупреждение коррупции: монография. Омск: Омская академия МВД России, 2014. С. 51.

<sup>17</sup> См., например: Егорова Н.А. Теоретические проблемы уголовной ответственности за преступления лиц, выполняющих управленческие функции. Автореф. дис. ... докт. юрид. наук. Саратов, 2006. С. 15; Кононов Д.А. Указ. соч. С. 21; Макаров С.Д. Указ. соч. С. 12.

<sup>18</sup> См., например: Шнитенков А.В. Ответственность за преступления против интересов службы. Автореф. дис. ... докт. юрид. наук. Омск, 2006. С. 10; Асанов Р.Ф. Указ. соч. С. 14; Маслов Е.В. Проблемы уголовной ответственности за преступления против интересов службы в коммерческих и иных организациях. Автореф. дис. ... канд. юрид. наук. Ростов-на-Дону, 2012. С. 13-14.

<sup>19</sup> См., например: Тумаркина Л.П. Уголовная ответственность за коммерческий подкуп. Автореф. дис. ... канд. юрид. наук. М., 2007. С. 12.

<sup>20</sup> Шнитенков А.В. Указ. соч. С. 10.

<sup>21</sup> Ожегов С.И., Шведова Н.Ю. Указ. соч. С. 721.

<sup>22</sup> Ожегов С.И., Шведова Н.Ю. Указ. соч. С. 825.



ХУУЛЬ САХИУЛАХУЙ

государстве.

Таким образом, анализ коммерческого подкупа с позиции нормального функционирования экономики России в целом, ее привлекательности для инвестирования, стабильности экономических отношений, субъектами которых выступают коммерческие и иные организации, позволил определить в качестве родового объекта мелкого коммерческого подкупа защищаемые уголовным законом экономические отношения.

Видовым объектом мелкого коммерческого подкупа следует признать порядок управления деятельностью коммерческих и иных организаций. Основываясь на том, что термин «служба» не может отражать суть взаимоотношений между лицом, управляющим организацией, и лицами, принятыми на работу, считаем целесообразным исключить слова «служба», «служебные» и «служебное» из диспозиции ст. 204 УК РФ.

Непосредственным объектом мелкого коммерческого подкупа, полагаем, выступает нормальное функционирование коммерческой и иной организации как хозяйствующего субъекта, представляющего частный сектор экономики.

#### Список использованной литературы

1. Курс уголовного права / под ред. Н.Ф. Кузнецовой, И.М. Тяжковой, Г.Н. Борзенкова, В.С. Комиссарова. М., 1999.
2. Козаченко И.Я. Уголовное право. Общая часть : учебник. 4-е изд., переработ. и доп. М. : Норма, 2008;
3. Новоселов Г.П. Учение об объекте преступления. Методологические аспекты. М., 2001. С. 60.
4. Макаров С.Д. Уголовная ответственность за коммерческий подкуп: учебное пособие. Иркутск : ИЮИ ГП РФ, 2001.
5. Шнитенков А.В. Ответственность за преступления против интересов службы. Автореф. дис. ... докт. юрид. наук. Омск, 2006;
6. Егорова Н.А. Теоретические проблемы уголовной ответственности лиц, выполняющих управленческие функции. Автореф. дис. ... докт. юрид. наук. Саратов, 2006;
7. Асанов Р.Ф. Преступления против интересов службы в коммерческих и иных организациях (Квалификация и ответственность). Автореф. дис. ... канд. юрид. наук. Н.Новгород, 1999.
8. Кузнецова И.А. Ответственность за коммерческий подкуп. Автореф. дис. ... канд. юрид. наук. М., 2003.
9. Гришин Д.А. Уголовная ответственность за преступления в сфере интересов службы в коммерческих и иных организациях. Автореф. дис. ... канд. юрид. наук. Тюмень, 2008.
10. Цугленок Н.Н. Получение предмета коммерческого подкупа. Автореф. дис. ... канд. юрид. наук. Красноярск, 2006.
11. <https://ru.wikipedia.org/wiki/Экономика>; Словарь иностранных слов. 18-е изд., стер. М. : Рус. яз., 1989.
12. Ежов Ю.А. Преступления в сфере предпринимательства: учебное пособие. М.: Маркетинг, 2001.
13. Красноусов С.Д. Коммерческий подкуп как форма коррупции в частном секторе: понятие и противодействие. Автореф. дис. ... канд. юрид. наук. Владивосток, 2012;
14. Кононов Д.А. Злоупотребление полномочиями и коммерческий подкуп: уголовно-правовая характеристика. Автореф. дис. ... канд. юрид. наук. М., 2016.
15. Сафронов Н.А. Экономика организации (предприятия) : учеб. для ср. спец. учеб. заведений. М. : Экономистъ, 2006.
16. Кононов Д.А. Злоупотребление полномочиями и коммерческий подкуп: уголовно-правовая характеристика. Дис. ... канд. юрид. наук. М., 2016.
17. Кононов Д.А. Указ. соч.
18. Борков В.Н. Уголовно-правовое предупреждение коррупции : монография. Омск : Омская академия МВД России, 2014.
19. Егорова Н.А. Теоретические проблемы уголовной ответственности за преступления лиц, выполняющих управленческие функции. Автореф. дис. ... докт. юрид. наук. Саратов, 2006.
20. Кононов Д.А. Указ. соч. С. 21; Макаров С.Д. Указ. соч.
21. Шнитенков А.В. Ответственность за преступления против интересов службы. Автореф. дис. ... докт. юрид. наук. Омск, 2006.
22. Асанов Р.Ф. Указ. соч.
23. Маслов Е.В. Проблемы уголовной ответственности за преступления против интересов службы в коммерческих и иных организациях. Автореф. дис. ... канд. юрид. наук. Ростов-на-Дону, 2012.
24. Тумаркина Л.П. Уголовная ответственность за коммерческий подкуп. Автореф. дис. ... канд. юрид. наук. М., 2007.
25. Шнитенков А.В. Указ. соч.
26. Ожегов С.И., Шведова Н.Ю. Указ. соч.



## ОБЩЕСТВЕННАЯ ОПАСНОСТЬ ПОСЯГАТЕЛЬСТВА НА ЖИЗНЬ СОТРУДНИКА ПРАВООХРАНИТЕЛЬНОГО ОРГАНА ПО УГОЛОВНОМУ ЗАКОНОДАТЕЛЬСТВУ РОССИЙСКОЙ ФЕДЕРАЦИИ

PUBLIC DANGER OF ENCROACHMENT ON LIFE OF LAW ENFORCEMENT OFFICER IN THE CRIMINAL LEGISLATION OF THE RUSSIAN FEDERATION

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН АМЬ БИЕД ХАЛДАХ ГЭМТ ХЭРГИЙН НИЙГМИЙН АЮУЛ

### АМАРСАНАА В.

Адъюнкт Омской академии МВД России, старший лейтенант полиции Монголии

### АМАРСАНАА V.

Post-graduate student of the Chair of Criminal Law of the Omsk Academy of the Ministry of Internal Affairs of Russia

### В.АМАРСАНАА

ОХУ-ын ДХЯ-ны Омскийн академийн адъюнкт, цагдаагийн ахлах дэслэгч

✉ [amarsanaa0923@mail.ru](mailto:amarsanaa0923@mail.ru)

**Аннотация:** Рассмотрена общественная опасность посягательства на жизнь сотрудника правоохранительного органа по уголовному законодательству РФ. В частности, отмечается, что общественная опасность данного вида преступления определяется не только его многообъектным характером, но и таким криминологическим показателем, как распространенность.

**Abstract:** The public danger of infringement on life of the law enforcement officer on the criminal legislation of the Russian Federation is considered. In particular, it is noted that the social danger of this type of crime is determined not only by its multi-object nature, but also by criminological indicators such as prevalence.

**Товч агуулга:** Оросын Холбооны Улсын Эрүүгийн хуульд тусгалаа олсон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын амь биед халдах гэмт хэргийн нийгмийн аюулын түвшинг хэрхэн тодорхойлсон болохыг авч үзсэн болно. Энэхүү гэмт хэргийн нийгмийн хор аюул нь олон объектот шинжээр илэрхийлэгддэг төдийгүй нийгэмд өргөн хүрээтэй үйлдэгддэгээрээ онцлогтой байна.

**Ключевые слова:** общественная опасность, посягательство на жизнь сотрудника правоохранительного органа, общественный порядок и общественная безопасность.

**Keywords:** public danger, an encroachment on life of the employee of law enforcement body, public order and public safety.

**Түлхүүр үгс:** нийгмийн аюул, хууль сахиулах байгууллагын алба хаагчдын амь биед халдах, нийгмийн эмх журам, нийгмийн аюулгүй байдал.

Важным условием нормального функционирования любого государства является организация и порядок управления обществом, осуществляемая властными органами и их служащими — должностными лицами, в том числе представителями всех ветвей власти.

Успешная служебная деятельность сотрудника органов внутренних дел как государственного служащего возможна при наличии многих условий. Одним из важных является уверенность в надежной защите со стороны государства его прав, свобод и как гражданина данного государства, и как лица, осуществляющего функции государственного органа, то есть представителя власти<sup>□</sup>. В соответствии с Федеральным законом

РФ «О государственной защите судей, должностных лиц правоохранительных и контролирующих органов»<sup>□</sup> сотрудники и их близкие обладают правом на обеспечение безопасности в случае совершения посягательства на их жизнь и здоровье и имущество с целью воспрепятствования законной служебной деятельности, либо принуждения к изменению ее характера, либо из мести за указанную деятельность. Помимо этого обеспечения, есть еще более серьезный способ защиты жизни и здоровья представителя власти. Таковым является защита представителя власти средствами уголовно-правового воздействия.

Среди преступлений против порядка управления наибольшую опасность



представляют те, которые связаны с психическим или физическим воздействием на субъектов управленческой деятельности<sup>1</sup>. Одним из таких является преступление, предусмотренное ст. 317 УК РФ (посягательство на жизнь сотрудника правоохранительного органа). В этом отношении представляется достаточно справедливым суждение о том, что группа преступлений, характеризующихся различными формами противодействия субъектам управленческой деятельности, является наиболее опасной из преступлений против порядка управления. Повышенная общественная опасность данного преступления обуславливается тем, что нарушение нормальной деятельности правоохранительных или иных органов сопряжено с одновременным воздействием в различных формах на жизнь представителей власти в связи с исполнением ими своих служебных обязанностей. В российской уголовно-правовой доктрине традиционно имеется точка зрения, согласно которой одновременное воздействие на нескольких групп общественных отношений свидетельствует о более высокой степени общественной опасности совершенного лицом посягательства<sup>2</sup>. Сопряженность нескольких посягательств выступает в роли одного из показателей более высокой общественной опасности. В этом отношении вызывает особое внимание позиция высшей судебной инстанции РФ: «согласно ст. 6 УК РФ справедливость наказания заключается в его соответствии характеру и степени общественной опасности преступления, обстоятельствам его совершения и личности виновного. Характер общественной опасности преступления определяется уголовным законом и зависит от установленных судом признаков состава преступления. При учете характера общественной опасности преступления судам следует иметь в виду прежде всего направленность деяния на охраняемые уголовным законом социальные ценности и причиненный им вред»<sup>1</sup>. Речь здесь идет о посягательстве на жизнь сотрудника правоохранительного органа (ст. 317 УК РФ). Как уже было сказано выше, данная норма по своей сути содержит наиболее опасное посягательство среди преступлений

против порядка управления, причем оно обладает многообъектным характером.

Обеспечение безопасности личности от преступных посягательств представляет одну из основных обязанностей правового государства. Интересно при этом отметить, что, например, в революционный период все усилия государства были направлены на решение вопросов борьбы с преступностью, в связи с чем партия подчеркнула, что «неизменной задачей остается использование всей силы советских законов в борьбе с преступностью и другими правонарушениями, чтобы люди в любом населенном пункте чувствовали заботу государства об их покое и неприкосновенности, были уверены, что ни один правонарушитель не уйдет от заслуженного наказания»<sup>2</sup>.

Безусловно, профессия защитника общественного порядка и общественной безопасности традиционно является одной из самых опасных в современном обществе. Находясь на переднем краю борьбы с преступностью и терроризмом, сотрудники полиции и военнослужащие внутренних войск ежедневно подвергают свою жизнь огромному риску. Учитывая общественную опасность посягательства на жизнь и здоровье сотрудника правоохранительного органа и трудность работы сотрудников правоохранительных органов, тем более невозможную утрату человека, в ноябре 2011 года приказом министра РФ России было объявлено Днём памяти погибших при исполнении служебных обязанностей (обязанностей военной службы) сотрудников органов внутренних дел и военнослужащих внутренних войск. Это может служить одним из примеров высокой степени общественной опасности, в частности, посягательства на жизнь тех, кто находится на службе ради общего блага.

Возвращаясь к анализу общественной опасности посягательства на жизнь сотрудника правоохранительного органа, необходимо указать реальное количество погибших в связи с исполнением служебных обязанностей по обеспечению общественного порядка и общественной безопасности.

Осложнение современной криминальной ситуации в России обусловлено, в первую очередь, стремительным ростом организованной


<sup>1</sup> Михеева С. Н., Скипский Г. А. Особенности реализации мер государственной защиты сотрудников правоохранительных органов и их близких при возникновении угрозы жизни, здоровью и имуществу // Деятельность правоохранительных органов в современных условиях: сборник материалов XXII международной научно-практической конференции. Том II. 2017. С. 149.

<sup>2</sup> О государственной защите судей, должностных лиц правоохранительных и контролирующих органов: федеральный закон от 20 апреля 1995 г. № 45-ФЗ (в ред. от 7 февраля 2017 г.) // Российская газета. 1995. 26 апр.

преступности, значительным увеличением числа насильственных преступлений, активизацией насильственных акций в отношении представителей власти и органов управления. Организованные преступные сообщества имеют целью не только скомпрометировать, ослабить работу правоохранительных органов, но и воздействовать насильственно на отдельно взятых исполнителей. Сложившаяся ситуация предопределила концептуальное положение о необходимости повысить уровень правовой защищённости сотрудников правоохранительных органов<sup>3</sup>.

Исходя из данных государственной уголовной статистики (форма № 1-ЕГС «Единый отчет о преступности»), количество зарегистрированных преступлений, предусмотренных ст. 317 УК РФ, в 2013 году составило 364 соответственно, в 2014 г. – 223, в 2015 г. – 181, в 2016 г. – 264, в 2017 г. – 245.

График № 1. Количество преступлений, предусмотренных ст. 317 УК РФ, в период с 2013 по 2017 гг.



Статистика посягательства на жизнь сотрудника правоохранительного органа РФ за последние пять лет свидетельствует о том, что данный вид преступления не имеет динамики к снижению. Более того, наблюдается постепенный рост посягательств данного типа.

Таким образом, анализ общественной опасности преступления, посягающего на жизнь сотрудника правоохранительного органа, позволяет сделать следующие выводы:

1. Общественная опасность рассматриваемого преступления определяется объектом посягательства, то есть общественными отношениями, на которые направлено деяние. Действительно, общественная опасность деяния повышается за счет удвоения объекта посягательства, то есть посягательство нарушает две группы

общественных отношений.

2. Стабильный рост количества преступлений, предусмотренных ст. 317 УК РФ, свидетельствует о высокой степени общественной опасности данного преступления и требует дальнейшего ужесточения противодействия средствами уголовно-правового воздействия.

### Список использованной литературы

1. Михеева С. Н., Скипский Г. А. Особенности реализации мер государственной защиты сотрудников правоохранительных органов и их близких при возникновении угрозы жизни, здоровью и имуществу // Деятельность правоохранительных органов в современных условиях: сборник материалов XXII международной научно-практической конференции. Том II. 2017.

2. О государственной защите судей, должностных лиц правоохранительных и контролирующих органов: федеральный закон от 20 апреля 1995 г. № 45-ФЗ (в ред. от 7 февраля 2017 г.) // Российская газета. 1995. 26 апр.

3. Уголовное право Российской Федерации. Особенная часть : учебник / под ред. А. И. Марцева. Омск, 2000.

4. Например: Никифоров Б. С. Объект преступления. М., 1960. С. 143-145; Коржанский Н. И. Объект и предмет уголовно-правовой охраны. М., 1980.

5. П. 1 Постановления Пленума Верховного Суда Российской Федерации от 22 декабря 2015 г. № 58 «О практике назначения судами Российской Федерации уголовного наказания» // URL: [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_190932/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_190932/) (дата обращения: 23.09.2016).

6. Материалы XXVII съезда Коммунистической партии Советского Союза. М., 1986.

7. Борисихина С. А. Насильственные посягательства на работников правоохранительных органов: проблемы квалификации (обзор практики) // Следователь. 2003. №9.

<sup>3</sup> Уголовное право Российской Федерации. Особенная часть : учебник / под ред. А. И. Марцева. Омск, 2000. С. 562.



ХУУЛЬ САХИУЛАХУЙ

## ЮРИДИЧЕСКИЙ АНАЛИЗ ПРЕДМЕТА ПРЕСТУПЛЕНИЯ, ПРЕДУСМОТРЕННОГО СТ. 174.1 УК РФ.

### THE LEGAL ANALYSIS OF THE CRIME SUBJECT, STIPULATED BY ART. 174.1 OF THE CRIMINAL CODE

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ТУСГАЙ АНГИЙН 174.1 ДҮГЭЭР ЗҮЙЛД ЗААГДСАН ГЭМТ ХЭРГИЙН ХАЛДЛАГЫН ЗҮЙЛИЙН ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН ТАЙЛБАР

**ЛУПЫРЬ М.В.**

Адъюнкт Омской академии МВД России

**LUPYR M.V.**

Postgraduate student of the Omsk Academy,  
Ministry of Internal Affairs of Russia

**М.В.ЛУПЫРЬ**

ОХУ-ын ДХЯ-ны Омский академийн адъюнкт

✉ [urmax@bk.ru](mailto:urmax@bk.ru)

**Аннотация:** В статье анализируется проблема предмета преступления предусмотренного ст. 174.1 УК РФ. Рассматривается значение термина «иное имущество». Исследуется вопрос о возможности легализации (отмывания) имущественных прав и имущества имеющего индивидуально-определенные признаки. Автор статьи приходит к выводу о том, что предикатные преступления, в результате которых были созданы законные основания распоряжаться преступно приобретенным имуществом, являются одновременно и как преступления, с помощью которого было преступно приобретено имущество и как преступления целью которых является получение законного права на преступно приобретенное имущество.

**Abstract:** The article analyzes the problem of the crime subject to art. 174.1 of the Criminal Code. The meaning of the term “other property” is considered. The issue of the possibility of legalization (laundering) of property rights and property with individual-specific characteristics is being investigated. The author comes to the conclusion that the predicate offenses, which resulted in the creation of legal grounds for disposing of the property acquired as crime, are both a crime by means of which property was criminal acquired and as a crime whose purpose is to obtain a legal right to the property acquired in a criminal manner.

**Товч агуулга:** ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 174.1 дүгээр зүйлд заагдсан гэмт хэргийн халдлагын зүйлсийн талаарх тулгамдсан асуудлууд болон «Бусад эд хөрөнгө» хэмээх нэр томъёоны талаар товч байдлаар авч үзлээ.

**Ключевые слова:** легализация, имущественные права, индивидуально-определенное имущество.

**Keywords:** financial operations, property rights, individually-defined property.

**Түлхүүр үгс:** мөнгө угаах, эд хөрөнгийн эрх, хувийн тодорхой эд хөрөнгө.

В ст. 174.1 УК РФ предметом легализации (отмывания) являются денежные средства или иное имущество. В постановлении Пленума Верховного Суда РФ от 07 июля 2015 № 32 под денежными средствами понимаются наличные денежные средства в валюте Российской Федерации или в иностранной валюте, а также безналичные и электронные денежные средства. Под иным имуществом понимается движимое и недвижимое имущество, имущественные права, документарные и бездокументарные ценные бумаги, а

также имущество, полученное в результате переработки имущества, приобретенного преступным путем или в результате совершения преступления (например, объект недвижимости, построенный из стройматериалов, приобретенных преступным путем)<sup>2</sup>.

На сегодняшний день проблемным является вопрос о том, может ли выступать предметом легализации (отмывания) имущественные права, а также имущество, имеющее индивидуально-определенные признаки, и подлежащее обязательной

государственной регистрации, поскольку из анализа судебной статистики следует, что сделанные Пленумом Верховного суда Российской Федерации разъяснения не оказывают большой практической пользы, а сам состав преступления требует доработки.

Следует сказать, что термин «имущественные права» используемый законодателем в составе ст. 174.1 УК РФ, не имеет достаточно четкого определения ни в гражданской, ни в уголовной, ни в какой либо другой отрасли права. В теории гражданского права имущественные права представляют собой комплексную категорию, включающую в себя вещные, обязательственные, исключительные, наследственные, а также смешанные права<sup>1</sup>. Основным интерес представляются вещные права, которые включают в себя право собственности, а именно право владения, пользования и распоряжения, поскольку проблема вещного права в рамках состава преступления предусмотренного ст. 174.1 УК РФ заключается в том, возможно использовать имущественные права и имущество, имеющее индивидуально-определенные признаки можно только при наличии зарегистрированных на такие предметы, определенным образом прав.

Для рассмотрения данного вопроса интерес представляет правомочие распоряжения, являющееся составной частью права собственности, наделяющее владельца такого правомочия возможностью отчуждать имущество, определять его судьбу. Остальные правомочия владения и пользования, имеющие большое значение в гражданском праве, малопригодны для защиты действительных прав на имущество<sup>2</sup>.

Е.А. Суханов правомочие распоряжения описывает как возможность определения юридической судьбы имущества путем изменения его принадлежности, состояния или назначения (отчуждения по договору, передача по наследству, уничтожение и т.д.)<sup>2</sup>. Кроме того, многими учеными подчеркивается то обстоятельство, что распоряжение является основным, самым существенным правомочием собственника, поскольку без распоряжения немислимо и право собственности.

Правомочие распоряжения может

возникнуть с момента государственной регистрации права собственности, т.е. действий которые являются обязательным для лиц желающих приобрести права на имущество. Данный порядок, к примеру, действует в отношении объектов недвижимости, земельных участков. Однако как следует из ст. 174.1 УК РФ цель легализации заключается в придании правомерного вида владению, пользованию и распоряжению, т.е. праву собственности. Однако как мы уже сказали, такие объекты гражданских прав, как имущественные права и имущество, имеющее индивидуально-определенные признаки могут быть использованы в гражданском обороте только после приобретения на них права собственности, что не согласуется с целью легализации, которая в основном заключается в распоряжении.

Для совершения сделок направленных на легализацию права распоряжения в отношении индивидуально-определенного имущества, подлежащего обязательной государственной регистрации, необходимо первоначально как минимум приобрести данное правомочие или же право собственности, поскольку, к примеру, при отсутствии такого права невозможно совершение какой либо сделки с недвижимым имуществом, так как юридически они не будут иметь правовых последствий и соответственно возможности легализации (отмывания). Поэтому для совершения указанных в ст. 174.1 УК РФ действий, необходимо в первую очередь приобрести право на имущество, т.е. фактически заполучить его. Но в таком случае, возникает вопрос о необходимости квалификации дальнейших действий с имуществом как легализация (отмывание), поскольку если есть правомочие, то есть и само право.

Ответ на наш взгляд, кроется в том, что если при совершении предикатного преступления преследовалась цель, заключающаяся в приобретении правомочия распоряжения на имущество, то предикатное преступление выступает одновременно и как преступление, с помощью которого было преступно приобретено имущество и как преступление целью которого являлось получение юридически подтвержденного права на него. В связи с этим, последующая сделка лица виновного в совершении предикатного преступления с чужим имуществом,



Хууль сахиулахуй

<sup>1</sup> Семенов В.В. Имущественные права в гражданском праве и защита их в обязательстве // Юрист – Правоведь. 2008. № 1. С. 42-44.

<sup>2</sup> Клепицкий И.А. Недвижимость как предмет хищения и вымогательства // Государство и право. 2000. № 12. С. 14.





имеющим индивидуально определенные признаки и подлежащим обязательной государственной регистрации, полученным им в результате совершения преступления, охватывается составом предикатного преступления, поскольку представляет собой акт распоряжения имуществом как своим собственным, право на которое было приобретено им преступным путем, что исключает возможность осуждения по ст. 174.1 УК РФ. Подобные действия, на наш взгляд свидетельствуют лишь о то, что сделки с рассматриваемым имуществом совершаются в целях, невозможности истребования предметов предикатного преступления пользу действительно законного собственника.

Однако легализация (отмывание) в некоторых случаях, все же будет иметь место, но только в том случае, если индивидуально-определенное имущество было конвертировано, т.е. была изменена его первоначальная форма, к примеру, путем продажи, обмена на денежные средства. Это связано с тем, что деньги не имеют индивидуально-определенных признаков, следовательно, приобретя право на них, связь с предикатным преступлением, с помощью которого было приобретено право, к примеру, на недвижимое имущество, прерывается.

#### Список использованной литературы

1. Постановление Пленума Верховного Суда Российской Федерации от 7 июля 2015 г. № 32 // Доступ из СПС «КонсультантПлюс».
2. Семенов В.В. Имущественные права в гражданском праве и защита их в обязательстве // Юрист – Правоведь. 2008. № 1.
3. Клепицкий И.А. Недвижимость как предмет хищения и вымогательства // Государство и право. 2000. № 12.
4. Гражданское право: учебник под ред. Е.А. Суханова. 3-е изд. Т. 2. М., 2004.

## ОХУ БОЛОН МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, НИЙГМИЙН ХЭВ ЖУРМЫГ ХАМГААЛАХ АЖИЛЛАГААНД ОРЧИН ҮЕИЙН ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙГ АШИГЛАХ АСУУДЛЫГ ХАРЬЦУУЛАН СУДЛАХ НЬ

COMPARATIVE STUDY REGARDING THE ISSUE ON THE USE OF MODERN TECHNIQUES AND TECHNOLOGIES FOR THE PREVENTION OF CRIME AND PUBLIC ORDER IN RUSSIA AND MONGOLIA

### Б.МЭНДБАЯР

ОХУ-ын ДХЯ-ны харьяа Удирдлагын академийн сонсогч, цагдаагийн хошууч

### MENDBAYAR B.

Police Major, Student of the Academy of Management, Ministry of Internal Affairs of Russia

✉ [bok\\_mvd@mail.ru](mailto:bok_mvd@mail.ru)

**Товч агуулга:** Уг илтгэлээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон нийгмийн хэв журам хамгаалах ажилд орчин үеийн техник хэрэгслийг ашиглаж буй өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, түүний арга барил удирдлага, ажлын зохион байгуулалтыг боловсронгуй болгох зарим арга хэлбэрийг тодорхойлохыг зорив.

**Abstract:** The purpose of this article is to offer possible improvements to the maintenance of public order system in Mongolia based upon current studies and literature on crime statistics.

**Түлхүүр үгс:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, техник, технологи, статистик бүртгэл.

**Keywords:** Maintenance of public order, technical, technological, statistics.

### Удиртгал

Маш хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй нийгмийн хөгжлийн энэ үед Монгол улсын цагдаагийн байгууллагад зүй ёсоор тавигдах болсон шаардлага бол нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэхэд орчин үеийн техник, технологийн шийдлийг ашиглах явдал юм.

1997 оны 12-р сарын 05-нд Монгол Улсын Их Хурлаас “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” хуулийг баталсан нь төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлох чухал ач холбогдолтой болсон. Энэхүү хууль нь хэрэгжиж эхэлснээр нийгэмд ихээхэн эерэг өөрчлөлтийг авчирсан ба гэмт хэргийн гаралт өмнөх үетэй харьцуулбал буурсан юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, олон нийтийн хүчинд түшиглэх, иргэд оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд энэ талаар зохион байгуулж байгаа ажилд оролцох, аж ахуйн нэгж, байгууллага дотооддоо болон үйл ажиллагааныхаа хүрээнд гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг арилгах ажлыг хариуцан зохион байгуулах зарчимд тулгуурлана<sup>1</sup>.



Цагдаагийн байгууллага нь хууль тогтоомжоор болон төрийн эрх бүхий бусад байгууллагаас тогтоосон нийтээр дагаж мөрдөх журмыг сахиулж, хүн амын амгалан тайван байдлыг хангах үүрэг хүлээдэг билээ.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан ажлын хүрээнд “Аз жаргалтай хот” хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Нийслэлийн аялал жуулчлалын газартай хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 62 дугаар тогтоолоор “Гэмт хэргийн хяналтын цогц систем”, “Телекамер”, “Эргүүл” дэд хөтөлбөрүүдийг батлуулж, төсөв санхүүг шийдвэрлүүлсэн.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2017 оны 61 дүгээр

<sup>1</sup> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль. 1997.

“Төрийн” мэдээлэл эмхэтгэл. №1. 1998.





захирамжаар Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын хүрээнд “Гэмт хэргийн хяналтын цогц систем бүхий Удирдлагын төвийн хөдөлгөөнт автомашины тусгай тоноглолын гүйцэтгэл, техник, тоног төхөөрөмж”-ийг 49,672,580 төгрөгөөр, “Эргүүлийн алба хаагчдын байршил тогтоогч” /GPS/-ийг 39,204,000 төгрөгөөр, нийт 88,876,580 төгрөгөөр, мөн Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2017 оны 84 дүгээр захирамжаар Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын хүрээнд 830,000,000 төгрөгөөр цагдаагийн алба хаагчдын техник, тусгай хэрэгсэл, хөдөлгөөнт эргүүлийн автомашин худалдан авах эрхийг Нийслэлийн цагдаагийн газарт шилжүүлсний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна<sup>2</sup>.

Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн<sup>3</sup> гэж зааж өгсөн байдаг. Тиймээс цагдаагийн байгууллагаас дараах урьдчилан сэргийлэх ажлуудыг хийж эхлүүлээд байгаа билээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлж буй олон хөтөлбөрүүдийн дундаас “Оюутан цагдаа” хөтөлбөр билээ. Уг хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр Нийслэл хотын хэмжээнд гадаадын иргэдээс үйлдсэн гэмт хэрэг 3 бүртгэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 нэгжээр буюу 40 хувиар, жуулчдаас гэмт халдлагад өртөж хохирсон тохиолдол 2 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1 нэгжээр буюу 33.33 хувиар тус тус буурсан<sup>4</sup>.

### **Нийгмийн хэв журам хамгаалах ажлын ойлголт, мөн чанар**

Эрх зүйн дэг журам нь нийгмийн хэв журмын хамгаалах хүрээнд оршиж, эрх зүйн хэм хэмжээгээр тогтоогдож, эрх зүйн хэрэгжилт, түүний үрдүнгээр тодорхойлогдож байгаа эрх зүйн харилцааны бодит харилцаа

<sup>2</sup> Нийслэлийн цагдаагийн үйл ажиллагааны үндсэн тайлан 2017 он. <http://www.ub.police.gov.mn> (Хандалт: 2018.01.10)

<sup>3</sup> Цагдаагийн албаны тухай хууль. УБ. 2017.02.09. <http://www.legalinfo.mn/law/details/12469> (Хандалт: 2018.01.10)

<sup>4</sup> Нийслэлийн цагдаагийн үйл ажиллагааны үндсэн тайлан 2017 он. <http://www.ub.police.gov.mn> (Хандалт: 2018.01.10)

мөн гэж тодорхойлоод Монгол Улсын Үндсэн Хуульд “нийгмийн хэв журам”, “Нийгмийн дэг журам” гэсэн нэр томьёо орсон бөгөөд “нийгмийн дэг журам” гэсэн ойлголтыг “төрийн дэг журам” биш харин “эрх зүйн дэг журам” гэж тайлбарлаад эрх зүйн дэг журам нь хууль ёс, эрх зүйн үндсэн дээр журамлагдсан нийгмийн харилцааны бодит байдлын хувьд хууль ёстой салшгүй холбоотой болохыг онцлон үзжээ<sup>5</sup>. Нийгмийн дэг журам нь өргөн агуулгатай, харин нийгмийн хэв журам нь түүний доторх бүрэлдэхүүн хэсэг бол нийгмийн дэг журмыг төрийн дэг журам гэж ойлгож зөвхөн хэрэгжүүлэгч субъектийн талаас нь авч үзэх нь оновчтой байна.

Нийгмийн хэв журмын ойлголтын талаар хийсэн судалгаандаа тулгуурлан үзвэл “Нийгмийн хэв журам гэдэг нь төр, иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид өөрийн хууль ёсны эрх ашиг, эрх, эрх чөлөөгөө ашиглах бүхий л боломжийг хангах, эдгээр эрх ашиг нь зөрчигдсэн тохиолдолд найдвартай хамгаалах, нийтийн зарчимд үндэслэсэн зорилго бүхий нийгмийн гишүүдэд тогтсон нийтлэг үнэлэмжид нийцсэн эрх зүй, ёс суртахуун, зан заншлын хэм хэмжээгээр зохицуулагдаж буй нийгмийн харилцааны өвөрмөц бүрдэл” гэж тодорхойлж болохоор байна.

Одоо мөрдөгдөж буй Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар: Цагдаагийн байгууллага нь нийтийн хэв журмыг хамгаалах чиг үүргийн хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, хуулиар харьяалуулсан зөрчлийг шалгаж шийдвэрлэх, байгууллага, алба хаагчийг мэдээллээр хангах;

Гудамж, талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт эргүүл хийх, байнгын болон түр ажиллагаатай хянаж-нэвтрүүлэх цэг ажиллуулах дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, бусад арга, техник хэрэгсэл ашиглан хяналт тавих;

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

Насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

<sup>5</sup> Ч.Нямсүрэн. “Эрх зүй, төрийн ерөнхий онол”. УБ., 2004. 319 дахь тал.



Гэрээт харуулын болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад илэрсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, тэдгээрийг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдэд шаардлага, сэрэмжлүүлэг өгөх, биелэлтийг нь хангуулах;

Олон нийтийн цагдааг мэргэжил, арга зүйгээр хангах<sup>6</sup> гэж тус тус зааж өгсөн байдаг билээ.

### **Нийгмийн хэв журам хамгаалах ажилд орчин үеийн дэвшилтэт техник, технологи ашиглаж буй өнөөгийн байдал**

Нийслэл хотын орон сууц, гэр хорооллын гудамж, талбайг камержуулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Монгол улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, нийслэлийн засаг даргын тамгын газар, нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран “Камержуулалт” болзолт уралдааныг зохион байгуулж ажиллаж байгаа нь маш том түлхэц болсон юм.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай байгаа “Мэдээлэл, танилцуулгын систем”, “Дотоод хяналт, аюулгүй байдлын цогц програм хангамж”, “Мөрдөн байцаах албаны 7 хоног бүрийн статистик тайлан”, “Жолооны сургалтын төвийн бүртгэл”, “Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг бүртгэх програм”, “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүртгэл”, “Нийтийг хамарсан арга хэмжээний бүртгэл”, “Жагсаал, цуглааны бүртгэл”, “Хууль бус аргаар байгалийн ашигт малтмал олборлогч иргэдийн хөдөлгөөний бүртгэлийн систем”, “Гадаад болон дотоодод зохион байгуулагдсан сургалтын бүртгэлийн програм хангамж”-ийг боловсруулж нэвтрүүлсэн.

“Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих” програмд шаардлагатай нэмэлт, өөрчлөлт, “ECS” програм хангамжид дуудлага, мэдээллийн шийдвэрлэлт, авч хэрэгжүүлсэн арга

хэмжээг тухайн газар, хэлтсийн жижүүрийн офицерууд засварлах боломжийг бүрдүүлж, нийслэлийн хэмжээнд 102 дугаарын утсанд дуудлага, мэдээлэл ирэхэд “Дуут дохио” өгдөг болгох, “Статистикийн тайлан боловсруулах” явцад дутуу боловсруулагдсан тайлангуудыг нэгтгэх, хэвлэх, зөрүүтэй баганад бичлэг нэмэх, хасах, эрүүгийн хэрэг, гомдол, мэдээллийн шилжилт, хөдөлгөөнтэй холбоотойгоор тухайн мэдээллийг засварлах боломжтой програм хангамж, “Patrol” системээс иргэний мэдээллийг регистрийн болон жолооны үнэмлэхийн дугаараар хайж, шаардлагатай мэдээллүүдийг ашиглах, тээврийн хэрэгслийг улсын дугаар, арлын дугаараар хайх боломжийг бүрдүүлж, хууль тогтоомж, ЦБҮАЖ /код/, гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага, мэдээлэлтэй танилцах, Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан “Гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн бүртгэлийн болон статистикийн мэдээ боловсруулах” програм хангамжид нэмэлт засвар, өөрчлөлтүүдийг 2017 онд оруулсан байна<sup>7</sup>.


**Зөрчил бүртгэх камерын системийг ашиглах:** Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “5.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах чиглэлээр: 5.4.9-д Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбайг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулах” ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган хэрэгжүүлж байна.

Нийслэлийн хэмжээнд нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гудамж талбайд хяналт тавих чиглэлээр 2010 оноос эхлэн улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээлээр нийслэл хот, алслагдсан 3 дүүргийн нутаг дэвсгэрт нийт 1222 хяналтын камертай 18 төрлийн бие даасан теле хяналтын системүүдийг суурилуулж эхэлж байсан бол 2017 оны байдлаар 1567 камерыг суурилуулан ашиглаж байна. /Камер суурилуулсан газар, байршил, тоог дараах зургаар харуулав./

Зураг 1. Камер суурилуулсан газар,

<sup>7</sup> Нийслэлийн цагдаагийн үйл ажиллагааны үндсэн тайлан. 2017. <http://www.ub.police.gov.mn> (Хандалт: 2018.02.10)

<sup>6</sup> Цагдаагийн албаны тухай хууль. УБ., 2017. <http://www.legalinfo.mn/law/details/12469> (Хандалт: 2018.01.10)



Мөн орон нутаг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гудамж талбай, авто замын хөдөлгөөнд хяналт тавих зорилгоор дараах 3 төрлийн нийт 1120 ширхэг теле хяналтын системүүдийг суурилуулан ашиглаж байна. Үүнд:

1. Автомашины улсын дугаар таних камер /LPR/
2. Хөдөлгөөнт камер /PTZ/
3. Хөдөлгөөнгүй камер /FXD/ зэрэг болно.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлын 2013 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 80 тоот тогтоолоор нийслэлийн хэмжээнд замын хөдөлгөөний зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор ажиллаж байгаа “Зам, тээврийн хяналтын оновчтой тогтолцоо”-г /зөрчил бүртгэх камерын систем/ ашиглан замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн зөрчлийг илрүүлэх, торгууль ногдуулах, торгуулийн мэдэгдэх хуудсыг тээврийн хэрэгслийн бүртгэлийн хаягаар хүргэх, төлбөр барагдуулах үйл ажиллагааг зохицуулахаар тогтоосон. Үүний дагуу Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас Замын хөдөлгөөний хяналтын камераар илрүүлсэн зөрчилд хариуцлага тооцох журмыг баталснаар 2013 оноос эхлэн замын хөдөлгөөний хяналтын камераар илэрсэн зөрчилд хариуцлага тооцох болсон. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчин иргэдийн оролцоо сэдэвт “камержуулалт-2”

болзолт уралдааныг 2018 оны 4 дүгээр сарын 1 - 6 сарын 1-ний хооронд зохион явуулах гэж байгаа нь цаг үеэ олсон зөв шийдэл билээ.

Замын хөдөлгөөний хяналтын камер нь автоматжуулсан системтэй учир тээврийн хэрэгслийг аль замд, хэзээ, хэдэн км цагийн хурдтай орсныг болон аль уулзварт хэдэн цагт улаан гэрлээр нэвтэрснийг зураг болон бичлэгээр баталгаажуулан гаргадаг.

**“Цахим зураглал” програм хангамжийг ашиглах:** Улаанбаатар хотын цагдаагийн газар нь Мэдээллийн технологи, холбооны газартай хамтран 2015 оноос газар зүйн мэдээллийн системийг цагдаагийн байгууллагад нэвтрүүлэх чиглэлээр судалж, гэмт хэргийн цахим зураглал боловсруулан, цагдаагийн байгууллагын мэдээллийн санд гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл бүртгэхэд үйлдэгдсэн газрын уртраг, өргөргийн мэдээлэл харагддаг байхаар нэвтрүүлсэн.

Цагдаагийн байгууллагад орон зайн мэдээллийн дэд бүтэц бий болгохоор Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газар, Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Газрын харилцаа геодези, зураг зүйн газар, Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн зэрэг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудад хүсэлт гарган засаг, захиргааны нэгж, байгаль орчин, авто зам, аймаг сумдын байршлын



мэдээллийг авч цагдаагийн байгууллагын хэмжээнд ашиглаж болохуйц нэгдсэн сан бүрдүүлсэн.

Дээрх мэдээллийн санг ашиглан АНУ-ын ESRI компани Монгол улсын газрын зургийг өдөр, шөнө болон хиймэл дагуулын гэсэн

сонголттойгоор боловсруулж цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэг болон өргөдөл гомдлын мэдээллийн сантай холболт хийснээр гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг газрын зурагт тэмдэглэн харуулсан шинэлэг технологийн шийдэл болсон.



2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс Улаанбаатар хотын цагдаагийн газрын харьяа дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд туршилтын хугацаагаар нэвтрүүлэн ашиглаж байна.

Гэмт хэрэг, зөрчлийн цахим зураглалын систем нь цагдаагийн байгууллагын дотоод сүлжээнд ашиглагдах бөгөөд алба хаагч өөрт олгогдсон эрхийн хүрээнд нэвтрэх боломжтой бөгөөд гэмт хэрэг, зөрчлийг үйлдэгдсэн газар, огноо, Эрүүгийн хуулийн зүйл заалт, үйлдэгдсэн өдөр, цаг, авсан арга хэмжээ зэргээр сонголт хийж судалгаа дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлсэн.

АНУ-ын ESRI компанийн бүтээгдэхүүнийг бусад орны хууль сахиулах байгууллага өргөнөөр хэрэглэж байгаа бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр бодлого боловсруулах, хүч, техник хэрэгслийг оновчтой хуваарилах зэрэгт ашиглаж байна.

Уг бүтээгдэхүүнийг Монгол улсад “Мон-

Мэп” ХХК албан ёсны эрхтэйгээр борлуулдаг бөгөөд төлбөр төлөхгүйгээр туршилтын лицензийг түр хугацаагаар авч дээрх цахим зураглалын системийг боловсруулсан. Цагдаагийн ерөнхий газраас гэмт хэрэг, зөрчлийн цахим зураглалын лицензийн зардал шийдвэрлүүлэх талаар Улаанбаатар хотын удирдлагуудад хүсэлт гаргасны дагуу Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2016 оны 09 сарын 06-ны өдрийн 44 тоот захирамжаар “Гэмт хэргийн орон зайн мэдээллийн системийн лиценз” худалдаж авах 260,000,000 төгрөгний зардлыг шийдвэрлэж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

**Зарим гадаадын орнуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах ажилд орчин үеийн дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж ашиглаж буй туршлагаас дурдвал:**

Өнөөдөр дэлхийн өндөр хөгжилтэй



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ САХИУЛАХУЙ



улс оронд нийгмийн хэв журмыг хангах, нийтийг хамарсан арга хэмжээ, шашин, урлаг, соёлын тоглолт, спортын уралдаан тэмцээн, гадаадын зочин төлөөлөгчийн хамгаалалтыг хууль сахиулах байгууллагаас зохион байгуулахдаа иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангахуйц төрөл бүрийн арга, хэрэгслийг ашиглах болсон.

Манай улсын цагдаагийн байгууллага нь дэлхийн зарим улс орны цагдаагийн байгууллагад ашиглаж байгаа дэвшилтэт техник хэрэгсэл, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх замаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд таслан зогсоох боломжтой юм. Тиймээс судалгааныхаа энэ хэсэгт нийгмийн хэв журам хамгаалах ажилд орчин үеийн дэвшилтэт техник, хэрэгсэл ашиглаж буй гадаад орнуудын туршлагыг харьцуулан судлахыг хичээсэн болно.

Бидний судалсан гадаадын орнуудад дараах техник, тоног төхөөрөмжийг нийгмийн хэв журам хамгаалах ажилд түлхүү ашиглаж байгаа нь харагдсан юм. Үүнд:

- Дрон буюу нисгэгчгүй онгоц;
- Автожир буюу бага оврын нисдэг тэрэг;
- Хурдны хяналтын камер;
- Иргэний болон бусад бичиг баримтыг унших төхөөрөмжийн талаар;
- Усан хөөрөгт автомашин;
- Хурд хэмжигч;
- Тээврийн хэрэгслийн улсын дугаар илрүүлэгч зөөврийн төхөөрөмж;
- Зөөврийн принтер;
- Аминд үл хүрэх зэвсэг;
- Биедээ зүүдэг дүрс бичлэгийн төхөөрөмж;
- Хамгаалалтын нүдний шил;
- Зүүж болдог компьютер;
- Хамгаалалтын дуулга (араг ясны хэлбэртэй) гэх мэт орчин үеийн тоног төхөөрөмжийг ашиглаж байна.

Бид дээрх техник, тоног төхөөрөмжүүдийн зарим хэрэглээ, хүчин чадал, зориулалт зэргийг судлан үзэж, гадаадын орнуудад хэрэглэгдэж буй туршлага, хамрах хүрээ, үр дүн зэргийг харьцуулан үзсэн юм.

Нисгэгчгүй онгоцыг дэлхийн 50 орчим улсад үйлдвэрлэж байна. БНХАУ, АНУ, Канад, Израйл, Ирак зэрэг улсууд маш идэвхтэй энэ талаар судалж, хөгжүүлж, үйлдвэрлэл, технологио улам бүр шинэчилж

байдаг. Зарим улс орны цагдаагийн байгууллага нисгэгчгүй онгоцыг үйл ажиллагаандаа ашиглаад 10 орчим жил болж байна. Тухайлбал,

**ХБНГУ:** Нийтийн эзэмшлийн гудамж талбай, хана, төмөр замын буудал зэрэг газарт шүршдэг өнгийн будгаар зураг зурах нь гэмт хэрэгт тооцогддог бөгөөд жил бүр 10 сая орчим ам доллар зарцуулж буцааж будаж цэвэрлэдэг гэсэн тооцоо бий. Ингээд 2013 онд нэг бүр нь 78.600 ам долларын үнэтэй, 145 метрийн тойргийг хянах хүчин чадалтай, дулаан мэдрэгч камер суурилуулсан нисгэгчгүй онгоцыг дээрх гэмт хэрэг ихээр үйлдэгддэг газруудад хөөргөж туршиж эхэлсэн. Харамсалтай нь Германы Хууль бусаар мөрдөн мөшгөх тухай хуульд зааснаар нисгэгчгүй онгоц нь хувь хүний нууцад зөвшөөрөлгүй халдаж байна гэсэн үндэслэлээр туршилтыг түр зогсоосон.

**АНУ:** Нисгэгчгүй онгоцыг цэргийн зориулалтаар ашиглаад удаж байгаа боловч цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд 2011 оноос эхэлж хэрэглэж эхэлсэн. Учир нь нисгэгчгүй онгоцноос авч байгаа мэдээлэл нь хувь хүний нууцтай холбоотой хэмээн Үндсэн хуулийн хүний эрхтэй холбоотой 3-5 дугаар заалтуудтай зөрчилддөг.

Гэвч Хойд Дакато муж анх удаа нисгэгчгүй онгоцыг цагдаагийн байгууллагадаа ашиглахыг зөвшөөрсөн. 1989 онд дээд шүүхээс цагдаагийн байгууллага нийтийн агаарын орон зайд ажиглалт хийх нь иргэний хувийн нууцад халдаагүй гэсэн шийдвэрийг гаргасныг иш болгон (аль ч шатны шүүхийн шийдвэр нь хуультай ижил үйлчилдэг) зарим муж өөрсдийн хууль тогтоомжоо өөрчилж байгаа юм байна. Жишээлбэл, 2014 онд Калифорн мужийн Сенатаас хууль сахиулах болон бусад төрийн байгууллага нисгэгчгүй онгоцыг үйл ажиллагаандаа ашиглаж болно, гэхдээ нэн яаралтайгаас бусад тохиолдолд заавал шүүхээс зөвшөөрөл авч байхаар хууль баталсан.

**БНХАУ:** Тус улсын аймаг, хотуудын цагдаагийн газрууд харилцан адилгүй олон төрөл, загварын нисгэгчгүй онгоцыг ашиглаж байна. Мөн ОХУ-ын замын цагдаагийн албанд ашигладаг. Жишээ нь: Үзэгдэх орчин хязгаарлагдмал үед төхөөрөмжийг дээш хөөргөж замын хөдөлгөөний дүрмийг зөрчиж буй эсэхийг хянана. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот нь гурван сая хүн амтай бөгөөд гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх хяналтын камерын системийг суурилуулснаар гэмт

хэрэг, зөрчил 30 хувиар буурч, илрүүлэлт 17 хувиар өссөн байна. Түүнчлэн энэхүү камерын хяналын системийг ажиллуулж эхэлснээс хойш 200 хоногийн хугацаанд ӨМӨЗО-ны цагдаагийн байгууллагад нэг ч гэмт хэрэг, зөрчлийн дуудлага ирээгүйг Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимийн дарга Ма Мин онцолсон юм<sup>8</sup>.

Мөн тус улсын цагдаагийн байгууллага өдөр тутмын үйл ажиллагаандаа ID ID, IDC-V, иргэний болон жолооны үнэмлэхийг унших /сканер/төхөөрөмж, нэгдсэн удирдлага, хяналтын систем буюу (Secure event Management system (SEMS)) нь бүрэн уялдаа холбоо бүхий бүртгэл, шалгалт, итгэмжлэл, нэвтрэх эрхийн систем юм.

**ОХУ:** 2011 оны хоёр дугаар сарын 7-нд батлагдан одоо хэрэгжиж буй “Цагдаагийн байгууллагын тухай” хуульд орчин үеийн техникийн шинжлэх ухааны ололт амжилт ба шинэ төрлийн техник технологи болон мэдээллийн системийг ашиглах нь тус байгууллагын үндсэн үйл ажиллагааны томоохон чухал хэсэг хэмээн оруулж өгснөөр тэдгээрийг үйл ажиллагаандаа өргөнөөр нэвтрүүлэх болсон.

ОХУ-нь үйлдэгдэж байгаа бүх гэмт хэргийн статистик мэдээллийг 2012 оноос “Единый отчет преступности” гэсэн маягаар гаргадаг ба үүнийг цахимжуулж ОХУ-ын УЕП-ын дэргэдэх судалгаа мэдээллийн үндэсний төв дээр төвлөрүүлж байна.

2011 оны 03 дугаар сарын 1-нд “Мэдээлэл технологийн ба мэдээллийн аюулгүй байдлын хэлтсүүдийн үйл ажиллагаанд орчин үеийн IT-технологийг нэвтрүүлэх тухай” ОХУ-ын ерөнхийлөгч зарлиг гаргаж ОХУ-ын нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг илрүүлэх ажиллагаанд ихээхэн өөрчлөлтийг авчрах болов.Одоогийн байдлаар “Аюулгүй хот” төслийн хүрээнд 747 хот сууринд 185,3 мянган видео камер суулгаад байна. Тэдэн дундаас хүний хүний царай таних чадвартай камерийг Дагестан, Краснодар, Татарстан, Мордов, Самар, Рязань, Тульск, Калининград, Санк-Петербург, Москва гэх мэт хотуудад суурилуулаад байгаа ба тэдгээр нь эрхн сурвалжлагдаж буй этгээдийг хайхад ихээхэн үр нөлөө үзүүлж байна<sup>9</sup>. Мөн хиймэл дагуулын тусламжтай

<sup>8</sup> Хууль зүй, дотоод хэргийн яамны албан ёсны сайт: <http://mojha.gov.mn> (Хандалт: 2018.01.10)

<sup>9</sup> <http://www.apkbg.ru/> Аппаратно-программный комплекс «Безопасный город» (Хандалт: 2018.01.10)

албан үүргээ гүйцэтгэж байгаа машин техник, аврах бүлгийн байршлыг GPS –р тогтоон тэдгээр хяналт тавьж удирдлагаар ханган ажиллаж байна.

Нийслэл хотын орон сууц, гэр хорооллын гудамж, талбайг камержуулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран ажиллаж байгаа нь гэмт хэргийн гаралтыг бууруулах, гарсан гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэхэд чухал түлхэц болж байна.

### Дүгнэлт

Эрх зүйт төр, иргэний нийгмийг цогцлоон хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон тунхагласан Монгол Улс маань эрх зүйн шинэтгэлийг тасралтгүй хийсээр байна. Энэхүү шинэтгэлд дэвшилттэй тал байгаа хэдий ч хэрэгжүүлэх механизмын бүрдэл хараахан сайн бус, техник технологийн хөгжлийн хоцронгүй байдал зэргээс шалтгаалан шинэтгэлийн үр нөлөөг төдийлөн сайн хүртэж чадахгүй байна гэж хэлж болно.

Цагдаагийн байгууллага нь цаг үетэйгээ нийцэн техник технологийн шинэтгэлүүдийг хийж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэх болсон. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах, үйлдэгдсэн гэмт хэргийг хурдан шуурхай илрүүлэх, таслан зогсоох, гэмт хэргийн статистик мэдээллийг цахим хэлбэрт оруулж бүртгэлжүүлэх, түүндээ дүгнэлт шинжилгээ хийх зэрэгт техник технологи ашиглах нь ихээхэн үр дүнгээ өгч байгаагаас дүгнэн хэлэхэд цаашид энэ ажлыг нэмэгдүүлэн үр дүнтэй ажиллах нь зүй ёсны шаардлага болоод байгаа билээ.

### Санал

Нийгмийн хэв журам хамгаалах ажилд орчин үеийн техник, технологийг ашиглах асуудлыг боловсронгуй болгоход төрийн бодлого, зохицуулалт, өөрөөр хэлбэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, улс, ард иргэдийн өмч хөрөнгийг хамгаалах зэрэг олон талт үйл ажиллагаа зайлшгүй төлөвлөж явуулах шаардлага



тулгараад байна. Үүнд:

Техник технологид тулгуурлан эргүүл, харуул, хамгаалалтыг үр дүнтэй зохион байгуулах;

Камержуулалт (орон сууц, гэр хороолол болон авто машины хар хайрцаг);

Орчин үед хүн бүр гар утас интернет байгаа тул цагдаагийн байгууллагын аппликейшн бүтээж түүгээр дамжуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагаагаа ард иргэдэд тайлагнаж, мэдээ, мэдээлэл, эрэн сурвалжилж буй эд зүйл амьтан, хүнийг зураг болон дүрс бичлэгээр харуулах, гэмт хэргийн талаар төлбөртэй мэдээ, мэдээллийг цуглуулах гэх мэт;

Дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн жижүүр дээр Улаанбаатар хотын цогц 3D дүрслэл бүхий программ суулгах;

Цагдаагийн байгууллагын газар, хэлтсүүд дээр электрон буудлагын тир суурилуулахад шаардлагатай эдийн засгийн тооцоог гарган хэрэгжүүлэх;

ХСИС-ийн оюутнуудад зориулсан техник технологийн өндөр түвшний виртуал кабинет бий болгох;

Гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий хуулийн бусад байгууллагын ажилтнууд, энэ чиглэлээр судалгаа хийж байгаа эрдэмтэн, судлаачдын дэвшүүлж буй санал санаачилгыг практикт турших зэрэг нь чухал байгаа билээ.

### Эх сурвалжийн жагсаалт

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль. 1997. (Төрийн мэдээлэл эмхэтгэл №1). 1998.

Нийслэлийн цагдаагийн үйл ажиллагааны үндсэн тайлан. 2017. <http://www.ub.police.gov.mn> (Хандалт: 2018.01.10)

Цагдаагийн албаны тухай хууль. УБ., 2017. <http://www.legalinfo.mn/law/details/12469> (Хандалт: 2018.01.10)

Нийслэлийн цагдаагийн үйл ажиллагааны үндсэн тайлан. 2017. <http://www.ub.police.gov.mn> (Хандалт: 2018.01.10)

Ч.Нямсүрэн. Эрх зүй, төрийн ерөнхий онол. УБ., 2004.

Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудас: <http://mojha.gov.mn> (Хандалт: 2018.01.10)

Аппаратно-программный комплекс «Безопасный город» <http://www.apkbg.ru/> (Хандалт: 2018.01.10)

## МАЛЫН ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛД ЧИП АШИГЛАХ БОЛОМЖ

OPPORTUNITIES TO USE CHIP FOR FIGHTING CRIME AND PREVENT OF THEFT LIVESTOCK

### Б.ДАЯДАН-ЭРМЭД

ХСИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хил судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, дэслэгч

### DAYDAN-ERMED B.

Lieutenant, Researcher at the Border Studies Center, Scientific Research Institute, LEU

### Б.ГАНЗАГАС

ХСИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хууль сахиулахуйн инновацийн төвийн эрдэм шинжилгээний ажилтан, дэд ахлагч

### GANZAGAS B.

Junior sergeant, Researcher at the Law Enforcement innovation Center, Scientific Research institute, LEU

✉ [daydanermed.b@leu.gov.mn](mailto:daydanermed.b@leu.gov.mn)

**Товч агуулга:** Уг илтгэлд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын онцлог, энэ чиглэлд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар болон тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлохын зэрэгцээ алдуул малыг эрэн сурвалжлах, тэдгээрийн байршлыг тогтоох, нэгдсэн бүртгэлийн сан бүрдүүлэх ажиллагаанд шинжлэх ухааны ололт амжилтын нэг болох бүртгэлийн чип ашиглах боломжийн талаар авч үзсэн болно.

**Abstract:** The report identifies opportunities to use for one of the successes science operation to provide of complex registration, investigating lost livestock and determining their location. Along with to determine and solve problems and ways of exception works which fighting crime and prevent of theft livestock.

**Түлхүүр үгс:** бүртгэлийн сан, малыг дуу дүрсээр шууд дамжуулах, хүлээн авч үзэх систем, малыг эрж олох систем.

**Keywords:** registration database, system of direct transmission of voice and video of livestock, system of acceptance, system of search for livestock.

Судалгаанаас харахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн дотроос хулгайн гэмт хэрэг нийт бүртгэгдсэн хэргийн 60 гаруй хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 1,8 хувийг мал хулгайлах гэмт хэрэг бүрдүүлж байна. Хэдийгээр малын хулгайн гэмт хэрэг бага мэт харагдаж байгаа боловч хулгайд алдсан малаа мэдээлээгүй байдал амьдралд ихээхэн байдгаас дээрх тоон үзүүлэлт бага байна. Иймд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлд шинжлэх ухаан, техник технологийн дэвшилтэт аргыг хэрэглэх шаардлага зүй ёсоор тулгараад байна. Түүхийн эх сурвалжид дурдсанаар Хүннү гүрний үед хэргийн хэлбэрээс хамааран гэм буруутай этгээдэд өмчлөх эрхийг хасах, бэрээдэх, цаазаар авах зэрэг ял шийтгэлийг оноодог байжээ. Мөн Түрэг үеийн хуулиар чөдөртэй мориноос өөр эд зүйл хулгайлсан тохиолдолд учирсан хохирлыг 10 дахин нугалж төлүүлдэг байсан бол Киданы үед хулгай хийсэн хүнийг цаазаар авах,

төрсөн эцгийнх нь гавалыг бүх насаар нь хүзүүнд нь зүүх зэргээр цээрлүүлдэг байв. Үүнээс харахад манай орны хувьд хулгайн гэмт хэрэг, түүний дотроос малын хулгайн гэмт хэрэгтэй хатуу тэмцэхийн зэрэгцээ, урьдчилан сэргийлсээр ирсэн уламжлалтай юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 5-р зүйлийн 5 дахь хэсэгт: “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна”<sup>1</sup> гэж заасан.

Өнөөдөр малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх талаар төр, засаг, олон нийтийн зүгээс багагүй анхаарч байна. Тухайлбал, энэ чиглэлд эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор олон төрлийн хууль, эрх зүйн актуудыг боловсруулан мөрдөж байна. Эдгээрээс “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 5 хэсэг.







тухай хууль” /шинэчилсэн найруулга/, “Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль” болон ЦЕГ-ын болон ХЦУГ-ын даргын хамтран баталсан “Хамтран ажиллах журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хүнс хөдөө аж ахуйн сайдын хамтарсан тушаалаар баталсан “Алдуул мал бүртгэх, мэдээлэх журам”, “Монгол мал” үндэсний хөтөлбөр зэргийг онцолж болох юм.

2002 онд баталсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлд заасны дагуу мал хулгайлах гэмт хэргийг “Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг”<sup>2</sup> гэсэн ангилалд нэгтгэсэн байсныг 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 17.12 дугаар зүйлд “Мал хулгайлах”<sup>3</sup> гэж багтааж гэмт хэргийг тусгайлан зүйлчилсэн нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд ахиц гаргах зохицуулалт болсон гэж судлаачид үздэг.

Хэдийгээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлд дэвшилттэй талууд байгаа ч, энэ төрлийн гэмт хэргийн тоо буурахгүй байна. Тухайлбал, сүүлийн гурван жилд үйлдэгдсэн малын хулгайн гэмт хэргийн үзүүлэлтийг бүсчилсэн байдлаар харьцуулж үзэхэд, уг гэмт хэргийн тоо төдийлөн тогтвортой бус байх бөгөөд энэ нь цаашид уг төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлд тодорхой арга хэмжээ авч, хэрэгжүүлэх шаардлагатай болохыг гэрчилж байна (Хүснэгт 1).

Он Бүс нутаг	2015	2016	2017
Баруун бүс	150	109	139
Хангайн бүс	369	256	279
Төвийн бүс	327	203	247
Зүүн бүс	225	123	155
Улаанбаатар	108	113	81
Нийт	1,180	805	901

Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх болон урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулахын тулд, юуны өмнө түүний шалтгаан нөхцөлийг бодитой тодорхойлсон байх ёстой. Үүнтэй уялдуулан энэ чиглэлд тулгамдсан асуудлыг тодорхойлж, тэдгээрийг оновчтой шийдвэрлэх арга замыг боловсруулах асуудал чухал байгаа. Тулгамдсан асуудлуудад дүгнэлт хийсний үндсэн дээр урьдчилан сэргийлэх чиглэлээр

<sup>2</sup> Эрүүгийн хууль 145 дугаар зүйл. 2002.

<sup>3</sup> Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ 17.12 дугаар зүйл. 2015.

дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж бид үзэж байна. Үүнд:

- мах болон малын гаралтай бусад түүхий эдийг худалдан авах, зарж борлуулах үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтын нэгдсэн тогтолцоонд оруулах;

- энэ чиглэлд эрдэмтэд, судлаачдын анхаарлыг хандуулах эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг практикт бодитой нэвтрүүлэх арга замыг эрэлхийлэх;

- сургалт, эрдэм шинжилгээ, практикийн уялдаа холбоог бэхжүүлэх;

- энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх;

- малын хулгайтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд орчин үеийн шинжлэх ухааны дэвшилтэд арга, аргачлал, технологийг нэвтрүүлэх гэх мэт.

Бид малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга замын нэг нь малд “чип” суулгах замаар бүртгэл, хяналтын нэгдсэн системд шилжүүлэх явдал гэж үзэж байна.

GPS (Global Positioning System)-ийн хувьд өнгөрсөн зууны 70-аад оны сүүл үед бий болсон бөгөөд гол санаачлагч орон нь АНУ юм. Энэхүү систем нь өөр хоорондоо 120 градусын зөрүүтэй 3 өөр орбитод байрлах бөгөөд тэдгээр нь тус бүртээ 8, нийтдээ 24 хиймэл дагуулаас бүрдэнэ. Хиймэл дагуулын хувьд дэлхий орчмын тойрог замд, далайн түвшнээс дээш 20350 км өндөрт байрладаг. Өнөөдрийн байдлаар энэхүү GPS системтэй зарчмын хувьд төстэй, ОХУ-ын GLONASS, БНХАУ-ын BAIDOU хэмээх байр зүйн системүүд бий болсон. Тэгвэл эдгээр төхөөрөмжийг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглах боломжтой эсэхийг авч үзье. Юуны өмнө GPS хэмээх байршил тодорхойлох төхөөрөмжийг бүртгэлийн чиптэй адилтган ойлгож болохгүй. Учир нь эдгээр төхөөрөмжийн ажиллах зарчим, зориулалт, чиг үүрэг харилцан адилгүй юм. Өргөн уудам нутагтай манай орны хувьд алдуул малыг эрж хайх, тэдгээрийн байршлыг хоёр ижил цэгийн байршлыг өөр хооронд нь харьцуулан тодорхойлох замаар тогтоох нь илүү үр дүнтэй юм. Энэхүү аргын гол зарчмыг дараах байдлаар тайлбарлаж болно. Дээрх цэгүүдийн нэг нь мал байх бөгөөд энэ зорилгоор уг малд тусгайлж бэлтгэсэн хүзүүвч зүүнэ. Нөгөөх цэг нь малын эзэн байх бөгөөд түүний мэдэлд хөдөлгөөнт буюу үүрэн зориулалтын цахим төхөөрөмж

байна. Цэг хоорондын зайнаас үл хамааран малын байршлыг сансарын хиймэл дагуулын тусламжтайгаар тодорхойлох боломжтой.



Зураг 1. Малын байршил тодорхойлохын тулд GPS төхөөрөмжийн ажиллах зарчим

Малчны мэдэлд байгаа үүрэн төхөөрөмжийн дэлгэц дээр малын байршлын зүг чиг болон зай зэргийн талаарх мэдээлэл өндөр нарийвчлалтайгаар өгөгдөнө.



Зураг 2. Гар төхөөрөмж дээр харагдах дүрс


Малын хүзүүнд байрлуулсан болон малчинд байгаа гар төхөөрөмжийг олон удаагийн хэрэглээтэй зориулалтын тэжээлээр цэнэглэнэ. Бүртгэлийн нэгдсэн сангийн хувьд юуны өмнө радио электрон технологийн аргад суурилсан байх шаардлагатай. Манай орны хувьд мал бүртгэх зорилгоор олон аргыг туршиж үзсэн хэдий ч өнөөг хүртэл төдийлөн үр дүнгээ өгөхгүй байна (Зураг 3). Иймд өнөөдөр энэ чиглэлд орчин үеийн техник, технологийг түлхүү ашиглах асуудал чухалд тооцогдож байна.



Зураг 3. Малыг бүртгэхийн тулд гадаргуу дээрээ тоо бүхий тэмдэгтэй хуванцар ялтсыг малын чихэнд зүүх зориулалттай зүйл. Уг арга нь өнөөгийн нөхцөлд хоцрогдсонд тооцогдож байна

Дараагийн арга нь радио электрон технологид суурилсан RFID (Radio Frequency Identification) буюу "бүртгэлийн чип" бөгөөд уг төхөөрөмжийн үндсэн үүрэг нь малыг бүртгэхэд зориулагдсан байна. Гол зарчим нь иргэний үнэмлэхний нэгэн адил мал тус бүрт үнэмлэх олгоно гэсэн үг юм. Бүртгэлийн чип нь төрөл бүрийн хэлбэр, хэмжээ, хэв маягтай байх бөгөөд бүртгэлтийн объектын онцлогоос хамааран өөр өөр радио долгион дээр ажиллана. Малыг бүртгэхийн тулд дараах төрлийн чипийг ашиглах боломжтой (Зураг 4.5).

Нэгдүгээрт, малын арьсанд ердийн тариурын аргаар суурилуулах зориулалттай чип.



Зураг 4. Мэдрэгчтэй чип




МОНГОЛЫН ХУУЛЬ САХИУЛАХУЙ



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ САХИУЛАХ  
ЯРИЙ АЖИЛЛАГАА  
МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ САХИУЛАХ  
ЯРИЙ АЖИЛЛАГАА



Зураг 5. Ердийн тариур



Зураг 6. Малын арьсанд тариурын аргаар байрлуулах чип

Хоёрдугаарт, малын чихэнд зүүж байрлуулах зориулалттай чип. Үүнийг ялтаст хэлбэрийн чиптэй андуурдаг бөгөөд энэ нь 2 см орчим тойрогтой, товч хэлбэртэй байна (Зураг 7).



Зураг 7. Ялтаст хэлбэрийн бүртгэлийн чип

Электрон төхөөрөмжид суурилсан бүртгэлийн чипний ач холбогдолыг дараах байдлаар тодорхойлж болох юм. Үүнд:

- малын удам, угшил, өөрөөр хэлбэл "ургийн бичиг"-ийн мэдээллийн сан бүрдүүлэх;
- холбогдох мэдээллийг түгээх, ашиглах ажиллагааг хялбаршуулах зэрэг болно;

Үүнээс гадна бүртгэлийн чипний тусламжтай олж авсан мэдээллийг уншиж боловсруулах шаардлага тавигдах бөгөөд үүний тулд зохих төхөөрөмжийг зохион бүтээх шаардлага тулгарч байна. Иймд чипний зориулалтаас хамааран бүртгэлийн чипээр илгээх мэдээллийг таньж унших төхөөрөмжийг бүтээх боломтой юм. Өнөөгийн нөхцөлд монгол орны ихэнх

нутагт үүрэн холбооны 3G сүлжээ нэвтрээд байгаа тул уг сүлжээний тусламжтай чипний өгөгдлийг унших төхөөрөмжийг мэдээллийн нэгдсэн сантай холбох боломжтой юм. Мөн сүлжээгүй орчинд offline горимоор ажиллах уншигч төхөөрөмжийг бүтээх замаар ашиглах боломжтой. Эдгээр төхөөрөмжийг дотоод хүч бололцоогоо ашиглан хийх бүрэн боломж харагдаж байна.

### Дүгнэлт, санал

Монгол Улсад мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа боловч өнөөг хүртэл тодорхой үр дүнд хүрээгүй байгаа тул алдуул малыг эрж хайхад үр дүнтэй арга замд малд бүртгэлийн чип суулгах арга гэж үзэж байгаа. Бүртгэлийн чипийг үүрэн холбооны 3G сүлжээг ашиглан нэвтрүүлэх бүрэн боломжтой бөгөөд уг төхөөрөмжийг өөрийн орны нөхцөлд нийцүүлэн, дотоод нөөц бололцоондоо тулгуурлан, хямд өртгөөр бүтээж, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлд ашиглах боломжтой гэж үзсэн болно.

### Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль /Төрийн мэдээлэл №1. УБ., 1992.
2. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. 2015.
3. Статистик мэдээллийн нэгдсэн сан. [www.1212.mn](http://www.1212.mn)
4. С.Цэрэнсамбуу. "Мал хулгайлах гэмт хэргийн криминологийн шинж ба урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох нь". УБ., 2011.
5. Г.Болор-Эрдэнэ. "Мал хулгайлах гэмт хэргийг нотлох ажиллагаа". УБ., 2016.

**МОНГОЛЫН ЗАРИМ ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН ОЮУТНУУДЫН СУРАЛЦАХ  
ХЭВ МАЯГИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА  
(ХСИС-ИЙН СУРАЛЦАХ ХЭВ МАЯГИЙН ЖИШЭЭН ДЭЭР)**

THE COMPARISON STUDY OF LEARNING STYLE AMONG STUDENTS OF MONGOLIAN  
UNIVERSITIES (BASED ON LAW ENFORCEMENT UNIVERSITY)

**Л.ЭНХТҮШИГ**

ХСИС-ийн Эрх зүй Нийгмийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн багш, сэтгэл судлалын магистр

**ENKHTUSHIG L. (MA of Psychology)**

Psychology lecturer at Faculty of Social Science, Institute of Law and Social Science, LEU

✉ [bwtushig@gmail.com](mailto:bwtushig@gmail.com)

**Товч агуулга:** Энэхүү судалгааг хийснээр бид ирээдүйн төрийн тусгай албан хаагч болох ХСИС-ийн оюутнууд нь МУИС, МУБИС, АШУҮИС зэрэг сургуулиудын оюутнуудын суралцах хэв маягаараа ялгаатай, дутагдалтай талаа тодорхойлж, бусад сургуулийн оюутнуудын суралцах хэв маягийг ХСИС-ийн оюутнуудын суралцах хэв маягтай харьцуулан дүгнэхэд оршино.

**Abstract:** On this study, we conducted how universities students learning styles are differed from each others. Moreover, what is the core learning style of Law Enforcement University and its relation from faculties. We compared to the learning style of other universities.

**Түлхүүр үгс:** Суралцах хэв маяг, Хүртэхүйн, Хувь хүний онцлогт суурилсан хэв маяг, Когнитив хэв маяг, Мэдээлэл хүлээн авах хэв маяг.

**Keywords:** Learning style, Perceptonal, Cognitive style and Style based on personal.

**Удиртгал**

Монгол Улсын хэмжээнд 200 гаруй их, дээд сургууль, 180 мянга гаруй оюутан тус бүрийн мэргэжлээр мэдлэг эзэмшин сурч боловсорч байна. Ихэнх оюутанд нийтлэг тулгардаг асуудал суралцах явцад үүсдэг бөгөөд аливаа хичээлийг ойлгохыг хүссэн ч ойлгохгүй, үүнээс болж бухимдах, сэтгэл гутралд орох, өөрийгөө үнэлэх үнэлэмж буурах зэрэг маш олон сөрөг үр дагавар үүсдэг. Ихэнх их, дээд сургуулиуд оюутны суралцах хэв маяг буюу тэдний сонсох, бичих, туршиж үзэх зэрэг хүртэхүйн онцлогийг нь үл харгалзан сургалт явуулдаг бөгөөд энэхүү асуудал нь нэг талаас оюутан өөрийн онцлогийг, нөгөө талаас багш оюутнуудыгаа тодорхойлоогүй байгаатай холбоотой гэж бид таамаглаж байна.

Суралцаж буй оюутан нь өөрийн сурах арга барилаа тодорхойлсноор өөрийн ойлгохгүй байгаа хичээлийг өөрт тохиромжтой аргаар судлан суралцах, өөрийн дутагдал болон давуу талд үнэлэлт дүгнэлт хийх чадвартай болох юм. ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн 1-р дамжааны сонсогч Д.Өнөболд, М.Мөнхсүлд, Б.Төмөрбэх нарын бүрэлдэхүүнтэй судалгааны баг нийгмийн сэтгэл судлалын

доктор, профессор Девид Колбын суралцах хэв маягийн сорилын үзүүлэлтийг ашигласан бөгөөд судалгаандаа ХСИС, МУИС, МУБИС, АШУҮИС-ийн 1, 2, 3-р курсийн 470 гаруй оюутнуудыг хамруулсан болно.

Судалгааны зорилго: Энэхүү судалгааг хийснээр бид ирээдүйн төрийн тусгай албан хаагч болох ХСИС-ийн оюутнууд болон МУИС, МУБИС, АШУҮИС зэрэг сургуулиудын оюутнуудын суралцах хэв маягаараа ялгаатай, дутагдалтай талыг тодорхойлж бусад сургуулийн оюутнуудын суралцах хэв маягийг ХСИС-ийн оюутнуудын суралцах хэв маягтай харьцуулан дүгнэхэд оршино.

**Таамаглал**

1. Сургууль бүр өөрийн гэсэн суралцах хэв маягийн онцлогтой.
2. ХСИС-н оюутнуудын хүртэхүйн хэв маяг нь хөдөлгөөний буюу тактил хэв шинжтэй. /юмсыг туршиж суралцдаг/

**Судалгааны арга зүй**

Бид судалгаандаа Дэвид Колбын боловсруулсан “Суралцах хэв маяг”-ийн илрүүлэх тестийг ашиглаж санамсаргүй түүврээр 470 гаруй оюутан, сонсогчдыг хамруулж, тэднийг тестийн аргаар судалсан болно. Судалгааны үр дүнг аль болох



объектив болгох үүднээс тоо, статистикийн аргаар “R” программыг ашигласан.

### Судлагдсан байдал

МУБИС-ийн БоСС-ийн Боловсролын судалгаа арга зүйн тэнхимийн багш, доктор Р.Намжилдагва, Д.Баярлах нарын бичсэн “Суралцах хэв маяг оюутны сурлагын амжилтад нөлөөлөх хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлд дурдагдсанаар дэлхийн нэртэй сэтгэл судлаач эрдэмтэд суралцахуйн хэв маяг үйлийн явцад сайжирдаг, үүнд хувь хүнээс болон орчноос хамаарах зүйл багагүй байдгийг үндэслэн МУБИС-ийн 5 салбар сургуулийн хүрээнд судалгаа явуулан суралцах хэв маяг оюутны сурлагын амжилтад нөлөөлдөг гэж үзсэн байна.

### Нэг. Суралцах хэв маягийн онолын үндэс

“Суралцах нь мэдлэг туршлагын өөрчлөлтөөр бүтээгдэж буй үйл явц юм” гэж Д.Колб тодорхойлсон байдаг. Суралцах хэв маяг нь түүний үзсэнээр 4 үе шатанд хуваагдсан тойргийн үйл явцыг дагаж хөгждөг бөгөөд тэрхүү хөгжил нь мэдлэгийг туршлагын өөрчлөлтөөр бүтээх үед өрнөдөг байна.

Суралцах хэв маягийн үндсэн долоон шинж байдаг бөгөөд энэхүү судалгаанд тэдгээр шинжийг харьцуулан тэдгээрийн хүнд илрэх хамаарлыг тусгасан болно.

Тус судалгаанд суралцахуйн олон хэв маягаас Ф.Вестерийн гаргасан хэв маяг түүнчлэн Д.Колбын суралцах хэв маягийг голчлон үзэж оюутнуудын суралцах хэв маягийг тодорхойлсон.

Суралцах хэв маягийг олж авахын өмнө туршлага суралцах тойрог буюу “experiential learning style”-г цаг тутамд туулдаг. Үүнийг Д.Колб 4 үе шатад хуваасан байдаг<sup>3</sup>. Үүнд:

1) Хянуур туршлага – шинэ туршлага эсвэл нөхцөл байдалтай тулгарсан, эсвэл байсан туршлагыг дахин дүгнэх үе.

2) Шинэ туршлагыг эргэцүүлэн ажиглах – Туршлага ба ойлголтын тодорхой ач холбогдлын нийцэхгүй байдлуудыг ажиглах үе.

3) Хийсвэр концепциаци – тунгаан бодох нь шинэ санааны эхлэл эсвэл байгаа хийсвэр санаанд өөрчлөлт оруулахад хүргэдэг үе.

4) Идэвхтэй туршилт – суралцагч

дүгнэлтээ гадагш хэрэгжүүлж үр дүнгээ хардаг үе.

### 1. Хүртэхүйн хэв маягууд:

Ф.Вестерийн<sup>4</sup> (F.Vester, 1975) үзсэнээр хүний хүртэхүйн эрхтнүүд нь хүн бүрт өөрөөр хөгжсөн байдаг бөгөөд энэ хөгжил нь бага наснаас нь эхлээд тавигдсан байдаг. Эдгээр хэв маягуудыг хүн өөрөө хөгжүүлж болох бөгөөд хөгжүүлснээр сурлагын түвшинг дээшлүүлэх боломжтой хэмээн тэрээр дэвшүүлэн үзсэн байдаг. Хүртэхүйн хэв маягийг харааны буюу visual, сонсголын буюу auditory, хөдөлгөөний буюу tactile-kinesthetic гэж 3 бүлэг<sup>5</sup> хуваадаг. Харин хувь хүний онцлогт суурилсан хэв маягууд болох экстрроверт, итроверт хэв шинж нь бага насанд төлөвшдөг бөгөөд тус хэв шинжийг нь өөрчлөх боломжгүй хэмээн үзсэн байна.

Харааны (Visual) – Ийм хэв маягтай суралцагч нь ой тогтоолт сайтай, сонсож, ярихаас илүү унших, бичих даалгавар хийх дуртай байна. Тэд харсан, уншсан, зүйлээ онцгой сайн санадаг. Тиймээс ч тэдний унших, бичих чадвар илүү сайн хөгжсөн байдаг тул энэ төрлийн хичээлд амжилт үзүүлэх нь элбэг. Ийм суралцагч эмх цэгц, нарийн дэг журамд дуртай. Хэрэв багш самбар дээр дэлгэрэнгүй тайлбарлан бичвэл илүү сайн ойлгон тогтоодог. Үзүүлэн таниулах материалууд болон график, схем, диаграмм зэрэг нь ойлгоход дэм, дөхөм болдог. Сурахдаа ашигладаг хэрэглэгдэхүүн нь ном, зураг, үзүүлэн, таниулах материал, видео материал зэрэг болно.

Сонсголын (Auditory) – Ийм хэв маягтай суралцагч нь ой тогтоолт сайтай, ярих болон сонсох чадвар нь түлхүү хөгжсөн байдаг тул сонсож ойлгох дасгал, даалгаврыг амжилттай гүйцэтгэдэг. Эхийг чангаар дуудан унших, бусад хүний ярьж байгааг сонсох, хүмүүстэй харилцах дуртай, цээжлэх ой тогтоолт маш сайтай, аман даалгаврыг төвөггүй биелүүлдэг, гадны дуу чимээнд анхаарал нь амархан сарнидаг. Тэдний дуртай дасгал, даалгаврын төрөлд сонсох дасгал, харилцан яриа, ярилцлага зэрэг орно.

Хөдөлгөөний буюу тактил (Tactile-Kinesthetic) - Ийм хэв маягтай суралцагч нь ширээний ард сууж уншиж, бичих юм уу ярих даалгавар гүйцэтгэхийн оронд аль болох биеийн идэвхтэй, хөдөлгөөн шаардсан, тухайлбал, тоглоом, жүжигчилсэн тоглолт, ямар нэгэн зүйл угсарч эвлүүлэх зэрэг

<sup>1</sup> Р.Намжилдагва, Д.Баярлах. Суралцах хэв маяг оюутны сурлагын амжилтад нөлөөлөх хандлага

<sup>2</sup> Oxford, R. (2003): “Language learning styles und strategies an overview” Oxford, Cala

<sup>3</sup>Kolb D. (1984). Experiential Learning. Englewood Cliffs, New Jersey Prentice Hall

<sup>4</sup> Kolb D. (1984). Experiential Learning. Englewood Cliffs, New Jersey Prentice Hall

<sup>5</sup> Kolb D. (1981). “Learning styles and disciplinary differences”.





идэвхтэй дасгал, даалгаврыг хийх хүсэлтэй байдаг. Тиймээс ч тэдэнд багш төвтэй уламжлалт хичээлд удаан цагаар ширээний ард суух уйтгартай бөгөөд хүндрэлтэй.

Дээрх гурван хэв маягийн нэгийг нь илүү сайн эзэмшлээ гээд нөгөөг нь сайн эзэмших боломжгүй гэсэн үг биш. Хэв маягууд нь ойролцоо, ижил хэмжээнд хөгжих нь боломжтой байдаг. Харааны ба сонсголын хэв маяг нь сайн хөгжсөн хүн уншиж бичих даалгавартаа сайн бөгөөд аман даалгавар сонсож ойлгох дасгалд ч сайн болгож болно.

## 2. Хувь хүний онцлогт суурилсан хэв шинж (Сэтгэлзүйн)

Хувь хүний онцлогт суурилсан сурах хэв маягууд нь сэтгэл судлалын ухагдахуун болохын хувьд хүний онцлог шинж чанартай холбоотой тул илүү тогтвортой бөгөөд ямар ч сургалтын нөхцөл байдалд бараг өөрчлөгдөхгүй. Тиймээс ч хувь хүний онцлогийг илтгэсэн хэв шинж нь амьдралын турш тогтвортой байхын зэрэгцээ гадны хүчин зүйлийн хүчтэй нөлөөнд орсон ч үндсэн зан чанар хэвээр хадгалагддаг.

Экстрове́рт - Ийм суралцагч нь шинэ хүмүүстэй танилцах, харилцах дуртай, тиймээс ч өөрийн эргэн тойронд болж буй зүйлд анхаарлаа хандуулж байдаг. Бусадтай хамтран хичээллэх хүсэлтэй. Аливаа шийдвэрийг түргэн гаргадаг. Аз турших дуртай учир эхлээд туршин хийж үзээд дараа нь нарийвчлан ойлгох буюу шаардлагатай бол залруулга хийдэг.

Интроверт - Ийм суралцагч дуугүй, хүмүүстэй хурдан дотно болдоггүй, ганцаараа ажиллах, хичээллэх дуртай, хэрэв багаар ажиллаж байгаа тохиолдолд аль болох чимээгүйхэн сонсохыг илүүд үздэг. Тэрээр сахилга баттай, өөрийн байр сууриа мэдэхээс гадна, багшийн мэдлэг, чадвар, нэр хүндийг өндөрт өргөдөг.

Суралцагч нь экстрове́рт буюу гадагшаа чиглэсэн, интроверт буюу дотогшоо чиглэсэн хэв шинжийг тэнцүү агуулсан байна гэдэг нь тухайн суралцагч гадагш харилцах дуртай бөгөөд ганцаараа байх дуртай гэж ойлгохоос илүү багаар ажиллахдаа сайн байхын зэрэгцээ ганцаарчилсан даалгаврыг ч сайн гүйцэтгэдэг байж болно.

## 3. Когнитив хэв маяг

Когнитив хэв маяг нь дээр өгүүлсэнчлэн сэтгэл судлалаас гаралтай ухагдахуун бөгөөд энэ бүлэгт гадаад хэл сурах үйл явцад чухал үүрэгтэй хэмээн тодорхойлдог хэв маягуудыг авч үзнэ.

Зөгнөн баримжаалах хэв маяг - Зөгнөн

баримжаалах буюу интуитив хэв маягтай суралцагч нь бүтээлчээр ургуулан бодох чадвартай бөгөөд аливаа зүйлийн учир шалтгааныг олон талаас нь эргэцүүлэн бодохыг хичээдэг. Мөрөөдөмтгий, шинийг эрэлхийлдэг. Бусдаар тайлбарлуулахаас илүүтэй өөрөө олж мэдэхийг хүсдэг. Хүнтэй ярилцаж байхдаа өөрийн гэсэн олон шинэ санаа дэвшүүлж чаддагийн зэрэгцээ ч хамтрагчийнхаа дэвшүүлсэн санал, санаачилгуудыг хүлээн авах чадвартай. Мэдэхгүй байгаа зүйлээ таах, урьдчилан тааж хэлэх оролдлого хийдэг.

Хянуур буюу конкрет хэв маяг - Хянуур буюу конкрет хэв маягтай суралцагч нь нарийн зааварчилгаа, эмх цэгц, логик дэс дарааллыг илүүд үздэг. Багшийн өгч буй дасгал даалгавар эмх цэгцтэй ойлгомжтой байхад дуртай бөгөөд багшийн зааварчилгааг сайн дагадаг. Хичээлийн сэдэвтэй холбогдолгүй яриа тэдэнд хичээл ойлгоход саад болдог. Цээжлэх барилыг түлхүү ашигладаг. Өнөөдрөөр амьдрах дуртай, ирээдүйн талаар мөрөөдөх дургүй. Аливаа зүйлийг ашиглаж, хэрэглэхээсээ өмнө зааврыг нь уншдаг.

## 4. Мэдээлэл хүлээн авах хэв маяг

Ерөнхийлөн тоймлох (Global) - Сурах хэв маягтай суралцагч нь асуудлын болон эхийн ерөнхий гол утга санааг барьж авах нь хангалттай гэж үздэг тул мэдэх ёстой чухал нарийн чухал мэдээ, мэдээллийг анзааралгүй орхигдуулдаг. Харилцан ярианы аргаар буюу хүмүүстэй харилцаж байж сурах хүсэлтэй байдаг. Сонсох, ярих, дасгал даалгаврыг илүүд үздэг. Урт сунжирсан тайлбарын оронд товч энгийн хариулыг сонгох хандлагатай. Асуудлын бүдүүвч дүр зураг, ерөнхий төлөвлөлтэй ажиллах дуртай.

Нарийвчлан задлах (Analytic) - Сурах хэв маягтай суралцагч нь шинжлэх ухааны хэлийг алдаагүй бөгөөд дүрмийн дагуу сурахыг хичээдэг, нарийн зааварчилгаанд дуртай. Асуудлын нарийн жижиг зүйлд ч гэсэн анхаарлаа хандуулдаг. Ихэвчлэн бусдаас хамааралгүй, ганцаараа сурах хүсэлтэй. Өөрийн байх сууриа мэдэхээс гадна, багшийн мэдлэг чадвар, нэр хүндийг өндөрт өргөдөг. Сахилга батыг чандлан сахиж, хүмүүстэй хурдан дотно болдоггүй.

## Хоёр. Судалгааны үр дүн

Тус судалгаанд Фредерик Вестерийн суралцах хэв маягийг голчлон үзэж хэв маягийг тодорхойлох сорилыг ХСИС-ийн бүрэлдэхүүн 5 сургууль, МУИС-ийн салбар

2 сургууль, МУБИС салбар 2 сургууль, АШУҮИС тус бүрээс төлөөлөн авсан 1, 2, 3 курсийн нийт 470 гаруй оюутнаас санамсаргүй түүврээр судалж авсан судалгааны үр дүнг математик, статистикийн “R” программаар боловсруулсан болно.

АШУҮИС (ASHUUIS) – Анагаахын шинжлэх ухааны их сургууль

Хууль сахиулах их сургуулийн бүрэлдэхүүн сургууль:

- ЦС (TS) - Цагдаагийн сургууль
- ХС (HIL) - Хилийн сургууль
- ЭЗНУС (EZNUUS) - Эрх зүй нийгмийн ухааны сургууль
- ОБС (OBS) - Онцгой байдлын сургууль
- ШШГС (SHSHG) - Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль

Монгол Улсын их сургуулийн салбар сургууль:


- ХШУИС (NUM-PH) – Хэрэглээний шинжлэх ухааны их сургууль
- ШУС (NUM-N) – Шинжлэх ухааны сургууль

Монгол Улсын боловсролын их сургуулийн салбар сургууль:

- БС (MUBIS-BS) – Багшийн сургууль
- ДУТС (MUBIS-HS) – Дүрслэх урлаг, технологийн сургууль

### Диаграмм 1. Корреляци

1-р диаграмм нь корреляци буюу хоёр зүйлийн харилцан хамаарлыг харуулж байна. Диаграмм 1-ээс харахад хүний хэв маягуудын дийлэнх нь эерэг хамааралтай байгаа боловч тодорхой хэмжээний хэв маяг нь хамааралгүй буюу урвуу хамааралтай байна. Тус диаграммд нас нь бусад хэв маягуудтай сөрөг бол хамааралгүй гэх үр дүнг гаргаж байна. Жишээлбэл: Оюутнуудын нас ахих тусам харааны хэв шинж, сонсголын хэв шинж нь муу байх бол интроверт, экстревэрт хоёр нь урвуу хамааралтай байгаа нь оюутнуудын хэв шинжийн харилцан хамаарлыг харуулж байна.




### Диаграмм 2. Хүртэхүйн дундаж

Энэхүү диаграммд сургууль хоорондын хүртэхүйн хэв маягийн ялгаа, тэдний хамаарлыг харуулж байна. Жишээлбэл: Харааны болон сонсголын суралцах хэв маягийн үзүүлэлт доогуур байгаа Хилийн сургууль нь хөдөлгөөний хэв шинжээр илүү давамгайл байх зэрэг онцгой хэв шинжийг агуулж байна.




МОНГОЛ УИХААНЫ  
ХУУЛЬ САХИУЛАХУЙ




**Диagramм 3. Хувь хүний онцлогийн дундаж**

Доорх диаграммд хувь хүний онцлогт суурилсан хэв шинжийн ялгаа нь сургууль бүрт харилцан адилгүй байгааг харуулж байна. Интроверт, экстреверт нь эсрэг ойлголт тул үр дүн нь харилцан адилгүй байгааг харуулж байна.




**Диagramм 4. Когнитив хэв маягийн дундаж**

Тус диаграммд оюутнуудын зөгнөн баримжаалах буюу интуитив, хянуур буюу конкрет хэв шинжийн ялгаа сургууль бүрт хэрхэн тусч байгааг харуулж байна. Жишээлбэл, МУИС-ийн Физик электроникийн бүрэлдэхүүн сургууль нь хоёр хэв шинжид тэнцвэртэй байр суурьтай байгаа нь тэдний когнитив хэв маяг нь харьцангуй тэнцвэртэй хөгждөг гэж дүгнэж болно.




**Диagramм 5. Мэдээлэл хүлээн авах хэв маягийн дундаж**

Энэхүү диаграммд сургууль бүрийн оюутнуудын мэдээлэл хүлээн авах хэв маягийн ялгааг харуулж байна. Жишээлбэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх сургууль нь дийлэнх оюутнууд глобал буюу ерөнхийлөн тоймлох хэв маягаар мэдээллийг хүлээн авдаг байна. Харин Онцгой байдлын сургуульд нарийвчлан задлах буюу аналитик хэв шинж давамгайл болно.




### Диagramм 6. Сургууль бүрийн хүртэхүйн хэв маягийн ялгаа

Тус диаграммд судалгаанд хамрагдсан 4 сургуулийн тус бүрийн хүртэхүйн хэв маягийн дундаж оноог харуулж байна. Жишээлбэл, Монгол Улсын их сургуулийн нь харааны хэв маяг давамгайлсан мөн Ангаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь сонсголын хэв маяг давамгайлсан харин Хууль сахиулахын их сургууль нь хөдөлгөөний хэв шинжээр тус тус давамгайлж байна.



### Диagramм 7. Сургууль бүрийн хувь хүний онцлогт суурилсан дундаж дүн

Тус диаграммд сургууль бүрийн хувь хүний онцлогт суурилсан хэв шинжийн ялгааг харуулж байна. Диаграммыг харвал экстреверт хэв шинж бүхий сургууль нь интроверт хэв шинжээр сул байгаа нь урвуу хамаарал буюу сургуулиудад аль нэг хэв шинж илүү харагдаж байгаа нь харагдахгүй байна.




МОНГОЛ УЛСЫН  
ИХ СУРГУУЛЬ  
ХУУЛЬ САХИУЛАХ  
УНДЭСНИЙ  
ИХ СУРГУУЛЬ




### Диagramм 8. Сургууль бүрийн когнитив хэв маягийн ялгаа

Энэхүү диаграммд сургууль бүрийн когнитив хэв шинжийн ялгааг харуулж байна. Диаграммыг харвал МУИС нь зөгнөн баримжаалах буюу интуитив, хянуур буюу конкрет хэв шинжүүдээр давамгайлсан байна.




### Диagramм 9. Мэдээлэл хүлээн авах хэв маягийн ялгаа

Тус диаграммаар сургууль бүр хүлээн авсан мэдээллийг хэрхэн зохицуулж түүнийгээ боловсруулж буй ялгааг харуулж байна. Жишээлбэл, Оюутнуудын дийлэнх нь глобал буюу ерөнхийлөн тоймлох хэв шинжтэй байдаг бөгөөд нарийвчлан задлах хэв шинжийг харьцангуй бага хүн эзэмшиж байна.



### Диagramм 10. Сургууль бүрийн нийт дундаж

10-р диаграмм нь сургууль бүрийн хүртэхүй, хувь хүний онцлог, когнитив, мэдээлэл хүлээн авах хэв маягуудын нийт дундаж дүнгийн ялгааг харуулсан болно. Тус диаграммд аль сургууль бүр тэнцвэртэй хэв шинжтэй бус харин харьцангуй аль нэг хэв шинж нь давамгайлах үед нөгөө хэв шинжид нь эерэг эсвэл сөргөөр нөлөөлж байгааг харуулж байна. Жишээлбэл: Хувь хүний онцлог, когнитив хэв шинжид тэргүүлж буй Цагдаагийн сургууль нь бусад хэв шинжид харьцангуй тэнцвэртэй байр суурьтай байгааг харуулж байна.



### Гурав. Дүгнэлт

Хууль сахиулах их сургууль, Монгол Улсын боловсролын их сургууль, Ангаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль зэрэг их сургуулиудын оюутны хүрээнд суралцах хэв маягийг тодорхойлсон энэхүү судалгаа нь оюутан залууст эргэцүүлэл болох үүднээс дараах дүгнэлтийг хийж байна.

Оюутнуудын суралцах хэв маягийг тодорхой сорилоор тогтоож, тэдний суралцах нөхцөл болсон их, дээд сургууль бүр өөрийн эзэмшүүлж буй мэргэжил болон мэдлэгийг олгох үйл явцдаа хичээлийг өөр өөрсдийн онцлог аргад тулгуурлан явуулдаг байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд их, дээд сургуулийн оюутнууд өөрийн гэсэн нийтлэг сурах арга барилтай байгаа бөгөөд энэ нь сургууль тус бүр дээр илэрч байна. Тухайлбал Монгол улсын их сургуулийн оюутнууд харааны суралцах хэв маяг давамгайлсан байхад, Ангаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль сонсголын хэв маяг давамгайлсан, Хууль сахиулах их сургууль хөдөлгөөний суралцах хэв маяг давамгайлсан байна.

Бидний дэвшүүлсэн нэгдүгээр таамаглалын хувьд АШУУИС-ийн оюутнуудын харааны ой тогтоолт илүү давамгай байсан зэргээр сургууль тус бүрийн онцлог илэрсэн хэдий ч бие биеэсээ хүчтэй урвуу хамаарал байсангүй. Хамаарлын графикт харуулснаар судалгаанд хамрагдсан бүх их, дээд сургуулиудад илэрсэн онцлог үр дүн бол суралцах хэв маяг “нас” буюу анги дэвшихтэй огт холбоогүй нь батлагдсан. Харин хоёрдугаар таамаглалын хувьд ХСИС-ийн оюутан, сонсгогчдын суралцах хэв маяг бусад их, дээд сургуулиудаас урвуу хамааралтай байсан бөгөөд гол төлөв “Хөдөлгөөний” буюу юмсыг туршиж үзэх хандлагатай байсан нь манай сургуулийн өөрийн гэсэн хэв шинж, суралцах хэв маягтай байх гэсэн таамаглалыг баталсан.

Энэ бүхнээс үүдэн суралцаж буй оюутан өөрийн суралцах хэв маягийг тодорхойлох шаардлагатай бөгөөд үүнийг тодорхойлсноор өөрийн ойлгохгүй байгаа хичээлийг өөрт тохиромжтой аргаар судлан суралцах, өөрийн дутагдал болон давуу талд үнэлэлт дүгнэлт хийх чадвартай болох юм. Мөн сургууль бүр энэхүү судалгааны



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ САХИУЛАХ  
УЛСЫН  
ХУУЛЬ САХИУЛАХ  
УЛСЫН

ач холбогдол, давуу талыг ойлгосноор сургалтын үйл ажиллагаа зөвхөн нэг хэв шинжээр бус харин судалгааны үр дүнд суурилж сургуулийнхаа онцлогийг танин мэдсэнээр ямар төрлийн сургалт явуулбал илүү үр дүнтэй болохыг ойлгох юм.

#### Эх сурвалжийн жагсаалт

1. М.Азжаргал, Ч.Сувд-Эрдэнэ. “Сургалтад сурах хэв маягийг харгалзах нь”. УБ., 2014.
2. Р.Намжилдагва, Д.Баярлах. “Суралцах хэв маяг оюутны сурлагын амжилтад нөлөөлөх хандлага”. УБ., 2012.
3. Kolb D. (1984). *Experiential Learning*. Englewood Cliffs, New Jersey Prentice Hall
4. Oxford, R. (2003). “Language learning styles and strategies an overview” Oxford, Cala
5. Frederic Vester (2002). “Thinking, Learning, Forgetting”.
6. Kolb D. (1981). “Learning styles and disciplinary differences”.

#### Цахим хуудас:

1. McLeod, S.A. (2017). Kolb – learning learning styles. Retrieved from [www.simplypsychology.org/learning-kolb.html](http://www.simplypsychology.org/learning-kolb.html)
2. Maïke LooB (2001) LooB – types of learning? Retrieved from [www.oecd.org/education/cei/34926352.pdf](http://www.oecd.org/education/cei/34926352.pdf)

## ЦАГДААГИЙН СОЁЛ, ТҮҮНИЙГ ТОДОРХОЙЛОХ ХҮЧИН ЗҮЙЛ

## POLICE CULTURE AND ITS DEFINING FACTORS

**Л.НЯМДАВАА**

Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа  
**NYAMDAAVA L.**

Police Colonel, Head of Legal Division, Headquarter of National Police Agency of Mongolia

✉ [lnyam2009@yahoo.com](mailto:lnyam2009@yahoo.com)

**Товч агуулга:** Цагдаагийн соёлд нөлөөлдөг хүчин зүйлийг цагдаагийн байгууллагын тогтолцоо, үнэт зүйлийн баримжаа, албан хаагчийн чадварын түвшинд авч үзэж, мэргэжлийн болон нийгмийн үнэт зүйлс дээр тулгуурласан сөрөг байдлыг арилгах арга замууд нь Цагдаагийн албаны дэд соёлыг бий болгох талаар авч үзсэн.

**Abstract:** The purpose of this research is to identify the factors that influence police culture that are considered at the police system, identification of values, and employees' level of competitiveness and ways to eliminate adverse events based on professional and social values to establish the sub culture of police officers communication.

**Түлхүүр үгс:** Харилцааны соёл, цагдаагийн соёл, мэргэжлийн үнэт зүйлс.

**Keywords:** Communication culture, police culture, professional wealth.

**Удиртгал**

Цагдаагийн байгууллага нь хуулиар тогтоосон тусгай чиг үүргээ хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэд нийтийн оролцоонд түшиглэж явуулах нь үр нөлөөтэй гэдэг нь нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд энэ нь тухайн цагдаагийн байгууллагын соёл ямар түвшинд байгаагаас хамаарч харилцан адилгүй хэрэгждэг. Тиймээс цагдаагийн байгууллагын соёлыг илэрхийлэх хүчин зүйлсийг судлах, өнөөгийн байдлыг тодорхойлох зорилгоор судалгаа хийж ирснээс дурдвал, ЦЕГ, УЕП-ын дэргэдэх Мөрдөх байцаах албанаас 2007 онд “Монгол Улс дахь цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэргийн төлөв байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам”, Философи Социологи эрхийн хүрээлэнгээс 2008 онд “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн байдал, боловсронгуй болгох чиглэл”, “Максима” судалгааны төвөөс 2008 онд “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэд, алба хаагчдын дунд явуулсан судалгаа”, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2012 онд “Цагдаагийн байгууллагын 2011 оны үйл ажиллагаанд хэрэглэгчдээс өгсөн үнэлгээ” сэдвээр болон иргэдийн сэтгэл ханамжийн талаарх судалгаа, мөн цагдаагийн байгууллагын алба хаагчдын сахилга, ёс зүй, шийтгэлийн судалгааг тус тус байна.

Гэсэн хэдий ч цагдаагийн байгууллагын дэд соёл гэж юуг ойлгох, түүнд ямар хүчин зүйлүүд хамаарахыг дэлхий нийтийн чиг хандлага, судлаачдын үзэл баримтлал, цагдаагийн албаны өнөөгийн байдалтай харьцуулан дэд соёлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлон түүнийг бууруулах арга замыг эрэлхийлэх хэрэгцээ шаардлага байсаар байна.

**Цагдаагийн соёлын ойлголт, түүнийг тодорхойлох хүчин зүйл**

Хөгжилтэй орнуудын түүхэн туршлагыг харвал орчин үеийн цагдаагийн шинж нь хагас цэрэгжсэн байдлаас илүү энгийн хэлбэр лүү, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргээс иргэний үйлчилгээний чиг үүрэг рүү тэмүүлсэн хөгжлийн чиг хандлага давамгайлж байна<sup>1</sup>.

Энэ утгаараа цагдаагийн байгууллага нь дэлхийн аль ч оронд дотоодын аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах үүргийг гүйцэтгэдэг ба энэхүү үүргээ гүйцэтгэхдээ иргэд, олон нийтийн хүчинд түшиглэж<sup>2</sup>, тэдний дэмжлэгийг авч ажиллах нь зайлшгүй юм.

Түүнчлэн Цагдаагийн байгууллага нь сүүлийн үед гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх гол

<sup>1</sup> Д.Зүмбэрэлхам. “Орчин үеийн цагдаагийн байгууллагын хөгжлийн чиг хандлага” илтгэл. 2006

<sup>2</sup> А.Отгонсүх. “Цагдаа-иргэдийн харилцааны уламжлал шинэчлэл” сэдэвт магистрын дипломын ажил. УБ., 2007. 7 дахь тал.





чиглэл болсон урьдчилан сэргийлэх ажлаа идэвхжүүлж ажил үйлсээ төрийн захиргаа, хууль хяналт, төрийн бус олон нийтийн байгууллага, иргэдийн хүчин туслалцаанд түшиглэх замаар явуулж эхэлсэн нь чухал ач холбогдолтой болохыг харуулж байна<sup>3</sup>.

Цагдаагийн байгууллагаас өөрийн үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах, иргэдтэй харилцах нэг том шалгуур нь цагдаагийн байгууллагын соёл юм. Цагдаагийн байгууллагын соёл нь нийгмийн соёлын онцлогийн тусгал бөгөөд дараах хэд хэдэн шинжээр ялгаа нь харагддаг.

Нэгдүгээрт цагдаагийн тогтолцооны нөлөөлөл. Хоёр загвараар хэрэгждэг ба эхний загварын хувьд Франц, Итали, Дани гэх мэт улсуудад төрийн зүгээс цагдаагийн байгууллагын удирдлагыг төвлөрүүлэн, түүний эрх мэдлийг өргөн хүрээтэй байлгадаг. Харин АНУ-д нутгийн захиргааны байгууллагуудын тогтолцоогоор удирдлагыг сааруулж, үүрэг даалгаврыг багасгаж, хүн амтай илүү нягт холбоо тогтоодог ялгаатай загвар байна.

Хоёрдугаарт нийгмийн соёлын үнэт зүйлийн нөлөөлөл. Цагдаагийн байгууллагын соёлыг нийгмийн соёлын онцлогтой салшгүй холбоотой байдгийг нотолсон А.Джиаогийн судалгааны ажлаас тухайлан авч үзвэл нийгмийн соёлын үнэт зүйлс / үнэ цэнэ/ нь цагдаагийн үйл ажиллагааг зохион байгуулахад болон албан хаагчдын үйл хөдлөлд нөлөөлж байдгийг харуулсан. Жишээлбэл, Хятадын соёл нь ёс суртахуун дээр суурилсан Кунзийн үзэл баримтлал бөгөөд Кунз хүмүүсийн үйл ажиллагаа хуулиар тодорхойлогдох ёстой гэж үзээгүй, харин энэ улс дахь төр засгийн гүйцэтгэх үүрэг нь хууль тогтоомжид бус, ёс зүй, ёс суртахууны зарчмууд дээр тулгуурласан байна гэж үздэг. Хятадын хууль сахиулах байгууллагуудын үзэл баримтлал нь нийгмийн тэнцвэртэй байдал буюу эв нэгдлийг хадгалахад оршдог.

Америкийн хувьд хувь хүний хариуцлага, ёс зүй, бие даасан, хараат бус байдал, хувийн орон зай, эрх чөлөө зэрэг үнэт зүйлстэй байдаг. Тиймээс АНУ-д цагдаагийн үйл ажиллагааны үндсэн санаа бол хууль дээдлэх ёс ба нийгмийн гишүүдийн хувийн хариуцлага юм.

Гуравдугаарт цагдаагийн байгууллагын соёлд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлс нь мэргэжлийн онцлог болон цагдаагийн алба

<sup>3</sup> Т.Сосорбарам. "Цагдаагийн байгууллага ба төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, түүнийг боловсронгуй болгох зарим асуудал" сэдэвт магистрын дипломын ажил. УБ., 2006. 52 дахь тал.

хаагчийн мэдлэг, чадвар, дадлага туршлага, харьцааны соёл, ёс зүй, авир араншин, биеэ авч явах байдал, хайхрамжгүй байдалтай шууд холбогддог.

Мэдлэг, чадвар-Цагдаагийн алба хаагч үүргээ нэр төртэй, шударга, хуулийн хүрээнд биелүүлэхэд хамгийн гол хэрэгсэл нь түүний мэдлэг чадвар юм. Хэдий чинээ мэдлэг чадвар өндөр байна төдий чинээ асуудлыг эергээр харах, шийдвэрлэх арга замыг тодорхойлж чаддаг байх, албан үүргээ үүргээ амжилттай гүйцэтгэх ба энэ нь эргээд хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх боломжтой.

Дадлага, туршлага- Аливаа ажлын үр нөлөөтэй хэрэгжих явдал нь дадлага, туршлага бүхий алба хаагчдаар дамжин биеллээ олдог. Судалгаанаас харахад цагдаагийн алба хаагчдын талаарх гомдол саналын дийлэнх нь харьцангуй цөөн жил ажилласан алба хаагч нартай холбоотой байдгийг тэд ажлын дадлага, туршлага багатай, иргэдтэй харилцах талаар бүрэн бэлтгэгдээгүй байдагтай холбон тайлбарлаж байна.

Харьцааны соёл- Өнөөдөр цагдаагийн алба хаагчидтай холбоотой гомдол саналын магнайд тэдний харьцааны соёлтой холбоотой хэсэг тэргүүлж байгаа нь бодит үнэн юм. Иргэдээс цагдаагийн алба хаагчидтай холбоотой ирүүлж байгаа гомдол санал, тэдний гаргаж байгаа алдаа, дутагдлын ихэнх хувь нь харилцааны алдаанаас үүдэлтэй байдаг<sup>4</sup>. Мэдлэг, чадвар, дадлага туршлагыг тасралтгүй нэмэгдүүлснээр харилцаа хандлагыг өөрчлөх ухамсрыг бий болгодог.

Ёс зүй- Цагдаагийн албан хаагчийн ёс зүйн үүрэг хариуцлагыг Монгол Улсын цагдаагийн тангарагт тодорхой зааж өгсөн. Цагдаагийн тангарагт зааж өгсөн энэ үүрэг хариуцлага нь цагдаагийн алба хаагчдаас албан үүргээ мэргэжлийн өндөр түвшинд үнэнч шударгаар биелүүлж, ажил хэргийн болон хувийн өндөр зохион байгуулалт, чанд сахилга, эмх журамтай байх, хуульч шуурхай ажиллагаа, сонор сэрэмж, уйгагүй хөдөлмөр, соёлч эелдэг харилцааг өдөр тутмынхаа үйл ажиллагаанд хэрэгжүүлэхийг шаардаж байдгаараа бусдаас онцлогтой<sup>5</sup>.

Авир араншин /темперамент/- МЭӨ 4-р зууны үеэс хүний биеийн шингэн, мимик, эрхтний хэлбэрээр авир араншинг тодорхойлох оролдлого хийгдэж байсан ба 4 хэлбэрт авч үзсэн байна. Эдгээрээс

<sup>4</sup> И.Цэдэн-Иш. "Цагдаагийн алба хаагчийн ёс зүй". УБ., 2004. 80 дахь тал.

<sup>5</sup> Мөн тэнд. 48 дахь тал.





цагдаагийн албанд хамгийн тохиромжтой нь флегматикууд байдаг. Учир нь тэд бусдаасаа хариуцлага хүлээх, сурах, ажиллах чадвар сайтай, бусадтай харилцахад асуудал багатай байдгаараа давуу талтай. Тэгвэл сангвиникийн хариуцлага хүлээх чадваргүй, холерикийн цочмог уур, гэжүүд зан, меланхоликийн хэт дүнсгэр зан чанар нь цагдаагийн алба хаагчид үл нийцэх билээ. Судлаачдын үзэж байгаагаар сангвиник, флегматикийн холимог авир араншинтай хүн нь цагдаагийн албанд хамгийн нийцтэй байна.

Биеэ авч явах байдал—Судалгаагаар хүмүүс цагдааг зөвхөн гадаад байдал /дүрэмт хувцас/-аар нь л таньж мэддэг болохоо илэрхийлжээ. Энэ нь тийм ч гайхмаар үр дүн биш. Учир нь дээрх асуудал иргэдийн сонирхлыг төдийлөн татдаггүй байна. Нэгэнт гадаад төрхөөрөө иргэдэд танигдаж буй цагдаагийн алба хаагч нь өөрийн биеэ авч явах байдалд анхаарал тавих нь зүйтэй. Цагдаагийн алба хаагчийн гадаад үзэмж, зөв зохистой хувцаслалт, үг яриа, дууны өнгө гэх мэт нь иргэдийн итгэлийг төрүүлж, харилцаагаа сайжруулахад чухал болох нь илэрхий юм. Эсрэг тохиолдолд үс, сахал, хувцсандаа ч анхаарч чаддаггүй алба хаагчид иргэд итгэж хандах нь эргэлзээтэй юм.

“Хайхрамжгүй байдал”. Хайхрамжгүй чанар нь онцгой гажиг биш боловч хоосон нэрэлхүү зан, үүргээ умартах, залхуурал, тэнэглэл, алмайрал, биеэ тоолт, атаархал зэрэг олон гажуудын уршиг байдаг. Анзааргагүй, салан задгай этгээд үүргээ умартах дутагдлыг байнга давтдаг ба түүндээ дасал болж, хайнга хайхрамжгүй загнасаар, яваандаа алдаа осол гаргана. Алмай тэнэг байдал нь хүнийг байгаа орчинд нь хязгаарлаж, эргэн тойронд нь юу болж байгааг ухаарч сэхээрэхгүй, анзаарч хайхрахгүй болгон, бодол сэтгэлгээг нь царцааж, шилэн хоргоны загас адил тусгаарлана. Биеэ тоосон ихэмсэг этгээд өөрийгөө бүхнээс дээгүүр бодож, бусдаас илүү чадах мэт сагсуурч, хүмүүсийн санаа бодол, үйлдэл хөдлөлд огтын хайхрамжгүй хандана.

Эх орныхоо болон ойрынхоо хүмүүсийн хувь заяанд хайхрамжгүй ханддаг, хүмүүнлэг бүхэн өөрт нь харийн санагддаг, тийм хүнээс илүү аюултай зүйл гэж үгүй ба ойрынхоо хүмүүсийн хувь заяанд хайхрамжгүй хандана гэдэг нь хүний ёсноос гадуур, хэтэрхий хувиа хичээсэн бэртэгчийн шинж төрх. Английн нэрт зохиолч Б.Шоу

“Ойрынхоо хүмүүсийн хувьд үйлдсэн хамгийн том нүгэл нь үзэн ядалт бус, харин хайхрамжгүй байдал байдаг бөгөөд чухамхүү үүнд хүмүүнлэг бус чанар оршдог” хэмээн бичжээ. Сайн муу, сайхан муухай аль алинд нь адилхан хайхрамжгүй хандана гэдэг ёс суртахууны зэрэмдэг байдал.

Цагдаагийн албан хаагч “хайхрамжгүй байдал”-аас сэргийлэх боломжтой ба энэ нь шулуун шударга, эр зоригтой, зарчимч, энэрэнгүй зэрэг төгс зан чанаруудыг өөртөө агуулсан байх, үлгэр дуурайлал болох ёстой гэсэн агуулгаар илэрхийлэгдэнэ.

### Дүгнэлт, санал

1. Гадаад оронд цагдаагийн байгууллагын соёлыг бий болгож буй сайн жишгийг туршлага болгон цагдаагийн байгууллагын соёлыг цагдаагийн тогтолцоо, мэргэжлийн үнэт зүйлтэй холбон албан хаагчид нөлөөлөх нөлөөллийг тодорхойлж, нэвтрүүлэх шаардлагатай.

2. Цагдаагийн байгууллагын соёлд нөлөөлөх бусад хүчин зүйлийн нөлөөллийг багасгах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

3. Мэдлэг, чадварыг сайжруулах, тогтмол сургалтад хамруулах, үр дүнг тооцох;

4. Томилогдсон албан тушаалд дадлагажуулах, ажиллах хүсэл эрмэлзэл, тэмүүллийг нэмэгдүүлэх;

5. Хувь хүний зан араншинтай холбож тохирох ажилд томилох, албан тушаалын онцлогоос хамаарсан шалгуур үзүүлэлтийг бий болгох;

6. Харилцаа, хандлага, ёс зүй, биеэ авч явах байдлын шалгуур хангаагүй алба хаагчдыг албанаас чөлөөлөх хүртэл арга хэмжээ авах.

### Эх сурвалжийн жагсаалт

1. И.Цэдэн-Иш. Цагдаагийн алба хаагчийн ёс зүй. УБ., 2004. 7 дахь тал.

2. Д.Зүмбэрэлхам. “Орчин үеийн цагдаагийн байгууллагын хөгжлийн чиг хандлага” илтгэл. 2006.

3. Т.Сосорбарам. “Цагдаагийн байгууллага ба төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, түүнийг боловсронгуй болгох зарим асуудал” сэдэвт магистрын дипломын ажил. УБ., 2006.

4. А.Отгонсүх. “Цагдаа-иргэдийн харилцааны уламжлал шинэчлэл” сэдэвт магистрын дипломын ажил. УБ., 2007.

## БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ҮНДЭСНИЙ ЖЕНДАРМЫН БОЛОН ҮНДЭСНИЙ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

### ORIGIN AND DEVELOPMENT OF THE NATIONAL POLICE AND THE NATIONAL GENDARMERIE OF THE FRENCH REPUBLIC

#### Ш.БААСАНДОРЖ

ХСИС-ийн докторант, хуульч, прокурор

#### BAASANDORJ SH.

Public prosecutor, lawyer, Ph.D student of the LEU

✉ [baskashirchmaa@yahoo.fr](mailto:baskashirchmaa@yahoo.fr)

**Товч агуулга:** БНФУ-ын үндэсний жендарм, үндэсний цагдаагийн байгууллагын үүсэл, хөгжлийг тоймлон судалж, эх газрын эрх зүйн бүлийг үндэслэгч, гол төлөөлөгч тус улсын жендарм, цагдаагийн байгууллагын чиг үүрэг, мөн чанарыг түүхэн үечлэлээр авч үзэж судалгааны эргэлтэд оруулах, цаашид гүнзгийрүүлэн судлах санал дэвшүүлэхэд оршино.

**Abstract:** We have been summarized the origin and development of the National Police and the National Gendarmerie of the French Republic. The representative and founder of continental law, we take into account the role and function of the police department in the country and proposes the circulation of police science and propose a more in-depth study of researchers.

**Түлхүүр үгс:** БНФУ-ын үндэсний жендарм, үндэсний цагдаагийн байгууллагын үүсэл, хөгжил, шүүх болон цагдаагийн байгууллагын уялдаа холбоо, харилцан хамаарал, жендарм, цагдаагийн чиг үүрэг, шүүхийн мөрдөн байцаалт, цагдаагийн мөрдөн байцаалт, комиссар мөрдөн байцаагч, цагдаагийн генерал лейтенант, эрүүгийн лейтенант, цэргийн шүүх, тусгай шүүх, шүүхийн цагдаа, захиргааны цагдаагийн ялгаа, цагдаа судлал.

**Keywords:** Origin and development of the National Police and the National Gendarmerie of the French Republic, coherence and interdependence, depending on the police and the gendarmerie, judicial investigation, police investigations, commissioner-investigator, lieutenant general of police, criminal lieutenant, military justice, particular justice, criminal investigation police, administrative police, police study.

#### Удиртгал

Цагдаа (фр:police) хэмээх үг нь (фр:terminologie) хэд хэдэн нэршил, нэр томъёог тодруулж судлахад хүргэдэг. Тодруулбал, Эртний Грекийн "polis" (фр:city), "politia", "politeia", эртний франц хэлний "pollice" гэх мэт. Эртний Грекийн "Polis" нь хотын анхны суурин, буурь, хотын төв хэсэг (фр:city), хотхон, хот (фр: ville), "politeia" (фр:art de gouverner la city) нь хотыг удирдах урлаг, "pollice" (орчин үеийн франц хэлээр:gouvernement) засгийн газар гэх тус тусын утга санааг илэрхийлдэг байв. Полис хэмээх үг нь нийгмийн дэг журмыг сахиулах, нөхөн сэргээх явдлыг хангах эрх бүхий байгууллага, чиг үүрэг, дүрэм, журмын өнөөгийн нэр утгыг олж авахын тулд өмнө хотын удирдлага, менежментийн хүрээнд л хязгаарлагдаж байв. (фр:le mot s'est limité a la gestion d'une city pour acquirir son sens actuel d'organe, de rigle et de mission permettant d'assurer le maintien et

le rйtablissement de l'ordre public)<sup>1</sup>.

Хотын удирдлага, менежмент, бодлогын хүрээнд томъёологдож байсан нэр томъёо нь тодорхой цаг хугацааны явцад хот доторх дэг журмыг сахиулах байгууллагын нэр болон тогтжээ. Францад энэ л утга агуулгаар ойлгож, одоог хүрсэн бөгөөд цагдаа (фр:police)нь хот, суурин газрын дэг журмыг сахиулах, мөн тодорхой хөгжлийн явцад хотын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн байцаах чиг үүргийг хэрэгжүүлж иржээ. Хот, сууринаас гадна бусад газар, хөдөө, орон нутагт дэг журам сахиулах, тухайн газар оронд үйлдэгдсэн гэмт хэргийг шалгах чиг үүргийг эртний маршуссее (фр:marйchaussйe) хэмээх алба гүйцэтгэж байв. Энэ алба нь өнөөгийн жендармын анхны үүсэл эхлэл байжээ.

Эртний Ромд ч өнөөгийн цагдаагийн чиг үүргийг түшмэлүүд гүйцэтгэж байсан бол муж, хязгаар нутаг болон Ромын их

<sup>1</sup> <https://www.police-nationale.interieur.gouv.fr/Prйsentation-generale/Histoire>



замыг дагасан нутаг дэвсгэрт миллис хэмээх цэргүүд нь цагдаагийн чиг үүргийг гүйцэтгэж байжээ<sup>2</sup>

Эртний галли (Франц)нь Эртний Ромын эзэнт Улсын үед харьяанд байсан нь Ромын эрх зүйн тогтолцоо, өв соёлыг өвлөн авах үндэс болсон юм. Галлид олон тооны Ромчууд ирж суурьшин томоохон газар болон боол эзэмшигчид болжээ. Тэд амьдралын тансаг хэв маяг, технологи хөгжлийг (фр:elle sy installa avec sa technologie, les raffinements de son savoir vivre) дэлгэрүүлэхийн зэрэгцээ өөрийн хууль тогтоомжоо ч нутагшуулжээ. Улмаар тэдгээр угсаатнууд хоорондоо холилдон уусаж, тэднийг галло-ромчууд (фр:Gallo-Romains) хэмээн нэрлэх болжээ<sup>3</sup>

Баруун Ром унасны дараа Франкын эзэнт Улс өнөөгийн Францын нутаг дэвсгэрт байгуулагдаж, уугуул галли, галло-роман, британи, норманд, вестгот, бургунд, франк зэрэг олон угсаатан түмэн амьдарч байв. Энэхүү түүхэн цаг хугацаанд олон угсаатан, түмнээс Франц үндэстэн нь үндэстэн угсаатны хувьд бүрэлдэн бий болж, Галло-Роман угсаатнаар дамжин суурин соёл, иргэншил, Франк угсаатнаар дамжин нүүдэлчин соёл, иргэншил өвлөн авч, европын их соёл, иргэншлийг бүтээхэд түүхэн үүрэг гүйцэтгэжээ. Европын соёл иргэншил нь дэлхийн соёл иргэншлийн түүхэнд хамгийн чухал байр суурь эзлэх бөгөөд орчин үеийн өрнөдийн соёл иргэншлийн эх үндэс нь юм.

Энэхүү соёл, иргэншлийг тээгч, Франц Улсын үндэсний жендарм болон үндэсний цагдаагийн байгууллагын үүсэл, хөгжлийг түүхийн баримтад тулгуурлан цаг хугацаагаар нь танин мэдэхүйн хүрээнд тоймлон судаллаа.

### Үндсэн хэсэг

Эртний Ромын эзэнт гүрний Эзэн хаан Август(empereur Auguste)-ын хаанчлалын үед хөдөө, орон нутаг, мужид буй милис буюу милиция<sup>4</sup> (фр: milice, лат: militia)

<sup>2</sup> Ш.Баасандорж. Ром-Германы эрүүгийн процесс. УБ., 2018. 168 дахь тал

<sup>3</sup> Ш.Баасандорж. Ром-Германы эрүүгийн процесс. УБ., 2018. 23 дахь тал

<sup>4</sup>Милис буюу милиция /militia/ нь Эртний Ромоос гаралтай цэргийн бүтэц, нэгж байсан бөгөөд пост социалист орнуудад нийгмийн дэг журмыг сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлдэг нэгж, бүтэц /байгууллага/ байв. Өнөө үед зарим улс оронд ялангуяа ОХУ-д энэ бүтэц болох байгууллага нь Дотоод явдлын яамны харьяанд чиг үүргээ гүйцэтгэж байна. ОХУ-ын Ерөнхийлөгч асан Дмитрий Медведев 2011 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Оросын милиция /militia russe/ хэмээх бүтэцээ полиция гэж өөрчлөн нэрлэсэн байна.

Манай улсад "Сэргийлэх салаа" нэртэйгээр цагдаагийн албаа 1921 онд байгуулж,нийгмийн дэг журам сахиулах

гэж нэрлэсэн цэргийн албан хаагчид дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг үндсэн чиг үүргийг хажуугаараа эрхлэн явуулж байлаа. Эдгээр цэргийн нэгдсэн жижиг ангийн дарга нар (фр:chef de ces petites unités militaires) гэмт этгээдийг (дээрэмчдийг) таслан зогсоох, хамтран оролцогчдыг баривчлах, тэднийг байцаах, шүүгчид хүргэх (фр:chargé d'arrêter les malfaiteurs, de les interroger, d'attraper les complices et de les livrer aux juges) ажиллагааг явуулдаг байв<sup>5</sup>.

Шүүгчид нь магистрат<sup>6</sup> (фр:magistrat, лат:magistratus) нар байлаа. Магистрат нар цэргийн хүч ашиглаж эхэлснээр онц ноцтой гэмт хэргийг таслан зогсоох, шүүн шийтгэх ажиллагаанд ахиц дэвшил гарч, мөрдөн байцаалт болон шүүн таслах ажиллагаанд татан оролцуулж буй цэргийн албан хаагчид нь зөвхөн туслах чиг үүргийг л гүйцэтгэж байжээ. Тухайн цаг үед мөрдөн байцаалт, мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагаа салж тусгаарлагдаагүй, бүх ажиллагааг магистрат нар эрхлэн явуулдаг байв. Тэдэнд гэмт хэргийг таслах зогсоох, мөрдөхөд хүч дутагдаж байсныг цэргийн хүчээр нөхсөн ажээ. Ромын магистрат нь консул (фр:consul), претор (фр:prteur), едил (фр:йдиле), кестор (фр:questeur) нараас бүрдэнэ.

Франц Улсад Эртний Ромын магистрат нар шууд өвлөгдсөн бөгөөд тэдний чиг үүрэг нь зөвхөн шүүхийн үйл ажиллагааг эрхлэх байдлаар тодорхойлогдсон байна. Магистрат нарын нэгдлийг Магистратур<sup>7</sup>

чиг үүргийг хариуцсан цэргийн нэгж бий болгосон нь Орос улсын дээрх бүтэцтэй адилхан бөгөөд энэ нь эртний Ромын "militia"-тай дүйцүүлэн үзэж болох юм.Учир нь Ромоос эхтэй милиция нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй байжээ. Иймээс уг бүтцийг оросоор дамжуулан нутагшуулахдаа "сэргийлэх салаа" гэж орчуулан буулгасан байх магадлалтай. Түүнчлэн цэрэг армид хэрэглэгддэг "анги" гэсэн үгийг орон нутаг болон хотод байгуулсан цагдаагийн нэгжээ "цагдан сэргийлэх анги" гэж нэрлэсэн нь ч дээрхтэй холбоотой болохыг гэрчилнэ.

Монгол Улсын нэр томьёоны комиссын 1978 оны хууль зүйн нэр томьёонд "полиция"-г харгис цагдаа гэж албан ёсоор орчуулан буулгаж байсан байна. Харин уг улсын нэр томьёонд "милиция"-г цагдан сэргийлэх газар, цагдаагийн газар гэж орчуулсан1990 онд Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрыг Цагдаагийн ерөнхий газар болгон өөрчлөн зохион байгуулжээ. Өөрөөр хэлбэл, "милиция" гэх нэршлийг больж, Барууны орны жишгийн дагуу "полиция" гэсэн нэршилээр нэрлэх болов.

<sup>5</sup>Ш.Баасандорж. Ром-Германы эрүүгийн процесс. УБ., 2018.55 дахь тал

<sup>6</sup> Энэ үгийг монголчилбол түшмэл гэсэн нэршил бөгөөд Эртний Ромд засаг захиргаа, шүүхийн чиг үүргийг гүйцэтгэж байсан бол Франц Улсад мэргэжлийн шүүгч, прокуророо ийнхүү нэрлэдэг байна. Харин Англид эсрэгээрээ мэргэжлийн бус шүүгч нарын шүүхийг нэрлэдэг байна.

<sup>7</sup> Шүүх эрх мэдэл эрхэлсэн Түшмэдийн нэгдэл гэж



(фр:magistrature) гэдэг. Францад Магистратур хэмээх нэр томъёо нь магистрат нарын нэгдлийг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, шүүх засаглалыг хэрэгжүүлж буй бүх хүмүүсийг хэлнэ (фр:Le terme magistrature désigne en France l'ensemble des magistrats, c'est-à-dire toute personne ayant un pouvoir judiciaire).<sup>8</sup>

Энд бичсэн бүх хүмүүс нь одоогийнхоор бол зөвхөн шүүгч, прокурор нар болно.

Харин Дундад зууны Францад шүүх засаглалыг хэрэгжүүлж буй бүх хүмүүст олон нэршил бүхий хүмүүс багтаж байжээ. Тухайлбал, хаан, сеньор, превот, бальи, сенешал, коннетабль, маршал, вигер, хааны хүмүүс, хааны прокурор, хааны адвокат, комиссар мөрдөн байцаагч, иргэний лейтенант, эрүүгийн лейтенант, цагдаагийн генерал лейтенант гэх мэт.

Дундад зууны Францад шүүх, цагдаагийн функц, чиг үүргүүд нягт холбоотой байв (фр:les fonctions de Police et de Justice sont étroitement liées). Цагдаа, шүүхийн тухай ойлголтууд нь тэр цаг үед өнөө үеийнхтэй адилхан утга, агуулгатай байсангүй. Цагдаа нь шүүхийн нэг хэсэг бөгөөд түүний гүйцэтгэгч байгууллага байв (фр:Les notions de police et de justice n'ont a cette époque pas la même signification que de nos jours. La police fait partie de la justice et en est le corps d'exécution).<sup>9</sup>

Үүний жишээ нь марешуссее-гээс эхтэй үндэсний жендармын байгууллага (фр:de la Maréchaussée a la Gendarmerie) хүртэлх түүхэн хөгжлөөс нь харагдана. Иймээс Францын Улсын Үндэсний жендармын газрын үүсэл, хөгжлөөс эхэлбэ.

### Нэг. Францын Улсын Үндэсний Жендармын газар

(фр:Gendarmerie nationale française,ор: Национальная жандармерия Французской республики)- ын үүсэл, хөгжил.

Францын сенешаль <sup>10</sup>(фр:sénéchal de France, ор : сенешаль Франции) нь Баруун Франси<sup>11</sup> (Francie occidentale) Улсын хаан Лотарь-ийн шийдвэрээр 978 онд бий болж, үүний дараа тус улсыг Франц Улс гэж нэрлэж эхэлсэн эхэн үеэр буюу 1191 онд коннетабль (фр:connétable, лат:comes stabuli, анг:constable, ор:коннетабль) гэсэн нэршилтэй цэргийн гүн бий болжээ. Эдгээр цэргийн гүнүүд Эртний Ромын милициа-гийн эрх бүхий орчуулж болохоос гадна шүүх засаглал гэж буулгана.

<sup>8</sup> <https://fr.wikipedia.org/wiki/Magistrature>

<sup>9</sup> [https://fr.wikipedia.org/wiki/Histoire\\_de\\_la\\_Gendarmerie\\_nationale\\_française](https://fr.wikipedia.org/wiki/Histoire_de_la_Gendarmerie_nationale_française)

<sup>10</sup> Хааны армийг командлах эрх бүхий гүн байв.

<sup>11</sup> Франкын эзэнт улсын дараа Франц Улс гэж нэрлэхээс өмнө Баруун Франси гэж нэрлэдэг байв.

албан тушаалтнуудаас эхтэй юм. Тэрээр цэрэг, арми захирахаас гадна язгууртан, рыцарь нарын хоорондох хэрэг, маргааныг шийдвэрлэж байв. Тэдний даргалж буй цэрэг арми нь XII зуунд үндсэндээ бүрэн байгуулагдаж дууссан гэдэг. Тэрхүү цэрэг арми нь нэн түрүүнд цэрэг дайчид, тэнүүлчин дээрэмчидэд хяналт тавьж ажиллахаас гадна арми дахь шүүхийн чиг үүргийг гүйцэтгэж байлаа. Энэ чиг үүрэг нь тусгай шүүхийн эхлэл байсан юм (фр:il dispo- sement йgalement d'une juridiction spйciale). Энэхүү шүүхийг коннетабль-ийн трибунал (фр:tribunal de laconnétable) гэж нэрлэнэ. Английн "Court of Chivalry" гэсэн шүүхтэй адилхан юм. Мөн тэрээр, цагдаагийн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Коннетабль-д нэг болон хэд хэдэн маршлууд чиг үүргээ хэрэгжүүлэхэд тусалж байв (фр:Le connétable йtait secondé par un ou plusieurs maréchaux)<sup>12</sup>. Эдгээр хүмүүс нь Францын Маршал (фр:maréchal de France, ор:маршал<sup>13</sup> Франции)-ууд байсан бөгөөд тэд нарын нэгдлийг марешуссее (фр:maréchaussée)гэнэ. Энэ нэршил нь маршлын оффисе (фр:office de maréchal) гэсэн нэршилтэй дүйцэх нэр юм. Маршал нь эртний франц хэлний "mareschal", эртний франк хэлний "marhschalk", "marahscalh" үгсээс гаралтай юм. Маршал хэмээх нэршлийг 1185 оноос хэрэглэж эхэснээс хойш, Францад 342 маршал <sup>14</sup> байсан бөгөөд XIII зуунаас маршалын оффис нь цэргийн байгууллага болсон байна(фр:Depuis la création du titre, en 1185, il y a eu 342 maréchaux de France. L'office de maréchal n'est devenu militaire que depuis le début du XIIIe siècle)<sup>15</sup>.

Коннетабль, маршалуудын даргалж буй цэрэг армиуд Англи Франц Улсуудын хооронд өрнөсөн зуун жилийн дайны үед цэрэг армийн оргодол босуул цэргүүдийг шалгах, армийг хянах бүрэн эрхтэй байлаа. Өөрөөр хэлбэл, дайны үеийн эмх замбараагүй байдлыг цэгцлэх, үймээн

<sup>12</sup> <https://fr.wikipedia.org/wiki/Connétable>

<sup>13</sup> Маршал гэж Францад анх цэргийн, цагдаагийн болон шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлдэг эрх бүхий албан тушаалтныг нэрлэдэг байв. Үүнээс өмнө Францад marhschalk-д хэмээх адуун сүрэг хариуцсан даамал байсан гэдэг. Энэ эрхэм нэршлээр францчууд эрүүгийн хэрэг шалгадаг, мөрддөг, шүүдэг эрх бүхий албан тушаалтныг нэрлэдэг байсан бол сүүлдээ энэ нэршлээр зөвхөн цэргийн өндөр дээд цол "маршал" гэж нэрлэхээр тогтож, харин энэ алба нь жендармын үүсэл болж цагийн уртад өөрчлөгдөн байгуулагдсан байна.

<sup>14</sup> Цэргийн маршал цолтой этгээд бус цэрэг, шүүхийн чиг үүргийг хэрэгжүүлэгч албан хаагч гэж ойлгоно уу.

<sup>15</sup> [https://fr.wikipedia.org/wiki/Maréchal\\_de\\_France](https://fr.wikipedia.org/wiki/Maréchal_de_France)



самуун, бослогоос сэргийлэх, тэмцэх, цэрэг армид дэг журам сахиулах, сахилга батыг бэхжүүлэх, цэргүүд анги байрлалаа орхиж, тарж бутрахтай тэмцэх, цэргээс оргосон цэргүүдийн барих, цэргүүдийн үйлдсэн гэмт хэргүүдийг мөрдөн шалгах зэрэг олон чиг үүргийг гүйцэтгэж байв. Өөрөөр хэлбэл, арми доторх цэрэг цагдаагийн арми байлаа. Манайхан энэ чиг үүрэгтэй адилхан цэргийн ангийг комендант гэж нэрлэдэг байсан. Энэ л чиг үүргийн хүрээнд Д.Сүхбаатар жанжин ардын журамт цэргийн түр комендант-ийг байгуулж, 1924 онд Нийслэл хүрээний цэргийн комендант болон өргөжин тэлж байжээ.

Англи-Францын 100 жилийн дайн гэж түүхэнд нэрлэгдсэн дайн нь 1337-1457 оны хооронд завсарлагатайгаар явагдаж Франц Улсын ялалтаар өндөрлөж байсан юм. Энэ дайны үед коннетабль, маршал-ууд дээр дурдсан чиг үүргээс гадна шүүн таслах чиг үүргийг хэрэгжүүлж байсан бөгөөд 1373 оны хааны ордоннонсе-оор тус шүүхийн төв оффис Парист байгуулагдаж байв. Дайны үеэр марешуссее-гийн ач холбогдол ихэд өсөж хаант засаглалын дэргэдэх хамгийн чухал институт болж, нийслэл хүрээний болон бүх газар нутгийг хамарч үйл ажиллагаа явуулахаас гадна далай тэнгист чиг үүргээ хэрэгжүүлж байлаа. Энэ урт үргэлжилсэн дайны хугацаанд армид дэг журам, сахилга бат сахиулах, цэрэг армис оргох босох, гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх, үүнтэй тэмцэх чиг үүрэг нь их чухлаар тавигдаж байсан нь гарцаагүй юм. Ямартай ч дайн Францын ялалтаар төгссөн тул уг алба нь чиг үүргээ хангалттай хэрэгжүүлсний нэгэн баталгаа энэ буй за. Коннетабль, маршал-ууд нь превоти (шүүх) –ийн болон превот (фр:prévôt) нарын эрх мэдлийг төлөөлөн хэрэгжүүлж байв (фр:Connétable et maréchaux d'illigent leurs pouvoir a leurs prévôts (du latin praepositus, « prévôt »), d'où le nom de prévôt). Тэдний ажиллаж байсан "maréchaussée"-г мөн "jurisdiction des maréchaux" болон "les tribunaux des prévôts des maréchaux" гэж нэрлэнэ. Монголчилбол "Маршалуудын шүүх" болон "Маршалуудын превотийн шүүх" гэсэн үг ажээ.

Тэдгээр шүүхүүд анхлан амбулатори<sup>16</sup> байдлаар зохион байгуулагдаж, хожим Франсуа I (François I<sup>er</sup>) хааны үед нэгтгэгдэж, түүний оффис Парисын шүүхийн гангиг ордонд коннетабль болон маршуссеегийн трибунал гэсэн нэрийн доор байгуулагдаж

байв (фр:Leurs juridictions, d'abord ambulatoires, fusionneront sous François I<sup>er</sup> et s'installèrent a Paris sous le nom de tribunal de la Connétable et Maréchaussée de France, avec son siége a la table de marbre du Palais de justice de Paris)<sup>17</sup>.

Эдгээр шүүхүүд нь 1536 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн Парисын едит-ээр хувь иргэн хүн болон цэргүүд, гэр оронтой болон гэр оронгүй этгээдүүдийн үйлдсэн их замын дагуух онц хүнд хэргүүдийг таслах шийдвэрлэх бүрэн эрхтэй болж өргөжжээ. Мөн Маршалуудын превотийн шүүх (фр:Les tribunaux des prévôts des maréchaux) нь нэг талаас цэргийн албан хаагч (фр: gens de guerre), оргодол босуул болон урван тэрслэгчид (фр:déserteurs) нарын хэргийг шийдэхээс гадна нөгөө талаас их замын хулгайч дээрэмчид (фр: voleurs de grand chemin), үймээн самуун дэгдээгч, гаргагчид (фр: йmeutiers), тэнүүлчид (фр: vagabonds), гэм буруугаа хүлээгээгүй этгээд (фр: gens sans aveu) зэрэг холбогдогч нарын хэргийг шүүн тасалдаг байв. Мөн бослого үймээн, халз тулаан, хулгайн ан, хуурамч мөнгөний эсрэг гэмт хэрэг, нийтийн аюулгүй байдал болон хааны эрх мэдэлд халдсан гэмт хэргийг шийдвэрлэх бүрэн эрх нь нэмэгдэж өргөжин тэлж байсан гэдэг. Марешуссее нь өргөжин тэлсээр Францын бараг бүх газар нутгийг хамарсан бүх ард түмэнд зориулсан цагдаагийн хүчин болсон байна (фр:qui йtait devenu progressivement une force de police compйtente pour l'ensemble de la population sur la quasi-totalitй du territoire franзais)<sup>18</sup>.

Франсуа I хаан (1494-1547) францын ард түмний аюулгүй байдлыг хангахын тулд бүх нутаг дэвсгэрт (хотоос бусад) үйл ажиллагаа явуулахаар марешуссеег өргөжүүлэн тэлэх арга хэмжээг үе шаттай авч байсныг зориуд тэмдэглэх нь зүйтэй.

1624 онд Ришелье-ээр шийдвэрээр коннетабль-ийн оффис татан буугдсаны дараа маршууд армийн дээд түвшний дарга нар болжээ (фр:Apris l'abolition de l'office de connétable par Richelieu en 1624, les maréchaux deviennent les chefs suprimes de l'armée).

Марешуссее нь Дундад зуунаас эхлэн арми дахь шүүхийн болон цэрэг цагдаагийн чиг үүргийг хослон хэрэгжүүлдэг цэргийн байгууллага (фр:Maréchaussée, corps de militaires chargй de la police et de la jus-

<sup>16</sup> Энэ "амбулатори" үг нь эмнэлгээс гадна тогтсон тодорхой байршилгүй шүүхүүдийг энэ үгээр илэрхийлдэг байна.

<sup>17</sup> Ш.Баасандорж. Ром-Германы эрүүгийн процесс. УБ., 2018. 169 дахь тал

<sup>18</sup> [https://fr.wikipedia.org/wiki/Histoire\\_de\\_la\\_Gendarmerie\\_nationale\\_franзaise](https://fr.wikipedia.org/wiki/Histoire_de_la_Gendarmerie_nationale_franзaise)





tice aux armées depuis le Moyen Age)<sup>19</sup> байсан юм. Орон нутагт маршалын трибуналын чигүүргийг маршалын лейтенант<sup>20</sup> (фр:lieutenant) нар гүйцэтгэнэ. Энэ шүүх нь цэргийн шүүхээс гадна тусгай шүүхийн эхлэл байсан бөгөөд тусгай шүүхийн онолыг үндэслэгч нь хуульч Мюарт (Muyart De Vouglans) байсан юм. Тусгай шүүхийн эрх зүйн үндэс, түүний үйл ажиллагаа нь 1564 оны Шарль 9-ын едит (зарлиг, тогтоол) -ээр эцсийн байдлаар бүрэн тодорхойлогдсон байна (фр: En 1564, un idit de Charles IX fixe définitivement leur juridiction)<sup>21</sup>. 1779 онд жендармид 3 300 албан хаагчид ажиллаж байсан бол Францын хувьсгалын өмнө 4114 албан хаагчид байв.

Францын 1789 оны хөрөнгөтний ардчилсан хувьсгалын үеэр буюу 1791 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар “маршуссее” хэмээх байгууллагыг Үндэсний жендармын байгууллага болгон өөрчлөн нэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл, 1791 онд маршлын оффис нь Францын үндэсний жендарм (фр: Gendarmerie nationale française, ор:национальная жандармерия Франции) гэж нэрлэгдэх болжээ. Нэр өөрчлөгдөх болсон нэгэн шалтгаан нь Монтескье-гийн засаглал хуваах онолын дагуу шүүхийг цагдаагийн хүчнээс тусгаарласантай холбоотой юм. Энэхүү эртний институтын үйлчилгээ нь иргэн, цэргийн холимог шинжтэй болсон байна.

Иргэний шинж гэдэг нь захиргааны цагдаа (фр:police administrative)-гийн салбар дахь нийгмийн дэг журам сахиулах, бусдын эд хөрөнгө, хувь хүний аюулгүй байдлыг хангах зэрэг чиг үүргийг, шүүхийн цагдаа (фр:policejudiciaire)-гийн салбар дахь энгийн иргэдийн үйлдсэн гэмт явдлыг мөрдөн байцаалт явуулан шалгах, нотлох баримт цуглуулах, гэм буруутай этгээдийг эрэн сурвалжлан тогтоох зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг болсноор илэрдэг байна. Армид зэвсэгт хүчний цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлдэг, цэргийн цол, статустай байдлаар цэргийн шинж нь илэрдэг ажээ. 1849 оноос Бүгд найрамдах

улсын хамгаалалт (фр: garde rйpublicaine) гэх хүндэт харуулын ангийг жендармид нэгтгэж байжээ.

Өнөөгийн жендарм<sup>22</sup> нь цэргийн статустай цагдаагийн хүчин (фр:force de police a statut militaire) бөгөөд хот орчмын бүс, хөдөө орон нутгийн аюулгүй байдлыг хариуцахын зэрэгцээ Францын далайн чанад дахь нутаг дэвсгэрт, эх газрын бараг бүх газар нутагт үйл ажиллагаагаа явуулж байна. Жендарм нь 2009 оноос эхлэн Батлан хамгаалахын сайдаас гадна Дотоод явдлын сайдын бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш хотын бүс нутагт (хот дотор) ч цагдаагийн хамт ажилладаг болжээ. Тус байгууллага нь энэ зуунд францын нутаг дэвсгэрийн 95 хувьд чиг үүргээ гүйцэтгэж, нийт франц түмний 55 хувьд хүрч ажиллаж байна. Үндэсний жендарм нь аюулгүй байдал, хамгаалалт хариуцах, гэмт хэрэгтэй тэмцэхээс гадна далай тэнгис, уул нуруу, зам, агаарын цагдаагийн мэргэшсэн чиг үүргийг гүйцэтгэдэг ажээ. Энэ үйл ажиллагаандаа орчин үеийн байлдааны зэвсэг, техник хэрэгсэл ч ашиглана.

#### Жендармын үндсэн чиг үүрэг нь:

- Шүүхийн цагдаа<sup>23</sup> (фр:police judiciaire)-гийн чиг үүрэг буюу мөрдөн байцаалт явуулах чиг үүргийг хэрэгжүүлэх
- Захиргааны цагдаа (фр:police administrative)-гийн чиг үүрэг болох нийтийн аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журмыг сахиулах, тусламж дэмжлэг үзүүлэх, замын хөдөлгөөнийг зохицуулах, байгаль орчныг хамгаалах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэх

<sup>22</sup> Энэ армийн зэвсэгтэй хүн гэсэн үгнээс гаралтай ажээ.

<sup>23</sup> Шүүхийн цагдаа гэж шууд орчуулагдах “police judiciaire” нэршил нь утга агуулгаараа мөрдөн байцаалт явуулах чиг үүргийг нэрлэж буй эрүүгийн процессын хуулийн нэр томъёо юм. Францын эрх зүйд “police judiciaire” гэх ойлголт эрүүгийн процессын хуулийн 12-15 дугаар зүйлүүдэд тодорхойлогдсон байдаг. “Police judiciaire” хэмээн томъёологдсон чиг үүргийг үндэсний цагдаагийн газар, үндэсний жендарм, гааль, хотын цагдаагийн газраас гадна тусгай бүрэн эрх олгогдсон зарим төрийн байгууллага дахь төрийн албан хаагчид хэрэгжүүлж болно. Тухайнбал, Францын үндэсний төмөр замын нийгэмлэгийн болон Парис хотын тээврийн газрын агент, хөдөлмөрийн байцаагч /inspecteurs du travail /,байгаль орчны байцаагч /inspecteurs de l'environnement /, татварын захиргааны агент /agents de l'administration fiscale /, тусгай хамгаалагч /garde particulier /, хотын мэр, түүний орлогч гэх мэт. Энд нэрлэгдсэн төрийн албан хаагчид эрүүгийн хуульд заасан болон бусад дүрэм журамд заасан зөрчлийг /contravention / шалгаж шийдвэрлэдэг байна. Францын гэмт явдал гурван ангилалд хуваагдаж онц хүнд гэмт хэрэг, гэмт хэрэг /ердийн /, жижиг хэрэг, зөрчил гэж ангилагддагийг мэднэ. Тэгэхээр зөрчил шалган шийдвэрлэж буй процесс ч “police judiciaire” хэмээх ойлголтод багтана.

<sup>19</sup> [https://fr.wikipedia.org/wiki/Histoire\\_de\\_la\\_Gendarmerie\\_nationale\\_franzaise](https://fr.wikipedia.org/wiki/Histoire_de_la_Gendarmerie_nationale_franzaise)

<sup>20</sup> Лейтенант нар нь монголоор дэслэгч гэсэн цэргийн цолны нэр юм. Тухайн үедээ лейтенант эрүүгийн хэрэг шалгадаг, шүүдэг эрх бүхий албан тушаалтныг ийнхүү нэрлэдэг байсан бол хожим нь цэргийн нэгэн цолны нэр болон үлдсэн гэдэг. Мөн генерал лейтенант гэсэн шүүн таслах бүхий албан тушаалтан байсан бөгөөд энэ нэршил нь өнөөгийн дэслэгч генерал гэсэн цолны нэр юм.

<sup>21</sup> Ш.Баасандорж. Ром-Германы эрүүгийн процесс. УБ., 2018. 70 дахь тал



• Цэргийн чиг үүргийг гүйцэтгэх хүрээнд цэргийн цагдаа, хамгаалалтын болон байлдаанычигүүрэг(цөмийнзэвсгийнхяналт, хамгаалалт, батлан хамгаалах тодорхой ажиллагаа) -ийг тус тус хэрэгжүүлдэг байна. Одоогийн Үндэсний Жендармын ерөнхий газар (фр:direction гийнаrale de la Gendarmerie nationale) нэрээр цэргийн статусын доор цагдаагийн үйл ажиллагааг гүйцэтгэдэг гэдгийг дээр дурдсан. Жендарм нь нэн эртний улсын цагдаагийн хүчин (фр:C'est la force de police йtatique la plus ancienne) байсан гэдэг нь түүний үүсэл, хөгжлөөс тодорхой харагдаж байна<sup>24</sup>. Жендармын бүрэлдэхүүнд нь 100 000 албан хаагч ажиллаж байна. Жилийн төсөв нь 8,3 тэрбум евро байдаг ажээ.

Тус газрын бүтэц, тогтолцоо нь их энгийн бөгөөд үндэсний жендармын газар, бүс тойрог, муж, хорооны жендармын газар гэсэн босоо тогтолцоотой. Үүнд:

- Үндэсний Жендармын ерөнхий газар (фр:direction гийнаrale de la Gendarmerie nationale)

- Жендармын бүсийн газар (фр:гйгion de gendarmerie)

- Мужийн жендармын групп (фр:groupement de gendarmerie дйpartementale)

- Мужийн жендармын анги (фр:compagnie de gendarmerie дйpartementale)

- Мужийн жендармын бригад (фр:brigade de gendarmerie дйpartementale)

#### **Хоёр. Үндэсний цагдаагийн газар (фр:Police nationale, ор: национальная полиция)-ын үүсэл, хөгжил**

Үндэсний цагдаагийн газар нь 1254 онд Францын хаан Сан Луй (Saint-Louis) Парис хотын шөнийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий шөнийн манааны рыцарь (фр:chevalier du gue, guet royal)-уудыг байгуулснаар анхны шаваа тавьсан гэж үздэг.Тэд морьтой 20 түрүүч (фр:sergent), 26 явган түрүүч нараас бүрдэж байлаа. Тэднийг рыцарь толгойлно. Мөн тэднийг хөрөнгөтөний цэргүүд буюу буржва милисе, милиция (фр:milice bourgeoise) гэж нэрлэж байв<sup>25</sup>

Энэ мөчөөс хойш дараах хэллэг Парист үүсэн гэдэг. "Bonnes gens, dormez en paix!" Монголоор "Сайн санаат хүмүүсээ, энх

<sup>24</sup> Ш.Баасандорж. Ром-Германы эрүүгийн процесс. УБ., 2018. 171 дахь тал

<sup>25</sup> Ш.Баасандорж. Ром-Германы эрүүгийн процесс. УБ., 2018. 168 дахь тал

тайван (амар тайван) унт даа". Энэ нь нөгөө талаараа та нарын аюулгүй байдлыг бид манаж хононо, та бүхэн амар тайван аюулгүй унтаж амар даа гэсэн утга, санаа агуулж байжээ. Энэ нь Франц Улсын цагдаагийн үүсэл байсан бөгөөд тэд Парис хот доторх нийгмийн дэг журмыг сахиулах, аюулгүй байдлыг хангах чиг үүргийг гүйцэтгэж байв. Энэ алба нь аажмаар бусад хотуудад үүсэн бий болов. Хотууд ч дундад зуунд хөгжиж байв.

Харин 1306 онд хаан Филипп Ле Бел нь Шатле (Парисын шүүх) -д шалгагч комиссаруудыг бий болгожээ (фр:сгйation en 1306 par Philippe le Bel des commissaires examineurs au Chbtelet)<sup>26</sup>

Комиссарууднь мөн комиссар мөрдөн байцаагч (фр:commissaires enqukteurs) нараас бүрдэж байв. Тэд Парис хот доторх гэмт хэрэгтэй тэмцэх үүргийг хэрэгжүүлж байлаа. Шүүх засаглалын үйл ажиллагааны бүрэн дүүрэн бэлэг тэмдгийн илэрхийлэл болсон магистратын адил урт нөмрөгийг тэд өмсдөг байв. Тиймээс энэ комиссарыг нэг талаас цагдаагийн комиссар, нөгөө талаас магистрат гэж үзэж болох юм. Тэднийг Шатле дахь комиссар (фр:commissaires au Chbtelet)-ууд гэж нэрлэнэ. Комиссарууд цагдаа, шүүхийн чиг үүрэг, зарим шүүхийн мөрдөн байцаалтыг гүйцэтгэж, Парис хотын превот-ын лейтенант (фр: lieutenants du ргйvft de Paris) нартай хамтарч ажиллана<sup>27</sup>. Лейтенант нар шүүхийн мөрдөн байцаалтыг хэрэгжүүлдэг гол субъектүүдийн нэг байв. 1526 онд шүүх засаглалын үйл ажиллагааны хязгаарлагдсан үүргийн бэлэг тэмдгийн илэрхийлэл болсон богино нөмрөг өмссөн эрүүгийн лейтенант (фр:lieutenant criminel) гэх тэнүүлчин, гуйлгачид бусад эмзэг хэсгийнхэнтэй тэмцэх үүргийг хэрэгжүүлэх албан тушаалтныг бий болгосон байна. 1559 онд Хенри II хаан шөнийн манааны хааны албыг өргөтгөснөөр 208 албан хаагч, 32 офицероос бүрдэх болжээ. 1563 онд 4 лейтенант уг албанд томилогдож рыцарь-ийн хамт ажилладаг болов.

1667 онд Луй XIV хааны үед Кольбертын танилцуулсны дагуу хааны зарлигаар цагдаагийн женерал лейтенант <sup>28</sup> (фр:lieutenant-гйнарal de police)-аар

<sup>26</sup> <https://www.police-nationale.interieur.gouv.fr/Presentation-generale/Histoire>

<sup>27</sup> [https://fr.wikipedia.org/wiki/Commissaire\\_de\\_police\\_\(France\)](https://fr.wikipedia.org/wiki/Commissaire_de_police_(France))

<sup>28</sup> Энэхүү нэршлийг монгол руу хөрвүүлбэл цагдаагийн дэслэгч генерал юм. Гэхдээ энэ нь тэр үедээ цол бус шүүх, засаг захиргаа /дэг журам хариуцах/ -ны чиг үүргийг хариуцсан өндөр дээд албан тушаалтны нэр байв. Өөрөөр хэлбэл, энд дурдсан чиг үүргийг



Нисола Де Ла Рейни (Nicolas de La Reynie) томилогдсон байна. Энэ цагдаагийн лейтенант нь давхар каскет малгай бүхий төлөөлөгч байв. Тэр хаанаас бүрэн хамаарал бүхий байхаас гадна ердийн шүүхэд адилхан хамааралтай Шатле-гийн лейтенант байсан юм (фр: le lieutenant de police est un agent a double casquette: il depend du roi mais également de l'ordre judiciaire puisqu'il est lieutenant du Châtelet)<sup>29</sup>.

1667 оноос эхлэн шөнийн манааны цэргүүд цалин хөлс төрөөс авдаг боллоо. Энэ алба нь 1765 онд жинхэнэ цэргийн нэгж болон өөрчлөгдөж Парисын хамгаалалтын алба (фр:garde de Paris) гэж нэрлэгдэх болов. Францын хувьсгалын үеэр Парист цагдаагийн түр хороо (фр:comité provisoire de police)-г байгуулав. Директор (фр: Directeur) ор: директория)-ийн шийдвэрээр Цагдаагийн ерөнхий яам (фр:ministère de la Police гийн) -ыг байгуулжээ. Засгийн газрын шийдвэрээр 1796 оноос эхлэн 5000 дээш хүн амтай хот бүрт цагдаагийн комиссар (фр:commissaires de police)-ууд томилогдсон байна. Францад 1600 оны байдлаар хотын хүн ам нь 5000 дээш гарсан олон хотууд байв. Тухайлбал, Парис хот<sup>30</sup> нь 220 000-300001 хүн амтай байсан бол Руон хот 60000-70000 хооронд, Орлеан хот 40000- 70000 хооронд, Бордо хот 40000, Тулуз хот 40000, Луон 35000-200000, Лилль хот 33000, Ренне хот 33000 зэрэг хүн амтай хотуудаас гадна 26 хот 5000 дээш гарсан хүн амтай байжээ<sup>31</sup>. Эдгээр хотуудад цагдаагийн алба ажиллаж байв. Тиймээс цагдаагийн үүсэл хөгжил хотын үүсэл хөгжилтэй зайлшгүй холбоотой бөгөөд цагдаагийн байгууллага нь хотыг дагаж бий болсон, хөгжсөн байгууллага юм.

Наполеоны үед 1799 оноос 1815 он хүртэл эзэн хааны цагдаагийн газар (фр:Police impériale) болон өөрчлөгдөв. Парисын цагдаагийн префектур (фр:préfecture de police de paris)- ыг 1800 оны 2-р сарын 17-ны

хэрэгжүүлэх эрх бүхий Парисын хамгийн өндөр албан тушаалтан байсан аж. Харин өнөө үед өндөр албан тушаалтын нэр бус цэрэг, арми, цагдаад өндөр албан тушаал хашиж буй хүний цол хэргэм билээ. Гэхдээ цэргийн болон иргэний гэж ангилагддаг.

<sup>29</sup> <http://www.justice.gouv.fr/histoire-et-patri-moine-10050/la-justice-dans-lhistoire-10288/le-chatelet-de-paris-24777.html>

<sup>30</sup> Парис хот тухайн үедээ хамгийн олон хүн амтай (300 000 хүн амтай)Европын хот байв. Лондон хот 187 000-225 000 хооронд, Ром хот 100 000, Москва хот 80 000, Мадрид 57 000-65000 хооронд, Амстердам 54 000-72 000 хооронд, Вена 50 000-60 000 хооронд тус тус хүн амтай байжээ

<sup>31</sup> [https://fr.wikipedia.org/wiki/Population\\_des\\_villes\\_europennes\\_vers\\_1600](https://fr.wikipedia.org/wiki/Population_des_villes_europennes_vers_1600)

өдрийн (фр:loi du 28 pluviôsean VIII - 17 février 1800) хуулиар байгуулсан байна. Ийнхүү өнөөгийн Парисын цагдаагийн префектур хэмээх байгууллагын суурь тавигджээ. Энэ байгууллага нь Парисын цагдаагийн генерал лейтенантыг залгамжлан гарч ирсэн гэж үздэг байна. Францад 1815 оноос эхлэн зарим цагдаагийн байгууллагын бүтэц, нэгж нь хотын засаг захиргааны байгууллагын харьяалалд шилжив. Өөрөөр хэлбэл, Хотын хөгжил их хүчтэй явагдсанаар хотын буюу орон нутгийн цагдаагийн газар (фр:police municipale, ор: муниципальная полиция) төрөлжин ялгарч гарч ирсэн байна. Энэ цаг үе хүртэлх хугацаанд цагдаагийн байгууллага нь 1667-1789 оны цагдаагийн лейтенант нарын үе, 1789-1799 оны түр цагдаагийн хорооны үе, 1799- 1815 оны эзэнт гүрний цагдаагийн газрын үе зэргээр түүхэн үечлэл, цаг хугацааг дамжин хөгжсөн байна. Гэхдээ шүүхтэй холимог хэлбэртэйгээр хөгжиж байсныг дурдах зүйтэй. Ялангуяа цагдаагийн лейтенант нарын үед.

Тус улсад 1818 онд цагдаагийн ерөнхий яам нь дотоод явдлын яам (фр:ministère de l'intérieur) болон өөрчлөгдөв. Францад 1829 онд хотын түрүүч (фр:corps des sergents de ville) гэсэн цагдаагийн бүтэц бий болж, гурван түрүүч (хэсгийн цагдаа) дүүрэг болгонд суурин ажиллаж эхлэв. Парис хотын түрүүч нар анх бий болсноор дэлхий дахины анхны дүрэмт хувцастай цагдаа (фр:la première police en uniforme du monde) байгуулагдсан гэж үздэг юм. Энэхүү түүхэн үйл явдал нь цагдаа (фр:la police) нь цэрэг армиас (фр:armée) ангид өөрийн гэсэн дүрэмт хувцастай, иргэний статус бүхий цагдаа мэндэлсний нотолгоо юм. Өөрөөр хэлбэл, Ромын милициа-гаас эхтэй цэрэг цагдаагаас орчин үеийн дүрэмт хувцас бүхий полициа ялгаран гарчээ гэж ойлгож болно. Тус улсын цагдаагийн байгууллага нь цаашдаа:

- 1848 – 1884 оны хотын цагдаагийн газрын үе
- 1883 оны дэлхийн цагдаагийн анхны сургуулийн үе (фр:la première école de police du monde)
- 1884 он 3 дугаар Бүгд Найрамдах Улсын цагдаагийн газрын үе
- 1882 -1910 оны техник, шинжлэх ухааны (криминалистик) цагдаагийн үе
- 1800 –1900 оны эхэн үеийн барын бригадуудын үе
- 1941 оны чөлөөт францын цагдаагийн үе
- 1944 оны төрийн цагдаагийн үе

• 1966 оноос үндэсний цагдаагийн газрын үе гэсэн байдлаар хувьсан өөрчлөгдөж, хөгжсөөр иржээ.

Цагдаагийн тэрхүү түүхэн хөгжлийн явцад цагдаагийн генерал лейтенант<sup>32</sup> гэх өндөр зэргийн албан тушаалтныг бий болгон томилж байсан цаг үе байсныг дурдсан. Өөрөөр хэлбэл, тэрхүү албан тушаалтан нь Францын хуучин дэглэмийн үеийн өндөр чиг үүрэг, үйл ажиллагааг (фр:une haute fonction dans l'Ancien Régime français) хэрэгжүүлэгч, албан тушаалтны нэр байж. Яг л прокурор, шүүгч гэж байгаатай адил юм. Иймээс цэргийн дэслэгч генерал гэх цэргийн цол, хэргэм зэв (фр:grade militaire de lieutenant-гйпйral)-тэй цагдаагийн офицер байсан гэж андуурч болохгүй нь байна.

Цагдаагийн болон шүүхийн чиг үүргүүд нь хэт өргөн хүрээтэй, хоорондоо нийцэхгүй, ихэнхдээ зөрчилдөж байх тул ганц офицер (ганц төрийн албан хаагч) гүйцэтгэхэд хүндрэлтэй” гэж 1667 оны 3-р сарын едит-ээр тогтоож өгсөн байдаг (фр:Ce constat est йtabli par l'йdit de mars 1667 qui dispose que les fonctions de justice et de police sont souvent incompatibles et trop йtendues pour ktre exercйes par un seul officier “(fonctionnaire”). Энэ дүгнэлт нь шүүхийн мөрдөн байцаалт, цагдаагийн мөрдөн байцаалт нэг байж болохгүйг хүлээн зөвшөөрсөн дүгнэлт байлаа. Мөн нөгөө талаар шүүн таслах ажиллагааны явцад шүүх, цагдаа нь нэгдмэл байгааг буруутгасан дүгнэлт юм. Ер нь Дундад зууны үеүдэд шүүх, цагдаагийн мөрдөн байцаалтын ажиллагаа нь ялгарч зааглагдаагүй бараг нэгдсэн байдлаар явагдаж байв<sup>33</sup>. Өөрөөр хэлбэл, шүүхийн мөрдөн байцаалт (фр:instruction, information judiciaire), цагдаагийн мөрдөн байцаалт (фр:enqute de police) нь нэгдмэл байдлаар явагдаж, энэ сэжмээр шүүх, цагдаа нь холимог хэлбэрээр хөгжиж байсан бол нийгмийн дэг журам сахиулах чиг үүрэг нь заагтай байдлаар хөгжиж байсныг дурдах хэрэгтэй.

Франц Улсад мөрдөн байцаалтын ажиллагааг явуулдаг эрх бүхий цагдаа нь шүүхийн цагдаа (фр:police judiciaire) гэсэн нэршлээр, нийгмийн дэг журам сахиулах чиг үүргийг гүйцэтгэдэг цагдаа нь захиргааны цагдаа (фр:police administrative) гэсэн нэршлээр тус тус хуульчлагдаж, чиг үүргээрээ зааглагдсан байдаг. Францад

гарсан хөрөнгөтний ардчилсан хувьсгалын үеэр батлагдсан 1795 оны 10 дугаар сарын 25-ны Гэмт хэрэг, ял шийтгэлийн хууль (фр:Code des dйlits et des peines du 25 octobre 1795) хэмээх эрүүгийн процессын хуулиар дээрх нэр томьёонууд хуульчлагдаж байсан юм. Энэ хууль нь 1795 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж, 1808 оны гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны тухай хууль (фр:Code d'instruction criminelle de 1808) буюу Наполеоны эрүүгийн процессын хууль батлагдан мөрдөгдөх үе хүртэл үйлчилсэн байна.Тэрхүү 1795 оны 10 дугаар сарын 25-ны Гэмт хэрэг, ял шийтгэлийн хууль нь 646 зүйл, заалтаас бүрдэх шүүхийн зохион байгуулалт, цагдаагийн үйл ажиллагаа, эрүүгийн процессын ажиллагаа, ял шийтгэлийн талаар тус тус зохицуулсан хууль байжээ<sup>34</sup>. Энэ хуулиар захиргааны цагдаагийн чиг үүргүүдэд ердийн гэмт хэрэг, онц хүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийг хамааруулж, шүүхийн цагдаагийн чиг үүргүүдэд ердийн гэмт хэрэг, онц хүнд гэмт хэргийг таслан зогсоохыг хамааруулж зааглан ялгасан байна (фр:Il distingue les missions de police administrative, qui relivent de la pйvention des crimes et des dйlits, des missions de police judiciaire, qui relivent de la rйpression de ces crimes et dйlits). Тухайлбал, Уг хуулийн нэгдүгээр номын 16 дугаар зүйлд “Олон нийтийн дэг журам, эрх чөлөө, эд хөрөнгө, хувь хүний аюулгүй байдлыг сахиулах зорилгоор цагдаагийн байгууллага байна” (фр:La police est instituйe pour maintenir l'ordre public, la libertй, la propriйtй, la sйretй individuelle), 18 дугаар зүйлд “Цагдаа нь захиргааны цагдаа болон шүүхийн цагдаад хуваагдана” (фр: Elle se divise en police administrative et en police judiciaire), 19 дүгээр зүйлд “Захиргааны цагдаагийн зорилго нь ерөнхий захиргаа, газар бүрт нийтийн дэг журмыг тогтмол сахиулах явдал юм. Энэ нь гол төлөв гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой байна (фр: La police administrative a pour objet le maintien habituel de l'ordre public dans chaque lieu et dans chaque partie de l'administration гйпйrale. Elle tend principalement a pйvenir les dйlits), 20 дугаар зүйлд “Шүүхийн цагдаа нь захиргааны цагдаагийн урьдчилан сэргийлж чадаагүй үйлдэгдсэн гэмт хэргийг эрэн сурвалжилж, нотлох баримтыг цуглуулж, хуулиар шийтгэл оногдуулах шүүхэд холбогдогч нарыг хүргэх үүргийг хэрэгжүүлнэ (фр: La

<sup>32</sup> Женерал лейтенант нь орчин үеийн дэслэгч генерал цолны нэршил болон тогтжээ

<sup>33</sup> Ш.Баасандорж. Ром-Германы эрүүгийн процесс. УБ., 2018. 169 дахь тал

<sup>34</sup> [https://fr.wikipedia.org/wiki/Code\\_des\\_dйlits\\_et\\_des\\_peines](https://fr.wikipedia.org/wiki/Code_des_dйlits_et_des_peines)




police judiciaire recherche les délits que la police administrative n'a pu empêcher de commettre, en rassemble les preuves, et en livre les auteurs aux tribunaux chargés par la loi de les punir)<sup>35</sup> гэх мэтээр зохицуулсан байна. Энэхүү эрх зүйн зохицуулалтаас хойш шүүх, цагдаагийн мөрдөн байцаалт тус тусдаа явагддаг болжээ.

Гэхдээ бүрэн нэг мөр зааглагдаж чадаагүй байсны жишээ нь 1800 –аад оны сүүл үеэр бий болсон барын бригадууд (фр:brigades du Tigre) гэрчилнэ. Учир нь Барын бригадууд францын шүүхийн цагдаагийн өвөг юм (фр:brigades du Tigre sont l'ancêtre de l'actuelle police judiciaire française)<sup>36</sup> гэсэн тодорхойлолтоос харагдаж байна.

Францын Үндэсний цагдаагийн газарт 2017 оны байдлаар 149 700 орчим албан хаагч, ажилчид ажиллаж байна. 2017 оны төсөв нь 10,48 тэрбум евро байв.

Тус улсын Үндэсний цагдаагийн ерөнхий газрын бүтэц:<sup>37</sup>



### Дүгнэлт, санал

Францын цагдаа нь жендарм болон үндэсний цагдаагийн газар гэсэн хоёр том бүтцээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тэдгээр нь өөр хоорондоо харилцан хамааралтай, тус тусын онцлогтой, түүхэн хөгжил нь өөр өөрийн замаар замнан ирсэн түүхэн үйл явцтай байна.

Францын цагдаагийн үүсэл хөгжил нь европын болон дэлхийн цагдаагийн үүсэл хөгжлийн түүхэнд голлох байр суурийг эзэлдэг цагдаа судлалын зайлшгүй судлах судалгааны объект болно.

Францын цагдаа нь үйл ажиллагаа, үйлчилгээг (фр:services), цагдаагийн хүч (фр:forces de police)-ний тусламжтайгаар гүйцэтгэдэг бөгөөд түүнийг үндсэн болон туслах хүч гэж ангилна.

Үндэсний цагдаагийн газар, Үндэсний жендармын газар нь үндсэн хүчинд, хотын цагдаагийн газар нь туслах хүчинд тус тус хамаарна.

Хэдийгээр цагдаагийн байгууллага нь ард түмэндээ үйлчилгээ үзүүлэх боловч хуулиар зөвшөөрөгдсөн хүчгүй бол тэрхүү үйлчилгээгээ үзүүлж чадахгүйд хүрэх учир хүч хэрэглэх субъект мөн.

Манай улсад цагдаа болон хууль хүчний байгууллагуудыг ерөнхийд нь хүчний байгууллага гэж нэрлэж ирсэн байдаг. Франц Улс ч Зэвсэгт хүчнээ "force armée" гэж нэрлэдэг. "Force" гэсэн монголоор хүч гэж орчуулагдах нэр үгээр тодотгож хэлдэг. Энэ нь цагдаад "forces de police" гэж хэрэглэгдэж, томъёологддог юм. Энэхүү цагдаагийн хүч нь прокурор, шүүхийн хяналтан доор, эдгээр байгууллагуудад туслах чиг үүргийн хүрээнд л явагдаж байх учиртай ажээ.

Франц Улсын цагдаагийн байгууллагын үүсэл, хөгжлөөс дүгнэхэд цагдаа нь тус улсын хөрөнгөтний ардчилсан хувьсгалын хойно буюу тус улсын нэн шинэ түүхийн үед мөрдөн

<sup>35</sup> [https://ledroitcriminel.fr/la\\_legislation\\_criminelle/anciens\\_textes/code\\_delits\\_et\\_peines\\_1795/code\\_delits\\_et\\_peines\\_1795\\_1.htm](https://ledroitcriminel.fr/la_legislation_criminelle/anciens_textes/code_delits_et_peines_1795/code_delits_et_peines_1795_1.htm)

<sup>36</sup> [https://fr.wikipedia.org/wiki/Brigades\\_regionales\\_de\\_police\\_mobile](https://fr.wikipedia.org/wiki/Brigades_regionales_de_police_mobile)

<sup>37</sup> Jacques Buisson Police pouvoirs et devoirs йditions dalloz, 2015 p-183



байцаалт явуулах эрхтэй болж, энэ чиг үүргээ зөвхөн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд туслах зорилготойгоор хэрэгжүүлж иржээ.

Харин жендармын өвөг болох марешуссее нь өөрийн харьяаллын хэрэгт мөрдөн байцаалт явуулахаас гадна шүүн тасалж байсан онцлогтой байв. Тус байгууллага нь засаглал хуваах онолын дагуу шүүн таслах эрхгүй болж, цагдаагийн адил шүүх эрх мэдэлд туслах буюу цагдаагийн мөрдөн байцаалтыг явуулдаг болжээ.

Цагдаа, жендарм аль алинд нь маршал, лейтенант, женерал (генерал) лейтенант, комиссар, комиссар мөрдөн байцаагч зэрэг нэр бүхий олон албан тушаалтнууд ажиллаж байжээ. Эдгээр нэршлүүд нь Дундад зууны эхэн үеийн буюу нэлээд эртний нэршил, нэр томьёонууд юм.

Тодруулбал, комиссар мөрдөн байцаагч гэсэн нэршлээс цагдаагийн мөрдөн байцаалт гэсэн нэршил нь эхтэй бол комиссар нь өнөөгийн цагдаагийн удирдах албан тушаалтан юм.

Цагдаагийн мөрдөн байцаалт нь хойшлуулшгүй мөрдөн байцаалт, урьдчилсан мөрдөн байцаалт гэсэн хоёр төрөлтэй байдаг. Тус улсын эрүүгийн процесс ажиллагаанд болон цагдаагийн байгууллагад мөрдөгч (фр:dйtective) гэсэн нэр томьёо хэрэглэдэггүй байна. Энэ мөрдөгч гэсэн нэршил нь хувийн мөрдөгч (фр:dйtective privй,анг:private detective) гэсэн утга, агуулгыг илэрхийлдэг ажээ.

Дээрхээс нэгтгэн дүгнэхэд тодорхой хууль зүйн нэршил, нэр томьёог өөрчлөхдөө дэлхийн дахин, олон улсын хэмжээнд судалж байж, дотоодын хууль тогтоомждоо өөрчлөн нэрлэж байх нь зүйтэй болов уу. Тийм ч учраас цагдаагийн байгууллага, түүний чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой нэршил, нэр томьёог цагдаа судлалын хүрээнд зайлшгүй нарийвчлан судлах шаардлагатай байна гэсэн саналыг дэвшүүлж байна.

### Эх сурвалжийн жагсаалт

1. Ш.Баасандорж. Ром-Германы эрүүгийн процесс. УБ., 2018.
2. Jacques Buisson Police pouvoirs et devoirs йditions dalloz, 2015
3. <https://fr.wikipedia.org/wiki/Magistrature>
4. <https://fr.wikipedia.org/wiki/Connetable>
5. [https://fr.wikipedia.org/wiki/Marechal\\_de\\_France](https://fr.wikipedia.org/wiki/Marechal_de_France)
6. [https://fr.wikipedia.org/wiki/Histoire\\_de\\_la\\_Gendarmerie\\_nationale\\_franzaise](https://fr.wikipedia.org/wiki/Histoire_de_la_Gendarmerie_nationale_franzaise)
7. <https://www.police-nationale.interieur.gouv.fr/Presentation-generale/Histoire>
8. [https://fr.wikipedia.org/wiki/Brigades\\_regionales\\_de\\_police\\_mobile](https://fr.wikipedia.org/wiki/Brigades_regionales_de_police_mobile)
9. [https://fr.wikipedia.org/wiki/Code\\_des\\_dйlits\\_et\\_des\\_peines](https://fr.wikipedia.org/wiki/Code_des_dйlits_et_des_peines)
10. <https://www.police-nationale.interieur.gouv.fr/Presentation-generale/Histoire>
11. [https://fr.wikipedia.org/wiki/Commis-saire\\_de\\_police\\_\(France\)](https://fr.wikipedia.org/wiki/Commis-saire_de_police_(France))
12. [https://fr.wikipedia.org/wiki/Popula-tion\\_des\\_villes\\_europennes\\_vers\\_1600](https://fr.wikipedia.org/wiki/Popula-tion_des_villes_europennes_vers_1600)
13. <http://www.justice.gouv.fr/histoire-et-patrimoine-10050/la-justice-dans-lhistoire-10288/le-chatelet-de-paris-24777.html>
14. [https://ledroitcriminel.fr/la\\_legislation\\_criminelle/anciens\\_textes/code\\_delits\\_et\\_peines\\_1795/code\\_delits\\_et\\_peines\\_1795\\_1.htm](https://ledroitcriminel.fr/la_legislation_criminelle/anciens_textes/code_delits_et_peines_1795/code_delits_et_peines_1795_1.htm)



## ХИЛИЙН МАНАА БИЕЙН ХҮЧ, ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ, ГАЛТ ЗЭВСЭГ ХЭРЭГЛЭХ ҮЕД ГАРЧ БОЛЗОШГҮЙ АЛДАА, ЗӨРЧЛӨӨС СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

ISSUES AND WAYS TO PREVENT VIOLATIONS DURING THE USAGE OF PHYSICAL EXERTION, SPECIAL EQUIPMENT AND FIREARMS

### Б.ЗУЛБАДРАХ

ХСИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хил судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант, дэд хурандаа

### ZULBADRAKH B.

Lieutenant Colonel, Ph.D student, Researcher of Border Studies Center, Scientific Research Institute, LEU

✉ [zulbadrakh.b@leu.gov.mn](mailto:zulbadrakh.b@leu.gov.mn)

**Товч агуулга:** Хилийн тухай хууль, дүрэм, зааврууд шинэчлэгдэж, биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх талаар орсон өөрчлөлтүүд нь улсын хил дээр үүссэн нөхцөл байдалд тохирсон зөв шийдвэр гаргах өргөн боломж, нарийн шаардлагыг бий болгосон тул улсын хил хамгаалах үүрэг гүйцэтгэж буй хилчдэд нөхцөл байдлыг зөв үнэлж, зөв шийдвэр гаргахад туслах, тэднийг болзошгүй алдаа, зөрчлөөс сэргийлэх зорилгоор Хилийн тухай хуулийн тавдугаар бүлгийн биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заалтуудыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлыг энэхүү илтгэлд тусгасан.

**Abstract:** Reforms on laws and regulations regarding the border protection has given a wide range of possibilities and strict challenge on making the right decision on situations arose at the state border. This paper reflects on issues considering the implementation of physical exertion, special equipment, firearms which are stated in article number 5 of the Law on Border in order to help border protection officers in assessing the situation, making the right solution and to prevent from possible mistakes and violations.

**Түлхүүр үгс:** Хил хамгаалалттай холбогдолтой хууль, эрх зүйн шинэчлэл, биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх эрх зүйн акт, гарч болзошгүй эрх зүйн зөрчил, сэргийлэх арга зам.

**Key words:** Legal reform on Border protection laws, legal acts on using physical exertion, special equipment, firearms, possible legal violations, ways to prevent.

### Үндсэн хэсэг

Хил хамгаалах байгууллагаас шинээр батлагдсан хууль, тогтоомж, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд “Хил хамгаалах байгууллагын алба хаагч, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх заавар”<sup>1</sup>, “Хил хамгаалах байгууллагад хэрэглэх тусгай хэрэгслийн жагсаалт”<sup>2</sup>, “Хил хамгаалах албаны бэлэн байдлын журам”, “Хилийн төлөөлөгчийн албаны заавар”<sup>3</sup>, “Хилийн зурвас, боомт, бүсэд нэвтрэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”, “Монгол Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх журам”<sup>4</sup>, “Хүүхдийг Монгол Улсын хилээр

нэвтрүүлэхэд хяналт тавих журам”<sup>5</sup>, “Штамп эзэмших, ашиглах, хадгалах журам”<sup>6</sup>, “Хилийн хуудас ашиглах, хэвлүүлэх журам”<sup>7</sup>, “Шалган нэвтрүүлэх албаны үйлчилгээний стандарт”<sup>8</sup>, “Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журам”<sup>9</sup>, “Албаны нохой бэлтгэх, ашиглах, хамгаалах журам”, Хилийн отряд, заставын зэрэглэлийг тогтоох тухай, Хилчний хувцас хэрэглэл, хүнсний хангамжийн норм, хилийн нэмэгдлийг тогтоох тухай, Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын албан тушаалын ангилал,

<sup>5</sup> Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/49 дугаар тушаал

<sup>6</sup> ХХЕГ-ын даргын 2017 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн А/112 дугаар тушаал.

<sup>7</sup> ХХЕГ-ын даргын 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/83 дугаар тушаалын 2 дугаар хавсралт.

<sup>8</sup> ХХЕГ-ын даргын 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/45 дугаар тушаал.

<sup>9</sup> Монгол Улсын Ерөнхий прокурор, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/70, А/174 дугаар хамтарсан тушаал.

<sup>1</sup> Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/160 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт.

<sup>2</sup> Мөн тушаалын 2 дугаар хавсралт

<sup>3</sup> ХХЕГ-ын даргын 07 дугаар сарын 26-ны өдрийн Н/56 дугаар тушаал.

<sup>4</sup> ХХЕГ-ын даргын 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/131 дугаар тушаал.



цэргийн цолны зэрэглэл тогтоох тухай... зэрэг 20 орчим эрх зүйн баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд "Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна"<sup>10</sup> гэж заасан бөгөөд улсын хилийн халдашгүй дархан байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг сахин хамгаалах үүрэг хүлээж, хил хамгаалах албан үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагч Хилийн тухай хуулийн дагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх эрхийг хуулиар баталгаажуулсан.

Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад хил хамгаалах байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх үндэслэл, тохиолдлуудыг зааж өгсөн боловч хил хамгаалалтын практикт эргэлзээтэй олон асуудлуудтай тулгардаг. Үүнд: хилийн манаанаас 500 м зайтай газраар хил зөрчихөөр явж байгаа автомашиныг яах вэ? Мал нь хил даваад араас нь малаа авахаар хил зөрчин орж ирсэн хил залгаа улсын малчныг яах вэ? Хилийн манааны шаардлагыг үл биелүүлсэн этгээдэд биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсгийн алиныг эхлэн хэрэглэх вэ? Хил зөрчигч явган зугааад, хилийн манаанд гүйцэгдэхгүй хил давах гэж байвал яах вэ? Хил зөрчигчийн биед үзлэг хийх үед эсэргүүцэл үзүүлбэл яах вэ? Олон нохой дагуулсан буутай хил зөрчигчийг саатуулах үед нохойгоо турхирч дайруулсан тохиолдолд яах вэ? Хил зөрчөөд нутгийн гүн рүү зугтгасан хурд, хүч, туулах чадвар сайтай автомашиныг яах вэ? Хил зөрчиж, хил орчмын нутаг дэвсгэрт нислэг үйлдэж байгаа онгоц, нисдэг тэргийг яах вэ? Хил даван застав, харуулын байрлалд нислэг үйлдэж байгаа нисгэгчгүй нисэх хэрэгслийг яах вэ? Богино зайд хил зөрчин ан хийж байгаа хил залгаа улсын хилийн албаны хүмүүсийг яах вэ? Хилийн манаа тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэсний дараа ямар арга хэмжээ авах вэ? Үүнтэй төсөөтэй олон тохиолдлуудад хилийн манаа харилцан адилгүй шийдвэр гаргаж, зарим тохиолдолд шийдвэр мэргэн байдаг бол зарим тохиолдолд бурууддаг. Иймд хилийн манаа нь хил залгаа улсын Хил хамгаалах байгууллагын хамтын ажиллагаа, цэрэг, улс төрийн байдал, улсын хил дээр үүссэн нөхцөл байдалд дүгнэлт хийж, Олон Улсын гэрээ, хэлэлцээр, Хилийн тухай хууль, тогтоомж, дүрэм, зааврууд, бусад хууль, журмыг зөрчихгүйгээр үүссэн нөхцөл байдалд тохирсон зөв шийдвэрийг богино

<sup>10</sup> Монгол Улсын Үндсэн хууль. Нэгдүгээр бүлэг. 4 дүгээр зүйл. 1 дэх заалт. УБ., 1992.

хугацаанд гаргахад туслах зорилгоор энэхүү өгүүлэлд эрх зүйн зарим тайлбарыг оруулсан.

Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж<sup>11</sup>, тус хуулиар хилчид биеийн хүч хэрэглэх,<sup>12</sup> нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэх,<sup>13</sup> тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгсэл<sup>14</sup> болон албаны нохой ашиглах<sup>15</sup> талаар шинээр заалт оруулж, Хилийн цэргийн анги, салбар, хилийн манаанаас галт зэвсэг хэрэглэх талаарх заалтад өөрчлөлт оруулсан<sup>16</sup> зэрэг эрх зүйн шинэ зохицуулалтыг хуульчилж өгсөн нь галт зэвсэг хэрэглэх явдлыг бууруулах, түүнээс үүдэн гарч болзошгүй хохирлыг багасгах ач холбогдолтой болсон гэж үзэж байна.

Хилийн цэргийн анги, салбар, хилийн манаа нь 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан Монгол Улсын Хилийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ тавдугаар бүлгийн 40-48 дугаар зүйлд заасны дагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, албаны нохой, галт зэвсэг хэрэглэхийг хуулиар зөвшөөрсөн хэдий боловч буруу хэрэглэсэн тохиолдолд залруулж болохгүй алдаа, хор уршгийг дагуулдаг болохыг хатуу анхаарч энэхүү хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан журам, зааврыг хилийн манаа, хилчин нэг бүрд хүргэж, сургалт дадлага явуулах нь болзошгүй ажиллагааны үед ажиллах дадлага чадварыг бий болгодог. Энэхүү дадлагыг заставын дарга өөрөө биечлэн хариуцаж өдөр бүр томилгооны хуваарийн дараа 5-10 минут жагсаалын талбайд хилийн албаны тактикийн бодлого бодуулах жүжигчилсэн тоглолт байдлаар явуулахад бүрэлдэхүүн амархан дадлагаждаг, отрядын төвд тусгай хөтөлбөрөөр сургалтыг явуулж, үзүүлэх хичээл, хээрийн гаралтаар бататгаж байх нь оновчтой байдаг.

### Нэг. Биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх

Улсын хилд үүрэг гүйцэтгэж байгаа хилчин үүссэн нөхцөл байдлаас шалтгаалж, нэг бүрийн тусгай хэрэгслийг Монгол улсын Хилийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр бие даан шийдвэр гаргаж хэрэглэнэ. Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх явцад эсхүл нэг бүрийн тусгай хэрэгсэл байхгүй,

<sup>11</sup> Төрийн мэдээлэл. №06. УБ., 2017.

<sup>12</sup> Монгол Улсын Хилийн тухай хууль. /шинэчилсэн найруулга/ 40 дүгээр зүйл. УБ., 2016.

<sup>13</sup> Хилийн тухай хуулийн 41, 42, 43, 44, 45 дугаар зүйл.

<sup>14</sup> Хилийн тухай хуулийн 46 дугаар зүйл.

<sup>15</sup> Хилийн тухай хуулийн 47 дугаар зүйл.

<sup>16</sup> Хилийн тухай хуулийн 48 дугаар зүйл.



түүнийг хэрэглэх боломжгүй үед Хилийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан үндэслэлээр биеийн хүч хэрэглэнэ. Биеийн хүч хэрэглэх гэж хилчин өөрийн бие махбод, мэргэжлийн тусгай бэлтгэлийг ашиглан бусдын хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор биеэр хийх үйлдлийг ойлгоно.<sup>17</sup>

Тусгай хэрэгсэл гэж хилийн манаа, бүлэг улсын хилийн бүс, зурвас, боомтод албан үүрэг гүйцэтгэх үед хил орчмын иргэд, байгууллага, хилчдийн амь нас, эрүүл мэндэд хил зөрчигч, гэмт этгээдийн зүгээс халдлага үйлдэх, боомтын аюулгүй байдлыг сахиулах, таслан зогсоох үед хэрэглэх зориулалт бүхий тусгай хэрэгсэл, төхөөрөмж<sup>18</sup>-ийг хэлнэ.

Хилийн манаа нь хил зөрчигчийг саатуулах, баривчлах үед эсэргүүцэл үзүүлсэн тохиолдолд биеийн хүч хэрэглэхийг урьтал болгохгүйгээр урьдчилан сануулж, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэж аюулгүй байдлаа хангана. Учир нь хил зөрчигч тулааны болон самбо, жүдогийн хориотой техник эзэмшсэн, бэлтгэгдсэн хүн байж болох талтай.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг Хилийн тухай хуулийн 45 дугаар зүйлд заасан үндэслэлээр Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч, түүний эрх олгосноор тухайн ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтны шийдвэрээр хэрэглэнэ. /ХЗДХ-ийн сайдын А/160 дугаар тушаалаас/

Хил хамгаалах байгууллагын алба хаагч биеийн хүч тусгай хэрэгслийг хэрэглэх зааварт дараах шаардлагууд тавигддаг.<sup>19</sup> Үүнд:

1. Алба хаагч нь биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх сургалтад хамрагдсан байх. Хил хамгаалах, хууль сахиулах албан үүргээ гүйцэтгэхийн тулд өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, өрсөлдөгч этгээдийг гэмтээж эрхшээлдээ оруулах, барьж баривчлахад биеийн хүч, тусгай хэрэгсэл ашиглах сургалт нь чиглэгддэг<sup>20</sup>.

Биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх сургалт нь гүйцэтгэх үүргээрээ саатуулах, баривчлах, үзлэг хийх, өөрийгөө хамгаалах, бусдыг

<sup>17</sup> Монгол Улсын Хилийн тухай хууль. Тавдугаар бүлэг. Тайлбар хэсэг. УБ., 2016.

<sup>18</sup> Г.Даваадорж. Д.Батгэрэл. Б.Батжав, "Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагааны үндэс". УБ., 2009.

<sup>19</sup> Хууль зүй дотоод хэргийн сайдын тушаал. 2017. 06. 09. А/160. Нэгдүгээр хавсралт. Хил хамгаалах байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх заавар. 1.3 дугаар заалт.

<sup>20</sup> С.Хаянгарваа. Хууль сахиулах үйл ажиллагаа: онол, практикийн тулгамдсан асуудал сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. 407 дугаар тал. УБ., 2016.

хамгаалах, журам сахиулах, амьд үлдэх..., сургалтын төрлөөрөө үндэсний бөх, жүдо, байлдааны самбо, каратэ ... гэх мэт олон хэлбэртэй байдаг бөгөөд тухай бүрдээ өөрийн гэсэн онцлогтой тул сургалтын хөтөлбөрийг боловсруулахад анхаарах шаардлагатай. Хамгийн гол нь эрх зүйн мэдлэг буюу Хилийн тухай хуулийн 5 дугаар бүлгийн бүх заалтууд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/160 дугаар тушаал, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг нарийн судлуулж, дадлага хийлгэж хэвшил болгосноор болзошгүй аюулаас сэргийлнэ.

2. Биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх тухайгаа урьдчилан сануулах. Урьдчилан сануулснаар Хилийн тухай хуулийн тавдугаар бүлгийн 40 дүгээр зүйлд заасан биеийн хүч хэрэглэх, 43 дугаар зүйлийн 43.1.1, 43.1.2, 43.1.3, 43.1.7, 43.2-д заасан нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхээр заасан нөхцөл байдал өөрчлөгдөж улмаар биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх шаардлагагүй болох боломжтой. Иймд урьдчилан анхааруулах нь чухал ач холбогдолтой.

3. Үүссэн нөхцөл байдалд иргэд, байгууллагад хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх. Иргэд байгууллагад хамгийн бага хохирол учруулах боломж нь нөхцөл байдал тохирсон зөв шийдвэр гаргахаас шууд шалтгаалдаг.

4. Хүнлэг бус харьцаанаас ангид байх. Хилчид ёс суртахуунгүй үйлдэл гаргахгүй, хараалын үг хэллэг хэрэглэхгүйгээр хуулийг хэрэгжүүлж, үүссэн нөхцөл байдлыг арилгана гэсэн үг. Биеийн хүч, тусгай хэрэгслийг хэрэглэх гэдэг нь бусдын амь нас, эрүүл мэндийг хохирооно гэсэн үг биш. Энэ шийдвэр залруулшгүй алдаанд хүргэж мэднэ. Хил зөрчигч, гэм буруутай этгээд ч гэсэн хүн. Магадгүй, нэгэн өрхийн амьдралыг үрч яваа хүн байж болох тул тэднийг өнчрүүлж хэрэггүй, хүнлэг бай. Хүнлэг байснаар болзошгүй гэмт хэргээс өөрийгөө хамгаална.

5. Бусдын биед гэмтэл, эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх. Гэмтэж, эрүүл мэндэд хохирол учирсан хүн нь хэн ч байлаа гэсэн эмнэлгийн анхны тусламжийг үзүүлж, хамгийн ойрхон байгаа эмнэлэг, эмчийн үзлэгт оруулах шаардлагатай. Бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол шууд захирах даргад даруй илтгэж, илтгэх хуудсаар танилцуулна. Шууд захирах дарга<sup>21</sup> харьяа нутаг дэвсгэрийн прокурорт нэн даруй мэдэгдэнэ. Олон хүнд нөлөөлөх тусгай

<sup>21</sup> Цэргийн дотоод албаны дүрэм. Хоёрдугаар бүлэг. 21 дүгээр заалт. Шууд захирах дарга.



хэрэгслийг эмнэлгийн тусламж, үйлчилгээг яаралтай үзүүлж чадах тийм нөхцөлд ашиглах хэрэгтэй. Учир нь тэдний дунд хүүхэд, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай, бэртэл гэмтэлтэй, хууч өвчтэй хүмүүс байх тул амь насаа алдаж болох өндөр эрсдэлтэй юм. Хэрэв командлагчаас шийдвэр ирж олон хүнд нөлөөлөх хэрэгслийг хэрэглэсэн тохиолдолд үйл ажиллагааны явцыг гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр баримтжуулах бүлгийг томилж ажиллуулна. Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэсэн даруй тухайн ажиллагааг удирдсан албан тушаалтан Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагчид илтгэнэ.<sup>22</sup>

Хил хамгаалах байгууллагад хэрэглэгдэх тусгай хэрэгслийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/160 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан бөгөөд хүн нэг бүрийн тусгай хэрэгсэлд 25, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэлд 5, тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгсэлд 2 төрлийн тусгай хэрэгслийг зааж өгсөн. Эдгээр тусгай хэрэгсэлд ороогүй хэрэгслийг ашиглах, гарын доорх материалыг тусгай хэрэгслийг орлуулан хэрэглэх талаар хуульд заагаагүй, зааварт тусгагдаагүй тул аргагүй хамгаалалтаас бусад тохиолдолд хэрэглэхгүй байхыг зөвлөж байна.

Хилийн заставын тусгай хэрэгсэлд шаардлагатай зүйлсийн талаар ХСИС-ийн сургуулийн Удирдлагын академийн 24, Хил судлалын магистрын ангийн 36, Хилийн 0146 дугаар ангийн 56 офицер, нийт 116 хүнээс судалгаа авч, үр дүнг нэгтгэсэн. Хилийн тухай хууль, Хил хамгаалах байгууллагад ашиглах тусгай хэрэгслийн жагсаалтад ороогүй, судалгаанд хамгийн их санал өгсөн дараах тусгай хэрэгслүүд байгааг анхаарах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

Хар тамхины сорьц, хурууны хээ авах хэрэгсэл, ул мөр баримтжуулах хэв, биеийн дулаан хэмжих багаж, томруулагч шил, шүгэл, GPS, энгэрийн нууц дуу дүрс бичигч, нүдний боолт, чанга яригч, камертай дуулга малгай, уян камер, сансрын холбоо, олс /бөөн иргэдийг хэсэгчлэн хуваах/, уул, цасанд авирах улавч, гутлын гинж, муурын хумс, цан, байршил мэдээлэгч чип, хийлдэг гудас, бороо цаснаас хамгаалах нөмрөг, торон буу, нүүрний будаг, талбай тусгаарлах тууз, усны хамгаалалттай хайрцаг, флаш диск, толгойн гэрэл гэсэн нь жагсаалтад ороогүй хил хамгаалалтад хэрэгцээтэй тусгай хэрэгслүүд олон байгааг харуулж байна.

<sup>22</sup> Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал. А/160. 1 дүгээр хавсралт. 5.10 дугаар заалт.

Улсын хилд албан үүрэг гүйцэтгэж байгаа хилчин биеийн хүч хэрэглэх үед гаргаж болзошгүй алдаа, түүнээс сэргийлэх. Үүнд:

- Тухайн нөхцөл байдлыг дутуу үнэлж, хүч хэрэглэх сонголтоо буруу хийх. Энэ нь тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх нөхцөл байдлыг дутуу үнэлснээс хилчид хариу халдлага довтолгоонд өртөх аюултай.

- Харилцаж байгаа этгээдийн нас, хүйс, биеийн хэмжээ, эсэргүүцэл үзүүлэх чадварыг буруу үнэлэх. Энэ тохиолдолд бусдын амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах, аль эсвэл хариу үйлдэлд өртөх аюултай.

- Тухайн этгээдийн ойр орчиндоо болон бусдад учруулж болох аюул, эрсдэл, биедээ нуусан зэвсэг, зэвсгийн чанартай зүйлийг дутуу тооцоолох. Тиймээс биеийн хүч хэрэглэхээс өмнө биедээ авч яваа бүх зүйлийг газарт хаяулан түүнээс 10 м холдуулсны дараа биеийн хүч хэрэглэж баривчлах, саатуулах ажиллагааг явуулах хэрэгтэй.

- Амьд үлдэх тулааны хориотой мэх хэрэглэж, харилцагч этгээдийн бие махбодод хүнд гэмтэл учруулах. Тухайн нөхцөл байдал, харилцагч этгээдэд тохирсон биеийн хүчний арга хэлбэрийг сонгож баривчлах, саатуулах, аюулгүй болгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- Биеийн хүч хэрэглэсний дараа харилцагч этгээдэд зовуурьтай шинж илэрсэн үед эмнэлгийн тусламжийг яаралтай үзүүлэх, эмч, эмнэлгийн байгууллагад хандах. Харилцагч этгээд суурь өвчтэй, гэмтэл бэртэлтэй байж болзошгүйг анхаарах хэрэгтэй.

Улсын хилд албан үүрэг гүйцэтгэж байгаа хилчин тусгай хэрэгсэл хэрэглэх үед гаргаж болзошгүй алдаа, зөрчил түүнээс сэргийлэх. Үүнд:

- Тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэрийг буруу гаргах. Нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх шийдвэрийг улсын хилд үүрэг гүйцэтгэж байгаа хилчин бие даан гаргадаг байхад тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгслийг хэрэглэх шийдвэрийг хилийн анги /салбар/-ийн захирагч, эсхүл тухайн ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэх шийдвэрийг Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч тус тус гаргадаг.

- Тусгай хэрэгслийг хэрэглэх шийдвэр нь үүссэн нөхцөл байдал, хуульд заасан үндэслэлтэй тохироогүй байх. Нэг бүрийн тусгай хэрэгслийг Монгол Улсын хилийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 1-д заасан





8 тохиолдол, 2-д заасан 3 тохиолдолд хэрэглэдэг байхад олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг тус хуулийн 45.2-д заасан 5 тохиолдолд 45.3.1, 45.3.2, 45.4 -д заасан анхааруулга, мэдээлэл хийж, 45.5-д заасан хугацаанд, үйлдлээ зогсоогоогүй, шаардлагыг биелүүлээгүй, эсхүл хүний амь нас, эрүүл мэнд хохирох эрсдэл бүхий нөхцөл байдал үүссэн бол хэрэглэдэг. Харин тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгслийг Хилийн тухай хуулийн 46.1-д заасан 3 тохиолдолд хэрэглэхийг зөвшөөрдөг бол 46.2-д заасан тохиолдолд хориглодог.

- Хүний биеийн хориглосон хэсэгт тусгай хэрэгсэл хэрэглэх, тусгай хэрэгслийг хэрэглэх хугацаа, зай, хэмжээ, орчин нөхцөл, аргаа буруу сонгох. Хил хамгаалах байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх зааварт гав, хүлэг, ороох цамц, бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, цахилгаан гүйдлээр цохигч буу, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр, резин болон хуванцар, үрлэн сумтай буу, тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгсэл, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх<sup>23</sup> талаар тодорхой заавруудыг тусган оруулсан байгаа бөгөөд хэрэглэх явцад эдгээр зааврын зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ<sup>24</sup> гэж заасан. Иймд эдгээр заалтуудыг хилчин бүр мэдэж, тусгай хэрэгсэл хэрэглэхдээ баримталж хэвшсэнээр эрх зүйн зөрчил гаргахгүй байх нөхцөл бүрэлдэнэ.

### Хоёр. Галт зэвсэг хэрэглэх

Хилийн цэргийн анги, салбар, хилийн манаа нь Хилийн тухай хуульд зааснаар урьдчилан анхааруулж болон анхааруулахгүйгээр галт зэвсгийг хэрэглэдэг. ХХЕГ-ын даргын н/24 тоот тушаалд хилийн манааны ахлагчийн шийдвэрээр галт зэвсэг хэрэглэхээр зааж өгсөн. Монгол Улсын Галт зэвсгийн тухай хуульд “галт зэвсэг” гэж даринь шаталтаас үүссэн өндөр даралтын хүчээр сумны хошуу болон үрэл гол төмрөөс шидэгдэж амьд болон бусад биетийг гэмтээх, хөнөөх, устгах зориулалт бүхий буудлагын хэрэгслийг<sup>25</sup>, “байлдааны зориулалттай галт зэвсэг” гэж байлдааны

болон тусгай ажиллагаанд ашиглах зэвсэг, галт хэрэгсэл, түүний эд ангийг<sup>26</sup> тус тус заасан байдаг.

Хилийн цэргийн анги, салбар, хилийн манаа нь урьдчилан анхааруулахгүйгээр дараах тохиолдолд галт зэвсэг хэрэглэнэ<sup>27</sup> гэж заасан.

**1. Монгол Улсын нутаг дэвсгэрт цөмөрсөн зэвсэгт халдлагыг няцаахын тулд урьдчилан анхааруулахгүйгээр галт зэвсэг хэрэглэх.** Энэ заалт нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн аюулгүй байдалд цэрэг, зэвсгийн хүчээр түрэмгийлэл үйлдсэн тохиолдолд дайсан этгээдэд байлдааны зэвсгээр боломжит бүх хөнөөлийг гэнэт учруулах талаар тусгасан.

**2. Улсын хил дээр үүссэн зэвсэгт өдөөн хатгалга, хорлон сүйтгэх ажиллагааг таслан зогсоохын тулд урьдчилан анхааруулахгүйгээр галт зэвсэг хэрэглэх.** Хилийн тухай хуульд зэвсэгт өдөөн хатгалгын үед урьдчилан анхааруулахгүйгээр<sup>28</sup>, өдөөн хатгалгын үед урьдчилан анхааруулж зэвсэг хэрэглэхээр заасан.<sup>29</sup> Монгол Улсын цэргийн номлолд “Зэвсэгт өдөөн хатгалга”-ыг дайн, зэвсэгт түрэмгийлэлд турхирч буй анхны хэлбэр гэж үздэг бөгөөд энэ нь улсын хил давж, зэвсэг хэрэглэн дээрэм, тонуул хийх хэлбэрээр илэрдэг. “Хорлон сүйтгэх” гэдгийг “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, батлан хамгаалах, эдийн засгийн хүчин чадлыг сулруулах зорилгоор барилга байгууламж, зам, мэдээлэл, холбооны хэрэгсэл, үндэсний шинж чанартай мэдээллийн сан, архив, хүн амын амьдралыг хангах объектыг сүйтгэсэн, гэмтээсэн, үйл ажиллагааг нь доголдуулсан; хүн, амьтан, ургамлын гоц халдварт өвчин тараасан<sup>30</sup>...” гэж Эрүүгийн хуульд заажээ. Эндээс дүгнэлт хийхэд Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, батлан хамгаалах, эдийн засгийн хүчин чадлыг сулруулах зорилгоор улсын хил давж, дайн түрэмгийлэлд турхирсан үйлдлийг урьдчилан анхааруулахгүйгээр галт зэвсэг хэрэглэж таслан зогсооно гэсэн үг.

<sup>26</sup> Монгол Улсын Галт зэвсгийн тухай хууль. 1 дүгээр бүлэг. 3 дугаар зүйл. 3.1.1 дүгээр заалт.

<sup>27</sup> Монгол Улсын Хилийн тухай хуулийн тавдугаар бүлгийн 48 дугаар зүйлийн 48.1 дүгээр заалт.

<sup>28</sup> Монгол Улсын Хилийн тухай хууль. 5 дугаар бүлэг. 48 дугаар зүйл. 48.1.2 дугаар заалт.

<sup>29</sup> Монгол Улсын Хилийн тухай хуулийн тавдугаар бүлгийн 48 дугаар зүйлийн 48.2.1 дүгээр заалт.

<sup>30</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль. 19.6 дугаар зүйл. Хорлон сүйтгэх. УБ., 2015.

<sup>23</sup> Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал. А/160. 3, 4, 5 дугаар заалт

<sup>24</sup> Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал. А/160. 6 дугаар заалт

<sup>25</sup> Монгол Улсын Галт зэвсгийн тухай хууль. 1 дүгээр бүлэг. 3 дугаар зүйл. 3.1.1 дүгээр заалт. УБ., 2015.



### 3. Хил зөрчигчийн зэвсэгт эсэргүүцлийг таслан зогсоохын тулд урьдчилан анхааруулахгүйгээр зэвсэг хэрэглэх.

Эрүүгийн хуульд “Зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл” гэж иж бүрдэл, бүтцийн хувьд аливаа биетийг устгах, гэмтээх, бие хамгаалах, дохио өгөх зориулалттай эд зүйл, тоног төхөөрөмж, хэрэгслийг хамааруулж ойлгоно. Зэвсэг нь галт, хүйтэн, хийн, үйлдвэрийн, гар хийцийн аль нь ч байж болно. “Тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл” гэж хүний биед гэмтэл, эд хөрөнгөд хохирол учруулахаар тусгайлан бэлтгэсэн, засаж тохируулсан хүйтэн зэвсэг, галт зэвсэг, эд зүйл, хэрэгслийг ойлгоно<sup>31</sup>. Эсэргүүцэл гэдэг нь хил зөрчигч, гэм буруутай этгээдийг саатуулах явцад өөрийн амь нас, эрүүл мэндэд бодит аюул, хор уршиг учруулахаар хийж буй үйлдлийг хэлнэ. Эсэргүүцэл нь эс үйлдлийн шинжтэй байж болохгүй. Өөрөөр хэлбэл хил зөрчигчийн зэвсэгт эсэргүүцэл бодитоор үүссэн үед аргагүй хамгаалалтын хэлбэрээр галт зэвсэг хэрэглэнэ гэсэн үг. Энэ тохиолдолд зэвсэг хэрэглэхдээ хил зөрчигчийн зэвсэгт эсэргүүцлийг эхний сумаар таслан зогсоосон бол дахин нэг удаа хий буудаж анхааруулах нь зүйтэй. Энэ нь хил зөрчигчийн дахин зэвсэгт эсэргүүцэл үзүүлэх санаархлыг дарахаас гадна, хуулийн өмнө хил зөрчигчийн зүгээс зэвсэгт эсэргүүцэл үзүүлээгүй гэсэн буруу дүгнэлт гарсан үед урьдчилан нэг удаа буудаж анхааруулсан гэж үзэх боломжтой болно. Хил зөрчигчийн зэвсэгт эсэргүүцлийг таслан зогсоохын тулд галт зэвсэг хэрэглэхдээ өөрийнхөө аюулгүй байдлыг бүрэн хангахын зэрэгцээ, хил зөрчигчийн амь нас, эрүүл мэндэд аль болох бага хохиролтой байхаар тооцоолох нь зүйтэй. Жишээ нь: эсэргүүцэл үзүүлж буй зэвсгийг нь устгах, боломжгүй бол амь наснаас аль болох хол хөндий хуруу, гар, хөл зэрэг эрхтэнд галт зэвсэг хэрэглэх бөгөөд хэрэв галт зэвсэг хэрэглэсэн тохиолдолд нэн даруй хил зөрчигчийг зэвсгээс нь холдуулан аюулгүй болгож, эмнэлгийн анхны тусламжийг гарын доорх материал ашиглаж, яаралтай үзүүлнэ. Хугацаа алдвал хил зөрчигчийн амь насанд аюултай тул хамгийн ойрхон байгаа отряд, застав, харуул, хөрш манаа болон сум, суурин, ард иргэдээс яаралтай тусламж авна.

<sup>31</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2015.

### 4. Хилийн зурвас, хилийн боомт, бүсэд хүн, тээврийн хэрэгслийг барьцаалсан болон террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны үед урьдчилан анхааруулахгүйгээр галт зэвсэг хэрэглэх. /Хилийн тухай хуульд шинээр нэмэгдсэн заалт. 2016 он/

Монгол Улсын Эрүүгийн хуульд хүн барьцаалах гэмт хэргийг “Суллах нөхцөл болгон тодорхой үйлдэл хийлгэх, үйлдэл хийхээс түдгэлзүүлэхэд төр, байгууллага, хүнийг албадах зорилгоор болзол тулгаж барьцааны хүнийг алахаар, эрүүл мэндэд хохирол учруулахаар заналхийлж эрхшээлдээ байлгасан<sup>32</sup>...”, террор үйлдэх гэмт хэргийг “Төр, олон улсын байгууллагаас тодорхой шийдвэр гаргуулах, гаргасан шийдвэрийг өөрчлүүлэх, шийдвэр гаргахаас татгалзуулах зорилгоор галдан шатаах, цахим сүлжээ, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, хими, биологийн хортой, аюултай бодис ашиглаж, ашиглахаар заналхийлж хүн амыг айдаст автуулсан; хүнийг алсан, эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан; зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд сөргөлдөгч аль нэг талд идэвхтэй оролцоогүй хүний амь бие, бие махбодод халдсан<sup>33</sup>...” гэж тодорхойлсон байдаг.

Монгол Улсын Терроризмтой тэмцэх тухай хуульд “терроризм” гэж хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж буй харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх ажиллагааг<sup>34</sup>, “террорист үйлдэл” гэж хүн амд айдас төрүүлэх, эсхүл энэ зорилгоор иргэнийг төрийн байгууллага, олон улсын байгууллагаас аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийхийг шаардах, эсхүл зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд сөргөлдөгч аль нэг талд идэвхтэй оролцоогүй иргэний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулах санаатай үйлдлийг<sup>35</sup>, “террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа” гэж террор ажиллагаа, террорист үйлдлийг илрүүлэн таслан зогсоох, террорист этгээдийг аюулгүй болгох, баривчлах зорилгоор цагдаа, тагнуулын болон цэргийн салбар,

<sup>32</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль. 13.3 дугаар зүйл. Хүн барьцаалах. УБ., 2015.

<sup>33</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль. 29.8 дугаар зүйл. Террор үйлдэх. УБ., 2015.

<sup>34</sup> Монгол Улсын Терроризмтай тэмцэх тухай хууль. 3 дугаар зүйл. 3.1.1 дүгээр заалт. УБ., 2004.

<sup>35</sup> Монгол Улсын Терроризмтай тэмцэх тухай хууль. 3 дугаар зүйл. 3.1.4 дүгээр заалт. УБ., 2004.



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮГИЙН ХУУЛЬ  
САХИУЛАХУЙ



байгууллагын хүч хэрэгслээр нэгдмэл бодлого, төлөвлөгөө, нэгэн удирдлагаар гүйцэтгэх ажиллагааг<sup>36</sup> тус тус нэрлэсэн байдаг. Эдгээр хуулийн заалтуудаас харахад хилийн зурвас, хилийн боомт, бүсэд хүн, тээврийн хэрэгслийг барьцаалсан болон террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны үед галт зэвсэг хэрэглэх нь нэгдмэл бодлого, төлөвлөгөө, нэгэн удирдлагын дор явагдах нь харагдаж байна.

**5. Улсын хил хамгаалах байгууллагын хамгаалалтад байгаа объектод хүч хэрэглэн халдсан, халдахыг завдсан тохиолдолд урьдчилан анхааруулахгүйгээр галт зэвсэг хэрэглэх. /Хилийн тухай хуульд шинээр нэмэгдсэн заалт. 2016 он/**

“Объектын хамгаалалт” гэж улсын онц чухал объектын хэвийн ажиллагааг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалж байгаа объектод нэвтрэх хүн, эд зүйл, тээврийн хэрэгслийг шалгах, хамгаалалтын бүсэд тогтоосон дэглэм, журмыг сахиулах цогц үйл ажиллагааг<sup>37</sup> хэлдэг. Хил хамгаалах байгууллагын зарим анги /салбар/-ууд цэргийн зориулалттай онц чухал объект, зэвсэг, галт хэрэглэлийн агуулахын хамгаалалтад үүрэг гүйцэтгэдэг. Хамгаалалтад байгаа объектод хүч хэрэглэн халдсан гэж заасан нь тухайн объектыг дээрэмдэх, булаан эзлэх, устгах зорилго агуулж байгаа тул галт зэвсэг хэрэглэх шаардлага болж байна гэж үзэх хэрэгтэй. Дээрх зорилго агуулаагүй төөрч будилсан, андуурч бухимдсан, согтуурч мансуурсан этгээдийн объектод ойртон ирсэн үйлдлийг галт зэвсэг хэрэглэн зогсоож хэрхэвч болохгүйг хатуу анхаарах хэрэгтэй бөгөөд анхааруулга, санамж өгч үйлдлийг зогсоогоод холбооны хэрэгслээр удирдлагад яаралтай илтгэнэ.

Хил хамгаалах байгууллагын хамгаалалтад байгаа объектод нисгэгчгүй нисэх хэрэгслээр зураг авах, бичлэг хийх нь хүч хэрэглэн халдахыг завдаж байгаа үйлдэл гэж үзэх үндэслэлтэй тул галт зэвсэг хэрэглэж, тус үйлдлийг таслан зогсоох шаардлагатай.


Хилийн манаа урьдчилан анхааруулах дохио өгсөн боловч уг халдлага, довтолгоон үргэлжилбэл дараах тохиолдолд галт зэвсэг хэрэглэнэ.<sup>38</sup>

1. Улсын хил дээр үүссэн өдөөн хатгалга, хил зөрчигчийн үйлдлийг өөр арга, хэрэгслээр зогсоох боломжгүй тохиолдолд урьдчилан анхааруулж, галт зэвсэг хэрэглэх. Хил зөрчигчийн өдөөн хатгасан /богино зайд хил зөрчиж, хилчдийг даллаж дуудах, хил зөрчихийн тулд эд зүйл өгөхөөр амлах, дохио зангаа үзүүлэх гэх мэт/ ажиллагаа, хил зөрчсөн болон зөрчихөөр завдсан үйлдэл хөдөлгөөн нь гүн тийш болон хил даван зугтахаар чиглэгдсэн түүнийг хилийн манаа зогсоох боломжгүй болсон үед урьдчилан анхааруулах зорилгоор галт зэвсэг хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл хилийн манаа тухайн этгээдийг зогсохыг шаардаж анхааруулан 3 хүртэл удаа хий буудах бөгөөд зогсохгүй тохиолдолд уналгыг нь галт зэвсэг хэрэглэж зогсооно гэсэн үг. Гэвч холын зайд уналгыг нь буудахдаа алдаж буудах, хад чулуу, газрын хатуу гадаргууд сум ойх зэргээс хамааран зөрчил гаргагч этгээд, түүний хамсаатныг онож гэмтээх, улмаар амь насаа алдаж, хилийн манаа зэвсэг хэрэглэсний улмаас буруудах, хариуцлага хүлээх тохиолдол байдаг тул урьдчилан анхааруулж, хий буудан зогсохыг шаардаад зөрчил гаргагч этгээдийн уналгыг мэргэн онож зогсоох боломжгүй тохиолдолд галт зэвсгээр чиглүүлэн буудахгүйгээр, улсын хил зөрчсөн, зөрчихийг завдсан мэдээг отряд, застав, харуулын даргад яаралтай илтгэх хэрэгтэй. Гүн тийш зугтсан хөдөлгөөнийг харилцан ажиллагаатай байгууллага, орон нутгийн иргэд, ХХТХГ-тэй хамтран саатуулах бөгөөд хил зөрчсөн/давсан/ хөдөлгөөнийг Хилийн төлөөлөгчийн холбоогоор хил залгаа улсын хил хамгаалах салбарт шуурхай мэдэгдэж саатуулах арга хэмжээ авах нь хилийн төлөөлөгчийн хамтын ажиллагаа өргөжсөн өнөө үед илүү үр дүнтэй арга юм. /Зураг 1/ Ачааны автомашиныг дугуй болон явах эд анги, түлшний саванд галт зэвсэг хэрэглэж зогсоох боломжтой, харин суудлын жижиг тэрэгний жолооч, зорчигчид суманд өртөх магадлал өндөр байдаг.

<sup>36</sup> Монгол Улсын Терроризмтай тэмцэх тухай хууль. 3 дугаар зүйл. 3.1.9 дүгээр заалт. УБ., 2004.

<sup>37</sup> Монгол Улсын Дотоодын цэргийн тухай хууль. Нийтлэг үндэслэл. 4 дүгээр зүйл. 4.1.4 дүгээр заалт. УБ., 2017.

<sup>38</sup> Монгол Улсын Хилийн тухай хууль. 5 дугаар бүлэг. 48 дугаар зүйл. 48.2 дугаар заалт.



Зураг 1. Хил залгаа улстай хамтран хил зөрчигчийг саатуулах

Хил зөрчигч гэм буруутай ч хүн гэдэг үүднээс хүндэтгэлтэй хандах, галт зэвсэг, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэж, амь нас, эрүүл мэндэд нь ноцтой хохирол учруулахгүй байх хүнлэг ёсны зарчмыг баримтлах хэрэгтэй. Хил зөрчигчийн зугтаж байгаа үйлдлийг галт зэвсэг хэрэглэн зогсоох нь тийм ч оновчтой шийдэл биш бөгөөд аль болох зайлсхийх хэрэгтэйг зөвлөж байна.

2. Иргэний өмчийг зэвсэгт халдлагаас хамгаалах арга хэмжээ авсан боловч таслан зогсоогдохгүй тохиолдолд урьдчилан анхааруулж галт зэвсэг хэрэглэх<sup>39</sup>.

Хил зөрчин байгалийн баялаг, ашигт малтмал ашиглах, ховордсон ан амьтан агнах, хил орчмын ард иргэдийг дээрэмдэх, адуу мал хил давуулан хулгайлах гэх мэт хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг галт зэвсэг хэрэглэхгүйгээр таслан зогсоох ямар ч боломжгүй үед эцсийн арга хэмжээ болгон хилийн манаа нь урьдчилан анхааруулж галт зэвсэг хэрэглэнэ. Урьдчилан анхааруулж дээш хий буудахад уг халдлага зогсоогдож, хил зөрчигч, гэмт этгээд бултан зугтасан үед дахин галт зэвсэг хэрэглэх шаардлагагүй гэсэн үг. Харин таслан зогсоогдохгүй уг халдлага довтолгоон үргэлжилбэл хил зөрчигч, гэмт этгээдийн үйлдлийг таслан зогсоох зорилгоор тэдний халдлагад ашиглаж байгаа зэвсэг, уналга хэрэгсэлд галт зэвсэг хэрэглэнэ. Халдлага зогсоогдвол нэмэлт хүч дуудаж, саатуулах, баримтжуулах ажиллагаа явуулна. Халдлага таслан зогсоогдохгүй бол хил зөрчигч, гэмт этгээдийн хуруу, гар, хөл зэрэг аминаас зайтай эрхтэнд галт зэвсэг хэрэглэн халдлагыг даамжруулахгүйгээр таслан зогсоож, яаралтай тусламж дуудан,

эмнэлгийн анхны тусламж үзүүлнэ. Аж ахуйн зорилгоор хил зөрчих гэж байгаа үйлдлийг харсан хилийн манааг хил зөрчигчид буц, улсын хил гэсэн дохиог харуулж хил зөрчихөөс сэргийлнэ. Хил давж байгаа малыг хилийн манаа уг чиглэлээр нь буцааж гаргана. Зарим тохиолдолд хилийн манаа хил зөрчигч барих хүсэл сонирхолдоо хөтлөгдөж, хил давж ирсэн малын хажууд отолт хийж байгаад хил залгаа улсын малчин малаа авахаар хил зөрчих үед саатуулдаг, саатуулах үед буцаад зугтахад анхааруулж, галт зэвсэг хэрэглэдэг нь Олон Улсын гэрээ, хэлэлцээрийг ноцтой зөрчиж байгаа хэлбэр гэдгийг хатуу анхаарна уу.

3. Хилчин, иргэний амь нас, аюулгүй байдалд заналхийлсэн нь зэвсэг хэрэглэхгүйгээр зогсоох бололцоогүй тохиолдолд урьдчилан анхааруулж галт зэвсэг хэрэглэх.<sup>40</sup>

Энэхүү заалтын дагуу хилчин, иргэний амь нас, аюулгүй байдлыг хамгаалахын тулд хилийн манаа хуулиар олгогдсон эрх, хүлээсэн үүргийн хүрээнд өөр арга хэрэгслээр зогсоох бололцоогүй үед урьдчилан анхааруулж, галт зэвсэг хэрэглэнэ. Энэ аргагүй хамгаалалтын нөхцөлтэй ижилхэн байна гэсэн үг. Монгол Улсын Эрүүгийн хуульд аргагүй хамгаалалт гэж өөрийн, ойр дотны хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг хууль бус ба тулгарсан довтолгооны эсрэг хийсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг хэлэх бөгөөд гэмт хэрэгт тооцохгүй. Аливаа хүн мэргэжил, тусгай бэлтгэл, албан ажлын байдал, аюултай довтолгооноос зайлсхийх, бусдаас тусламж авахаар хандах боломжтой байсан эсэхээс үл хамааран аргагүй хамгаалалт хийх эрхтэй. Аргагүй хамгаалалтыг бусдын хууль бус халдлага

<sup>39</sup> Монгол Улсын Хилийн тухай хууль. 5 дугаар бүлэг. 48 дугаар зүйл. 48.2.2 дугаар заалт.

<sup>40</sup> Монгол Улсын Хилийн тухай хууль. 5 дугаар бүлэг. 48 дугаар зүйл. 48.2.3 дугаар заалт.





эхэлсэн, эхлэх гэж байгаа нь тодорхой болсон үед хийнэ. Довтолгоо төгссөн хойно хийсэн үйлдлийг аргагүй хамгаалалтад тооцохгүй. Хуульд заасны дагуу галт зэвсэг, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх бүхий хууль сахиулагч албан үүргээ гүйцэтгэх, хэрэг шалган шийдвэрлэх явцдаа, харуул хамгаалалтын албан хаагч албан үүргээ гүйцэтгэх явцдаа галт зэвсэг, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэж хуулийн дагуу хийсэн үйлдлийг эсэргүүцсэн хариу үйлдлийг аргагүй хамгаалалтад тооцохгүй<sup>41</sup> гэж заасан байдаг.

Хилийн манааны шаардлагыг үл биелүүлсэн, эсхүл саатуулах, баривчлах үед эсэргүүцэл үзүүлсэн этгээдэд биеийн хүч, галт зэвсэг хэрэглэснээс тусгай хэрэгсэл хэрэглэх нь аюулгүй байдлаа хангахад үр дүнтэйгээс гадна, тухайн харилцагчид бага гэмтэл учруулдаг давуу талтай. Жишээ нь: Байлдааны хүрээр гар хөл рүү нь довтлох, нулимс асгаруулагч болон амьсгал боогдуулагч буу, шүршүүр ашиглах.

Хилийн манаа нь зэрлэг амьтнаас өөрийгөө болон бусдыг хамгаалах зорилгоор галт зэвсэг хэрэглэж болно. Харин ан хийх, хил давуулан буудахыг хориглоно гэж заасан.

Монгол Улсын Хилийн тухай хуульд Хил хамгаалах байгууллага, хилийн манаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу галт зэвсэг, тусгай хэрэгсэл, албаны нохой, биеийн хүч хэрэглэснээс үүссэн үр дагаврын төлөө хариуцлага хүлээхгүй<sup>42</sup> гэж заасан. Хилчид биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхэд зөвхөн Хилийн тухай хуулийн үндэслэл заалтыг мэддэг байх нь хангалтгүй бөгөөд түүнийг хэрэглэх журам, заавруудыг судлах шаардлагатай байдаг. Хуульд заасан үндэслэлээр галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхдээ журам, зааврын дагуу хэрэглээгүй тохиолдолд хууль, тогтоомжид заасан хариуцлага хүлээдэг.

Монгол Улсын Хил хамгаалалтын дүрэмд хилийн манаанаас зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх<sup>43</sup> талаар зааж өгсөн бөгөөд Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасан биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заалттай зөрчилдөж байгаа тул хил хамгаалалтын дүрмийг шинэчлэх шаардлага байгааг харуулж байна. Иймд хил хамгаалалтын дүрмийн энэхүү заалтыг

мөрдөхгүйгээр биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэхдээ Монгол Улсын Хилийн тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн А/160 тоот тушаалыг, галт зэвсэг хэрэглэхдээ Хилийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэл болгох нь зүйтэй.

Харин галт зэвсгийн хангалт, хадгалалт, хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг зохион байгуулахдаа Монгол Улсын Хил хамгаалалтын дүрмийн холбогдох заалтууд, ХХЕГ-ын даргын н/24, 1177 дугаар тушаалыг үндсэн удирдлага болгоно.

### Дүгнэлт

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хилийн зурваст үйлдэгдсэн гэмт хэрэгт Хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан тушаалтан хойшлуулшгүй мөрдөн шалгах, Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар Хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах хил орчмын дэглэмийн зөрчилд шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах болсон тул эдгээр албан тушаалтнуудад хууль эрх зүйн түргэвчилсэн сургалт явуулан хууль, эрх зүйн мэдлэг, гэрчилгээ олгох асуудал тулгамдсан асуудал болж байна.

Хуулийн энэхүү шинэчлэлттэй холбоотойгоор хүний нөөцийг бэлтгэх асуудалд онцгой анхаарч, Хууль сахиулахын их сургуулийн Хилийн сургуулийн сонсогчийн сургалтын хөтөлбөрт хууль эрх зүйн хичээлийг нэмж тусгах, төгсөгчдөд хилийн албаны ажилтан-эрх зүйч мэргэжил олгох нь өнөөгийн Хил хамгаалах байгууллагын хэрэгцээ болж байна.

Хил хамгаалалтын хууль, дүрэм, зааврууд шинэчлэгдэж, хил зөрчигчийг саатуулах, баривчлах, хуяглан хүргэх, эсэргүүцлийг нь таслан зогсооход биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх талаар шинэ заалтууд орсон тул үүссэн нөхцөл байдал тохирсон зөв шийдвэр гаргах шаардлага тулгарч байна. Хилийн манаа нь хил зөрчигч, гэмт этгээдүүдтэй тулгарсан үед шийдвэрийг асар богино хугацаанд, бодох завдалгүй, өөрт тогтсон дадлаараа бие даан гаргадаг бөгөөд энэ шийдвэр эрх зүйн зөрчилгүй, зөв байх шаардлагатай байдаг. Хэрэв шийдвэр гаргахдаа хугацаа алдвал өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул тулгарах эсхүл хил зөрчигч, довтлогч этгээд орон зугтах боломж үүсдэг бол буруу шийдвэр гаргасан үед бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж, хариуцлага хүлээдэг. Иймд биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх талаар шинээр гарсан хууль,

<sup>41</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль. 4.1 дүгээр заалт. Аргагүй хамгаалалт. УБ., 2015.

<sup>42</sup> Монгол Улсын Хилийн тухай хууль. 5 дугаар бүлэг. 48 дугаар зүйл. 48.5 дугаар заалт. УБ., 2016.

<sup>43</sup> Монгол Улсын Хил хамгаалалтын дүрэм. 3 дугаар анги. 3 дугаар бүлэг. 57-59 дүгээр тал. УБ., 2007.

дүрэм, заавруудаар хилийн анги, салбарт сургалт явуулан хилийн манаа, хилчин нэг бүрт тайлбарлан ойлгуулах болзошгүй алдаа, зөрчлөөс сэргийлэх ач холбогдолтой.

Хил хамгаалалттай холбогдолтой хууль эрх зүйн актууд шинэчлэгдэж, түүнтэй холбоотойгоо хил хамгаалах байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон тул Монгол Улсын хил хамгаалалтын дүрмийг бүрэн эхээр нь шинэчлэн боловсруулах шаардлага үүссэн.

### Санал

1. Хил хамгаалах байгууллагын хилийн застав, салбарын албан хаагчдад хууль, эрх зүйн түргэвчилсэн сургалтыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулж, гэрчилгээ олгох.

2. Хилийн сургуулийн сургалтын хөтөлбөрт хууль, эрх зүйн хичээлийг нэмэлтээр тусган өгч, бүх төгсөгчдөд эрх зүйч мэргэжил давхар олгох.

3. Хилийн анги, салбарууд хуулийн шинэчилсэн заалтаар театрчилсан сургалт, дадлага хийх болон хилийн албаны бодлогыг дадлага хэлбэрээр богино хугацаанд шийдвэр гаргаж бодуулах зэргээр болзошгүй цагийн байдалд зөв хариу үйлдэл үзүүлэх дадлыг хилчин нэг бүрт бий болгох.

### Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992.
2. Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын хилийн дэглэмийн гэрээ. УБ., 2006.
3. Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын гэрээ. УБ., 2010.
4. Хилийн тухай хууль. 2016.
5. Эрүүгийн хууль. 2015.
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017.
7. Зөрчлийн тухай хууль. 2017.
8. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. 2017.
9. Галт зэвсгийн тухай хууль. 2015.
10. Терроризмтой тэмцэх тухай хууль. 2004.
11. Дотоодын цэргийн тухай хууль. 2017.
12. Төрийн мэдээлэл. Хууль тогтоомжийн эмхэтгэл. №6. УБ., 2017.
13. Цэргийн дүрэм. 2008.
14. Хил хамгаалалтын дүрэм. 2007.
15. Хууль зүй дотоод хэргийн сайдын А/160 дугаар тушаал. Хил хамгаалах байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх заавар. УБ., 2017.
16. С.Хаянгарваа. Хууль сахиулах үйл ажиллагаа: онол, практикийн тулгамдсан асуудал сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. УБ., 2016.



## ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙН ХЭЛ: ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

### LANGUAGE OF FORENSIC EXAMINATION: PROBLEM ASPECTS AND WAYS TO SOLVE THEM

#### Б.ЦОЛМОН

ХСИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Шинжлэн магадлахуй судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хууль зүйн ухааны доктор, цагдаагийн дэд хурандаа  
**TSOLMON B. (Ph.D in Law)**

Police Lieutenant Colonel, Senior Researcher of Forensic studies center, Scientific Research Institute, LEU

✉ [tsolmon.b@leu.gov.mn](mailto:tsolmon.b@leu.gov.mn)

**Товч агуулга:** Уг эрдэм шинжилгээний өгүүлэлд шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны болон шинжлэн магадлахуйн салбарын хөгжилд хэлний эзлэх байр суурь, үүрэг, ач холбогдлыг тодорхойлж, мэргэжлийн хэлийг бүрдүүлж буй ойлголт, нэр томьёонд тавигдах шаардлага, тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар товч авч үзэв.

**Abstract:** The article examines the role, importance and functions of the language in the development of forensic examination, as well as the basic requirements for terms and concepts as constituent elements of a professional language, problem aspects and ways to solve them.

**Түлхүүр үгс:** хэлний хэлбэр; мэргэжлийн хэл; шүүхийн шинжээчийн хэл; шинжлэн магадлахуйн ухаан; шүүхийн шинжилгээ; хэлний нэгдмэл тогтолцоо; ойлголт, нэр томьёоны хэрэглэгдэхүүн.

**Keywords:** form of language, professional language, language of forensic expert, forensic expertology, forensic examination, language system, terminological terminology.

Хүний харилцааны гол хэрэгслийн нэг бол хэл юм. Хэлийг ердийн ярианы, шинжлэх ухааны, хэлбэршүүлсэн гэсэн үндсэн гурван хэлбэрт хуваах бөгөөд эдгээрээс шинжлэх ухааны буюу мэргэжлийн хэл чухалд тооцогдоно. Учир нь аливаа шинжлэх ухааны хөгжлийг түүний хэлний түвшингээр тодорхойлдог. Шинжлэх ухааны хэл нь ойлголт, нэр томьёо, ухагдахуун, тэдгээрийн тэмдэглэгээ, тайлбар, тодорхойлолт зэрэг олон хэсгээс бүрдэнэ.

Өнөөгийн даяарчлал болон техник технологийн үсрэнгүй хөгжил, мэдээ мэдээллийн асар хурдацтай тархалт, мэдлэгийн интеграци, дифференциаци зэрэг үйл явцтай уялдаад нийгмийн харилцааны бүхий л хүрээнд шинэ шинэ үгс, ойлголт, нэр томьёо нэвтрэн орж ирэхийн хажуугаар мөн тэдгээрийн зарим нь хэрэглээнээс түрэгдэн гарсаар байна. Үүний нэг нь шүүхийн шинжилгээний салбар юм. Тус салбарын хэлний асуудлыг хөндөхийн тулд, юуны өмнө шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны онцлогийг харгалзан үзэх нь зүйтэй. Учир нь шинжилгээ хийх ажиллагаа нь олон талт мэдлэгийн салбарыг

нэгтгэсэн, тусгай мэдлэг шаардахаас гадна түүний эцсийн үр дүн болох шинжээчийн дүгнэлтийг шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотолгооны түвшинд үнэлдэг. Иймд шинжээчийн дүгнэлт боловсруулах ажиллагаанд хэд хэдэн шаардлага тавигддаг.

XXI зууны эхэн үеэс шинжлэн магадлахуйн ухааны онолын суурь тавигдсанаар, өнөөдөр бие даасан мэдлэгийн салбар болж төлөвшөөд байна. Уг онолыг анх ОХУ-ын эрдэмтэд боловсруулсан бөгөөд түүнийг "общая теория судебной экспертизы"<sup>1</sup> (шинжлэн магадлахуйн нийтлэг онол) гэж нэрлэх болсон бол Ром-герман болон Англи-саксоны эрх зүйт тогтолцоотой орнуудад "forensic science", манай орны хувьд "шинжлэн магадлахуй"<sup>2</sup> хэмээн тус тус оноон нэрлэж байна.

Дээрх үйл явцтай уялдаад тус салбарын хэлний асуудал мөн чухал байр суурийг

<sup>1</sup> Зарим эрдэмтэн, судлаачдын зүгээс уг мэдлэгийн салбарыг "судебная экспертология" гэж нэрлэхийг санал болгодог.

<sup>2</sup> Уг онолтоор Б.Бат-Эрдэнэ, Т.Бямбаа, Б.Лхагвасүрэн, Т.Очирбат нарын эрдэмтэн, судлаачид нэрлэхийг санал болгосон бол бидний зүгээс "шүүхийн" гэсэн тодотголыг нэмж тусгах нь оновчтой гэж үзсэн болно (Б.Цолмон)





эзлэх болсон. Олон улсын практикаас харахад, шинжээчийн дүгнэлтийг эрүү, иргэн, захиргаа, арбитрын хэргийн шүүхээс гадна Үндсэн хуулийн цэцэг нотолгооны түвшинд ашиглаж байна. Иймд “шүүхийн” гэсэн тодотголтой шинжилгээг зөвхөн криминалистикийн ангилалд багтах шинжилгээгээр хязгаарлах бус бусад ангиллыг хамруулан илүү өргөн хүрээнд ойлгох нь зүйтэй юм. Үүнтэй уялдаад шинжээчийн дүгнэлт боловсруулах явцад олон салбарын хэлийг хослуулан хэрэглэх шаардлагатай. Энэ нь угтаа шүүхийн шинжээчийн хэл хосолсон буюу нийлэг (синтетик) шинжтэй болохыг гэрчилж байна<sup>3</sup>.

Түүнчлэн шинжээчийн дүгнэлтийг ойлгомжтой, оновчтой хэлээр боловсруулсан байх учиртай. Учир нь тусгай мэдлэг ашиглах цар хүрээ өргөжин тэлсээр байгаа өнөөгийн нөхцөлд, шинжээчийн дүгнэлтийг тусгай мэдлэг, ур чадвар эзэмшээгүй хэн бүхэн уншихад ойлгомжтой, нийтэд хүртээлтэй хэлээр боловсруулсан байх шаардлагатай. Энэ талаар ОХУ-ын эрдэмтэн Т.В.Аверьянова: “Шинжээчийн дүгнэлтэд үгээр илэрхийлэх хэсгийг аль болох илүүдэл мэдээлэлгүй товч, тодорхой хэлээр боловсруулсан байх ёстой” [2] гэсэн бол В.А. Юматов, О.А. Нестеров нар: “Шүүхийн шинжилгээний хэл нь шинжлэх ухааны хэлэнд зүй ёсоор тооцогдоно. Учир нь уг хэл шинжлэх ухааны хүрээнд боловсрогдож, түүний ололт амжилтад тулгуурлахын зэрэгцээ шинжилгээг хоёрдмол утгагүй, оновчтой хэлээр боловсруулсан байх шаардлагатай” гэжээ [14]. Үүнээс гадна шинжээчийн дүгнэлтийн боловсруулсан байдал нь тухайн шинжээчийн мэргэжлийн ур чадвар, мэдлэгийн түвшинг илэрхийлдэг.

Шинжлэн магадлахуйн хэл нь шинжлэх ухааны хэлний нэгэн адил хэд хэдэн үүргийг гүйцэтгэнэ. Эдгээрээс харилцааны гол хэрэгсэл болохын хувьд хэлээр дамжуулан бодол санаагаа илэрхийлэх, түгээх болон сэтгэн бодох, дүн шинжилгээ хийх, асуудал боловсруулах үүрэг чухалд тооцогдоно. Үүнтэй уялдаад шинжлэн магадлахуйн хэлний гүйцэтгэх үүргийг харилцааны болон үйл ажиллагааны (шинжилгээ хийж, дүгнэлт боловсруулах) гэсэн үндсэн хоёр хэлбэрт хувааж болохоор байна [4]. Чухамхүү хэлний эдгээр чиг үүргийн хүрээнд шинжээч өөрийн бодол санааг илэрхийлэх гол хэрэгслийн нэг болох шинжээчийн

дүгнэлтийг боловсруулдаг. Чухамхүү үүнд шинжлэн магадлахуйн хэлний үүргээс гадна ач холбогдол оршиж байна.

Шинжлэн магадлахуйн хэлний төлөвшил, хөгжилд түүний гол бүрдүүлэх хэсгийн нэг болох нэр томьёо чухал үүрэгтэй. “Нэр томьёо” гэдэгт шинжлэх ухаан, техник, урлаг зэрэг тусгай салбарын ойлголтыг дан буюу хоршоо хэлбэрээр нарийн оноож тогтоосон үгийг ойлгоно [11]. Шинжлэх ухааны хэлийг боловсронгуй болгохын тулд юуны өмнө түүнийг бүрдүүлж буй ойлголт, нэр томьёог эрэмбэлж цэгцлэх, тэдгээрийг нэгдсэн тогтолцоонд оруулах асуудал чухалд тооцогдоно. Учир нь аливаа шинжлэх ухааны үгсийн санд ижил болон олон утгатай үгс хэт олширвол хэлийг тогтворгүй байдалд хүргэдэг. Энэ нь хэдийгээр урт хугацааны түүхтэй боловч, ойлголт, нэр томьёо нь жигдэрч, нэгдсэн тогтолцоонд ороогүй мэдлэгийн салбарт элбэг тохиолддог [6]. Уг асуудал шинжлэн магадлахуйн салбарын өмнө мөн адил хамаатай юм. А.И.Винберг, Н.Т.Малаховская нарын үзэж байгаагаар: “Олон салбарын мэдлэгээс үл хамааран, шинжилгээ хийх явцад шүүхийн шинжээчийн зүгээс зөвхөн тухайн салбарын нэгдмэл байр суурийг илэрхийлсэн ойлголт, нэр томьёог хэрэглэх ёстой” гэжээ [6].

Нэр томьёонд хэлний нэгэн адил мөн хэд хэдэн шаардлага тавигддаг. Тухайлбал, нэр томьёог зөвхөн нэр үгээр оноох бөгөөд дан утгатай, товч, тодорхой, тогтвортой байх ёстой<sup>4</sup>. Эдгээр шаардлага нь шинжлэн магадлахуйн салбарын ойлголт, нэр томьёонд мөн адил хамаарна. Учир нь оновчгүй нэр томьёогоор илэрхийлсэн аливаа утга санаа нь буруу ойлголтыг төрүүлж, улмаар алдаатай шийдвэрт хүргэх гол шалтгаан болдог.

Монгол Улсын хувьд шинжлэн магадлахуйн онол, арга зүйд тулгуурлан шүүхийн шинжилгээний үйл ажиллагааг нэгдмэл тогтолцоонд оруулсан орны тоонд зүй ёсоор тооцогддог. Үүнтэй уялдаад тус салбарт хэрэглэж байгаа ойлголт, нэр томьёог эрэмбэлж цэгцлэх, нэгдсэн тогтолцоонд оруулах, улмаар шинжлэн магадлахуйн хэлийг боловсронгуй болгох асуудал чухалд тооцогдож байна. Иймд уг тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх үүднээс Монгол Улсын шүүхийн шинжилгээний практикт хэрэглэж байгаа зарим ойлголт, нэр томьёог хэрхэн оноон тогтоосон байдалд дүн шинжилгээ

<sup>3</sup> Энэ талаар Т.В.Аверьянова, Е.Р.Россинская, Е.И.Галышина, А.И. Винберг, Н.Т. Малаховская зэрэг эрдэмтдийн бүтээлд дурьдсан байна.

<sup>4</sup> Үүнийг хэл шинжлэлийн онолын үүднээс “норматив” буюу “тогтсон” хэлбэрийн хандлага гэнэ (илтгэгч Б. Цолмон, З.Сүлд)



хийж үзье.

Тухайлбал, тус мэдлэгийн салбарын нэрийн онолт өнөөг хүртэл нэг мөр жигдрээгүй байгаагийн дээр тухайн үйл ажиллагааны зорилго, зориулалт, чиг үүргийг тодотгож буй “шүүхийн” (латинаар - *forensic*, оросоор – судебный) гэсэн тэмдэг нэрийг харьяалал, хамаарал мэтээр буруу ташаа ойлгож, тайлбарлах хандлага ажиглагдсаар байна. Үүний улмаас тухайн мэдлэгийн салбарыг “шүүхийн шинжилгээ”, “шүүх шинжилгээ”<sup>5</sup>, “шүүхийн шинжилгээний үйл ажиллагаа”, “шинжлэн магадлахуй”, “шинжлэн магадлахын ухаан”, “шинжлэн магадлахуй судлал” гэх зэргээр олон хувилбараар оноон нэрлэсээр байна [13].

Мөн “шинжилгээ” гэдэг үгийг орос хэлнээ хөрвүүлбэл “исследование” буюу “судалгаа” гэсэн утгыг илэрхийлж байна. Манай улсын шүүхийн шинжилгээний практикт уг үгийг “экспертиза” буюу “expertus” гэсэн үгийн утгатай дүйцүүлэн ойлгосоор ирсэн. Гэтэл “шинжилгээ” гэсэн үгийг “судалгаа шинжилгээ”, “эрдэм шинжилгээ”, “шинжилгээний баг”, “харьцуулах шинжилгээ”, “шинжилгээ хийх”, “шинжилгээний хариу”, “шүүхийн шинжилгээ” гэх зэргээр олон утгаар хэрэглэх бөгөөд энэ үүднээс авч үзвэл “шинжлэх ухааны нэр томьёо дан утгатай байна” гэсэн шаардлагатай зөрчилдөж байна.

Тэгвэл “экспертиза” гэсэн үгийг авч үзье. Уг үг нь латин үгнээс гаралтай бөгөөд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, зориулалт болон чиг үүргийн хувьд тодорхой мэргэжлийн салбарт өргөн хэрэглэгддэг, дан утгыг илэрхийлсэн зэрэг нь шинжлэх ухааны нэр томьёонд тавигдах шаардлагад бүрэн нийцэж байна. “Экспертиза” гэдэг ойлголтын онолын тодорхойлолтыг авч үзвэл: “шинжлэх ухаан, техник, соёл урлаг болон гар урлал зэрэг салбарт тусгай мэдлэг шаардсан асуултад хариулт өгөхийн тулд, шинжээчийн зүгээс шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж ажиллагааг хэлнэ” гэжээ [11, 12]. Үүнээс харахад, оросоор шинжилгээний явц, үр дүнг нэгтгэн тусгаж буй баримт бичгийг бүхэлд нь “заклучение”<sup>6</sup>,

<sup>5</sup> Орос хэлний дүрэмд нийлмэл нэр үгнээс хоршоо үг үүсгэхийн тулд, тэдгээрийг холбох зураасаар тусгаарлаж, товчилно гэсэн заалт бий. Уг дүрмээр “судебная экспертная деятельность” гэснийг “судебно-экспертная деятельность” гэж, “научный технический процесс” гэснийг “научно-технический процесс” гэх зэргээр хоршоо үг үүсгэнэ. Тэгвэл эдгээр товчилсон үгийг монгол хэлнээ шууд утгаар хөрвүүлэн орчуулсанаас оновчгүй ойлголт, алдаатай үг хэллэг бий болж байна (жишээлбэл: “шүүх шинжилгээ”) (Б.Ц.).

<sup>6</sup> “Документ, фиксирующий утверждение, сделанное на основе вывода” буюу “Дүгнэлтэнд тулгуурлаж гаргасан

латинаар “conclusion” гэнэ. Өөрөөр хэлбэл, шинжээчийн зүгээс шинжилгээний арга, аргачлалд тулгуурлан явуулж буй ажиллагааны хэсгийг “исследование” буюу “шинжилгээ”, харин асуултад хариулт өгч эцсийн шийдвэр гаргаж буй хэсгийг “вывод” буюу “дүгнэлт”, эдгээрийг нэгтгэн тусгаж, боловсруулсан (баталгаажуулсан) баримт бичгийг бүхэлд нь “заклучение” буюу “шийдвэр” гэж тус тусад ялгаж оноосон байна. Гэтэл манай улсын практикт энэхүү баримт бичгийг бүхэлд нь “дүгнэлт” гэж оноосноор нарийн тогтсон дэг, дэс дараатай явагддаг шинжилгээ хийх ажиллагааны төгсгөлийн шат буюу шинжээчийн зүгээс тавигдсан асуултад хариулт өгч, үр дүнг нэгтгэж буй хэсгийг уг баримт бичгийн ерөнхий нэрээр “дүгнэлт” хэмээн давхардуулан оноож байгаа нь оновчгүй болсон байна. Иймд шинжилгээний явц, үр дүнг нэгтгэн дүгнэж, түүнд тулгуурлан шийдвэр гаргаж буй уг баримт бичгийг бүхэлд нь “шинжээчийн шийдвэр” харин уг ажиллагааны үр дүнг нэгтгэж байгаа төгсгөлийн шат буюу шинжээчийн зүгээс асуултад хариулт өгч буй хэсгийг “дүгнэлт” хэмээн зохионох нь зүйд нийцнэ гэж үзлээ.

Жишээ болгон “экспертиза” болон “шинжилгээ” гэсэн үгс шинжлэх ухааны нэр томьёонд тавигдах шаардлагад хэрхэн нийцэж байгааг харьцуулж үзье.

Нэр томьёо Тавигдах шаардлага, илрэх шинж	Экспертиза	Шинжилгээ
Үгийн гарал үүсэл	латин “expertus”	монгол
Илрэх шинж (хамрах хүрээ)	олон улсад	дотоодод
Зориулалт	шинжлэх ухаанд	өргөн хэрэглээнд
Утгын хувьд	дан	олон
Чиг үүрэг	мэргэжлийн хэлэнд	хосолсон хэлэнд

Үүнээс гадна “шүүх эмнэлэг” гэсэн үгийг орос хэлнээ булгавал “суд (судебная) больница” гэсэн оновчгүй утгыг илэрхийлэх бөгөөд уг хувилбараар хүлээн авбал, тухайн нэр томьёоны шинжлэх ухааны мөн чанар, тусгай үүргийн чадамж алдагдахад хүрч байна. Үүний гол шалтгааныг зарим нэр томьёог орос хэлнээс монгол хэл рүү хөрвүүлэн орчуулахдаа орос хэлний дүрэмд “нийлмэл нэр үгнээс хоршоо үг үүсгэхийн тулд, тэдгээрийг холбох зураасаар шийдвэрийг тусгасан баримт бичиг” гэнэ.



тусгаарлаж, товчилно” гэсэн заалтыг зөрчсөнтэй холбон тайлбарлаж болохоор байна [3]. Тухайлбал, уг дүрмээр “судебная экспертиза” гэснийг “судебно-экспертная” гэж, “судебная медицина” гэснийг “судебно-медицинская” гэх зэргээр товчлох бөгөөд эдгээрийг монгол хэлнээ “шүүх шинжилгээ”, “шүүх эмнэлэг” гэх зэргээр оноож байгаа нь монгол хэлний үг үүсэх дүрмийн заалттай зөрчилдөж байна. Мөн “шүүхийн” гэсэн үгээр харьяаллыг бус чиг үүрэг, зориулалтыг зааж байх тул зүй нь “шүүхийн анагаах ухаан” – “судебная медицина” – “forensic science” буюу “шүүхийн анагаах ухааны шинжилгээ” гэж оноох нь оновчтой юм.

Түүнчлэн практикаас харахад “дактилоскопи” (гарын хурууны хээ судлал), “пальмоскопи” (гарын алганы хээ судлал), “эйджескопи” (папилляр шугамын тэгш бус гадаргын судлал), “пороскопи” (хөлсний сүв судлал) зэрэг мэдлэгийн салбар тус бүрийн нэршлийг тус тусад нь судалж, оноон тогтоогүйгээс тэдгээрийг шинжилгээ хийх үйл явцад нийцүүлэх байдлаар “гарын мөрний шинжилгээ” гэсэн нэгдсэн нэрээр оноожээ. Гэтэл эдгээрийг олон улсын практикаас харахад “дерматоглифика”<sup>7</sup> буюу хүний арьсны товгор гүдгэр хэсгийг судлах мэдлэгийн салбарын хүрээнд нэгтгэн судалж байна.

Шинжлэх ухааны нэр томьёог боловсронгуй болгоход хууль тогтоомж чухал үүрэгтэй. Тухайлбал, манай орны хувьд 2010 онд баталсан “Шүүхийн шинжилгээний тухай хууль”-д шүүхийн шинжилгээний практикт хэрэглэж байгаа зарим ойлголт, нэр томьёог холбогдох тайлбарын хамт анх тусгаж, баталгаажуулсныг энэ чиглэлд гарсан дэвшил гэж үздэг. Гэхдээ уг хуулийн зарим ойлголт, нэр томьёоны оноолтыг залруулж, тодруулах шаардлагатай болох нь харагдаж байна. Жишээлбэл, тус хуулийн 6.1.1 дэх хэсэгт шүүхийн шинжилгээний тодорхойлолтод “шүүх нягтлан бодох бүртгэл” гэсэн шинжилгээний төрлийг “тусгай мэдлэг” хамааруулан тодотгосноор, шинжлэх ухааны төдийгүй шүүхийн шинжилгээний ангиллын хүрээг хэтэрхий хумьсан байдал ажиглагдаж байна. Мөн хуулийн “Зарим төрлийн шинжилгээний онцлог” гэсэн бүлэгт “Криминалистикийн шинжилгээний онцлог” (24 дүгээр зүйл), “Шүүх эмнэлгийн шинжилгээний онцлог” (25 дугаар зүйл), “Сэтгэц судлалын шинжилгээний онцлог” (26 дугаар зүйл),

<sup>7</sup> “Дерматоглифика” хэмээх мэдлэгийн салбарыг Чарльза Дарвины үеэл Френсис Гальтон гэгч анх 1892 онд үндэслэжээ.

“Эдийн засгийн шинжилгээний онцлог” (27 дугаар зүйл) [1] гэх зэргээр шүүхийн шинжилгээний ангиллуудыг тус тус дурдсан нь шинжилгээний төрөлд түүний ангиллыг хамааруулсан мэтээр ойлгогдож байна.

Түүнчлэн шүүхийн шинжилгээнээс гадна хууль зүйн бусад салбарын практикт “нэр томьёог оноож, тогтоохдоо зөвхөн нэр үгээр илэрхийлнэ” гэсэн зарчмыг зөрчсөн байдал ажиглагдаж байна. Тухайлбал, Эрүүгийн хуульд гэмт хэргийн зүйчлэлийг “хулгайлах”, “хүчиндэх”, “танхайрах”, “мөнгө угаах” гэх зэргээр төгс дууссан үйлдэл хэлбэрээр оноожээ. Зүй нь “хулгайн гэмт хэрэг”, “хүчингийн гэмт хэрэг”, “танхайн гэмт хэрэг”, “мөнгө угаалтын гэмт хэрэг” зэргээр оноолтыг нэр үгээр заах нь оновчтой юм [14].

Дараагийн анхаарал татсан асуудлын нэг бол шинжлэн магадлахуйн ойлголт, нэр томьёог практикт хэрэглэх явцад тулгарч буй хүндрэл бэрхшээл юм. Учир нь шинжилгээний ангилал, төрөл зүйл, объект нэмэгдэхтэй зэрэгцээд шүүхийн шинжилгээний практикт шинэ шинэ үгс, ойлголт, ухагдахуун нэвтэрсээр байна. Үүнтэй уялдаад эдгээрийг эрэмбэлж цэгцлэх, ялангуяа гарал үүслийн хувьд гадаад үгний язгуураас эхтэй ойлголт, нэр томьёог эх хэлнээ зээлдэн авах, оновчтой оноож тогтоохын тулд хэд хэдэн шаардлага тавигддаг. Эдгээрээс үгийн үүсэл гарал (этимологи); олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байдал; нэр томьёонд тавигдах шаардлага, стандартыг хангаж байгаа эсэх; шинжлэх ухааны үндэслэлтэй эсэх зэргийг онцолж болох юм.

Дуудлага, бичлэгийн хувьд бага зэргийн ялгаатай, үндэс язгуур нэгтэй үгийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн буюу “улс дундын хэрэглээний үг” гэнэ. Хэл шинжлэлийн үүднээс авч үзвэл, гадаад үгийг эх хэлнээ өөрчлөлтгүйгээр шууд авч хэрэглэх аль эсвэл утгачлан хөрвүүлж, шинээр нэр томьёо үүсгэх гэсэн хэлбэрийн шаардлага тавигддаг [3]. Гэхдээ гадаад хэлний үгийг дур мэдэн зээлдэх эсхүл оновчгүй бөгөөд ойлгомжгүй үгээр орлуулах буюу чиг үүрэг, зориулалтын хувьд тухайн салбарын үйл ажиллагаанд нийцэхгүй утгаар хөрвүүлэн орчуулж, хэрэглэх зэрэг нь эх хэлний хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг болохыг анхаарах хэрэгтэй.

Үүнээс гадна шүүхийн шинжилгээний практикт хэрэглэгдэж байгаа хэдий ч агуулга, чиг үүргийн хувьд хуучирсан зарим үгс, ойлголт, ухагдахууныг хэрэглээнээс гаргах, тэдгээрийг шинэчилж буюу орлуулан



тогтоохтой холбоотой асуудал тус салбарын хэлний хөгжилд чухалд тооцогдоно. Иймд судлаачдын зүгээс хийсэн судалгааны үр дүнд тулгуурлан цаашдын эрдэм шинжилгээ, судалгааны болон хэлэлцүүлгийн сэдэв болгох үүднээс шүүхийн шинжилгээний практикт хэрэглэж байгаа зарим нэр томъёог дараах хувилбараар оноож тогтоох саналтай байна. Тухайлбал:

- “шинжлэн магадлахуй” гэснийг “шүүхийн шинжлэн магадлахуйн ухаан” гэж;
- “шүүхийн шинжилгээ” гэснийг “шүүхийн шинжлэн магадлал” гэж;
- “гарын мөрийн шинжилгээ” гэснийг “дактилоскопийн шинжилгээ” гэж;
- “ерөнхий шинж тэмдэг” – “нийтлэг шинж тэмдэг”;
- “хувийн шинж тэмдэг” – “хэсгийн шинж тэмдэг”;
- “шинжээчийн дүгнэлт” – “шүүхийн шинжлэн магадлагчийн шийдвэр”;
- “нотолсон дүгнэлт” – “эрс эерэг дүгнэлт”;
- “үгүйсгэсэн (татгалзсан) дүгнэлт” – “эрс сөрөг дүгнэлт”;
- “криминалистикийн тоо бүртгэл” – “криминалистикийн данс бүртгэл” (данслал);
- “таамаг дэвшүүлэх” – “магадлал дэвшүүлэх”;
- “адилтгал” – “идентификаци”;
- “шүүх эмнэлэг” – “шүүхийн анагаах ухаан”;
- “мансууруулах бодис” буюу “хар тамхи” – “мансуурлын зүйл”, “бэлдмэл” гэх зэргээр тус тус оноохын зэрэгцээ шүүхийн шинжилгээний практикт шинээр “мэдээллийн хангалт”, “өгөгдлийн бүрдэл”, “иж бүрэн шинжлэн магадлал”, “иж бүрэн шинжилгээ”, “шинжилгээний иж бүрдэл” зэрэг ойлголтыг нэвтрүүлэх саналыг тус тус дэвшүүлэв [14].

Түүнчлэн ойлголт, нэр томъёоноос гадна тэдгээрийн онолын тайлбарыг оновчтой оноож тогтоох асуудал мөн чухалд тооцогдож байна. Жишээлбэл, “Орос - монгол – монгол - орос хэлний орчин үеийн их толь бичиг”-т “шинжээч” гэсэн ойлголтын тайлбарыг: “Эксперт – это человек, который совершил всевозможные ошибки в очень узкой специальности” [9] буюу монгол хэлнээ утгачлан орчуулбал: “Шинжээч гэж нарийн мэргэжлийн хүрээнд төрөл бүрийн алдаа дутагдал гаргасан хүнийг хэлнээ” гэсэн хувилбараар сонгон авч хэрэглэжээ. Гэтэл угтаа уг тайлбар нь Дани Улсын алдарт физикч Нильс Борын “Шинжлэх ухааны тухай” [5] нэртэй бүтээлийн зүйр цэцэн

үгсийн сангаас шууд авч хэрэглэсэнтэй холбон тайлбарлаж болохоор байна. Иймд шинжлэх ухааны тодорхой салбарын ойлголт, нэр томъёог оноож тогтоох, тэдгээрийн тодорхойлолтыг боловсруулах, сонгох ажиллагаанд хэл шинжлэлээс гадна тухайн мэдлэгийн салбарын судлаач, эрдэмтэн, мэргэжилтэн нарыг татан оролцуулж, тэдгээрийн санал, зөвлөмжийг харгалзах зайлшгүй шаардлагатай болох нь харагдаж байна.

Дээрх байдалд тулгуурлан шинжлэх ухааны нэр томъёог оновчгүй оноож, хэрэглэснээс үүдэж гарах сөрөг үр дагаврыг шинжлэх магадлахуйн мэдлэгийн салбар болон тус салбарын үйл ажиллагаатай холбон дараах байдлаар тодорхойлж болохоор байна. Тухайлбал:

- шинжлэх ухааны үзэл санаа буруу ташаа ойлгогдох;
  - хууль тогтоомжийн холбогдох зүйл, заалт зөрчилдөх;
  - шинжээчийн дүгнэлтийн утга агуулга алдагдаж, үнэлгээ буурах;
  - шинжилгээний арга, аргачлал зөрчилдөх;
  - давтан болон дахин хийх шинжилгээний тоо нэмэгдэх;
  - шинжээчийн мэргэжлийн түвшин, ур чадвар эргэлзээ төрөх;
  - шинжээчийн хараат бус байдал алдагдах;
  - хэргийн бодит байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, тал бүрээс нь бүрэн дүүрэн тогтоох эцэж хуулийн зарчим алдагдах зэргийг онцолж болохоор байна.
- Эдгээр сөрөг үр дагаврыг үүсгэж буй гол шалтгааныг шинжлэн магадлахуйн хэл, түүний бүрдүүлж буй ойлголт, нэр томъёотой шууд холбож болох бөгөөд үүнийг шийдвэрлэх оновчтой арга замын нэгд тус салбарын хэлийг боловсронгуй болгох асуудал юм.

### Санал

- Шинжлэн магадлахуйн хэлийг бүрдүүлж буй ойлголт, нэр томъёог эрэмбэлж цэгцлэх, нэгдсэн тогтолцоонд оруулахын тулд “Ойлголт, нэр томъёоны нэгдсэн сан байгуулах” ажлыг бодитой эхлүүлэх;
- Ойлголт, нэр томъёоны боловсруулах, хэрэглэх эргэлтэд оруулах ажиллагаанд хяналт тавьж, энэ чиглэлд судалгаа шинжилгээ хийх чиг үүрэгтэй, бие даасан нэгжийг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн эсвэл Хууль сахиулахын их сургуулийн бүтцэд бий болгох;



-Мэргэжлийн ойлголт, нэр томъёог оноож тогтоох явцад хэл шинжлэлээс гадна тухайн салбарын төлөөллийг оролцуулах талаар зохицуулалт хийх;

-Шинжлэн магадлахуйн ерөнхий онолоор сурах бичиг, ойлголт, нэр томъёоны тайлбар болон сэдэвчилсэн толь, гарын авлага, зөвлөмж боловсруулах ажлыг эрчимжүүлэх;

-“Мэргэжлийн харилцааны соёлын үндэс” нэртэй бие даасан хичээлийг Хууль сахиулахын их сургуулийн болон хууль зүйн бусад их, дээд сургуулийн хичээлийн хөтөлбөрт тусгах зэрэг болно.

### Дүгнэлт

Тусгай мэдлэг ашиглах цар хүрээ өргөжин тэлсээр байгаа өнөөгийн нөхцөлд, шинжээчийн дүгнэлтийг ойлгомжтой, хүртээлтэй, оновчтой хэлээр боловсруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ нөхцөлд юуны өмнө шинжлэн магадлахуйн онолын гол хэсгийн нэг болох хэл, түүнийг бүрдүүлж буй ойлголт, нэр томъёо эрэмбэлж цэгцлэх, нэгдсэн тогтолцоонд оруулах, улмаар тус салбарын төдийгүй хууль зүйн салбарын хэлийг боловсронгуй болгох асуудал чухалд тооцогдох болсон тул энэ чиглэлд тус салбарын эрдэмтэн, судлаач, шинжээч, мэргэжилтнүүдийн анхаарлыг хандуулах шаардлага зүй ёсоор тулгараад байна.

### Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хууль. /Төрийн мэдээлэл №2. УБ., 1992.
2. Аверьянова Т.В. Судебная экспертиза. Курс общей теории /Аверьянова Т.В. – М.: Норма 2008.
3. О.Адъяа. Хэл, хэл шинжлэл, орчуулга. УБ., 2005.
4. Белкин Р.С. Криминалистика изд., Норма. М. 2006.
5. Бор Н. Избранные научные труды. М.: Наука, 1971.
6. Винберг А.И., Малаховская Н.Т. Судебная экспертология (общетеоретические и методологические проблемы судебных экспертиз). Учебное пособие под ред. Б.А. Викторова. Волгоград. 1978.
7. Винокуров Г.О. Глагол или имя? - Русская речь. Новая серия. 1928.
8. Ивакина Н.Н. Профессиональная речь юриста. – М., 1997.
9. Крючкин Ю.Н. Большой современный

словарь русско-монгольский – монгольско–русский словарь. Изд-во Аист, Восток запад. М. 2006.

10. А.Лувсандэндэв. Монгол-Орос толь. М. 1957.

11. Ожегов С.И. Словарь русского языка М.1953.

12. Россинская Е.Р., Галяшина Е.И., Зинин А.М. Теория судебной экспертизы. Учебник. М.: Норма: ИНФРА-М, 2011.

13. Б.Цолмон. Криминалистик ба шүүхийн шинжилгээний харьцуулсан судалгаа. /Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2017.

14. Цолмон Б. Информационное обеспечение судебно-экспертной деятельности в Монголии /Док. дисс. канд. юрид. наук. М.2014.

15. Юматов В.А., Нестеров О.А. Язык криминалистики и судебной экспертизы. Современное состояние и перспективы развития. // Вестник Нижегородского университета им. Н.И. Лобачевского. 2012. №1.

## ГАРЫН МӨРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

### CURRENT CONDITION AND FUTURE TREND OF IDENTIFICATION OF FINGERPRINT

#### Б.НОМИН

ХСИС-ийн Шинжлэн магадлахуйн институтын багш, докторант, цагдаагийн хошууч

#### NOMIN B.

Police major, Lecturer, Institute of Forensic Science, LEU

✉ [nomin.b@leu.gov.mn](mailto:nomin.b@leu.gov.mn)

**Товч агуулга:** Сүүлийн жилүүдэд үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдал, тархалт, тоон үзүүлэлт, үйлдлийн арга улам нарийсаж байгаа нь дэлхийн даяарчлал, техник технологийн хөгжил болон мэдээ, мэдээллийг түргэн шуурхай авах бүрэн боломжтой байдлаас ихээхэн шалтгаалж байна. Гэмт этгээдүүд ул мөр үүсэх зүй тогтол, илрүүлж бэхжүүлэх ажиллагаа, түүний цар хүрээ, ач холбогдлыг судалснаар ул мөр, эд мөрийн баримтаа нуун далдлах, баллах хандлага ноёрхож байгаа нь нууц биш юм. Тэгвэл гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт этгээдүүдийн үйлдлийг нотлон тогтооход криминалистикийн шинжлэх ухааны ололт амжилтыг өргөнөөр ашиглахын сацуу шинэ төрлийн шинжилгээ хийх, арга аргачлалыг улам нарийвчлах зайлшгүй шаардлага бидний өмнө тулгарч байна.

Тэр дундаа хэргийн газраас хамгийн түгээмэл олддог, криминалистикийн бусад салбараас илүүтэйгээр эзэн холбогдогчийг шууд тодорхойлох боломжтой ул мөр болох гарын мөр, түүнийг илрүүлж бэхжүүлэх ажиллагаа, хэрэглэгдэхүүн, шинжилгээний цар хүрээ, арга, аргачлалыг улам нарийвчлан судлах шаардлагатай юм. Бид өнөөдөр гарын мөрөн дэх хээний ерөнхий болон хувийн онцлог шинж тэмдэг тулгуурлан шинжилгээ хийж эзэн холбогдогчийг тогтоодог. Тэгвэл тухайн мөр нь тоон болон чанарын үзүүлэлтээрээ адилтгалын шинжилгээний шаардлага хангахгүй байх тохиолдолд хээний шинж тэмдэгт бус тухайн хээг бүрдүүлж буй шугамын зах ирмэг, хөлсний сүвний онцлог шинж тэмдгүүдийг ашиглан адилтгалын шинжилгээ хийх боломжтой юм.

**Abstract:** Today, the fingerprint is the basics of modern criminal identification. We use Automatic Fingerprint Identification System (AFIS) technology. However, the AFIS uses automatic scanning devices that convert the only ridge's image of a fingerprint it isn't fulfill the requirements of the developing society. From day to day, number of crimes, situation and the methods of criminal actions are increasing in Mongolia. Therefore, we are required to improve the methods of forensic science. Especially, it is new type of identification of fingerprint needs to be developed. We have opportunity to use features in the ridge edge and sweat pores of the finger print for identification. We hope to introduce a new methodology of Ridge edge and Sweat pore's identification.

**Түлхүүр үгс:** Ховил, ирмэг, хөлсний сүв, онцлог, статистик, чанар.

**Keywords:** Ridge, edge, sweat pore, features, statistics, quality.

#### Удиртгал

Хүний гарын өндгөн хэсгийн хээний нарийн шугамын бүтцэд хөлсний сүв, папилляр шугамын зах ирмэг нь өөрийн гэсэн анатоми, биологийн зүй тогтлоороо оршиж байдаг ба криминалистикийн адилтгал хийх боломжтой ерөнхий болон хувийн онцлог шинж тэмдгүүдийг агуулж байдаг. Гэтэл энэхүү боломжийг бид практикт төдийлөн ашиглахгүй байгаа нь учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл хэргийн газраас илрүүлж бэхжүүлэн шинжилгээнд хүргүүлсэн гарын мөрүүдийн дийлэнх хувь нь гарын

хээний мөрийн харьцуулах шинжилгээнд тэнцэхгүй тул шинжилгээ хийхээс татгалзаж эзэн холбогдогчийг тогтоох боломжууд буурсаар байна.

Тэдгээр гарын мөрүүдийг тодорхой сэжигтэн этгээдүүдийн гарын хээний дардастай харьцуулж сэжигтнийг тогтоох боломж криминалистикийн шинжлэх ухаанд байсаар атал тухайн шинжилгээг хийхэд ашиглагдах техник хэрэгсэл, шинжилгээний арга, аргачлалыг Монгол Улсад судлаагүйн улмаас папилляр шугамын зах ирмэг, хөлсний сүвний шинж тэмдэгт үндэслэсэн





адилгалын шинжилгээ огт хийхгүй байна. Тиймээс гарын мөрийн хээний папилляр шугамын зах ирмэг, хөлсний сүвний ойлголт, мөр үүсэх зүй тогтол, түүнд хийх криминалистикийн шинжилгээний арга, аргачлал, ач холбогдол, практик хэрэглээг судлаач, суралцагчдад энэхүү нийтлэлээрээ таниулахыг зорилоо.

Гарын хээ судлалын судалгааны ажил нь гадаадын зарим орнуудад хүний биологи, анатоми физиологийн үйл ажиллагаатай асолуулан судалсны үндсэн дээр гарын мөрийн хээний папилляр шугамын зах ирмэг, хөлсний сүвний шинж тэмдэгт тулгуурлан адилгалын шинжилгээ хийж, гэмт хэргийн сэжигтэнг тогтоох асуудлыг шийдсэнээс хойш нэлээдгүй хугацаа өнгөрчээ. Харин Монгол Улсад энэ чиглэлийн судалгааны ажил нь төдийлөн хөгжөөгүй ба мэдээллийн чанартай, танин мэдэхүйн хүрээнд байгаа бөгөөд энэ талын мэдлэг, мэдээлэл байхгүйн улмаас энэ төрлийн шинжилгээ хийгдэхгүй байна.

Энэхүү сэдвийн хүрээнд эрдэмтэн судлаач С.Бадарчи "Гарын мөр", Ж.Хурцгэрэл "Криминалистик-1", Бө.Бат-Эрдэнэ "Криминалистик", Ш.Довдон "Гарын мөр", Ш.Довдон, Д.Энхзол "Криминалистик" / гарын мөр, автоматжуулсан системийн арга зүй, Б.Жаргалсайхан "Криминалистикийн техник" зэрэг ном сурах бичгүүд, Т.Бямбаа "Монгол Улсад гарын мөр судлал үүсэж хөгжсөн явц, хөгжлийн цаашдын төлөв", Э.Нарантунгалаг "Гэмт хэрэг илрүүлэхэд гарын хээний папилляр шугамын хөлсний нүх, ирмэгийн хувийн онцлог шинжийг практикт ашиглах боломж" сэдэвт судалгааны ажлуудад дурдагдсан байх ба Б.Номингийн "Дактилоскопийн шинжилгээний үр дүнг дээшлүүлэх арга зам /пороскопи, эджескопийн шинжилгээний асуудал/" сэдэвт магистрын судалгааны ажилд шинжилгээний арга, аргачлалыг нарийвчлан тусгасан байна.

Гарын хээний хөлсний сүв, папилляр шугамын зах ирмэгийн мөр судлалын судалгаандаа хүний гарын арьс болон түүний бүтцийн зүй зохицолгоо, тогтолцоог анатоми, биологийн талаас нь криминалистикийн гарын мөр судлалын арга, аргачлал, техник хангамжтай хослуулан судлах зорилго тавьж ажилласан бөгөөд объектын онцлог шинжүүд өөрчлөгдөж буй эсэхийн хөгжил хөдөлгөөнд нь судалсан диалектикийн, нэг буюу хэд хэдэн шинжлэх ухаан тэр дундаа байгаль, нийгэм, анатоми биологийн шинжлэх ухаануудад ашиглаж буй аргууд,

тэдгээрийн харилцан уялдаа холбоонд нь судалдаг ажиглалт, туршилт, анализын гэх мэт аргуудыг өргөнөөр ашигласан болно.

Мөн, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Гарын мөрийн шинжилгээний лабораторид хийгдсэн нийт шинжилгээнд нарийвчилсан судалгаа хийж үнэлгээ өгөх, задлан шинжлэх, шинжилгээний практикийг нэгтгэх, харьцуулалт хийх зэрэг аргуудыг уг судалгааны ажилдаа ашигласан болно.

Энэхүү судалгааг хийснээр хэргийн газраас ирүүлсэн папилляр шугамууд нь тодорхой сайн гарсан боловч хээний харьцуулах шинжилгээнд тэнцэхгүй гарын мөрүүдийг шинжилгээнд тэнцэхгүй хэмээн татгалзах бус харьцуулах шинжилгээ хийж гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдлийг шинжлэх ухааны үндэстэйгээр нотлон тогтоох ажилд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Гэмт хэрэг илрүүлэх, нотлох үйл ажиллагааг сайжруулахад Криминалистикийн шинжлэх ухааны аргуудыг бусад шинжлэх ухааны аргуудтай уялдуулан судалж шинэлэг арга, аргачлалыг гаргахад оршино.

### Гарын хээ судлал

Гарын хээ судлал нь нэн эртнээс улбаатай бөгөөд хууль эрх зүй, анатоми биологи, техникийн шинжлэх ухаануудын мэдлэгийг агуулсан өвөрмөц салбарын хувьд хөгжлийн тодорхой үе шатуудыг туулжээ. Одоогоос 3000 жилийн тэртээ бүтээсэн Түт-эн-Хаамэн<sup>1</sup> хааны бунхнаас илрүүлсэн гарын хээний ором бүхий шавар хавтан, эртний Ассирт (Asyria) чухал бичигт гарын хээний дардсаа дардаг байсныг гэрчлэх баримт болох, Британий музейд хадгалж байгаа шавар хавтан, алдарт Таж Махалын сүмийг бариулсан Моголын хан Шаах Жахааны гарын хээний дардсыг бүтнээр нь даруулж авсан "Панжа" хэмээх төрийн баримт бичиг зэргийг өдий хүртэл хадгалж ирсэн нь гарын мөрийн тухай мэдлэг нэн эртнийх болохыг гэрчилнэ. Ийнхүү эрт үеэс хүний гарын хээний онцлог шинжийг ашиглан бүртгэл хөтлөх, албан бичиг гэрчлэх, тоо бүртгэл, хүнийг таньж олох, гэмт этгээдийг олоход ашиглаж байсан нь түүний анатомийн бүтэц, зүй тогтлыг хүн төрөлхтөн нэн эртнээс мэддэг байсантай холбоотой.

Өөрөөр хэлбэл хүний гарын хээ нь нөхөн сэргээгддэг, өөрчлөгддөггүй, дахин давтагдашгүй, эд зүйлс дээр сайн

<sup>1</sup> МЭӨ 1351-1342 амьдарч байсан, Египедийн хааны нэр. Оросууд Тутанхамон гэдэг. 1922 онд Английн археологич Х. Каартэр малтлага хийж эртний Египетийн түүх соёлын дурсгалт зүйл илрүүлсний дотор энэ хавтан байдаг ажээ.



дүрслэгддэг бодгаль онцлогтой байдаг нь түүний арьсны анатомийн бүтцийн үүсэлтэй шууд холбоотой. Арьс нь биеийн яс, эд эсийг гадны ямар нэг нөлөөллөөс хамгаалж бие махбод, бодисын солилцооны илүүдэл хэрэггүй зүйлийг гадагш гаргах, гаднаас агарын солилцоо нарны элч болон хүний биед ашигтай зүйлүүдийг дотогш дамжуулах, мэдрэл цусны системээр дамжин дотоод эрхтнүүдтэй нягт холбогдох зэрэг хамгаалах, зохицуулах үүрэгтэй.

Хүний биеийн арьсны бүрдлийг Дерма гэж нэрлэх бөгөөд энэ нь дээд давхарга болох Эпидермис, доод давхарга болох Гиподерма гэсэн хоёр давхаргаас бүрдэнэ. Хүн эхийн хэвлийд бүрэлдэн биологийн бүтцэд бүрэн орсон 4-6 сартай үеэс арьсны доод давхарга болох Гиподерма давхаргын мэдрэмтгий биет, мэдрэлийн төгсгөлүүд, хөлсний булчирхайн бөөгнөрөл, тослог эд, хөхөнцрийн дотор талд цусны нарийн судаснууд нэгдэж торлог давхаргыг бүрдүүлж, хөлсний булчирхай нь хөлс гадагшлуулах сувгаар дамжин хөлсний сүв бий болгон хөлөг давхаргыг бий болгодог.

Улмаар дээд давхарга болох Эпидермис давхаргын бүрдлүүдийг бий болгон арьсны гадаргуу дээр "Гарын хээ"-г үүсгэдэг. Хэрэв эпидермис давхарга гэмтсэн тохиолдолд арьсны нөхөн төлжих чадвараар гэмтсэн гарын хээ нь эргэн нөхөн төлждөг бол гиподерма давхарга гэмтвэл эргэж нөхөн төлжиж чадалгүй хүний гарын хээн дээрх сорви болон тогтож үлддэг ба энэхүү хүний арьсны нөхөн төлжих чадвар нь криминалистикийн адилтгалын шинжилгээнд ихээхэн ач холбогдолтой юм.

Хүний арьсны гадна талын эвэрлэг давхарга нь тодорхой хугацаанд үхжиж, хуурч, гуужиж байдаг бөгөөд хүний амьдралын хугацаанд хүнээс 18 кг орчим арьс гуужин унадаг болохыг шинжлэх ухаан тогтоожээ.<sup>2</sup>

Арьс нь ойролцоо байгаа эрхтэн, булчинг тэжээж буй том судаснаас цусан хангамжаа авна. Нүүрний төрөлхийн онгорхой хэсгүүдийн зах, мэдрэхүйн эрхтэн, хурууны өндөг зэрэг газруудад судасны тор их байдаг энд хөлсний булчирхайнуудын цорго нээгдэх бөгөөд гарсан хөлс нь арьсны гадаргыг чийглэнэ". Гарын хээний папилляр шугамууд нь хүн анх эхийн хэвлийд бүрэлдэн тогтсон 4-6 сартай үеэс эхлэн үүсдэг бөгөөд нас барсны дараа арьсны бүрэн ялзрал болж дуусах хүртэл ч хадгалагдсаар байдаг ба гарын хээ болон түүнийг бүрдүүлж буй

<sup>2</sup> Ш.Довдон. "Криминалистик Гарын мөр-3". УБ., 2012. 27 дахь тал

папилляр шугамын зах ирмэг, хөлсний сүвний шинж тэмдэг нь өөрчлөгддөггүй энэхүү тогтвортой байдал нь гарын мөр судлалд ашигтай чухал чанар юм.

Папилляр хээний жижиг онцлогууд нийлбэрээрээ хослол-макро бүтэц бий болгодог ба энэ макро бүтэц нь нэг хүний гарын хуруунуудад давтагддаггүй юм. Тиймээс шинжээчид макро бүтцээс папилляр хээний бүтэц, хөлсний сүвний онцлог илэрдэг бичил бүтцийг ашиглах нь чухал ба хөлсний сүв хүний бүхий л биеэр байх боловч папилляр хээд бусдаас илүү олонтой байна. Нэг сантиметр урттай папилляр шугаманд 9-18 сүв байх ба тэдгээрийн хоорондын зай, хэлбэр, хэмжээ, байрлал, папилляр шугамын зах ирмэг нь мөн адил өөр өөрийн дүрслэл хэмжээ бүхий чухал шинж тэмдэгтэй нь мөн л дахин давтагдашгүй, тогтвортой шинжүүд юм. Өөрөөр хэлбэл гарын мөрөн дэх папилляр шугамын хээнд бус тэрхүү хээг бүрдүүлж буй хөлсний сүв, папилляр шугамын зах ирмэгийн шинж тэмдэгт адилтгалын шинжилгээ хийх боломжтой юм.

#### Гарын мөрийн шинжилгээний өнөөгийн байдал

Монгол улсын Цагдан сэргийлэх газрын харьяанд байсан Гүйцэтгэх хэлтэс /өнөөгийн эрүүгийн цагдаагийн алба/-ийн хийж гүйцэтгэсэн ажлын талаар 1937 онд ДЯЯ-ны сайдад Цагдан сэргийлэх газраас нэгэн илтгэх хуудас хүргүүлсэн байна.<sup>3</sup> Тус илтгэх хуудаст шинжлэх ухааны нарийн аргыг ашиглах явдал хоцрогдож байгаа, энэ талын мэргэжлийн албан хаагч дутагдаж байгаа талаар бичжээ. Энэ нь цагдан сэргийлэх байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шинжээч, мэргэжилтний туслалцаа хэчнээн чухал байсныг харуулж байна. Ингээд 1937 онд Улсын Цагдан Сэргийлэх Газрын Гүйцэтгэх хэлтэст гарын хээний шинжээч нэгийг 160 төгрөгийн цалинтайгаар ажиллуулахаар баталжээ.<sup>4</sup>

Ийнхүү цагдан сэргийлэх байгууллагын орон тоонд гарын хээ шинжээч бий болгож гэмт этгээдийг гарын хээгээр нь бүртгэж эхэлжээ. 1940 онд Дактилоскопийн тасаг байгуулж, 1942 оноос Оросын Холбооны Улсын Челябинск хотод гарын хээний шинжээчийг бэлтгэж эхэлсэн ба 1951 он болоход хурууны хээний карт бүртгэлийг аймгуудын хорих анги, ДЯЯ-ны харьяа хэлтсүүд, засан хүмүүжүүлэх газар, лагерь,

<sup>3</sup> ТЕГ-н тусгай архив. 1934. Фонд ХН. №28

<sup>4</sup> Т.Очирбат. "Шинжлэн магадлахуй". УБ., 2014. 26 дахь тал



колониудад хийж бүх хоригдлыг бүртгэсэн байна. 1955 оны 6 дугаар сарын 01-ний өдөр гэмт этгээдийг хурууны хээгээр бүртгэх шинэ заавар батлагдсан. БНМАУ-д хурууны хээ судлалын үндэс ийнхүү тавигдсан бөгөөд энэ нь эхлээд тоо бүртгэлийн зорилгоор, 1957 оноос гэмт этгээдийг гарын хээгээр нь адилтгах үндэслэлийг бүрдүүлжээ.<sup>5</sup>

1968 онд НАХЯ-ны сайдын 6 тоот тушаалаар 5 хурууны бүртгэлийг байгуулж зааврыг баталсан бөгөөд 1972 онд гарын хээний бүртгэлийн “Цоорхой карт” хөтлөх зааврыг баталж мөрдүүлжээ. Харин 1995 оноос ОХУ-ын Папилон фирмтэй гэрээ байгуулан Монгол улсад гарын хээний автомат адилтгалын “АДИС-Папилон” системийг нэвтрүүлэн өнөөг хүртэл шинэчлэн ашиглаж байна.

Анх Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Гарын хээний шинжилгээний хэлтэст тус системийн станцуудыг байрлуулан шинжилгээ хийж, санг баяжуулж байсан бол 2012 оноос эхлэн Нийслэл болон Аймгийн Шүүхийн шинжилгээний албуудад салбар станцуудыг байрлуулан сүлжээгээр холбосноор сэжигтэн этгээдүүдийн гарын хээний дардас, эзэнгүй хэргийн гарын мөрүүдийг нэгдсэн санд түргэн шуурхай оруулах, тэдгээрт адилтгалын шинжилгээ хийх нөхцөл бололцоотой болсон.

Одоогоор Папилон системийн нэгдсэн санд давхардсан тоогоор 560.000 гаруй хүний гарын хээний дардас, хэргийн газраас олдсон 130.000 гаруй гарын мөр бүртгэлтэй байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн гарын мөрийн шинжилгээний лабораторид 2012-2017 он, 2018 оны эхний 1 сард хийгдсэн шинжилгээний тоог бусад шинжилгээтэй харьцуулан үзвэл:

Шинжилгээний статистик:

Шинжилгээний төрөл	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Гарын мөр	4392	5331	6743	8420	10319	9541	1421
Мөр судлал	1037	1178	1296	1709	2012	1545	204
Бичиг баримт	1555	1067	1295	1402	1207	1066	152
Дүр зураг	191	104	154	140	133	98	10
Галт зэвсэг	255	271	216	302	249	222	33
Гэсрэх төхөөрөмж	11	12	2	7	7	7	-
Дүрс бичлэг	-	54	172	257	229	265	27
Авто техник	-	51	166	303	218	235	21
Компьютер судлал	-	-	30	50	132	131	13
Бусад	-	-	11	51	116	92	15
Бүгд	7441	8032	10085	12641	14622	13202	1896

Дээрх тоон үзүүлэлтээс харахад гарын мөрийн шинжилгээний тоо жил ирэх тусам өсөх хандлагатай байгаа нь харагдаж байна. Харин нэг жилд хэргийн газраас илрүүлж бэхжүүлэн шинжилгээнд хүргүүлсэн гарын мөрийн тоон үзүүлэлтийг гарын хээний нэгдсэн санд бүртгэгдсэн нийт гарын мөрийн тоотой харьцуулбал дараах судалгаа гарч байна.

Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 оны 1 сар
Хэргийн газраас илрүүлж бэхжүүлсэн гарын мөрийн тоо	14102	26236	24287	30503	39188	39153	5114
Гарын хээний нэгдсэн санд бүртгэгдсэн гарын мөрийн тоо	11323	14728	11909	19012	24346	19389	2685
Адилтгалын шинжилгээнд тэнцээгүйн улмаас шинжилгээ хийгдээгүй үлдсэн гарын мөрийн тоо	2779	11508	12378	11491	14842	19764	2429
Нийт илрүүлсэн гарын мөрийн шинжилгээнд тэнцэхгүй, санд бүртгэгдээгүй гарын мөрийн тоог хувиар илэрхийлэв	19%	43%	50%	37%	37%	50%	47%

Энэхүү судалгааны дүнг харахад хэргийн газраас илрүүлж бэхжүүлсэн гарын мөрийн 40-50 орчим хувь нэгдсэн санд бүртгэгдээгүй байх бөгөөд энэ нь олон шалтгаантай байх боловч дийлэнх гарын мөр нь хээний хувийн онцлог шинж тэмдэг тоон болон чанарын үзүүлэлтээрээ шаардлага хангахгүй байх үндэслэлээр огт шинжилгээ хийхгүй орхигдож байна. Тэгвэл тэдгээр хээний адилтгалын шинжилгээ хийх боломжгүй болсон гарын

<sup>5</sup> Ш.Довдон. "Криминалистик Гарын мөр-3". УБ., 2012. 20 дахь тал



мөрүүдэд тухайн гарын мөрийн хээний чанарын үзүүлэлтийг харгалзан үзэж түүнд гарын мөрийн хээн дэх папилляр шугамын зах ирмэг, хөлсний сүвний шинж тэмдгээр нь адилтгалын шинжилгээ хийх бүрэн боломжтой юм.

Гарын мөрийн хээн дэх папилляр шугамын зах ирмэг, хөлсний сүвний шинж тэмдгээр хийх адилтгалын шинжилгээний онолын үндэс

Гарын хээний нэгдсэн санг ашиглан гарын мөрийн шинжилгээ хийж түүнийг сэжигтний гарын хээний дардастай тохирох эсэхэд дүгнэлт өгөхөд тухайн шинж тэмдгүүд хангалттай бус эргэлзээтэй, сэжигтэн этгээд хэргээ хүлээхгүйн улмаас дахин дахин гарын мөрийн шинжилгээ томилсон маргаантай асуудлууд цөөнгүй тохиолддог. Дээрх нөхцөлд уг маргаан, эргэлзээг тэдгээр гарын мөрүүдийн хээн дэх папилляр шугамын зах ирмэг, хөлсний сүвний шинж тэмдгээр харьцуулалт хийн тодорхой сэжигтэн этгээдийн гарын хээний дардастай адилтгаж шинжилгээг баталгаажуулан хийх боломжтой.

Мөн гарын мөрийн хээнд харьцуулалт хийхэд доод тал нь 10 шинж тэмдэг тодорхой сайн гарсан бол харьцуулах шинжилгээнд тэнцэнэ гэж үздэг. Гэтэл хэргийн газар дээрээс тэр бүр бүтэн сайн гарсан гарын мөр олддоггүй ба тэдгээр гарын мөрөнд харьцуулалт хийх боломжгүй гэж үзсэнээр орхигддог. Тиймээс тэдгээр гарын мөрүүдийн хээн дэх папилляр шугамын зах ирмэг, хөлсний сүвний шинж тэмдгээр тодорхой сэжигтэн этгээдүүдийн гарын хээний дардастай адилтган шинжилгээ хийснээр шинжилгээнд тэнцэхгүйн улмаас орхигдоод байгаа дийлэнх гарын мөрүүдэд шинжилгээ хийн эзэн холбогдогчийг тодорхойлох боломжтой.

Гарын хээний мөрөн дэх хөлсний сүвэнд хийх шинжилгээг түүний хэлбэр, хэмжээ, өөр хоорондын байрлал, тэдгээрийг холбосон геометрийн дүрслэл зэрэгт тулгуурлан хийнэ.

Папилляр шугамын зах ирмэгийн мөрөнд хийх шинжилгээг хээний папилляр шугамуудын зах ирмэгийн онцлог, хэлбэр, хэмжээ зэргийг хөлсний сүвний мөртэй давхцуулан хослуулж шинж тэмдгүүдэд тулгуурлан хийнэ. Эдгээр шинжилгээнүүд нь гарын хээний мөрөн дэх шинжилгээтэй нягт холбоотой ба гарын хээний мөрний шинжилгээтэй хослуулж хийнэ.

Хөлсний сүвний амсар, папилляр шугамын зах ирмэгийн мөрөнд хийх адилтгалын шинжилгээ нь хийж буй шинжилгээний

арга, аргачлал, шинжлэгдэж буй объект, түүний ерөнхий болон хувийн онцлог шинж тэмдгүүд, шинжилгээний шаардлага хангах тоон болон чанарын үзүүлэлтүүд, дахин давтагдашгүй, үл өөрчлөгдөх баталгаатай шинж зэргээрээ шүүхийн шинжилгээний ангилал дахь нэгэн зүйл буюу гарын мөрийн бие даасан шинжилгээ юм. Өөрөөр хэлбэл шүүхийн шинжилгээний ангиллын мөр судлалын ангийн нэгэн төрөл буюу хүний мөр судлал дахь гарын мөр /Хэлбэр/-ийн нэгэн зүйл болох гарын хээний мөрөн дэх хөлсний сүвний амсрын мөр, гарын хээний папилляр шугамын зах ирмэгийн мөрөнд хийх шүүхийн шинжилгээ юм.

Гарын мөрөн дэх папилляр шугамын хээнд бус тэрхүү хээг бүрдүүлж буй хөлсний сүв, папилляр шугамын зах ирмэгийн хувийн онцлог шинж тэмдэгт тулгуурлан адилтгал хийх боломжтой бөгөөд өөрийн гэсэн анатоми, биологийн зүй тогтлоороо оршиж байдаг нь криминалистикийн адилтгал хийх ерөнхий болон хувийн онцлог шинж тэмдгүүд болж өгдөг.

Папилляр шугамын зах ирмэг, хөлсний сүвний шиж тэмдгүүд нь хэсэг газарт үлдсэн маш жижиг хэмжээтэй гарын мөрөнд харьцуулах шинжилгээ хийх цорын ганц арга гэж хэлж болно. Мөн энэхүү шинжилгээний аргачлал нь бүх тохиолдолд гарын мөрийн шинжилгээний нотолгоонд нэмэлт нотлох баримт, баталгаа болох юм. Түүний шинж тэмдгүүд нь анатоми, морфологи талаасаа хэлбэр, хэмжээ, байрлалаараа өөрчлөгддөггүй болохыг дээр дурдсан билээ.

Папилляр шугамын зах ирмэг, хөлсний сүвний шинж тэмдэгт тулгуурлан адилтгалын шинжилгээ хийхдээ дараах шинж тэмдгүүдийг баримтална. Үүнд:

- Сүвний хэлбэр: Дугуй, зууван, зуувандуу, дөрвөлжин, ромбо, гурвалжин, олон өнцөгтэй болон тодорхойлох боломжгүй зөв бус хэлбэртэй нүхнүүд байна.

- Сүвний хэмжээ: Хөлсний сүвний хэмжээ нь 88-200 микро байна, 1 микро=1000мм хэмжээтэй байна.

- Сүв хоорондын байрлал, давтамж: Зэрэгцээ 2 нүхний хоорондох зай нь 0.0037-2.0мм-ийн хооронд хэлбэлзэж байдаг. Зарим хүний хөлсний сүвнүүд хос хосоороо зэрэгцэн байрласан байдаг.

- Зэрэгцээ папилляр шугамуудын зэрэгцээ хөлсний сүвний амсруудыг хооронд нь шулуун шугам татах, эсвэл олон газар замбараагүй байрласан хөлсний сүвнүүдийг зураас татаж холбосноор геометрийн



МУОНГОЛ УЛСАД  
 ХУУЛЬ САХИУЛАХ  
 УРЬСЭН  
 ХАМГААГАХ  
 УНДГАВЬС  
 ХАМГААГАХ  
 УНДГАВЬС

тодорхой зураглал дүрс үүснэ. Уг дүрс, зургаар геометрийн арга ашиглан адилтгал хийж болно.

- Папилляр шугамын зах ирмэгийн хэлбэр: Хэлбэр нь шулуун цэх, гүдгэр төвгөр, оргил орой, ширээ, халаас, хонхор болон өнцөг булан зэрэг олон төрлийн хэлбэр, зузаантай байна.

- Дээрхээс гадна нэмэлт зарим онцлог шинж тэмдгүүд орно. Үүнд хөлсний сүвний сэтэрхий, битүү байдал, папилляр шугам хоорондын нарийн зураас, цэг, олон сүвнүүд хоорондоо бараг зайгүй шигүү байрласнаас нэг урт нүх мэт харагдах байдал гэх зэрэг олон шинжүүд байна.

Дээрх шинж тэмдгүүдийг өөр хооронд нь харьцуулан шинжилж анализ хийснээр тодорхой дүгнэлтэд хүрнэ. Хэрэв дүгнэлт өгөхөд эргэлзээтэй өөрөөр хэлбэл тохирч буй болон тохирохгүй байгаа шинж тэмдгүүд аль аль нь байгаа тохиолдолд дараах нэмэлтээр баталгаажуулалтын томьёоллыг европын орнуудад баримталдаг байна. Гэхдээ энэ томьёо нь тухайн мөрийг мөн, биш гэсэн эцсийн хариуг тогтоох бус харин тохирч байгаа шинжийг оноо хэлбэрээр хувилж гаргадаг байна. Энэхүү томьёог хөрвүүлбэл тохирч буй хөлсний сүвний тоог/ТТ/ хоёрт үржүүлэн түүнээсээ тохирохгүй байгаа хөлсний сүвний тоог хасан /ТҮ/ гарсан тоог нийт хөлсний сүвний тоонд /ТН/ хуваахад хөлсний сүвээрээ тохирч байгаа нийт оноо /ОС/ гарна. Томьёолбол:

$$ОС = (2 * ТТ - ТҮ) : ТН$$

Уг нэмэлтээр баталгаажуулалтын томьёогоор бодоход доод хязгаарын тоо /оноо/-1, бүрэн тохирч буй дээд хязгаар +1 буюу -1, +1 гэсэн тооны дунд хэлбэлзэлтэй юм.

Криминалистикийн тусгай арга зүй, шинжлэх ухаан-техник-анатоми биологийн арга хэрэгслийг ашиглан олон талаас нь шинжлэн судалж хийсэн судалгааны үр дүнг тоон болон чанарын хувьд онол практикийн түвшинд нэгтгэн дүгнэж шинжилгээний үе шатуудад тогтоогдсон мэдээллүүдийг нягтлан бүрэн ойлгож, тодорхой дүгнэлтэд хүрэх, түүний гэрэл зургийн үзүүлэлтийг хийж тэмдэглэл хийн дүгнэлтийг үйлдэнэ.

Папилляр шугамын зах ирмэг, хөлсний сүвний онцлог шинж тэмдгүүдээр хийх адилтгалын шинжилгээг криминалистикийн шинжилгээ хийх ерөнхий болон тусгай зарчим, криминалистикийн шинжилгээний арга, аргачлалын нэгэн адилаар хийнэ.

Харин папилляр шугамын зах ирмэг, хөлсний сүвний шинж тэмдэгт тулгуурлан

хийх адилтгалын шинжилгээнд тулгарч буй нэг хүндрэл бол тухайн шинж тэмдгүүд харагдахуйц гарын мөр илрүүлж бэхжүүлэх ажиллагаа юм. Гарын мөр илрүүлж бэхжүүлэх ажиллагаа хэдийгээр тодорхой зарчмаар хийгддэг боловч энэ төрлийн шинжилгээ хийхэд чанарын шаардлагыг хангахуйц дээр дурдсан шинж тэмдгүүд харагдах нь цөөн.

Иймд төрөл бүрийн гадаргуу дээр өөр өөр төрлийн цаг хугацаанд үүссэн гарын мөрийг илрүүлж бэхжүүлэх арга зүйг нарийвчлан боловсруулах, чанарын шаардлага хангахуйц гарын мөр илрүүлэх, шинэ дэвшилтэт аргыг нэвтрүүлэх шаардлага бидний өмнө тулгарах нь зүйн хэрэг. Энэхүү судалгааны ажлын үр дүнд Монгол улсад гарын мөрийн шинжилгээний үр дүнг дээшлүүлэх, гарын мөр илрүүлэхүйн онол, арга зүйн асуудлыг боловсронгуй болгох, шинжээч, мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэх, папилляр шугамын зах ирмэг, хөлсний сүвний шинж тэмдэгт хийх криминалистикийн шинжилгээг боловсронгуй болгох, практикт нэвтрүүлэхэд чиглэгдсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна.

### Дүгнэлт

Монгол улсад гарын мөрөнд хийх криминалистикийн адилтгалын шинжилгээний асуудал хөгжлийнхөө тодорхой шатанд хүрсэн гэж хэлж болно. Энэ нь криминалистикийн шинжээч мэргэжилтнүүд уг шинжилгээг хийх тодорхой аргачлалтай, шинжилгээ томилгох эрх бүхий албан тушаалтнууд уг шинжилгээний талаар тодорхой ойлголттой зэрэг байдлуудаар тодорхойлогдоно.

Харин гарын мөрийн хээн дэх папилляр шугамын зах ирмэг, хөлсний сүвний шинж тэмдэгт тулгуурлан хийх адилтгалын шинжилгээний талаарх ойлголт, уг шинжилгээг хийх аргачлал, техник хэрэгсэл, урвалж нунтаг бодис байхгүйн улмаас энэ төрлийн шинжилгээ хийгдэхгүй байна. Энэ төрлийн шинжилгээ нь европын улсуудад нэлээд хөгжсөн буюу шинжилгээ хийх аргачлалуудтай, шинжилгээний үр дүнг хэрхэн үнэлэх талаар нэгдмэл ойлголтод хүрсэн байх ба манай орны хувьд энэ чиглэлээр хийсэн судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл байхгүй байгаа нь өнөөгийн шүүхийн практикийн шаардлагыг хангахгүй байна.

1. Папилляр шугамын зах ирмэг, хөлсний сүвэнд хийх адилтгалын



шинжилгээний арга, аргачлалыг залуу судлаач, суралцагчид дахин судлан улам боловсронгуй болгох, практикт нэвтрүүлэх боломжийг судлах,

2. Шинжилгээний практик хэрэглээ нэмэгдүүлэх зорилгоор хөлсний сүв, шугамын зах ирмэг харагдахуйц чанартай гарын мөрийг төрөл бүрийн гадаргуу дээрээс илрүүлэх арга зүйг боловсронгуй болгох, туршилт судалгаа хийх,

3. Гарын мөр илрүүлэх нунтаг өндөр өртөгтэйгөөс гадна монгол орны нөхцөлд тохирсон нунтаг байдаггүй. Иймд өөрийн орны уур амьсгал, цаг уурт тохирсон нунтаг, урвалж бодисыг гаргаж авах, туршилт судалгаа хийх,

4. Гарын мөр илрүүлэх туршилт, судалгааны лаборатори байгуулах зэргэ асуудлуудыг шийдвэрлэвэл гарын мөрийн шинжилгээний үр дүн дээшлээд зогсохгүй гэмт хэрэгт холбогдсон хэнийг ч яллах болон цагаатгах, гэмт хэрэг үйлдсэн хэнийг ч ял завшихаас урьдчилан сэргийлэхэд шинжлэх ухааны үндэстэйгээр нотлох үйл ажиллагаа сайжирна.

#### Эх сурвалжийн жагсаалт

Монгол хэлээр хэвлэгдсэн зохиол, бүтээл

1. Ч.Алтаншиг. “Нэгэн жаран”. УБ., 2004.
2. Д.Амгаланбаатар, Б.Дагданбазар, С.Сүхбаатар. “Хүний биеийн эрүүл анатоми”. УБ., 2009.
3. С.Бадарчи. “Гарын мөр” (Следы рук). УБ., 1984.
4. Б.Бат-Эрдэнэ. “Криминалистик”. УБ., 2003.
5. Ш.Довдон. “Криминалистикийн гарын авлага”. УБ., 1991.
6. Ш.Довдон. “Криминалистик-Гарын мөр”. УБ., 2002.
7. Ш.Довдон, Д.Энхзол. “Криминалистик” /Гарын мөр, автоматжуулсан системийн арга зүй/. УБ., 2008.
8. Д.Мөрөн, Ч.Алтаншиг. “Шүүх-шинжилгээ”. УБ., 2004.
9. И.Пүрэвдорж. “Анагаах ухааны удам зүй”. УБ., 2003.
10. Ж.Хурцгэрэл. “Криминалистик- 1”. УБ., 2002.
11. Б.Лхагвасүрэн. “Гэмт үйлдлийн мөр”. УБ., 2008.
12. Б.Лхагвасүрэн. “Криминалистикийн шинжилгээ судлал”. УБ., 2010.
13. Б.Жаргалсайхан. “Криминалистикийн

техник”. УБ., 1998.

14. С.Бадарчи. “Монгол улсад гэмт хэрэгтэй тэмцэхэд криминалистик арга хэрэгслэлийг хэрэглэж байгаа нь /түүх, одоогийн байдал/. Докторын диссертаци. УБ., 1993.

15. Т.Бямбаа. “Монгол Улсад гарын мөр судлал үүсэж хөгжсөн явц, хөгжлийн цаашдын төлөв”. Докторын диссертаци. М., 2010.

16. Д.Мөнхбат. “Гарын мөрний адилтгал, мэдээллийн автоматжуулсан системийг хэрэглэх онол, арга зүйн зарим асуудал”. Магистрын дипломын ажил. УБ., 2010.

17. Р.Пүрэвжав. “Дактилоскопийн шинжлэх ухааны уламжлал, шинэчлэл”. Магистрын дипломын ажил. УБ., 2001.

18. Б.Номин. “Дактилоскопийн шинжилгээний үр дүнг дээшлүүлэх арга зам-Пороскопи, эджеоскопийн шинжилгээний асуудал”. Магистрын дипломын ажил. УБ., 2012.

#### Гадаад хэлээр хэвлэгдсэн зохиол бүтээл

19. Белкин С. “Ведется расследование”. М., 1976.
20. Винберг А.И., Малаховская Н.Т. “Судебная экспертлогия”. В., 1979.
21. Шмаков. “Система гражданской идентификации”. Челябинск, 2008.
22. Sisir Chakrabarti. “Identification standards”. Calcutta, 2005.
23. Sisir Chakrabarti. “History of finger prints & anthropometry”. Calcutta, 2006.
24. Эдмон Локар. “Руководство по криминалистике” /Пер. С франц. С.В.Позднышева, Н.В.Терзиева. Под ред. С.П.Митричева. М.: Юриздат НКЮ СССР, 1941.
25. “National institute of Scientific investigation”. Seoul., 2008.

#### Цахим эх сурвалжууд

26. [www.anatomyatlases.org.com](http://www.anatomyatlases.org.com)
27. [www.armorforensic.com](http://www.armorforensic.com)
28. [www.crimescene.com](http://www.crimescene.com)
29. [www.csiequipment.com](http://www.csiequipment.com)
30. [www.fbi.gov](http://www.fbi.gov)
31. [www.forensicmag.com](http://www.forensicmag.com)
32. [www.google.com](http://www.google.com)
33. [www.krimtex.ru](http://www.krimtex.ru)
34. [www.tritechusa.com](http://www.tritechusa.com)
35. [www.wikipedia.org](http://www.wikipedia.org)



## НИЙТЭД ТУСТАЙ АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ: УЛАМЖЛАЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

### EFFECTIVE COMMUNITY SENTENCES: TRADITION, LEGAL REGULATION, IMPLEMENTATION

#### Б.АЛТАНГЭРЭЛ

ХСИС-ийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, хууль зүйн ухааны доктор, дэд профессор, хурандаа

#### ALTANGEREL B. (Ph.D in Law, Assoc.Prof.)

Colonel, Head of Court Decision Execution center, Scientific Research Institute, LEU

✉ [altangerel.b@leu.gov.mn](mailto:altangerel.b@leu.gov.mn)

**Товч агуулга:** Монгол Улсад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд албадан хөдөлмөр хийлгэж ирсэн түүхэн уламжлал, өнөөгийн эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд оршино.

**Abstract:** An analysis of the historical traditions and current legal regulations and implementation of forced labor in Mongolia.

**Түлхүүр үгс:** Албадан хөдөлмөр, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, албадан ажил хийлгэх, нийтэд тустай ажил хийлгэх, шийдвэр гүйцэтгэгч.

**Keywords:** Forced labor, rehabilitation, to make useful work for the public, decision executor.

#### 1. Нийтэд тустай ажил хийлгэх ялын эрх зүйн зохицуулалтын уламжлал

Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилтөд албадан хөдөлмөр хийлгэх ялыг оногдуулж ирсэн эрх зүйн зохицуулалтыг дараах байдлаар үечлэн авч үзэж болох юм.

Эртний үеийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн албадан хөдөлмөр

Нийтэд тустай ажил хийлгэх ялтай дүйцэхүйц анхны эрх зүйн зохицуулалт нь “Халх журам” хуульд “залхалгүй дахин архи уувал хулгайчийн ёсоор жил дуустал хадъя, мөн энэ хугацаанд аргал түүлгээ”<sup>1</sup> гэж заасан байжээ.

Ардын хувьсгалаас өмнө үйлчилж байсан хууль цааз бөгөөд тус хуулиудад тогтоосон хорихоос өөр төрлийн ялыг төрлөөр нь авч үзвэл “Биеийг тарчлаах, тамлан зовоох шинжтэй дөнгөлөх<sup>2</sup>, Занчих<sup>3</sup>, Туйван, чавчирга эрүү, Шахаа, Дүүжин эрүү, Хүллэг эрүү<sup>4</sup>, ташуур занчих, эд зүйл хураан авах, торгох, албан тушаалаас огцруулах, Үйлтгэх, цөлөх<sup>5</sup>” ялын төрлийг хуульчлан хэрэглэж байжээ. Монголын төр, эрх зүйн түүхэнд “цөлөх” ялыг тэр бүр хэрэглэж

байгаагүй бөгөөд Манж Чин улсын үеэс хэрэглэх болжээ<sup>6</sup>. Цөлөх ялыг гэмт этгээдийг тодорхой нутаг зааж суулгах байдлаар хэрэгждэг байсан байна. Энэхүү ялыг эхнэр хүүхдийн хамт өртөөний хүнд ажилд зүтгүүлэх, ганцаарыг нь өртөөний хүнд ажилд зүтгүүлэх, цаг агаар муутай газарт байлгах зэрэг хэлбэрээр эдлүүлдэг байсан байна<sup>7</sup>. Мөн Үйлтгэх буюу албадан ажил хийлгэх ялыг энэхүү цөлөх ялтай хамт буюу нэмэгдэл ялын чанартайгаар хэрэглэдэг байсан байна.

Үйлтгэх: Энэхүү ял нь Манжийн үед анх хэрэглэж ирсэн ялын нэгэн төрөл юм. Тэр үед “үйлтгэх” гэсэн нэрээр хууль цаазын эх сурвалжуудад хэрэглэж байсан. Мөн “зовоох албанд явуулах” ч гэж нэрлэж байсан явдал бий. Үйлтгэх ялын хувьд “Монгол цаазын бичиг”-т юуг хэрхэн яаж хийх тухай заагаагүй ч Халх журмын агуулгаар бол хошуу засгийн түлээ, мод бэлтгүүлэх, ус зөөлгөх, сүм хийд цэвэрлэх, мөргүүлэх зэрэг ажил хийлгэдэг байж. Үйлтгэх ял нь биеэр эдлэх бусад төрлийн ялыг бодвол хөнгөн ялд хамаардаг байж<sup>8</sup>.

-Богд хаант Монгол Улсын шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэх яамны “Олноо

<sup>1</sup> В.Рязановский. Монголчуудын хууль цаазын дурсгалт бичгүүдийн түүхэн тойм. УБ., 2000.

<sup>2</sup> Б.Баярсайхан, С.Жанцан “Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). 38 дахь тал.

<sup>3</sup> Мөн тэнд. 26 дахь тал.

<sup>4</sup> Мөн тэнд. 38 дахь тал.

<sup>5</sup> Мөн тэнд. 23 дахь тал.

<sup>6</sup> Мөн тэнд. 30 дахь тал

<sup>7</sup> Б.Баярсайхан. Хууль зүйн тайлбар толь (Монгол Улсын төр, эрх зүйн түүх). УБ., 2003. 242 дахь тал

<sup>8</sup> Б.Баярсайхан, С.Жанцан. “Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). 29 дахь тал.





өргөгдсөний тэргүүн оноос нааш олон яамнаас айлтгаад тогтоосон ба тусгайлан зарлиг буулгаж нийтээр дагаж буй хэргийн товчоо дэвтэр” хэмээх данс бүртгэлд 1911 оноос 1917 оны 4 дүгээр сар хүртэл хугацаанд хааны зарлигаар тогтоосон хууль цаазын шинжтэй 63 бичиг бүртгэгдэж байжээ<sup>9</sup>. Тэдгээрийн нэг нь 1913-1919 оны хооронд “Таван яам хамт нийлж хувьсган тогтоож айлтгаад, одоогийн дагаж шийтгүүлэн буй хууль дүрмийн дэвтэр бичиг” буюу “Жинхэнэ дагаж явах хууль дүрэм” хэмээх 12 зүйл бүхий эрх зүйн актыг мөрдөж байжээ. Дүрмээр эрүүгийн эрх зүйн дараах төрлийн харилцааг зохицуулсан байна.Үүнд:

- архи уух, мөрийтэй тоглох;
- дамын наймаа хийх;
- хулгай худал байдлаар явах;
- мал хулгайлах зэрэг болно.

Архи ууж, мөрийтэй тоглоомыг хориглох тухай Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яам, Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэх яаманд Богд хаан зарлиг буулгаж эрхлэн шийтгэж байхаар тогтоосон бололтой.Тухайлбал, даалуу мөрийцөн наадаж баригдсан тайж Дорж, харц Даваа нарт .....цөм бага модон дөнгө дөнгөлж, хагас жилийн хугацаагаар үйлдвэр хийлгэж цээрлэл үзүүлэн..... хураасугай гэж шийтгэж байсан баримт байна.<sup>10</sup>Дээрх баримтад шинжлэн үзэхэд мөрийтэй тоглосон этгээдийг тодорхой хугацаагаар үйлдвэр хийлгэж цээрлэл үзүүлэх шийтгэл байсан байна.Түүнчлэн архи уусан лам нарыг нэмэгдүүлэн өөр өөрийн харьяат их хуралд зуун өдөр өнжүүлэлгүй хуруулан, өдөр тутам зуу мөргүүлэх шийтгэл оногдуулж байжээ.

Тухайн үед үйлдвэр хийлгэх гэдэг нь сүм хийдийг цэвэрлүүлэх ажил байсан ба 6 сараас 2 жилийн хугацаатайгаар оногдуулж байсан баримт байна.

Ардын хувьсгалын дараах үеийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн албадан хөдөлмөр

-1926 оны 1 дүгээр сарын 15-нд Монгол Улсын анхны Эрүүгийн хууль буюу Шүүх цаазын бичиг батлагджээ. Шүүх цаазын бичгийн хоёрдугаар бүлгийн 5 дугаар зүйл болох “Ял ба засан сайжруулах арга хийгээд ард олныг арчлан хамгаалах арга”-д Гяндан хорихгүйгээр албадан үйлдвэр хийлгэх ялыг хуульчилсан бөгөөд уг ялын хугацаа нь 100 өдрөөс үл хэтэрнэ гэж заажээ. Шүүх цаазын бичгийг судлан үзэхэд 97 дугаар зүйл “Аливаа хот ба хүн ард олноор цугларан хуралдсан газруудад морь ба тэрэг

<sup>9</sup> Б.Содовсүрэн. Хувьсгалын өмнөх Монголын төр ба хууль цааз (1911-1920). УБ., 1989. 56 дахь тал

<sup>10</sup> Мөн тэнд. 30 дахь тал

зэргээр болгоомжгүйгээр довтлон явагсдыг 30 хүртэл хоног хорихгүйгээр үйлдвэр хийлгэх...”, 99 дүгээр зүйл “Аливаа хүн тэжээсэн нохой ба догшин буур бух буюу араатныг болгоомжгүйгээр хадгалбаас 1 сар хүртэл гянданд хорих буюу 50 хүртэл хоног үйлдвэр хийлгэх...”, 100 дугаар зүйл “Аливаа давхарлагтай ихээхэн орон байшин зэргийг байлгуулж бүхий газар ба басхүү худаг, гүн нүхийг тусгай хашаа, хаалт үгүй байлгагсдыг 50 өдөр хүртэл хорихгүйгээр үйлдвэр хийлгэх...” гэсэн гурван төрлийн гэмт хэрэгт оногдуулж байжээ.

-1929 оны оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Засгийн газрын 30 дугаар их хурал, Улсын XIV бага хурлаар Шүүх цаазын бичгийг шинэчлэн баталжээ.Уг цаазын бичгийн 5 дугаар зүйл “Ард улсын арчлан хамгаалж засан сайжруулах арга зүйл”-д Хорихгүйгээр албадан ажил үйлдвэр хийлгэх ялыг мөн хуульчилсан бөгөөд уг ялын хугацаа нь 100 өдрөөс үл хэтэрмөй гэж заажээ.

Шүүх цаазын бичигт тусгагдсан нэг чухал зохицуулалт бол “...ядуу хоосон этгээдийг 100 төгрөгөөс хэтрүүлэхгүйгээр торгох бөгөөд хэрвээ уул зүйлийг төлөх хөрөнгө чинээ үгүй бол даруй хорихгүйгээр албадан ажил үйлдвэр хийлгэн, 1 өдрийн ажлыг 1 төгрөгөөр бодож гүйцэтгэх...” боломжийг хуульчилсан байна. 1929 оны Шүүх цаазын бичигт нийт 22 төрлийн гэмт хэрэгт /62, 68, 84, 95, 97, 104-108, 117, 120, 121, 127, 131-133, 147, 159, 183, 223, 227 дугаар зүйл/ албадан үйлдвэр хийлгэх ял оногдуулахаар тусгагдсан байна.

-1934 оны 5 дугаар сарын 4-ны өдөр Шүүх цаазын бичгийн ерөнхий ангийг Сайд нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, мөн сарын 24-нд Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн газраас, тусгай ангийг 1934 оны 8 дугаар сарын 24-нд Сайд нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, мөн оны 10 дугаар сарын 8-нд Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн газраас тус тус баталсан байна.Шүүх цаазын бичгийн 14 дүгээр зүйл “Шийтгэх ял”-д хорихгүйгээр албадан ажил хийлгэх ялыг хуульчлан ял шийтгэгдсэдийг ажил үйлдвэрээр засан сайжруулах ба сахилга журамтай болгохын тулд хэрэглэн, 7 хоногоос 6 сар хүртэл хугацаагаар тогтоодог байжээ.Түүнчлэн улаан цэргийн жинхэнэ албаны хүмүүст уг ялыг оногдуулж болохгүй, 16-18 насны хүмүүст уг ялыг оногдуулахдаа насанд хүрсэн хүнд шийтгэх ялын хугацааны гуравны нэг хувийг хасч тооцно гэж заасан байна.

-1942 оны 1 дүгээр сарын 17-нд Улсын



XXV бага хурлаас Эрүүгийн хуулийг баталсан ба уг хуулийн 19 дүгээр зүйлд Хорихгүйгээр засан хүмүүжүүлэх хөдөлмөр хийлгэх ялыг хуульчлан 14 хоногоос 1 жил хүртэл хугацаагаар тогтоож уг ажиллаж байсан газар дээр нь ажиллуулах ба цалингийн 10-25 хувийг суутган улсын орлого болгож байвал зохино гэжээ. Ажилгүй байсан хүмүүсийг засан хүмүүжүүлэх газар шилжүүлдэг байсан байна. Уг Эрүүгийн хуулийн 46 төрлийн гэмт хэрэгт /84, 86, 88, 89, 91, 93-95, 98, 107-109, 113-116, 120-122, 129, 135, 136, 139, 140, 145, 146, 150, 156-158, 169, 172-174, 179, 180, 182, 185, 191-193, 222, 224 дугаар зүйл/ уг ялыг оногдуулахаар хуульчилсан байна.

1947 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн Эрүүгийн хуулийн зарим зүйлүүдийг өөрчлөх ба нэмэлт оруулах тухай Улсын бага хурлын тогтоолд Шүүх таслах газрын тогтоолоор засан хүмүүжүүлэх ажил хийх явдлаас зайлсхийсэн хүн гарвал өдрийг өдөрт бодож, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн ажлаас үлдсэн хугацааг хорих шийтгэлээр солино гэжээ.

-1961 оны 1 дүгээр сарын 31-ны өдөр БНМАУ-ын Ардын Их Хурлаас Эрүүгийн хуулийг батлан гаргасан ба "Ял шийтгэлийн зорилгыг тодорхойлоходоо ял шийтгэх явдал бол шийтгэгчдийг хөдөлмөрт үнэнч шударга ханддаг, хуулийг нарийн чанд сахидаг, хамтын аж байдлын социалист хэв журмыг хүндэтгэн үздэг болгож засч хүмүүжүүлэх, тэрчлэн шийтгэгчдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс ба бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой гэжээ. Түүнчлэн ял шийтгэх явдал нь хүний бие махбодыг зовоох, хүн гэсэн нэрийг нь гутаан доромжлох зорилгогүй" гэж заасан байна. Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлд заахдаа Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг 1 сараас доошгүй, 1 жил 6 сараас дээшгүй хугацаагаар тогтоож, шийтгэгчдийн ажиллаж байсан газар буюу оршин суугаа газарт нь ойролцоо өөр газарт нь ажиллуулж, цалин хөлсний 10-25 хүртэл хувийг шүүхийн тогтоолд заасны дагуу суутган авч улсын санд нийлүүлдэг байсан байна.

Уг Эрүүгийн хуулийн 98 төрлийн гэмт хэрэгт /61, 64-68, 74, 75, 77, 79-81, 83, 84, 87, 90-96, 98-113, 115-125, 128-131, 134, 136, 137, 139-124, 144, 146-148, 150-152, 155-166, 174, 175, 178-190 дүгээр зүйл/ уг ялыг оногдуулахаар хуульчилсан байна. 1966 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлтийн хүрээнд "...Засан хүмүүжүүлэх ажлаас санаатайгаар

зайлсхийвэл засан хүмүүжүүлэх ажлын үлдсэн хугацааг хорих ялаар солих боловч есөн сараас хэтрүүлж болохгүй" гэсэн заалт орсон байна.

-1986 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн БНМАУ-ын АИХ-аас Эрүүгийн хуулийг батлан гаргажээ. 1986 оны Эрүүгийн хуульд ялын зорилгыг ялтныг үйлдсэн гэмт хэрэгт нь цээрлүүлэх, хөдөлмөрт үнэнч шударга ханддаг, хуулийг нарийн чанд биелүүлдэг, хамтын аж байдлын социалист хэв журмыг хүндэтгэдэг үзэлтэй болгон засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх, түүнчлэн ялтныг болон бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино гэж тодорхойлжээ. Эрүүгийн хуулийн 27 дугаар зүйлд Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг 3 сараас нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар оногдуулж, ялтны ажиллаж байсан газар эсхүл засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг биелүүлэх байгууллагын заасан, оршин суугаа газарт нь ойролцоо өөр газарт эдлүүлнэ.

Ялтны цалин хөлсний 10-25 хүртэл хувийг шүүхийн тогтоолд заасны дагуу суутган авч улсын орлогод оруулдаг байна. 1986 оны Эрүүгийн хуулийн 151 төрлийн гэмт хэрэгт /74, 78, 79, 83, 88, 89, 91-101, 103-111, 115, 116, 118-124, 126, 127, 129-138, 142-154, 157-161, 163-194, 196-200, 202, 204-206, 208-210, 217-221, 223-231, 233-240, 242-244, 246-253, 255, 256, 258, 263, 267 дугаар зүйл/ уг ялыг оногдуулахаар хуульчилсан байна.

-1993 оны 6 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хурлаас Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг батлан гаргасан. Уг хуульд ялын зорилгыг гэмт халдлагаас иргэн, нийгмийг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, засан хүмүүжүүлэх, түүнчлэн ялтныг болон бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино гэжээ. Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг үндсэн ялын чанартайгаар хуульчилсан байна. Түүнчлэн Улсын Их Хурлаас 1995 оны 12 дугаар сарын 11-ны өдөр "Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай" хуулийг батлан гаргажээ. Энэ хуульд зааснаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба хэрэгжүүлэх ба тухайн ял оногдуулсан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц Шүүх шийдвэрийн хувийг шийдвэр гүйцэтгэгч, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг эдлүүлэхээр заасан аж ахуйн нэгж байгууллагын захиргаанд тус тус хүргүүлдэг байна. Аж

ахуйн нэгж байгууллагын захиргаа ялтныг хөдөлмөр эрхлүүлж, зохих суутгал хийн ажилладаг байна.

- Улсын Их Хурлаас 2002 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр Эрүүгийн хуулийг баталсан ба уг хуульд зааснаар “эрүүгийн хариуцлага нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийн эрх, эрх чөлөөнд энэ хуульд заасны дагуу шүүхийн шийтгэх тогтоолоор хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын арга хэмжээ мөн. Эрүүгийн хариуцлагын зорилго нь иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсэн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино” гэжээ. Хуульд зааснаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг албадан ажил хийлгэх ял гэж нэрлэн уг ял нь нэг зуугаас таван зуун цагийн хугацаатай ба нэг өдөрт гурван цагаас доошгүй хугацаагаар үргэлжилнэ. Түүнчлэн албадан ажил хийлгэх ял эдлэхээс санаатайгаар зайлсхийсэн ялтны эдлээгүй үлдсэн ялын найман цагийн ажлыг нэг хонго баривчлах ялаар тооцож солино.

2002 оны Эрүүгийн хуулийн 35 төрлийн гэмт хэрэгт /98, 99, 103, 107, 114, 115, 117, 122, 124, 127-129, 134, 148, 153, 154, 168, 169, 171, 175, 193, 219, 229-234, 236, 237, 242, 245, 256, 258, 259, 266 дугаар зүйл/ уг ялыг оногдуулахаар хуульчилсан байна.

Монгол Улсад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд албадан хөдөлмөр эрхлүүлж ирсэн түүхэн уламжлал хангалттай байсан байна, үеийн Эрүүгийн хууль тогтоомжид гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах албадан хөдөлмөр эрхлүүлэх тухай зүйл, заалт байсан хэдий ч багасч байгаа судалгаа харагдаж байна.

## 2. Нийтэд тустай ажил хийлгэх ялын эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт

1990 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас “Хорихоос өөр төрлийн ял хэрэглэхэд баримтлах Нэгдсэн Үндэстний Байгууллагын наад захын стандарт журам” /Токиогийн дүрэм/-ыг баталсан ба түүний 8 дугаар зүйлийн 2 дах хэсэгт “Нийгмийн тустай ажлыг заавал хийлгэх ял”<sup>11</sup> буюу “Нийтэд үйлчлэх ял” хэмээх ялын төрлийг сонгох үндэслэл зарчмыг тодорхой заасан. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийг хуулиар зөвшөөрсөн

<sup>11</sup> Д.Баярсайхан. “Харьцуулсан эрүүгийн эрх зүй”. УБ., 2001. 150 дах тал

ажлыг хуульд заасан хугацаа, нөхцөлийн дагуу хүнлэг ёсны зарчимд нийцүүлэн, цалин хөлсгүй хийлгэж, түүнийг хорих ангид байлгах зорьгоор нийгэмд учруулсан хор уршгаа нийтэд тусгай ажил хийж засарч хүмүүжих боломж олгодог ял юм<sup>12</sup>.

Монгол Улсын Үндсэн хуульд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”<sup>13</sup>, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.1 дэх хэсэгт “Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш шударгаар үйлчлэх эрх зүйн орчныг цогцоор нь бүрдүүлнэ” гэсэн зорилгыг хэрэгжүүлэх үндсэн дээр 2015 оны Эрүүгийн хуульд ял шийтгэлийг шинээр тодорхойлсон нь ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, ял эдлүүлэхэд хяналт тавих ажиллагааг шинээр журамлах шаардлагыг бий болгосон байна<sup>14</sup>. Харин 2017 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдөгдөж буй Эрүүгийн хуульд заасан 52 гэмт хэрэгт /11.4, 11.5, 13.5-13.11, 13.13, 14.1-14.6, 14.8, 15.1, 16.3, 16.4, 16.7, 16.8, 16.10, 16.11, 17.1, 17.3, 17.5, 17.7, 17.8, 17.9, 17.11, 17.12, 18.1, 18.3, 18.4, 18.5, 18.11, 18.12, 18.16, 18.17, 20.15, 21.2, 21.3, 21.5, 21.8, 21.9, 23.2, 24.6, 25.1, 27.1, 27.4, 27.10, 27.11 / нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулахаар заасан байна.

Дээр дурдсан гадаад, дотоодын хүчин зүйлээс шалтгаалан Эрүүгийн хуульд “Нийтэд тустай ажил хийлгэх ял” шинээр томъёолсон байна.

Монгол Улсын Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журмын хүрээнд нийтэд тустай ажил хийлгэх ял, ялын хэрэгжилтийг хангах талаарх эрх зүйн зохицуулалтыг тусгаж өгчээ.

Эрүүгийн хуульд үндсэн ялын төрөл болж тусгагдсан нийтэд тустай ажил хийлгэх ялыг “Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг

<sup>12</sup> Ц.Мөнхбат “Албадан ажил хийлгэх ял ба нийтэд ажил хийлгэх ялыг харьцуулан судлах нь”, “Хүний эрх”, онол, арга зүйн сэтгүүл. УБ хот. 2016 он. №2, 50 дах тал

<sup>13</sup> Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 1992 он. №1, 19 дүгээр зүйл, 1 дэх хэсэг

<sup>14</sup> Ц.Мөнхбат. “Эрүүгийн хууль тогтоомжийн шинэчилсэн төсөл дэх нийтэд тустай ажил хийлгэх ялын онцлог, харьцуулалт, анхаарах асуудал”. Эрх зүйн процесс-эрх зүйн шинэтгэл, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл УБ., 2017. 19 дэх тал



нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ”<sup>15</sup> гэж тодорхойлсон байдаг. Эндээс харахад нийтэд тустай ажил хийлгэх ял нь:

- Шүүхээс тогтоосон;
- Нийтийн ашиг сонирхолд тустай;
- Цалин хөлсгүй;
- Албадлагын гэсэн шинжийг агуулж

байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүнд, биеийн эрүүл мэндэд шууд нөлөөлөхүйц нийтэд тустай ажил хийлгэх ялыг жирэмсэн эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд оногдуулахгүй байхаар мөн зохицуулсан.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт 4-с дээшгүй цагаар, нийт 240-720 цагаар тогтоодог байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд Шүүх дээрх ялыг оногдуулахдаа ялтны мэргэжил, ур чадварыг харгалзан ялтанд тодорхой нийтэд тустай ажлыг хийхээр даалгаж болохоор хуульд заасан бөгөөд шүүхийн шийдвэрт тусгайлан заагаагүй тохиолдолд нийтэд тустай ажлыг нутгийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас баталсан жагсаалтад заасан байгууллагад гүйцэтгэхээр хуульчилжээ.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч ялтныг нийтэд тустай ажил хийлгэх байгууллагыг тогтоох бөгөөд шийдвэр гүйцэтгэгч ажиллуулах байгууллагатай ялтны нэг өдөрт ажиллах цаг, гүйцэтгэх үүрэг /хөдөлмөрийн норм/, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажлын хувцсаар хангах, ажиллах нөхцөлийг урьдчилан тохиролцож, гэрээ байгуулж шүүхийн шийдвэр, ажил хийлгүүлэх тухай мэдэгдлийн хамт ажил хийлгэхээр тогтоосон байгууллагад биечлэн хүлээлгэж өгнө.

Шийдвэр гүйцэтгэгч нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагаанд биечлэн хяналт тавих, ялтны ажлын гүйцэтгэлд хяналт тавих эрх бүхий ажилтан, албан тушаалтнаас тайлбар, тодруулга авах, ажлын цаг ашиглалт, хөдөлмөрийн нөхцөлийг шалгах зэргээр тогтмол хяналт тавихаар хуульчилсан байдаг.

Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтийг ял шийтгэл гарцаагүй байх зарчмын хүрээнд бүрэн биелүүлэх шаардлага шийдвэр гүйцэтгэгч төдийгүй ял эдлүүлж байгаа байгууллагад өндрөөр тавигдах

<sup>15</sup> Эрүүгийн хууль. 2015. 5.4 дүгээр зүйл

болсныг дээрх эрх зүйн зохицуулалтаас бүрэн харж болохоор байна.

### **Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд:**

➤ Шүүхийн шийдвэрт тусгайлан заагаагүй тохиолдолд нийтэд тустай ажлыг нутгийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас баталсан жагсаалтад заасан байгууллагад гүйцэтгэнэ.

➤ Ялтныг ажиллуулахаар гэрээ байгуулсан байгууллага шийдвэр гүйцэтгэгчид бүх талын дэмжлэг үзүүлнэ.

➤ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа нэгжгүй нутаг дэвсгэрт оршин суух ялтны ял эдлүүлэх ажиллагаанд харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хяналт тавих бөгөөд ял эдлүүлэх ажиллагааны талаар 30 хоног тутам Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

➤ Ялтны ажлын цагийн бүртгэлийг нийтэд тустай ажил хийлгэхээр гэрээ байгуулсан байгууллага бүртгэж, шийдвэр гүйцэтгэгч ажлын цагийн бүртгэл, ажлын гүйцэтгэлийг үндэслэн ялын тооцоо хийнэ. Шийдвэр гүйцэтгэгч ялтны ажилласан цагийн бүртгэлийг үндэслэн ялын тооцоог үнэн зөв хийх, ял эдлэхээс зайлсхийсэн нөхцөл байдлыг шалган тогтоох, ялтны хувийн хэргийг хөтлөх үүрэгтэй.

➤ Шийдвэр гүйцэтгэгч 7 хоног тутам ялтны ажлыг биечлэн шалгаж, ажлын байрыг шалгасан тэмдэглэлд ялтан болон нийтэд тустай ажлыг хийлгэж байгаа байгууллагын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, баталгаажуулна.

➤ Нийтэд тустай ажлыг хийлгэж байгаа байгууллага нь ялтны хөдөлмөр эрхлэлт, ажлын цаг, ял эдлэлтийн талаар шийдвэр гүйцэтгэгчид 7 хоног тутам тогтмол мэдээлэл үүрэгтэй гэж журамлаж өгсөн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 8 дугаар сарын 31-ны өдрийн А/168 дугаар “Жагсаалт батлах тухай” тушаал<sup>16</sup>-аар нийтэд тустай ажил хийлгэх ялтай этгээдийг дараах байгууллагуудад ажиллуулах жагсаалтыг баталжээ. Үүнд:

1. Аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд:

- 1) Авто замын хөгжлийн газар;
- 2) Агаарын бохирдлыг бууруулах газар;
- 3) Архивын газар;
- 4) Аялал жуулчлалын газар;

<sup>16</sup> ШШГЕГ. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэрэглэгдэх эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ., 2017. 209 дэх тал





5) Байгаль орчны газар;  
6) Нийтийн биеийн тамир, спортын хороо;

7) Боловсролын газар;  
8) Нийслэлийн Газрын алба;  
9) Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар;

10) Гэр хорооллын дэд бүтцийн газар,  
11) Дотоод аудитын алба;  
12) Залуучуудын хөгжлийн газар;  
13) Мал эмнэлгийн газар;  
14) Мэдээллийн технологийн газар;  
15) Мэргэжлийн хяналтын газар,  
16) Нийгмийн даатгалын газар;  
17) Нийгмийн халамжийн газар;  
18) Нийтлэг үйлчилгээний газар;  
19) Нийслэлийн бүртгэлийн газар;  
20) Онцгой байдлын газар (Нөөцийн албатай);

21) Өмчийн харилцааны газар;  
22) Статистикийн газар;  
23) Соёл, урлагийн газар;  
24) Татварын газар;  
25) Тээврийн газар;  
26) Хөдөлмөр эрхлэлтийн газар;  
27) Хүнс, хөдөө аж ахуйн газар;  
28) Худалдан авах ажиллагааны газар;  
29) Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар;  
30) Улаанбаатар хотын цагдаагийн газар;  
31) Үйлдвэрлэл, инновацийн газар;  
32) Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба;  
33) Эрүүл мэндийн газар.

2. Сум, дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд:

1) Боловсролын хэлтэс;  
2) Биеийн тамир, спортын хороо;  
3) Газрын алба;  
4) Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс;

5) Дотоодын аудитын алба;  
6) Замын цагдаагийн хэлтэс;  
7) Мэргэжлийн хяналтын хэлтэс;  
8) Онцгой байдлын хэлтэс;  
9) Статистикийн хэлтэс;  
10) Соёлын ордон;  
11) Татварын хэлтэс;  
12) Улсын бүртгэлийн хэлтэс;  
13) Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс;

14) Худалдан авах ажиллагааны алба;  
15) Цагдаагийн хэлтэс;  
16) Эрүүл мэндийн даатгалын хэлтэс;  
17) Эрүүл мэндийн нэгдэл.

3. Аймаг, нийслэл, сум дүүргийн төрийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудад тус тус эдлүүлнэ.

Эдгээр байгууллагууд нийтэд тустай ажлыг хийлгэж байгаа ялтны ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, цагийг үнэн зөв бүртгэх, ялтны хөдөлмөр эрхлэлт, ажлын цаг, ял эдлэлтийн талаар шийдвэр гүйцэтгэгчид тогтоосон хугацаанд мэдээлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажлын хувцсаар хангах үүргийг тус тус хүлээнэ.

Албадан ажил хийлгэх ялын хэрэгжилтийн сүүлийн 5 жилийн байдлаас үзэхэд:

**2013 онд:** Албадан ажил хийх ялаар шийтгүүлсэн 467 ялтны 134317 цагийн ялыг эдлүүлэхээс 437 ялтны 127564 цагийн ялыг эдлүүлж, 30 ялтны 6753 цагийн үлдэгдэлтэй<sup>17</sup>.

**2014 онд:** Албадан ажил хийх ялаар шийтгүүлсэн 412 ялтны 117346 цагийн ялыг эдлүүлэхээс 367 ялтны 109577 цагийн ялыг эдлүүлж, 45 ялтны 7769 цагийн үлдэгдэлтэй<sup>18</sup>.

**2015 онд:** Албадан ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн 393 ялтны 112411 цагийн ялыг эдлүүлэхээс 376 ялтны 109058 цагийн ялыг эдлүүлж, 17 ялтны 3353 цагийн үлдэгдэлтэй<sup>19</sup>.

**2016 онд:** Албадан ажил хийх ялаар шийтгүүлсэн 331 ялтны 91924 цагийн ялыг эдлүүлэхээс 278 ялтны 83683 цагийн ялыг дуусгавар болгож, 53 ялтны 8241 цагийн үлдэгдэлтэй<sup>20</sup>.

**2017 онд:** Албадан ажил хийлгэх ял буюу нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн 498 ялтны 146968 цагийн ялыг эдлүүлэхээс 253 ялтны 94391 цагийн ялыг эдлүүлж, 245 ялтны 52577 цагийн үлдэгдэлтэй<sup>21</sup>.

Албадан ажил хийлгэх ялын бодит биелэлт, гүйцэтгэх хуудсаар дунджаар 80-90% хувьтай байна.

Судалгаагаар энэхүү ялын биелэлтийг хангахад нийгэмд тустай ажлын байр тэр бүр бэлэн бус хомс байсан, ЯЭА-нд хамааралгүй дүүрэг, сумын засаг дарга албадан ажил хийлгэх ажлын байраар хангах үйл ажиллагааг зохион байгуулах<sup>22</sup> субъект байхаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгасан нь тийм ч оновчтой зохицуулалт болж чадаагүй байна.

<sup>17</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2013 оны тайлангаас

<sup>18</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2014 оны тайлангаас

<sup>19</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2015 оны тайлангаас

<sup>20</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2016 оны тайлангаас

<sup>21</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2017 оны тайлангаас

<sup>22</sup> Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл /ШШГЕГ/. УБ., 2014. 63 дахь тал





## Дүгнэлт, санал

1. Нийтэд тустай ажил гэсэн нэгдсэн ойлголт, тодорхойлолт үгүй байгаа нэг мөр болгох шаардлага байна. Монгол Улсын Эрүүгийн хуульд нийгэмд ашигтай нийтэд тустай ажил гэж ямар шинжтэй ажил байхыг заагаагүй. Харин эрдэмтэн судлаачдын бүтээлд товчхон агуулгаар тусгасан. Тухайлбал: доктор, профессор Г.Совд “Тухайн нутаг дэвсгэрийн тохижилт үйлчилгээний чиглэлийн биеийн хүчний ажлуудыг”<sup>23</sup>, харин хуульч Д.Дэмбэрэлцэрэн “гудамж талбай цэвэрлэх, тохижуулах, хог цэвэрлэх булах, мод сөөг суулгаж арчлах зэрэг ажил” гэсэн бол<sup>24</sup> гэсэн бол доктор, профессор Б.Уранцэцэг “нийгэмд ашигтай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтны ажлын үр дүнг нийтээр эсвэл тодорхой нутаг дэвсгэрийн хүн ам хүртсэнээр уг ажлын нийгэмд ашигтай шинж илэрч байх ёстой.”<sup>25</sup> гэж тус тус үзсэн байдаг. Эдгээр судлаачдын зарим нь нийгэмд ашигтай ажлыг агуулга талаас нь тодорхойлсон бол нөгөө хэсэг нь илрэх хэлбэр талаас нь тодорхойлжээ.

Нийтийн ашиг сонирхолд тустай / нийгэмд ашигтай/ ажил гэж яг ямар ажил хийхийг тодорхойлоогүй тул эдгээр байгууллагууд ялтнаар ямар ажил хийлгэх нь тодорхойгүй, нэгдсэн ойлголтгүй байгааг онол, практикийн түвшинд нэг мөр болгох.

2. Шүүх шийтгэх тогтоолдоо гэм буруутай нь тогтоогдсон этгээдийг нийтэд тустай ямар ажил хийхийг заавал тусгасан байх шаардлагыг хуульчилсан хэдий ч тавьж байгаа мэт боловч бодит байдал дээр хэрэгжихгүй байна. Тухайлбал, хууль хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл 4 сарын хугацаанд улсын хэмжээнд нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн 272 этгээдэд холбогдох шүүхийн шийтгэх тогтоолд зөвхөн 3 буюу 1.1 хувьд нь ямар ажил хийхийг заасан, бусад 269 буюу 98,9 хувьд ойт заагаагүй нь судалгаагаар тогтоогдсон байна. Иймээс Шүүх шийтгэх тогтоолдоо хийх ажлыг зааж өгдөг байх зохион байгуулалтын арга хэмжээг авч байх.

3. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан нийтэд тустай ажил хийлгэх ялын хугацаа

<sup>23</sup> Д.Дэмбэрэлцэрэн. Эрүүгийн хуулийн ерөнхий анги: гол өөрчлөлтүүд, тэдгээрийг хэрэглэх асуудлууд. (Монголын төр, эрх зүй сэтгүүл). УБ., 2002. 49 дэх тал

<sup>24</sup> Д.Дэмбэрэлцэрэн. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн гол өөрчлөлтүүд, тэдгээрийг хэрэглэх асуудлууд. Монголын төр эрх зүй сэтгүүл. УБ., 2002. 49 дэх тал

<sup>25</sup> Б.Уранцэцэг. Албадан ажил хийлгэх ял бүхий ялтныг ажиллуулахад анхаарах зарим асуудлаас. Хүний эрх сэтгүүл. УБ., 2002. №2.

/240-720/ их байна гэж үзэж байна. Гадаадын зарим орны эрүүгийн хууль тогтоомжид нийтэд тустай ажил хийлгэх ялын хугацаа бага, тухайлбал, Дани 30 цагаас 240 цаг, Норвеги 30-420 цаг, Сингапур 40-240 цаг, Казакстан 60-240 цаг, Шинэ Зеланд 40-400 цаг, Украин 60-240 цаг, Орос 60-240 цаг, Англи, Франц, Шведэд 40-240 цаг, Чехэд 50-400 цаг, Франц 40-240 цаг, Литвад 460 цаг, Финляндад 20-220 цаг<sup>26</sup> байна.

Манай улсад нийтэд тустай ажил хийлгэх ялын хугацааг судлахад нийт 272 ялтны 234 буюу 86 хувь нь 240-400 цаг, 30 буюу 11 хувь нь 401-600 цаг, 8 буюу 2,9 хувь нь 601-720 цагийн ялаар шийтгүүлсэн байна.

Иймээс Монгол Улсын Эрүүгийн хуульд байгаа нийтэд тустай ажил хийлгэх нийт цагийн хугацааг багасгах.

4. Эрүүгийн хуульд заасан Шүүхээс тогтоосон газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан Шүүхийн шийдвэрт тусгайлан заагаагүй тохиолдолд нийтэд тустай ажлыг нутгийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагаас баталсан жагсаалтад заасан байгууллагад гүйцэтгэнэ гэсэн заалт нь хоорондоо зөрчилдөж байна. Зөвхөн байгууллагуудын жагсаалтыг баталснаар ялтнаар ямар ажил хаана хийлгэх нь тэдгээрийн эрх бүхий албан тушаалтны “эрх мэдэл”-ийн асуудал болж дураараа аашлах боломжийг нээж өгсөн байна. Харин хийж гүйцэтгэх боломжтой ажлын жагсаалтыг баталсан бол үр дүнтэй байх байжээ.

5. Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх ажиллагаанд хамгийн чухал асуудал бол хяналт бөгөөд гадаадын туршлагаас харахад тодорхой хүмүүстэй уулзах, бүс нутаг, байршилд нэвтрэхийг хориглох, мөн ажил, сургалт, эрүүл мэнд, эмчилгээний бусад нөхцөлүүдийг шүүх тогтоож болно. Дээрх үйл ажиллагаанд нь “Пробацийн алба” буюу “Probation Service” хяналт тавьж ажилладаг<sup>27</sup>, хугацаанд нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулдаг ба захиргааны хяналтыг 6 сараас 3 жил хүртэлх хугацаанд тухайн этгээдэд тавьдаг байна.

Манай орны тухайд нэг шийдвэр гүйцэтгэгч хяналт тавьж байгаа нь ажлын ачаалал, ялын үр нөлөөг багасгаж байна гэж үзэж байна. Иймд хяналтын тогтолцоог бий болгох, үүнд зөвхөн хүний бус, техникийн дэвшлийг түлхүү ашиглах шаардлагатай гэсэн саналуудыг тус тус дэвшүүлж байна.

<sup>26</sup> Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2011. 151 дэх тал.

<sup>27</sup> [https://en.wikipedia.org/wiki/Community\\_service](https://en.wikipedia.org/wiki/Community_service)



### Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992.
2. Монгол Улсын Эрүүгийн хууль. 2015.
3. Б.Содовсүрэн. “Хувьсгалын өмнөх Монголын төр ба хууль цааз” 1911-1920. УБ., 1989.
4. В.Рязановский. “Монголчуудын хууль цаазын дурсгалт бичгүүдийн түүхэн тойм”. УБ., 2000.
5. Б.Баярсайхан. “Хууль зүйн тайлбар толь” (Монгол Улсын төр, эрх зүйн түүх). УБ., 2003.
6. Б.Баярсайхан, С.Жанцан, Ж.Энхнасан, Д.Сумьяацэрэн. “Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал” (1911-2009). УБ., 2011.
7. Д.Баярсайхан. “Харьцуулсан эрүүгийн эрх зүй”. УБ., 2011.
8. Д.Дэмбэрэлцэрэн. “Эрүүгийн хуулийн ерөнхий анги: Гол гол өөрчлөлтүүд, тэдгээрийг хэрэглэх асуудлууд.” “Монголын төр, эрх зүй” сэтгүүл. УБ., 2002.
9. Б.Уранцэцэг. “Албадан ажил хийлгэх ял бүхий ялтныг ажиллуулахад анхаарах зарим асуудлаас”. “Хүний эрх” сэтгүүл №2. УБ., 2002.
10. Ц.Мөнхбат. “Албадан ажил хийлгэх ял ба нийтэд ажил хийлгэх ялыг харьцуулан судлах нь”. “Хүний эрх” онол, арга зүйн сэтгүүл. №2. УБ., 2016.
11. Ц.Мөнхбат. “Эрүүгийн хууль тогтоомжийн шинэчилсэн төсөл дэх нийтэд тустай ажил хийлгэх ялын онцлог, харьцуулалт, анхаарах асуудал”. Эрх зүйн процесс-эрх зүйн шинэтгэл, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2017.
12. ШШГЕГ. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэрэглэгдэх эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ., 2017.
13. ШШГЕГ-ын 2013-2017 оны тайлан.
14. [https://en.wikipedia.org/wiki/Community\\_service](https://en.wikipedia.org/wiki/Community_service)

## ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АСУУДАЛД

### MANAGEMENT ISSUES RELATED TO PRISON REHABILITATION PROGRAMS



#### Ц.ОЧГЭРЭЛ

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн профессорын багийн профессор, хууль зүйн ухааны доктор, хурандаа

#### OCHGEREL TS. (Ph.D in Law)

Colonel, Professor of the panel for Court Decision Executions Management and Strategy, Law Enforcement Management Academy, LEU

✉ [ochgerel.ts@leu.gov.mn](mailto:ochgerel.ts@leu.gov.mn)

**Товч агуулга:** Монгол Улсын хорих байгууллагын үйл ажиллагааны үндсэн нэг чиглэл болох ялтныг нийгэмшүүлэх ажлын төлөвлөлт, удирдлагын үйл ажиллагааг зөв зохион байгуулах нь ялын зорилгыг хангах, эрүүгийн ялын бодлогыг нийгэмд өгөөжтэй байдлаар хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Энэхүү илтгэлээр хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын менежмент буюу удирдлага, зохион байгуулалт, хяналт, манлайлал, түүний агуулга, хэлбэр, ач холбогдлын талаар судлаачийн зүгээс хийсэн дүгнэлт, саналаа илэрхийлэхийг зорилоо.

**Abstract:** The proper planning and management of rehabilitation programs is one of the main operations of prison facilities in Mongolia and is especially significant for implementing criminal sentencing policies in a manner that is beneficial to society. The purpose of this article is to propose new ideas about the management, organization, supervision and leadership of prison rehabilitation programs as well as to discuss about its contents, forms and significance.

**Түлхүүр үгс:** Хорих байгууллага, нийгэмшүүлэх ажил, удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалт, манлайлал, хяналт.

**Keywords:** Prison facility, rehabilitation, management, planning, organization, leadership, supervision.

Хорих байгууллага дахь нийгэмшүүлэх ажлын менежментийн асуудлыг хөндөн тавихын тулд юуны түрүүнд энэхүү мэргэжлийн, бие даасан үйл ажиллагаа нь Монгол Улс дахь ялын бодлого, ялын зорилготой хэрхэн уялдах, түүний агуулга, мөн чанар, тэдгээртэй холбогдсон эрх зүйн шинэчлэлийн асуудлыг цухас дурдах нь зүйтэй гэж үзлээ.

Хорих байгууллага нь төрийн зүгээс нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт явдалтай хийх тэмцлийн чиглэлээр явуулж буй эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэгч нэг чухал субъект төдийгүй аливаа улс орны “Эрүүгийн бодлого буюу төрийн зүгээс гэмт явдлын өсөлтийг бууруулах, тогтворжуулах зорилтыг хангах оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх замаар нийгмийг гэмт халдлагаас хамгаалах чиглэлээр явуулж буй идэвхтэй үйл ажиллагаа”-ны<sup>1</sup> салшгүй нэг хэсэг нь эрүүгийн ял эдлүүлэх ажиллагаа

<sup>1</sup> Беляева.Л.И. Уголовная политика и её реализация органами внутренних дел. М., 2003. с.7.

байдаг.

Зөвхөн гэмт явдалтай хийх тэмцэл, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд төрийн эрүүгийн бодлогыг тодорхойлох хандлага хууль тогтоогчдын дунд төдийгүй хууль зүйн салбарын эрдэмтэн, судлаачдын зүгээс шүүмжлэл дагуулж, эрх зүйн шинэтгэлийн нэг үндсэн чиглэл болох шатандаа хэдийнээ оржээ. Өөрөөр хэлбэл, зөвхөн тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд төрийн эрүүгийн бодлогыг чиглүүлэхээс илүүтэй нийгмийн бүхий л асуудлыг цогцоор нь харж, гэмт явдлын шалтгаан, нөхцөлтэй холбоотой тулгамдаж буй хүндрэлийг өргөн хүрээтэйгээр шийдвэрлэх явдал эрүүгийн бодлогод тодорхой байр суурийг эзлэх боллоо.

Гэмт явдлыг саармагжуулах, яваандаа арилгах алс хэтийн зорилтыг хэрэгжүүлэхэд ялын болон улс төр, нийгэм-эдийн засаг, эрх зүйн иж бүрэн арга хэмжээг төрийн эрүүгийн



бодлогын хүрээнд авч хэрэгжүүлдэг<sup>2</sup> талаар судлаачид өөрсдийн бүтээлдээ дурдсан байдаг. Судлаачдын зүгээс ял бол гэмт явдалтай тэмцэх гол арга хэрэгсэл биш гэж үздэгтэй миний хувьд санал нийлж байгаа хэдий ч ялын бодлого Монгол Улсын эрүүгийн бодлогын тулгуур хэсэг байх нь ойлгомжтой гэж үзэж байна.

Чухам нийгмийн болон хүний хөгжлийг дэмжих, нийгэм дэх эрх зүйн зөрчил, гэмт явдлын нийгэмд хор аюултай шинжийг өөрчлөх, шууд болон шууд бусаар үүсэх хор уршиг, сөрөг үр дагаврыг бууруулах, шоронжсон, гэмт бие хүний нийгэмд эзлэх хувь хэмжээг багасгах, хууль дээдлэх, шударга ёсыг хангах зарчмыг агуулсан байх шаардлагад эрүүгийн ялын бодлогын мөн чанар, үр нөлөөг нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

Энэ нь эрх зүйт төрийг бэхжүүлэх, хуулийн засаглалыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой байх нь гарцаагүй. Энэ ч үүднээс сүүлийн жилүүдэд ялын бодлогын агуулга, мөн чанарт томоохон өөрчлөлт эрх зүйн шинэтгэлийн ажлын хүрээнд хийгдсээр байгааг 2015 онд батлагдсан Эрүүгийн хуульд туссан ялын бодлогын өөрчлөлтөөс харж болохоор байна. Тухайлбал, тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 д.х хэсэгт "Ялын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас хөндөгдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин нийгэмшүүлэхэд оршино"<sup>3</sup> хэмээн тодорхойлсноос үүнийг харж болно.

Ял нь гэмт явдлаас урьдчилан сэргийлэх зорилгыг агуулахаас гадна гэмт хэрэг үйлдсэн хүний сэтгэл зүй, ухамсар дахь гэмт санаа бодлыг бууруулах, татгалзуулах, арилгах, түүнд эрх зүйн болон ёс суртахууны хэм хэмжээг хүндэтгэн сахих, нийгмийн харилцаанд зөв байр сууринаас оролцох хандлагыг бий болгох зорилгыг давхар агуулсан байх ёстой гэж судлаачийн зүгээс үзэж байна. Судлаачдын зүгээс ялын зорилгын талаар харилцан адилгүй байр суурь баримталж, цээрлүүлэх, иргэн нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, хүмүүжүүлэх, урьдчилан сэргийлэх, залхаах, гэмт хэргийн улмаас хохирсон эрхийг нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх зэргээр тодорхойлж ирсэн.

Өнөөдрийн илтгэлээр ялын зорилго,

<sup>2</sup> С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. (Ялын тухай сургаал) II боть. УБ., 2014. 20 дахь тал.

<sup>3</sup> <http://legalinfo.mn/law/details/11634?lawid=11634> 2016.11.08.

мөн чанарын талаар харьцуулан дүгнэх, мэтгэх, шүүмжлэх зорилго тавиагүй бөгөөд судлаачийн зүгээс ялын үндсэн зорилгын нэг нь дээр дурдсанчлан нийгмийн болон хүний хөгжлийг дэмжих, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх шаардлагыг агуулсан байх ёстой гэсэн байр сууринаас хандаж, улмаар эрүүгийн ялын хамгийн хүнд хэлбэр болох хорих ялыг эдлүүлэх явц дахь нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхэд удирдлагын үйл ажиллагааны үүрэг, оролцооны талаар өөрийн санааг дэвшүүлэн гаргахыг зорьсон.

Угаас эрүүгийн ялын бодлого дахь энэхүү зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүнд цаашид гэмт санаа бодол бүхий бие хүн болж төлөвших, шоронжих буюу эрүүгийн хэв шинжтэй (криминальная субкультура) болохоос урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэхэд чиглэгдэж, хорихоос өөр төрлийн ялын хэлбэрийг илүү нээлттэй, өргөн хэрэглэхийг шаардаж байна.

Чухам энэ нөхцөлд хорих ял эдлүүлэх ажиллагааны явц дахь нийгэмшүүлэх ажлыг эрүүгийн ялын бодлогод нийцүүлэн нарийн төлөвлөлттэй, гадаад улс орны зөв жишгийг нэвтрүүлсэн, нийгэмд эерэг үр нөлөө үзүүлэхүйц, ялтны хувь хүний зан үйл, хандлагад чиглэсэн хэлбэрээр зохион байгуулах хэрэгцээ, шаардлага байсаар байна.

Ялын үндсэн зорилгын нэг нь ялтныг нийгэмшүүлэх асуудал гэж үзвэл чухам хорих ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж буй хорих байгууллагын үйл ажиллагааны зорилго, чиглэлд ялтныг нийгэмшүүлэх ажлын оролцоог түлхүү тусгаж өгөх шаардлагатай байна.<sup>4</sup>

Өөрөөр хэлбэл төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага болохын хувьд хорих байгууллагын үйл ажиллагааны зорилго, тэргүүлэх чиглэл, эрх зүйн зохицуулалт, бүтэц, тогтолцоо, үйл ажиллагааны хөтөлбөр, үнэлгээ, судалгаа, шинжилгээний ажил зэрэг бүхий л чиглэлд ялтныг нийгэмшүүлэх ажлыг цогц хэлбэрээр тусгаж хэрэгжүүлэх нь нийгэмшүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах нөхцөл болох дамжиггүй юм.

Иймээс аливаа байгууллагын үйл ажиллагааг хэтийн зорилгод тулгуурлан хөгжүүлэх асуудлыг чухамдаа байгууллагын хөгжил, удирдлагын зөв зохион байгуулалттай холбон судлах шаардлага үүсэж байна.

Хорих байгууллагын үйл ажиллагаан

<sup>4</sup> Б.Алтангэрэл. Хорих ял эдлүүлэх онол, арга зүйн асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон диссертаци. УБ., 2015. 45 дахь тал.



дахь нийгэмшүүлэх ажлын зорилгыг тодорхойлох, үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хяналт, манлайлал зэргийг менежментийн үүднээс авч үзэх нь хорих ял шийтгэгдсэн хүнийг дахин нийгэмшүүлэх ажлыг эрүүгийн ялын бодлогын шаардлагад нийцүүлэх нөхцөлийг бий болгон нийгэм дэх эерэг үр дагаврыг бий болгох эхлэл болох нь зайлшгүй юм.

Аливаа байгууллагын амжилт, үр дүн нь түүний удирдлагын үйл ажиллагаа буюу менежмент, удирдлагын мэдлэг, боловсрол, дадлага, туршлага, чадвараас ихээхэн шалтгаалдаг<sup>5</sup>.

Эндээс юуны түүрүүнд менежмент гэж юу вэ, түүний судлагдахуун, мөн чанар зэргийг товч байдлаар тодорхойлон авч үзье.

Менежмент гэж юу вэ? гэсэн асуултыг тавьж, менежментийн сурах бичгүүдээс мэдээлэл хайвал “Менежмент бол байгууллагын зорилгод чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, боловсон хүчний нөөц бүрдүүлэх, идэвхжүүлэх, манлайлах, хянах үйл ажиллагаануудын нэгдэл юм” гэсэн ерөнхий тодорхойлолт олонтоо тааралдана. Нөгөө талаас менежмент бол үр дүнд суурилсан ойлголт буюу урлаг, байнгын шинж чанартай судалгаа, шинжилгээний ажилд тулгуурладаг учир шинжлэх ухаан хэмээн судлаачид үзсээр иржээ.

Судлаачдын бүтээл, туурвилаас авч үзвэл чухам байгууллага нь өөрийн үндсэн үйл ажиллагааны зорилгыг тодорхойлох, төлөвлөх, зохион байгуулахын зэрэгцээ яаж зөв ажиллах, оновчтой ямар аргыг хэрэгжүүлж, асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг нь менежментийн ухааны онцлог шинж байдаг<sup>6</sup>.

Менежментийн үүднээс авч үзвэл хорих байгууллага дахь нийгэмшүүлэх ажил зохистой түвшинд зохион байгуулагдаж байна гэж үзэхэд учир дутагдалтай байна. Тухайлбал, менежментийн үүднээс хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын чиглэлээр дараах үндсэн чиглэлд түлхүү анхаарсан бодлогыг баримтлах зүй ёсны шаардлага байна гэж судлаачийн хувьд үзэж байна. Үүнд:

- Нийгэмшүүлэх ажлын үйл ажиллагааны хэтийн зорилго, чиглэл, стратегийг зөв тодорхойлох.

- Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын чиглэлд мэргэшсэн хүний нөөцийн

хөгжлийн бодлогод суурилсан төлөвлөлтийг хөгжүүлэх.

- Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалтад ШШГБ-ын удирдлагын баг болон мэргэжлийн байгууллагын оролцоог байнгын шинжтэй хангах.

- Нийгэмшүүлэх ажлын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг мэргэжлийн болон судалгааны байгууллага, судлаачдын оролцоотой тогтмолжуулах. Судалгааны ажлын санг бий болгож, шинэлэг арга зүйг практикт нэвтрүүлэх.

- Нийгэмшүүлэх ажлын удирдлагын манлайллыг бэхжүүлэх.

- Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын хүрээнд хэрэгжих мэргэжлийн үйлчилгээ, нөлөөллийн арга хэмжээг багтаасан зорилтот хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн үнэлгээг хийж хэвших.

- Нийгмийн ажилтны ёс зүй, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ шалгуурыг боловсронгуй болгох гэх зэрэг олон нөхцөлийг дурдаж болно.

Судлаач нь менежментийн ухааны онол, хандлагын талаар судлан шинжлэх зорилго тавиагүй тул зөвхөн хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын хувьд өнөөгийн нөхцөл байдал дахь зарим тулгамдаж буй зарим асуудлыг тодотгон авч үзье. Үүнд:

Нэгд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зорилгод хоригдлыг нийгэмшүүлэх ажлын талаар тусгасан олон улсын жишгийг нэвтрүүлэх.

Энд судлаачийн зүгээс эрүүгийн хууль тогтоомжийн ялын зорилгын хэсэгт гэмт хэрэгт ял шийтгэгдсэн хүнийг дахин нийгэмшүүлэх чиглэл туссан хэдий ч түүний гүйцэтгэлийг хангах чиг үүрэг бүхий хуулийн зорилгод зайлшгүй тодотгон оруулах шаардлагатай гэж үзэж байна. Гадаад улс орнуудын эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны тухай хууль тогтоомжийн нэр, зорилгод ялтныг нийгэмшүүлэх агуулга тодорхой хэмжээнд туссан байдаг.

Хоёрт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага (Хорих байгууллага)-ын үйл ажиллагааны стратеги төлөвлөлтөд бие даасан бүлэг хэлбэрээр тусган, үе шаттай хэрэгжүүлэх зорилтуудыг тодорхойлох.

Судлаачийн үзэж байгаагаар хорих ял эдлүүлэх ажиллагааны стратеги төлөвлөлтийн нэг үндсэн хэсэг нь хоригдлыг нийгэмшүүлэх чиглэлд хэрэгжүүлэх багц зорилтыг агуулсан байх учиртай.

Чухамдаа Монгол Улсын эрх зүйн

<sup>5</sup> Н.Цэнд, Г.Батхүрэл нар. Менежмент. УБ., 2013. 28 дахь тал.

<sup>6</sup> Ц.Цэрэндорж, С.Цэрэндамба. Бидний менежмент. УБ., 2013. 25 дахь тал.



шинэтгэлийн хүрээнд хэрэгжиж буй хууль тогтоомжийн хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын стратеги төлөвлөлт, бодлогын баримт бичигт хорих ял эдлүүлэх байгууллагын хоригдлыг нийгэмшүүлэх агуулгыг тодорхой тусгахгүйгээр хорих байгууллага дахь нийгэмшүүлэх ажил нь ямар нэг эрх зүйн буюу хуулийн зохицуулалтгүй, төлөвлөлтгүйгээр орхигдох эрсдэлтэй гэж үзэж байна.

Гуравт, Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын албаны бие даасан, мэргэшсэн бүтцийг хөгжүүлэх, хорих анги, албадад зөвхөн мэргэшсэн сэтгэл зүйч, нийгмийн ажилтныг ажиллуулах.

Хэдийгээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны харьяанд Нийгэм, сэтгэл зүйн хэлтэс гэсэн нэршилтэй нэгж ажиллаж байгаа ч бүтэц, бүрэлдэхүүний хувьд нийгэмшүүлэх ажлын цар хүрээ, төлөвлөлт, зохион байгуулалттай холбоотой бүхий л чиг үүргийг хэрэгжүүлэхэд учир дутагдалтай байна. Тухайлбал, дээр дурдсан нэгж нь хорих байгууллагын хэмжээн дэх нийгэмшүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах дараах чиглэлийг хамарсан хангалттай хэмжээний бүтэцтэй байх шаардлагатай байна. Үүнд:

- Хоригдлыг нийгэмшүүлэх хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээг хийх.

- Эрх зүйн бичиг баримтын боловсруулалт, өөрчлөлтийг мэргэжлийн түвшинд хийх.

- Хоригдлыг сургах, мэргэшүүлэх бүхий л шатны үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах.

- Сэтгэл зүй, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байх.

- Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг тогтмол хангах.

- Хорих байгууллага дахь нийгэмшүүлэх ажлын үр нөлөө, хөгжлийн хандлага, хэрэгжилт, хоригдлын сэтгэл зүй, хандлагын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, шинжилгээний ажлыг тогтмол явуулах.

- Нийгэмшүүлэх ажлын санхүүжилт, эдийн засгийн болон нийгмийн үр ашгийг тооцох.

- Хорих анги дахь нөхцөл байдалд орчны үнэлгээ хийх, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарын үйл ажиллагаанд үнэлэлт,

дүгнэлт өгөх.

- Хорих байгууллагын удирдлагын манлайлалд нөлөөлөх гэх мэт маш олон чиг үүргийг бүрэн хангаж чадахуйц мэргэшсэн бүтэц шаардлагатай байна.

Түүнчлэн бодит байдал дээр нийгэмшүүлэх ажлын чиглэлээр ажиллаж буй ажлын байрны хүрэлцээ дутмаг байна. Тухайлбал, орон нутаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд сэтгэл зүйчийн ажлын байр огт байдаггүй, ачаалал бүхий хорих ангиудад нийгмийн ажилтны ажлын байр дутмаг, хорих байгууллагад тогтмол, тасралтгүй зохион байгуулагдах шаардлагатай хоригдлын төрөл бүрийн сургалтыг зохион байгуулах чиг үүрэг бүхий сургагч багшийн ажлын байр огт байхгүй байна.

- Дөрөв, Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, судалгаа шинжилгээний ажил хангалтгүй байна.

Тав, Хорих байгууллагын мэргэжлийн нийгмийн ажилтны сургалтын тогтолцоо, мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтын стандарт байхгүй, мэргэжлийн ажилтныг хөгжүүлэх, урамшуулан дэмжих ажил дутмаг.

Хорих ангиудад ажиллаж буй нийгмийн ажилтны дунд мэргэжлийн нийгмийн ажлын боловсрол эзэмшсэн ажилтны тоог нэмэгдүүлэх шаардлага байсаар байна. Түүнчлэн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг практик хэрэгцээнд тулгуурлан шинээр бий болгох шаардлагатай байгаагийн зэрэгцээ тэдгээрийн мэргэжлийн үйл ажиллагаа, ур чадварыг үнэлж дүгнэх аргачлал боловсруулж мөрдүүлэх, улмаар хөгжүүлэх, урамшуулах оновчтой зохион байгуулалтын арга хэлбэрийг хөгжүүлэх нь зүйтэй байна.

Зургаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын эрх зүйн үндсийг өргөжүүлэн тусгах шаардлагатай байна. Тухайлбал, зарчим, нэр томъёоны тайлбар, нийгэмшүүлэх албаны бүтэц, чиг үүрэг, нийгэмшүүлэх чиг үүрэг, бүхий ажилтны мэргэжлийн үйл ажиллагаа, нийгэмшүүлэх үйл ажиллагааны хэлбэр, арга, хамтын ажиллагаа, түүний үр дүнг үнэлэх асуудал, суллагдахад бэлтгэх гэх мэт асуудлыг дурдаж болно.

Иймд цаашид хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын менежментийн асуудлын чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай байна гэж үзэж



байна.

1. Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын зорилгыг салбарын түвшинд зөв тодорхойлох.

2. Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын төлөвлөлт, зохион байгуулалтыг олон улсын чиг хандлагад нийцүүлэн чамбайруулах.

3. Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын удирдлагын бүтцийг мэргэшсэн хэлбэрээр өргөжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны зохион байгуулалтын арга, хэлбэрийг тогтмол шинэчилж байх.

4. Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлыг хэрэгжүүлэх мэргэшсэн хангалттай тооны хүний нөөц бүрдүүлэх, хөгжүүлэх.

5. Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын албаны албан хаагчдыг идэвхжүүлэх, урамшуулах, ажлын үр дүнг үнэлж дүгнэх шинэчилсэн механизмыг бий болгох.

6. Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын манлайллыг мэргэжлийн түвшинд хөгжүүлэх. Үүнд мэргэжилтний манлайллаас гадна хорих байгууллагын удирдах ажилтны нийгэмшүүлэх ажлын мэдлэг, оролцоо, манлайллыг хөгжүүлэх.

7. Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох.

8. Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажлыг бусад салбарын үйл ажиллагаатай хамтран явагдах, уялдуулах нөхцөлийг бий болгох, сургалт, судалгааг өргөжүүлэх зэрэг саналыг дэвшүүлж байна.

Эдгээр саналын зарим хэсэг нь практикт удирдлагын түвшинд боловсруулагдаж байгааг тэмдэглэхийн сацуу сонирхон судлагч хэн боловч санал бүрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл солилцох асуудал ХСУА-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн профессорын багийн хувьд нээлттэй болохыг илэрхийлж байна.

### Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль. Албан ёсны хэвлэл. УБ., 1992.

2. Монгол Улсын хуулиудын эмхэтгэл. УБ., №6.

3. Төрийн мэдээлэл сэтгүүл. УБ., 2002. №2.

4. С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. (Ялын тухай сургаал) II боть. УБ., 2014.

5. А.Лхагва. Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй. УБ., 1996.

6. А.Лхагва. Шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүй. УБ., 1999.

7. А.Лхагва. Монгол Улсын Эрүү, иргэний хэрэгт холбогдох шүүхийн шийдвэр биелүүлэх хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 2005.

8. А.Лхагва. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж. УБ., 2014.

9. Н.Цэнд, Г.Батхүрэл нар. Менежмент. УБ., 2013.

10. Ц.Цэрэндорж, С.Цэрэндамба. Бидний менежмент. УБ., 2013.

11. Беляева.Л.И. Уголовная политика и её реализация органами внутренних дел. М., 2003.

12. Б.Алтангэрэл. Хорих ял эдлүүлэх онол, арга зүйн асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон диссертаци. УБ., 2015.



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ САХИУЛАХУЙ

## ХОРИХ БАЙГУУЛЛАГА ДАХЬ НИЙГЭМ, СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

FOCUSING ON THE IMPLEMENTATION PROCESS OF SOCIAL AND PSYCHOLOGICAL SERVICE PROGRAM IN PENAL INSTITUTIONS

### О.БАЯРЖАРГАЛ

ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш, ахмад

### BAYARJARGAL O.

Captain, Senior lecturer of Social work faculty, Institute of Court Decisions Execution, LEU

✉ [bayarjargal.o@leu.gov.mn](mailto:bayarjargal.o@leu.gov.mn)

**Товч агуулга:** Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр боловсруулан, түүнийг хорих анги, шийдвэр гүйцэтгэх газар хэрэгжүүлэх нь өнөөгийн нийгэмд ихээхэн чухал, цаг үеэ олсон, үр дүнтэй ажлын нэг юм. Хэдийгээр манай оронд нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ хөгжөөд төдийлөн удаагүй байгаа ч шүүхийн шийдвэр гүйцэтгэх салбарт энэхүү үйлчилгээг хөгжүүлж буй нь сайшаалтай бөгөөд нийгмийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэж байна.

Дэлхийн улс орнуудын жишгээс харахад ял эдэлж буй хоригдогчдод зориулсан олон төрлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг бөгөөд тэдгээр нь хоригдогчийн хандлага, зан үйлийг өөрчилж, дахин гэмт хэрэг үйлдэхээс бүрэн сэргийлэхэд чиглэгдсэн байна.

**Abstract:** It is a vital and effective project today to develop social and psychological service program for implementing in penal institutions and execution of court decision institutions. This service has become appropriate to the social demand whenever it has just developed in the field of execution of court decision.

In other countries, there are lots of programs developed with the aim of preventing from becoming recidivisms and changing inmates' attitudes and behaviors.

Our goal is also to rehabilitate inmates, change their attitudes and behaviors, and help them to prevent from committing crime, to become liable people and to live independently.

Therefore, we need to develop certain methodical program for inmates and deliver them our social and psychological service with the result of our work according to the program.

**Түлхүүр үгс:** Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ, хөтөлбөр, хоригдол, зан үйлийг өөрчлөх хандлага.

**Keywords:** Social and psychological service, program, attitude, inmate, changing behavior.

Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг тодорхой түвшинд ахиулахад тухайн нийгмийн хувь хүн бүрийн хөгжил чухал байр суурь эзэлдэг. Өөрөөр хэлбэл, хувь хүн бүрийн хөгжлөөс улс орны хөгжил хамаарна гэсэн үг. Гэтэл манай нийгмийн өнөөгийн байдлыг авч үзвэл нийт хүн амын 0,2 хувь<sup>1</sup> нь хорих анги, шийдвэр гүйцэтгэх газарт ял эдэлж байна. Гэмт хэрэг үйлдсэн хүмүүс тодорхой хугацаанд ял эдэлж, тэдэнд шийтгэл хүлээлгэж байгаа ч ял эдэлнэ гэдэг нь зөвхөн эрхийг нь хязгаарласан орчинд он жилүүдийг өнгөрөөнө гэсэн үг биш, харин энэ хугацаанд тухайн хоригдогчийн асуудал бүхий буюу нийгмийн эсрэг зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн янз бүрийн үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлж, <sup>1</sup>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2018 оны 3 сарын тайлан. МУ-ын Үндэсний статистикийн хороо / [www.nso.mn/](http://www.nso.mn/)

тухайн хүнийг засаж залруулах нь нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэх болно. Хэдийгээр ял эдлэх хугацаанд нь хөдөлмөр эрхлүүлж, түүгээр дамжуулан тухайн хүнд эерэг нөлөөлөл бий болгохыг зорьж байгаа ч бидний хүсэн хүлээж буй үр дүнд төдийлөн гарахгүй байна. Харин хоригдлын хувьд ажил хөдөлмөр эрхэлснээрээ нэг талаас цаг хугацааг өнгөрүүлэх, нөгөө талаас ял эдлэх хугацааг багасгах талаас нь тусган авч буй байдал ажиглагдаж байна.

Дэлхийн улс орнуудын жишгээс харахад ял эдэлж буй хоригдлуудад зориулсан олон төрлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг бөгөөд тэдгээр нь хоригдогчдын хандлага, зан үйлийг өөрчилж, дахин гэмт хэрэг үйлдэхээс бүрэн сэргийлэхэд чиглэгдсэн байна.

Бидний зорилго ч мөн адил хоригдлыг



төлөвшүүлж, зан үйл, хандлагаа өөрчлөн, дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлж, нийгэмд хариуцлагатай иргэн болж, бие даан амьдрахад тэдэнд туслах явдал юм. Үүний тулд тодорхой системтэй хөтөлбөр боловсруулж, түүний дагуу ажиллан, үр дүнг тооцож, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх шаардлагатай байна.

Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрийг хорих анги, шийдвэр гүйцэтгэх газарт ял эдэлж буй хоригдлуудын дунд хэрэгжүүлэх бөгөөд тэдэнд зориулан сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр нь дараах чиглэлээр боловсруулагдсан. Үүнд:

1. Архины шалтгаант зан үйлийг өөрчлөх
2. Харилцааны чадвар сайжруулах
3. Хүчирхийлэл үйлдэх зан үйлийг өөрчлөх
4. Уур бухимдлаа зохицуулах
5. Өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх
6. Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх

Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрт хорих ангид ял эдэлж буй бүхий л хоригдлыг хамруулахыг зорих боловч нэг бүлэгт хамрагдах хүмүүсийг сонгохдоо хоригдлын үйлдсэн гэмт хэргийн төрөл, хувь хүний онцлог, хандлага, нийгмийн чадварын түвшин зэргийг харгалзах хэрэгтэй. Зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн аливаа хөтөлбөрүүдэд ердийн нөхцөлд өөрийн хүсэл эрмэлзлэлийн дагуу хамрагдаж буй хүмүүс мэдэгдэхүйц ахиц өөрчлөлт буюу үр дүнд хүрдэг. Гэвч хорих ангийн нөхцөлд өөрийн хүсэлтээр гэхээс илүүтэй эрх зүйн орчин, байгууллага, нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу албадан сургалтын хөтөлбөрт хамруулах тохиолдлууд ч байдаг.

Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний ямар хөтөлбөрт хэн хамрагдах шаардлагатайг хоригдол хорих ангид ирсэн дарууд үнэлгээ хийж тодорхойлох ёстой. Гэхдээ хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлж эхэлж буй тохиолдолд тус асуудалд уян хатан хандах хэрэгтэй. Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний тодорхой нэг хөтөлбөрт хамрагдсан хүн өөр бусад хөтөлбөрт хамрагдах бүрэн боломжтой. Өөрөөр хэлбэл, хэрвээ шаардлагатай бол нэг хүн бусад боломжтой бүх хөтөлбөрт хамрагдаж болно. Харин хэрвээ тухайн хүн архины хамааралгүй, мөн хүчингийн гэмт хэрэг үйлдээгүй бол эдгээрт чиглэсэн хөтөлбөрт хамрагдах шаардлагагүй.

Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний

дээр өгүүлсэн 6 чиглэлийн хөтөлбөрт хоригдлын нийгэм, сэтгэл зүйн байдал болон архины хэрэглээний түвшинг тодорхойлсон үнэлгээгээр ерөнхийдөө архины хамааралтай, харилцааны ерөнхий чадвар сул, өөрийн үнэлэмж доогуур, уур бухимдлаа барьж чаддаггүй, хүчирхийлэгч зан авиртай, хүчингийн гэмт хэрэг үйлдсэн зэрэг хүмүүсийг хамруулна гэж үзвэл ял эдэлж буй бүхий л хоригдол хамрагдана.

Хорих ангид ял эдэлж буй ямар ч төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын хувьд харилцааны чадвар хөгжүүлэх, хүчирхийлэл үйлдэх зан үйлийг өөрчлөх, уур бухимдлаа зохицуулах, өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх зэрэг хөтөлбөрүүдэд бүгдэд нь хамрагдаж болно. Бүх төрлийн хоригдол хамрагдаж болох эдгээр хөтөлбөрүүдийн хувьд бүлгийн гишүүдийг тусгайлан сонгох шаардлагагүй бөгөөд насны хувьд 18-аас дээш насны, ямар ч хүйсийнхэнд тохирно. Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүдийн хорих ангид ч тус нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж болно.

Харин архины шалтгаант зан үйлийг өөрчлөх хөтөлбөрт архины асуудлыг илрүүлэх асуумж болон эрсдэлийн үнэлгээгээр архи хэтрүүлэн хэрэглэгч байж болзошгүй ба архи хэтрүүлэн хэрэглэгч, архины хамааралтай—архины шалтгаант төрх үйлийн эмгэгтэй болох нь тодорхойлогдсон хүмүүс хамрагдана.

Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх хөтөлбөрт бага насны хүүхэд болон насанд хүрсэн эмэгтэйчүүдийг хүчиндсэн, зөвхөн насанд хүрсэн эрэгтэйчүүд хамрагдах боломжтой. Харин тус хөтөлбөр нь эрэгтэйчүүдийг хүчирхийлсэн эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдэд зориулагдаагүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, эдгээрт зориулсан хөтөлбөр нь тус хөтөлбөрөөс өвөрмөц онцлогтой юм.

Хорих ангид хоригдогчийг анх ирэх үед хийсэн нийгэм, сэтгэл зүйн үнэлгээнд тулгуурлан нэн тэргүүнд ямар хөтөлбөрт хамруулах шаардлагатайг тодорхойлж, бусад хөтөлбөрүүдэд хэзээ хамруулахыг төлөвлөнө. Үүнийг төлөвлөхийн тулд ял эдлэх хугацааг харгалзах шаардлагатай болно. Жишээлбэл, нэг жилийн ял эдлэх болон 6 жилийн ял эдлэх хоригдлын хувьд хөтөлбөрт хамрагдах хугацааг өөр өөрөөр төлөвлөх хэрэгтэй гэсэн үг. Мөн нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний нэг хөтөлбөрт нэг хүн давтан хамрагдаж болох бөгөөд эсвэл тухайн хөтөлбөрийн ахисан түвшин



буюу дараагийн шатанд хамрагдаж болно. Тухайлбал, Хүчирхийлэл үйлдэх зан үйлийг өөрчлөх хөтөлбөрт хорих ангид ирээд 1 жилийн дотор хамрагдсан хүн ялын хугацаа дуусаж, суллагдахын өмнөх 6 сарын дотор дахин тус хөтөлбөрт хамрагдаж болно. Ингэснээр тус хөтөлбөрийн хүрээнд эзэмших чадвар, төлөвших хандлагыг дахин бататгаж өгнө. Бусад улс орны туршлагаас харахад суллагдсаны дараа нь үйлчилгээ үзүүлдэг буюу нийгэмд хүлээн авдаг байгууллагууд тэдгээр хөтөлбөрүүдтэй уялдаатай, хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, зорилтот зан үйлийг баттай хэвшүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулдаг байна.

Тухайн хөтөлбөрт хэнийг буюу ямар хоригдогчийг хамруулж, юунд зориулагдсан нь дараах байдлаар томъёологдсон. Үүнд:

- Архины шалтгаант зан үйлийг өөрчлөх хөтөлбөр:<sup>2</sup> Тус нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр нь архи, согтууруулах ундааны хэтрүүлэн хэрэглээ, хэв шинжит бус хэрэглээ, хамаарлын улмаас хүчирхийлэл үйлдэж, өөрийн болон бусдын эрх ашгийг хохироон, ял эдэлж буй хоригдлуудын чиглэгдсэн болно. Хөтөлбөрийн гол зорилго нь хоригдогчдын архи, согтууруулах ундааны шалтгаант сэтгэл, донтолтын мөн чанарыг тайлбарлаж ойлгуулах, хүлээн зөвшөөрүүлэх, улмаар зан үйлийн өөрчлөлтүүдийг засахад чиглэгдэж цаашид архидан согтуурснаас үүдэх гэмт хэрэг дахин үйлдэхээс сэргийлэх, сэрэмжлүүлэхэд оршино.

- Харилцааны чадварыг сайжруулах хөтөлбөр. Хууль бус үйлдлээс шалтгаалан эрх нь хязгаарлагдсан хүмүүст зориулагдаж тухайн нөхцөл байдал, харилцааны онцлогт тохируулсан, сэтгэл зүйн болон харилцааны асуудлаа шийдвэрлэхэд нь туслалцаа үзүүлэх, бие хүний болон хамтын харилцааны ур чадварыг сайжруулах, өөрийн зан үйлийг чиглүүлэхэд болон бусадтай харилцах харилцааны суурь мэдлэг чадварыг олгоход чиглэсэн болно. Харилцааны үндсэн ухагдахууныг танин мэдэж, хувь хүний харилцааны онцлогийг таних чадвартай, хамтын ба нийгмийн харилцааны тодорхой мэдлэг чадвар, ур ухааныг эзэмшүүлэхэд чиглэнэ.

- Хүчирхийлэл үйлдэх зан үйлийг өөрчлөх хөтөлбөр: Хоригдлуудын дунд явуулсан судалгаагаар хүчирхийлэл үйлдэх зан үйлтэй болох нь тогтоогдсон хоригдлууд хамрагдана. Тус хөтөлбөрийн зорилго бол 2 С.Мөнхтуяа ба бусад, "Архины шалтгаант зан үйлийг өөрчлөх нь" сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр.

эрх нь хязгаарлагдсан хүмүүс хүчирхийлэл үйлдэх сөрөг зан үйлийг өөрчилж, өөртөө итгэлтэй эерэг зан үйлийг хэвшүүлэх явдал юм.

- Уур бухимдлаа зохицуулах хөтөлбөр:<sup>3</sup> Эрх нь хязгаарлагдсан хүмүүсийн хувьд гэмт хэрэгт холбогдсон зэрэг нөхцөл байдалтай холбоотой хувь хүний амьдрах ухаан, асуудлыг шийдвэрлэх чадварыг сайжруулахад чиглэгдсэн. Уг хөтөлбөрт хамрагдсанаар уур бухимдлаа хянах, бууруулах, зөв зүйтэй илэрхийлэх мэдлэг чадварт суралцана.

- Өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх хөтөлбөр: Хорих байгууллагуудад ял эдэлж байгаа 18-аас 60 насны хоригдлуудад өөрийгөө бодитой үнэлж, бусдад зөв зохистой илэрхийлэх тухай шинжлэх ухааны үндэстэй мэдлэг олгож, тэдэнд өөрийн бодит боломж, өөрийгөө илэрхийлэх чадвараа зөв үнэлж дүгнэх, хянаж, зохицуулах чадвар, дадлыг төлөвшүүлж, нийгмийн амьдралын янз бүрийн нөхцөлд өөрийн үнэ цэнээ ухамсарлаж, өөрийгөө бүтээлчээр илэрхийлж сурахад зориулагдсан болно.

- Бэлгийн хүчирхийлэл үйлдэх зан үйлийг өөрчлөх хөтөлбөр: Тус хөтөлбөр нь бэлгийн хүчирхийлэл үйлдэж, бусдын эрх ашгийг хохироон, ял эдэлж буй хоригдлуудад чиглэгдсэн. Хөтөлбөрийн гол зорилго бол хоригдлуудад бэлгийн хүчирхийлэл үйлдэх зан үйлийг бууруулах, улмаар хүчингийн гэмт хэрэг дахин үйлдэхээс сэргийлэхэд чиглэнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, ерөнхий зохион байгуулалт хэсэгт хөтөлбөр тус бүрийн нийт үргэлжлэх хугацааг уулзалтын тоо буюу давтамж, нэг удаагийн уулзалтын үргэлжлэх хугацаа, мөн уулзалтыг хэрхэн зохион байгуулах талаар тусгасан. Сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр тус бүрийн уулзалтын тоо харилцан адилгүй байгаа бөгөөд түүнээс хамааран хөтөлбөрийг хэрэгжүүлэх нийт хугацаа өөр өөр байна. Хөтөлбөр тус бүрийн уулзалтын тоо, үргэлжлэх хугацааг харуулбал:

3 Н.Оюут-Эрдэнэ ба бусад. "Уур бухимдлаа зохицуулах нь" сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр.

№	Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр <sup>1</sup>	Уулзалтын тоо	Нийт үргэлжлэх хугацаа
1	Архины шалтгаант зан үйлийг өөрчлөх нь	12	3 сар
2	Харилцааны чадварыг сайжруулах нь	8	2 сар
3	Хүчирхийлэл үйлдэх зан үйлийг өөрчлөх нь	12	3 сар
4	Уур бухимдлаа зохицуулах нь	6	1.5 сар
5	Өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх нь	6	1.5 сар
6	Бэлгийн хүчирхийлэл үйлдэх зан үйлийг өөрчлөх нь	10	2.5 сар

Дээрх хүснэгт дэх хөтөлбөр тус бүрийн нийт үргэлжлэх хугацааг гаргахдаа нэг долоо хоногт 1 удаагийн уулзалтыг зохион байгуулахаар тооцсон болно. Нэг удаагийн бүлгийн уулзалтын үргэлжлэх дундаж хугацаа 1 цаг 30 минут байна. Харин шаардлагатай тохиолдолд хийх ганцаарчилсан уулзалтыг 45 минутаар тооцсон болно. Уг хөтөлбөрүүд нь бүлгийн зохион байгуулалтаар хэрэгжихээр төлөвлөгдсөн бөгөөд зарим хөтөлбөрийн хүрээнд шаардлагатай тохиолдолд ганцаарчилсан зөвлөгөө өгнө. Харин бэлгийн хүчирхийлэл үйлдэх зан үйлийг өөрчлөх хөтөлбөрийн хувьд хосолмол хэлбэрийг ашиглана.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тооцох аргачлал

Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тооцохын тулд хэд хэдэн зүйлийг урьдчилан хийсэн байх ёстой. Үүнд:

- Хөтөлбөрт хамрагдаж буй хоригдогчийн нийгэм, сэтгэл зүйн байдлыг хөтөлбөрийн эхэнд үнэлсэн байх
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад тодорхой хугацаанд ахиц өөрчлөлтийг үнэлсэн байх
- Хөтөлбөр дуусмагц төгсгөлийн үнэлгээ хийсэн байх

Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр тус бүр өөрийн өвөрмөц онцлогоос хамааран бүлгийн гишүүн тус бүрийн нийгэм, сэтгэл зүйн байдлыг үнэлэхийн зэрэгцээ холбогдох бусад үнэлгээг хийж, эхлэл цэгийн нөхцөл байдлыг тодорхойлно.

Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэд хэдэн зүйлийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Хөтөлбөрт хамрагдах хүмүүсийг сонгон авах
- Хөтөлбөрийн тасралтгүй тууштай үргэлжлэх байдлыг хангах
- Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий график гаргаж, бусад үйл ажиллагаатай уялдуулж,

ажиллах

- Хөтөлбөрт хамрагдаж буй хүн тус бүрийн зорилтот зан үйлийг өөрчлөхтэй холбоотой хэмжигдэхүйц зорилго тавих
- Хөтөлбөрийн үр дүнг тодорхой шалгуурын дагуу үнэлж, дүгнэх

Хөтөлбөрт хамрагдах шаардлагатай хэмээн тодорхойлогдсон хүмүүстэй ганцаарчилсан уулзалт хийж, хөтөлбөрт яагаад хамрагдах хэрэгтэй, хамрагдсанаар ямар ач холбогдолтой, тус хөтөлбөрт ямар хүмүүс хамрагдах, хөтөлбөрт хамрагдсан хүмүүст ямар урамшуулал олгох (тухайлбал, цагийг тооцож, ажлын хоног олгох эсвэл хөтөлбөрт хамрагдсанаар хувь хүнд гарч буй үр дүнгээр тодорхой ямар нэгэн урамшуулах олгох гэх мэт зүйлсийг ашиглах боломжтой), хөтөлбөрийн ерөнхий зохион байгуулалт зэргийг танилцуулж, зөвшөөрсөн тохиолдолд бүлэгт хамруулахаар сонгон авч болно. Хөтөлбөрт хамрагдахаар сонгогдсон хүмүүстэй анхны уулзалтын үеэр гэрээ байгуулах нь нэн чухал.

Хөтөлбөрийн тасралтгүй тууштай үргэлжлэх байдлыг хангахын тулд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан график гаргах хэрэгтэй. Тус графикийг харгалзан хөтөлбөрт хамрагдаж буй хоригдогчийн өдрийн дэглэмийг зохицуулах шаардлага гардаг. Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрийн явцад уулзалт тус бүрийг төлөвлөсөн хугацаанд зохион байгуулах нь чухал учраас нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн ажлын ачаалал, хоригдлын ажлын өдөр тутмын үйл ажиллагааны хуваарь зэргийг нарийн тооцох хэрэгтэй. Хэрвээ уулзалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулаагүй тохиолдолд хөтөлбөр тодорхой үр дүнд хүрч чадахгүй болохыг хатуу анхаар хэрэгтэй. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан график гаргахдаа долоо хоног тутамд 1 удаа уулзалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн бол уулзалтын өдөр болоод цагийг тогтмол байхаар зохицуулах хэрэгтэй. Өөрөөр



МОНГОЛЫН ХУУЛЬ САХИУЛАХУЙ



хэлбэл, хорих ангийн дотоод ажлын зохион байгуулалтаас хамаараад нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөрийн уулзалтыг долоо хоногийн 2 дахь өдөр байхаар төлөвлөсөн бол хөтөлбөрийн эхнээс дуусах хүртэл хугацаанд тогтмол тухайн өдөрт нэг л тогтсон цагт явуулж байх нь тогтвортой байдлыг хангахад тустай байх болно.

Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд хөтөлбөрт хамрагдаж буй хувь хүн тус бүрийн зорилтот зан үйл болон зорилгыг тодорхойлох нь чухал. Зорилгоо тодорхойлохын зэрэгцээ хөтөлбөрт хамрагдахын өмнөх түвшинг үнэлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, зөвлөгөөний уулзалт тус бүрийн хүрээнд зорилго, хүрэх үр дүнг тодорхойлж, тэдгээрт хүрэхийн тулд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгасан. Зөвлөгөөний уулзалтаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа тус бүрийн ач холбогдлыг нийгмийн ажилтан, сэтгэл зүйч өөрөө сайн ойлгосон байх шаардлагатай бөгөөд үйл ажиллагаа тус бүрийн үр дүнг хөтөлбөрт хамрагдаж буй хүмүүс мэдрэх ёстой. Өөрөөр хэлбэл, тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлснээр хувь хүн тус бүрт ямар өөрчлөлт бий болоход гол анхаарлаа хандуулах хэрэгтэй. Үйл ажиллагаа тус бүрийг дүгнэхийн зэрэгцээ уулзалтын үр дүнг бүхэлд нь үнэлж дүгнэнэ. Уулзалт тус бүрийн төгсгөлд хувь хүн бүрийн санал сэтгэгдэл, дүгнэлтийг сонсож, санаа бодлоо хуваалцах нь хөтөлбөрийг амжилттай хэрэгжихэд ихээхэн ач холбогдолтой юм. Уулзалт бүрийн төгсгөлд дараагийн уулзалт хүртэл хэрэгжүүлэх, турших, эзэмших чадвар, хандлагыг тусгасан даалгавар өгч, бататгах зүйлсийг тусгасан бөгөөд тэдгээрийг дараагийн уулзалтын эхэнд зайлшгүй ярилцаж, дүгнэх шаардлагатай.

### Эх сурвалжийн жагсаалт

1. Хууль зүй, дотоод хэргийн яам. “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журам”. УБ., 2017.
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. “Зан үйлээ засах сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүний зан үйлд нөлөөлөх сургалт явуулах журам”. УБ., 2017.
3. Л.Эрдэнэбаяр. “Монгол хүний архинд донтох зуршлыг арилгах загвар”. УБ., 2010.
4. Ч.Байгалмаа. М.Бямбабат. “Зан үйлийг өөрчлөх шатчилсан аргаар зөвлөгөө өгөх нь”. УБ., 2008.
5. Монгол өрх сэтгэл зүйн хүрээлэн. “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр”. УБ., 2018.
6. С.Мөнхтуяа ба бусад. “Архины шалтгаант зан үйлийг өөрчлөх нь” сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр.
7. Н.Оюут-Эрдэнэ ба бусад. “Уур бухимдлаа зохицуулах нь” сэтгэл зүйн үйлчилгээний хөтөлбөр.
8. Curt T. Griffiths, Ph.D, Yvon Dandurand, Danielle Murdoch. The social reintegration of offenders and crime prevention. Research report: 2007
9. Gwen Robinson, Lain D Grow. Offender rehabilitation. Theory and Practice.



## АРБИТРТ ОЛОН УЛСЫН АРИЛЖААНЫ МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭД ХЭРЭГЛЭГДЭХ ЭРХ ЗҮЙГ СОНГОХ ТАЛААР ОНОЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

### CHOICE OF LAW IN INTERNATIONAL COMMERCIAL ARBITRATION

#### С.ОЮУНЧИМЭГ

ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Эрх зүйн онолын тэнхимийн ахлах багш, ахмад

#### OYUNCHIMEG S.

Captian, Senior lecturer, Faculty of Law Theory, Law and Social Science Institute, LEU

✉ [oyunchimeg.s@leu.gov.mn](mailto:oyunchimeg.s@leu.gov.mn)

**Товч агуулга:** Олон улсын хувийн эрх зүй дэх эдийн засаг, бизнес, худалдаа арилжаа, хөрөнгө оруулалт, ажил гүйцэтгэх, хамтран ажиллах зэрэг эцсийн үр дүн нь эдийн засгийн үр ашиг авчрах аливаа гэрээ хэлцлээс үүссэн маргааныг гэрээний талууд харилцан тохиролцон тухайн харилцааг мэргэшсэн хөндлөнгийн өөрсдийн сонгосон этгээдээр шийдвэрлүүлэх шүүхийн бус арга буюу арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг олон улсын арилжааны арбитр гэж нэрлэнэ. Олон улсын арилжааны арбитрын үйл ажиллагааны онцлог нь олон улсын харилцааны нэгэн адил олон улсын төлөөлөгчид оролцдоггүй ч, маргааны талууд болон маргаж буй үйл баримт түүнээс үүсэх хууль зүйн үр дагавар нь нэг улсын шүүх засаглалаас хэтэрдэг явдал юм. Тиймээс арбитрын давуу тал нь талууд өөрсдөө маргааныг шийдвэрлэх арбитрчийг хэрхэн сонгох зохицуулалтыг арилжааны гэрээнд тусгаснаар маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэдэг. Гэрээнд аль болох маргааныг хэрхэн шийдвэрлэхийг тусгадаг хэдий ч Олон улсын арилжааны арбитрт талуудын холбогдох эрх зүйн хэм хэмжээний зөрчилдөөний улмаас маргаан автоматаар гарч ирдэг бөгөөд тухайн маргаанд хэрэглэх бодит хуулийн сонголтыг хийх хэрэгтэй болдог. Олон тохиолдолд, арбитр хэрэглэх гол хуулийг талууд анх тохиролцсоны дагуу тодорхойлж болох ч талууд маргаанаа зохицуулах хуулийн сонголтыг харилцан тохиролцоогүй нөхцөлд холбогдох хууль тогтоомжийг тодорхойлоход асуудлаар ярвигтай маргаан үүсдэг. Энэ тохиолдолд талууд маргааныг шийдвэрлэх эрх зүйг хэрхэн сонгох, хэрхэн тохиролцоонд хүрэх онолын асуудлыг олон улсын арбитрын маргаантай харьцуулах замаар тодорхойлох оролдлыг хийлээ.

**Abstract:** When the determination of disputes which is of a commercial nature involving an international element falls within the scope of private law, it gets termed as International Commercial Arbitration. International Commercial Arbitration is styled as international, not because sovereign nations participate, but because the parties, the facts, or the legal effects of the dispute extend beyond a single jurisdiction. Thus advantages of arbitration attract parties towards it and while entering into economic agreements, they often include arbitration clauses in their contracts to ensure that any dispute can be solved without recourse to litigation. However, in International Commercial Arbitration, when the parties are of different legal systems, there automatically arises a conflict of laws, and a choice of the substantive law to be applied in a given dispute has to be made. Many a time, the substantive law to be applied in arbitration may be specified by the parties in their original agreement. But problems arise in determining the applicable law in situations when the parties fail to agree upon a choice of law for the settlement of their dispute. An attempt is made here to examine this problem.

**Түлхүүр үгс:** Нийтийн дэг журам, арбитрын үйл ажиллагаа, олон улсын эрх зүй, эрх зүйн эх сурвалж, олон улсын эрх зүйн хэм хэмжээ, үндэсний буюу дотоодын иргэдийн нэгэн адил дэглэм, нэн тааламжтай буюу аливаа бусад олгодгоос дутуугүй тааламжтай дэглэм, арбитрын үйл ажиллагааг зохицуулах хууль, тухайн маргаанд хэрэглэгдэх хууль, талуудын тэгш байдал.

**Keywords:** Ordre public, arbitration, international law, Source of law, international law of provision, National Treatment, Most-favored nation, lex arbitri, substantive law, equal treatment of the parties.



### Нэг. Арбитрын хэлэлцээрт хэрэглэгдэх эрх зүйг сонгон хэрэглэсэн онолын асуудал

Олон улсын хувийн эрх зүйд “хувь хүн” гэдэгт харьяаллаас нь үл хамааран тухайн харилцаанд оролцож байгаа бүх хүнийг хамруулж үздэг. Гадаадын иргэдийн эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус гэх мэт хувийн харилцааг зохицуулахад хувь хүний эрх зүйн байдлыг тодорхойлох нь чухал ач холбогдолтой. Аливаа улс орны нийгмийн амьдралд гадаадын иргэдийн эзлэх байр суурийг тэдний эрх зүйн байдал хэмээх ухагдахуунаар илэрхийлдэг.<sup>1</sup> Эрх зүйн байдал гэдэгт чадвар, чадамжийн асуудал хөндөгдөнө. Олон улсын иргэний процессын эрх зүй буюу арбитра хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч гадаадын этгээдэд эрх зүйн дараах дэглэмийн аль нэгийг олгодог. Үүнд:

- Үндэсний буюу дотоодын иргэдийн нэгэн адил дэглэм (National Treatment)
- Нэн тааламжтай буюу аливаа бусад олгодог оос дутуугүй тааламжтай дэглэм (Most-favored nation)

Мөн ИХШХШТХ-ийн 189 дүгээр зүйлд үндэсний дэглэмийг тодруулан заасан байна: Монгол Улсын шүүхээр (арбитр) гадаад улсын иргэний хэргийг хянан шийдвэрлэхэд тэдгээр нь хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн адил эрхтэй байна.

Монгол Улсын иргэний процессын эрх зүйн чадвар, чадамжийг хуулиар тусгайлан тодорхойлоогүй юм. Иймээс иргэний эрх зүйн чадвар, чадамжтай аливаа этгээд нэгэн адил иргэний процессын эрх зүйн чадвар, чадамжтай байна.<sup>2</sup> Гадаадын этгээд, тухайлбал, гадаадын иргэн, харьяалалгүй этгээд, гадаадын хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар, чадамжийг тэдгээрийн хувийн хууль эсхүл Монгол Улсын хуулиар тодорхойлох тухай зохицуулалтыг Иргэний хуулийн 543 ба 544 дүгээр зүйлд тусгасан байна.

Арбитрын хэлэлцээр гэж гэрээний буюу гэрээний бус шинж чанартай байсан эсэхээс үл хамаарах эрх зүйн ямар нэг тодорхой харилцаатай холбоотойгоор тэдний хооронд үүсэн болон үүсэж болох бүх буюу тодорхой маргааныг арбитра шилжүүлэх тухай талуудын хэлэлцээрийг хэлнэ.<sup>3</sup> Ихэнх

улсад, түүний дотор арбитрын хэлэлцээрийн эрх зүйн нэгдсэн дэглэм тогтоосон байна. Тухайн хэлэлцээр нь холбогдох улсын хууль тогтоомжоор зөвшөөрсөн хэмжээнд улсын шүүхийн маргааны харьяаллыг хэрэглэхгүй байхад чиглэсэн талуудын хүсэл зоригийг илэрхийлдэг.<sup>4</sup>

Хэрэглэгдэх эрх зүйг сонгох асуудал<sup>5</sup>: Талууд үндсэн гэрээндээ уг гэрээнд хэрэглэх тухай заалтаас гадна арбитрын хэлэлцээрт хэрэглэх хуулийн талаар тусгана. Хэрэв үндсэн гэрээний талаар маргаан гарвал хэрэглэгдэх хуулийн дагуу шийдвэрлэх боломжтой, харин арбитрын заалтын талаар, тухайлбал уг заалт хүчин төгөлдөр эсэх талаар маргаан үүсвэл ямар хуулийг хэрэглэх вэ? Ийм асуулт арбитрын заалтаас (arbitration clause) гадна арбитрын бие даасан гэрээний (submission to arbitration) хувьд ч мөн хөндөгдөнө. Иймээс гэрээний төсөл бэлтгэхдээ арбитрын хэлэлцээрт холбогдох хуулийн сонголтыг тодорхой тусгах нь зохимжтой. Арбитрын заалт хэрэглэх хуулийн заалтын хамт, эсхүл түүний дараа үндсэн гэрээний төгсгөл хэсэгт голдуу орсон байдаг. Үндсэн гэрээний заалт болж буй арбитрын заалтын хувьд уг гэрээнд хэрэглэхээр сонгосон хуулийг нэгэн адил хэрэглэх нь зүй зохистой гэж үзэж болно. Үнэхээр талууд гэрээндээ хэрэглэх хуулиа илэрхий байдлаар сонгосон байхад тэр хуулиас өөр хуулийг арбитрын заалтын хувьд хэрэглэн гэж үзэх үндэслэл бага юм.

Арбитрын заалт бие даасан байх нь арбитрын заалт гэрээний бусад заалтын нэгэн адил ижил хуульд захирагдах үзэл бодлын талаар зарим эргэлзээ төрүүлэхэд хүргэж байна. Арбитрын заалт бие даасан шинжтэй бөгөөд гэрээнд тусгагдсан бусад заалтаас тусдаа байна. Энэхүү бие даасан байдал нь үндсэн гэрээнээс тусдаа өөр хуульд захирагдах боломжийг арбитрын заалтын хувьд нээлттэй болгоно. Ялангуяа талууд үндсэн гэрээндээ хэрэглэгдэх хуулийг илэрхий байдлаар сонгоогүй тохиолдолд арбитрын хэлэлцээр хэрэглэх хуулийг үндсэн гэрээнээс тусад нь тодорхойлох боломж илүүтэй харагдана. Энэ үед үндсэн гэрээнд хэрэглэх хууль, эсхүл арбитрын байрлах газрын хууль хоёрын аль нэгийг сонгох явдал бодит байдалд ихэвчлэн тохиолдож байна. Ийм дүгнэлтийг Нью-Йоркийн конвенцээр хүлээн зөвшөөрчээ.

<sup>1</sup> Э.Байгал. “Олон улсын хувийн эрх зүй, УБ., 2012. 114 дахь тал.

<sup>2</sup> Мэндсайхан.Т. “Олон улсын хувийн эрх зүй”. УБ., 2008. 193 дахь тал

<sup>3</sup> М.М.Богуславский. Олон улсын хувийн эрх зүй. (Орч. Ред: Амарсанаа.Ж, Мэндсайхан.Т...), УБ., 2008.

“Нээлттэй нийгэм форум” хэвлэл. 450 дахь тал.

<sup>4</sup> М.М.Богуславский. Олон улсын хувийн эрх зүй. (Орч. Ред: Амарсанаа.Ж, Мэндсайхан.Т...). УБ., 2008. “Нээлттэй нийгэм форум” хэвлэл. 450 дахь тал.

<sup>5</sup> Алтанцэцэг.Д нар. “Олон улсын арилжааны арбитра”, УБ., 2009. 239-243 дахь тал.



Арбитрын үйл ажиллагааны эрх зүйг сонгох асуудалд дараах асуудлыг анхаарах шаардлагатай: Арбитрын үйл ажиллагааг зохицуулах хууль (lex arbitri) буюу “Арбитрын хууль”-ийг тухайн маргаанд хэрэглэгдэх хууль (substantive law)-иас ялгаатай авч үзэх нь зүйтэй юм.<sup>6</sup> Энэ нь арбитрын үйл ажиллагаа талуудын харьяалагдах улсаас өөр улсад явагдах, арбитр нь талуудын харьяалагдах улсын арбитр биш байх зэрэг тохиолдлуудад илүүтэйгээр хөндөгдөнө. Харин аль нэг талын тогтолцооны арбитр буюу талуудын харьяалагдах улсын арбитраар маргаанаа шийдвэрлүүлж байгаа тохиолдолд арбитр байрлаж байгаа улсын дотоодын хууль тогтоомжийг буюу lex arbitri-ийг хэрэглэнэ. Үүнийг судлаачид дараах байдлаар хүлээн зөвшөөрсөн байна.

ОХУ-ын профессор М.М. Богуславский “Олон улсын хувийн эрх зүй” номдоо “Талуудын тогтолцооны арбитрт хандах, арбитрын бүрэлдэхүүнийг бүрдүүлэх, тухайн арбитраар маргааныг хянан хэлэлцүүлэх журмыг нутаг дэвсгэрт нь арбитр байрлаж байгаа улсын дотоодын хууль тогтоомж, олон улсын хэлэлцээр болон арбитрын өөрийнх нь Дэг журам, дүрмээр шийдвэрлэнэ”<sup>7</sup> гэжээ. Хууль зүйн ухааны доктор Т.Мэндсайхан “Олон улсын хувийн эрх зүй” номдоо “Арбитрын бүрэлдэхүүн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрсдийн санаачилгаар болон хэргийн оролцогчдын зүгээс тавьсан зарим хүсэлтийн дагуу зохих шийдвэр гаргаж, гадаад улсад нотлох баримт цуглуулах, шинжээч томилох, гадаадын байгууллагад даалгавар өгөх баримт бичиг гардуулах зэрэг үйлдэл хийлгэх арга хэмжээ авах шаардлагатай тулгарна. Дотооддоо ийм арга хэмжээ авах нь бэрхшээл багатай байдаг. Харин гадаад улсад ямар эрх зүйн хэм хэмжээг үндэслэн шийдвэр гаргаж хэрэгжүүлэх вэ? Ер нь арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд уг ажиллагаа явагдаж буй улсын хууль буюу lex arbitri мөрдөгдөнө.”<sup>8</sup> Энэтхэгийн Хууль зүйн ухааны доктор Ali Khaled Qtaishat “Олон улсын арилжааны арбитрт эрх зүйг сонгох асуудал” нийтлэлдээ “Процессын эрх зүйг сонгох асуудлыг

арбитрын хуулиар тодорхой хэмжээнд загвар акт буюу бусад процессын хуулиар шийдвэрлэх боломжтой...”<sup>9</sup> гэж үзсэн байна.

Арбитрын үйл ажиллагааны эрх зүйг сонгох нь арбитрын үйл ажиллагаа талуудын харьяалагдах улсаас өөр улсад явагдах, арбитр нь талуудын харьяалагдах улсын арбитр биш байх зэрэг тохиолдлуудад онолын ямар асуудал байдаг талаар дэлгэрэнгүй авч үзье. Энд дараах ойлголтууд хөндөгдөнө. Үүнд:

1. Lex arbitri буюу Арбитрын үйл ажиллагааны хуулийн зарчим
2. Арбитрын байрлах газрын зарчим
3. Арбитрын хуулийг сонгон хэрэглэх зарим бэрхшээлтэй асуудал

Lex arbitri буюу Арбитрын үйл ажиллагааны хуулийн зарчим

Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, арбитрын байгууллага болон арбитрын бүрэлдэхүүний уг ажиллагаанд холбогдох эрх хэмжээ, талуудын эрх чөлөөг аль улсын хуулийн дагуу тодорхойлох асуудал олон улсын арбитрын өмнө тавигдана. Ул бүрийн хууль агуулгын хувьд ижил биш нөхцөлд өмнө дурдсан олон асуултад хариулт өгөх хууль буюу “lex arbitri”-ийн ойлголт зайлшгүй хөндөгдөнө.

#### Тодруулбал:

✓ Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндэс нь маргааныг арбитраар шийдвэрлүүлэх боломжтой (arbitrable) байх явдал юм. Аливаа улс ямар маргааныг өөрийн шүүхийн эрх хэмжээнд авч үлдээхээ өөрсдөө шийдвэрлэнэ. Арбитрын гэрээнд хэрэглэгдэх хууль ба lex arbitri-ийн хуулийн дагуу тухайн маргааныг арбитраар шийдвэрлэх боломжтой боловч арбитрын шийдвэрийг гүйцэтгэх газрын хуулиар энэхүү боломжийг хаах тохиолдол бий. Энэ тохиолдолд Нью-Йоркийн конвенцээр гүйцэтгэх боломжгүй байна.

✓ Арбитрын үр өгөөжтэй ажиллагааг арбитрын шийдвэрийн биелэлтийг урьдчилан баталгаажуулах арга хэмжээ (intern measures)-гүйгээр төсөөлөх аргагүй. Энд үндэсний шүүхийн туслалцаа зайлшгүй чухал. Арбитрын байрлах газрын хуульд нийцүүлэн арбитрч ийм арга хэмжээ авах захирамж гаргаж болох боловч захирамжийг түүний биелэгдэх газрын шүүхийн туслалцаагүйгээр хэрэгжүүлэх боломжгүй юм.

<sup>9</sup>Ali Khaled Qtaishat, Dr. (2007). Web, Choice of Law in International Commercial Arbitration, India Law Journal , p.245-267

<sup>6</sup> Алтанцэцэг.Д нар. “Олон улсын арилжааны арбитр”, УБ., (2009), 202 дахь тал.

<sup>7</sup> Богуславский.М.М “Олон улсын хувийн эрх зүй”. (Орч. Ред: Амарсанаа.Ж, Мэндсайхан.Т ...), УБ.,(2008), “Нээлттэй нийгэм форум” хэвлэл. 456 дахь тал.

<sup>8</sup> Мэндсайхан.Т. Монголын үндэсний арбитрийн шийдвэрлэсэн маргаан: Олон улсын худалдааны эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх асуудал. Арбитр ба бизнесийн эрх зүй сэтгүүл. (2005 оны 2 дугаар улирал, №02 (07)), 41 дэх тал.



✓ Арбитрын ажиллагааг нэгтгэх (consolidate arbitrations), уг ажиллагаанд өөр этгээдийн оролцуулах эрхийг арбитрын бүрэлдэхүүн эсхүл шүүх эдлэх үү гэдэг асуудал lex arbitri-ийн хуулиар зохицуулагдсан байж болно. Зарим үед lex arbitri-ийн хуулиар талуудын хүсэн хүлээгээгүй үр дагавар бий болох тохиолдол бий.

Арбитрын байрлах газрын зарчим: Англи хэлээр "the country in which arbitration takes place" or "seat of the arbitration" or "forum or locus arbitrii" гэж нэрлэгдэх, харин монгол хэлээр "арбитрын оршин байгаа газар/улс" эсхүл "арбитрын үйл ажиллагаа явагдсан газар" гэж олон янзаар хэлж болох энэхүү ойлголт арбитрын гол ойлголтын нэг юм. Арбитрын байрлах газрын хуулиар арбитрын үйл ажиллагааг зохицуулна гэдэг үзэл баримтлал олон улсын арбитрын талаарх онол болон практикт бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн. Мөн үүнийг дотоодын болон гадаадын зарим судлаачид нэг ижил байр суурьтай байгаа тухай өмнө өгүүлсэн. Энэ нь 1923 оны Женевийн протоколоос эхлээд 1958 оны Нью-Йоркийн конвенц хүртэлх олон улсын конвенцүүдэд нэр томъёоны хувьд тусгалаа олжээ. Тухайлбал, Женевийн протоколын 2 дугаар зүйлд "арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журам, арбитрын бүрэлдэхүүнийг байгуулах асуудлыг талуудын хүсэл зориг болон арбитрын байрлах улсын хуулийн дагуу зохицуулна" гэж заасан байна. Мөн Нью-Йоркийн конвенцийн V.1'(d), (a), (e)-д "арбитрын байрлах улсын хууль ба арбитрын шийдвэр гаргасан улсын хууль нь арбитрын хууль байх"-аар ишлэл хийжээ. ЮНСИТРАЛ-ын загвар хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т мөн арбитрын байрлах газраар арбитрын хуулийг тодорхойлох тухай журмыг оруулжээ.

Арбитрын хуулийг сонгон хэрэглэх зарим бэрхшээлтэй асуудал<sup>10</sup>: Арбитр нь хэрэглэгдэх эрх зүйн талаар дүгнэлт гаргах шаардлагатай болох үед ажиллагаа явуулах аргыг сонгох эсхүл, бүтээх ёстой.<sup>11</sup> Уг асуудал нь дараах 3 асуудлын хүрээнд тулгарна.

Нэг. Гадаадын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийг сонгох

Нэг улсад явагдах арбитрын ажиллагаанд нөгөө улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг сонгон хэрэглэж болох уу гэдэг асуудал практикийн хувьд хэрэгжихэд их түвэгтэй, онолын хувьд

ихээхэн маргаантай юм. Жишээ нь, Швейцар улсад арбитрын ажиллагаа явагдаж буй хэргийн талууд Германы процессын хуулийг хэрэглэхээр тохиролцсон байж болно. Учир нь, Швейцарын Олон улсын хувийн эрх зүйн тухай хуулийн 182 дугаар зүйлээр талууд ийнхүү сонголт хийхийг зөвшөөрсөн байна. Ийм зохицуулалт Голланд, Итали болон Францын хуульд бий. Гэхдээ гадаадын иргэний хэрэг хянан шийдвэрлэх хууль сонгосон нь "нийтийн эрх ашиг"-ийг зөрчсөн гэх үндэслэлээр арбитрын шийдвэрийг хүчингүй болгох нэг үндэслэл болох магадлалтай. Хэрэв өөр улсын хуулийн журмыг сонгохоор бол энэ улсдаа арбитрын ажиллагааг явуулахаар талууд анхнаасаа тохиролцох нь зохимжтой байна.

Хоёр. Арбитрын шийдвэр гаргасан газар (place at which an award is made)

Арбитрын шийдвэр хаана гарсныг тогтоох явдал чухал ач холбогдолтой байдаг. Тухайлбал, "шийдвэр гарсан газрын хууль"-ийн дагуу арбитрын хэлэлцээр хүчингүй байна тухайн арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзах, эсхүл шийдвэр гарсан улсын шүүхээс тухай шийдвэрийг хүчингүйд тооцох, түр хойшлуулах асуудал цөөнгүй тохиолдоно. Зарим улсын арбитрын тухай хууль, дүрэмд шийдвэр гарсан газрыг онцгойлон дурдсан байдаг. Жишээ нь, арбитрын байрлах газарт, мөн шийдвэр дурдсан өдөрт арбитрын шийдвэр гарсан гэж үзэхээр Олон улсын Худалдааны төвийн арбитрын дүрэмд заасан байна. Ийм агуулга бүхий заалт загвар хууль ба Голландын 1986 оны, Английн 1996 оны хуульд тусгагджээ. Энд дурдсан хууль, журмын дагуу арбитрчид өөр өөр улсад байхдаа телефон, факс эсхүл имэйл-ээр харьцаж шийдвэрийнхээ эцсийн хувилбарыг тодорхойлж болохоор байна. Харин арбитрын шийдвэр хаана гарсныг тогтоох тухай тусгайлсан журам байхгүй үед асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь үйл баримтын асуулт уу эсхүл хууль зүйн презумц болох уу. Олон улсын худалдааны арбитрын ажиллагаанд гурван арбитрч бүхий бүрэлдэхүүн шийдвэрээ эцсийн байдлаар гаргах үедээ гурван өөр улсад гарын үсгээ зурах тохиолдол бий. Ийм тохиолдолд арбитрын байрлах газарт шийдвэр гарсан гэж үзэж болно. Гэхдээ үүний эсрэг арбитрчдын гарын үсэг зурсан газар арбитрын шийдвэр гарсан гэж үзэх үзэл бий.

Гурав. Газар нутгийн харьяалалгүй байх (Delocalisation theory)

<sup>10</sup> Ali Khaled Qtaishat, Dr. (2007). Web, Choice of Law in International Commercial Arbitration, India Law Journal , p.245-267

<sup>11</sup> Jack, J Ceo, Jr. (1997) International Commercial Arbitration American Principles and Practice in a Global Context. p.76.



Олон улсын худалдааны арбитрын хувьд дэлхийн аль улсад ажиллагаа явуулснаас үл хамааран өөрийн гэсэн тоглоомын талбайн дүрэм буюу universal lex arbitri-тай байж болох тухай үзэл баримтлал байдаг. Өөрөөр хэлбэл, арбитрын бүрэлдэхүүн арбитрын байрлах газрын хуулийг үл харгалзах эсхүл түүнд захирагдахгүй байх боломжийг хүлээн зөвшөөрөх тухай асуудал энд хөндөгдөнө. Мэдээж практикт universal lex arbitri-ийн асуудал хэтэрхий хийсвэр зүйл болно. Учир нь, улс бүр өөрийн онцлог, ашиг сонирхлыг харгалзан өөрийн нутаг дэвсгэрт явагдах арбитрын ажиллагааны талаарх эрх зүйн бодлогоо тодорхойлно. Олон улсын арбитрын талаарх зохицуулалт улс бүрт өөр өөр байна.

Гэрээнд хэрэглэгдэх эрх зүйг сонгоход дараах асуудалд анхаарах шаардлагатай: Процессын эрх зүйг сонгох асуудлыг тодорхой хэмжээнд загвар акт буюу бусад процессын хуулиар шийдвэрлэх боломжтой ч материаллаг эрх зүйн тухайд нарийн түвэгтэй байдал үүсдэг.<sup>12</sup> Хэрэг хянан шийдвэрлэх журмын буюу хэрэг шийдвэрлэх ажиллагааны асуудал тодорхойлогдсоны дараа арбитрын бүрэлдэхүүн хэргийн бодит үйл баримтыг тогтоох ажиллагаа явуулна. Ийнхүү үйл баримтыг тогтоосны үндсэн дээр шийдвэр гаргах бөгөөд үйл баримтад харгалзан ногдуулах хууль зүйн үр дагаврыг талуудын тохиролцсон хуулийн, эсхүл шударга ёсны дагуу тодорхойлно. Гэхдээ арбитрын бүрэлдэхүүн ихэнх тохиолдолд талуудын хоорондын байгуулсан гэрээний хүрэнээс хальж эрх зүйн хэм хэмжээг хайх шаардлагагүй. Юуны өмнө талуудын байгуулсан гэрээний нөхцөлийг баримтлан тэдгээрийн хоорондын маргааныг шийдвэрлэх ёстой. Учир нь, олон улсын бизнесийн гэрээний талууд ихэвчлэн гэрээний нөхцөлөө нэг бүрчлэн тохиролцох замаар өөрсдийн эрх үүрэг, хариуцлага, үүрэг биелэгдээгүйн үр дагаврыг нарийвчлан тодорхойлж гэрээндээ тусгасан байдаг. Иймээс зөвхөн талуудын гэрээг мэдэж, түүнийг баримтлах нь хангалтгүй бөгөөд уг гэрээнд хэрэглэгдэх хуулийг зайлшгүй мэдэх шаардлагатай юм. Олон улсын бизнесийн гэрээний хувьд хэрэглэгдэх хуулийг сонгон тодорхойлоход нэлээд түвэгтэй.

Энэтхэгийн олон улсын эрх зүйч, доктор Али Халед Кушат "Олон улсын арилжааны арбитрарт эрх зүйг сонгох асуудал" өгүүлэлдээ

<sup>12</sup> Ali Khaled Qtaishat, Dr. (2007). Web, Choice of Law in International Commercial Arbitration, , India Law Journal , p.245-267

хэрэглэгдэх эрх зүйг сонгон тодорхойлох асуудлыг дараах 3 арга замаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Талуудаас сонголт илэрхийлэх замаар,
2. Нөхцөл байдлаас дүгнэсэн сонголтоор,
3. Хэлцэл хамгийн нягт болон хамгийн бодитой холбоо бүхий эрх зүйн тогтолцоог тодорхойлох аргаар.<sup>13</sup>

Дээр дурдсанчлан гурван аргаар дэлгэрүүлэн авч үзье.

1. Талуудаас сонголт илэрхийлэх замаар гэрээний талууд хууль, шударга ёсонд нийцүүлэн нийтийн дэг журам зөрчихгүйгээр маргаанд хэрэглэх хуулийг сонгох ёстой. Ингэхдээ олон улсын бизнесийн гэрээний талууд энэхүү эрх чөлөөгөө бүрэн, зохих ёсоор эдэлж, гэрээндээ "хууль сонгох" тухай заалтыг оруулна. Хэрэв ийм заалтыг гэрээндээ тусгаагүй бол ийм сонголт хийхээс татгалзсан гэж үзэх бөгөөд маргаан гарсан үед хэрэглэгдвэл зохих хуулийг тодорхойлох багагүй бэрхшээлтэй ажиллагаа шаардана. Олон улсын бизнесийн ихэнх гэрээнд "хууль сонгох" заалтыг оруулсан байдаг. Зарим арбитрын байгууллагууд арбитрын загвар заалтыг санал болгохдоо "хууль сонгох" заалт оруулахыг мөн тэмдэглэсэн байна. Хууль сонгох тухай заалтыг энгийн нөхцөлөөр хийж болно. Тухайлбал, "энэхүү гэрээ нь аливаа асуудлын хувьд "Х" улсын хуульд захирагдана" гэсэн заалт байхад хангалттай. Хууль сонгох тухай заалтын талаар авч үзэхэд "гэрээний талуудын чөлөөт байдал", "сонголт хийх цаг хугацаа"-ны талаар судлан үзэх нь зүйтэй.

Гэрээний талуудын чөлөөт байдал

Дэлхийн ихэнх эрх зүйн тогтолцоонд олон улсын бизнесийн гэрээний талууд уг гэрээнд хэрэглэгдэх хуулийг чөлөөтэй сонгож болохыг үндсэндээ хүлээн зөвшөөрсөн байна.<sup>14</sup> Тухайлбал, ЮНСТРАЛ-ын загвар хууль болон арбитрын журамд гэрээний талууд гэрээнд хэрэглэгдэх "хуулийн журам" (rules of law)-ийг чөлөөтэй сонгохыг зөвшөөрсөн байна. Энэхүү хуулийн журамд "lex mercatoria" буюу худалдааны заншлын хэм хэмжээг багтаан ойлгоно. Харин талууд хуулийн журмыг сонгоогүй тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн нь зөвхөн аль нэг улсын хуулийг сонгож хэрэглэх ёстой. Монгол Улсын иргэний хуулийн 549 дүгээр зүйлд гэрээний талууд хэрэглэгдэх хуулийг чөлөөтэй сонгохыг зөвшөөрсөн байна.

<sup>13</sup> Мөн тэнд.

<sup>14</sup> Д.Алтанцэцэг нар. "Олон улсын арилжааны арбитрарт", УБ., 2009. 217 дахь тал.



Сонголт хийх цаг хугацаа

Гэрээнд хэрэглэгдэх хуулийг сонгох талуудын чөлөөт байдал нь анхандаа гэрээ байгуулж буй цаг хугацааны үед хамаарч байлаа. Гэвч талуудын энэ эрх өргөжиж гэрээ байгуулагдсаны дараа маргаан гарсан үед ч мөн хэрэгжих болов. Мэдээж гэрээ байгуулах үедээ хуулиа сонгох нь талуудад илүү үндэслэлтэй юм. Гэрээ байгуулахдаа талууд харилцан эдлэх эрх, хүлээх үүргээ тодорхойлох бөгөөд энэ үедээ тэдгээрийн хоорондын тохиролцооны гол зүйлийг тодорхойлох хуулийг сонгох нь тохиромжтой байдаг. Харин маргаан гарсны дараа хэрэглэгдэх хуулиа сонгохыг талуудад зөвшөөрөх нь зөрчил үүсгэх боломжтой. Талууд өмнө нь сонгосон хуулиас өөр хуулийг дараа сонгож болно. Хуулийг дараа сонгож болохоор Ромын конвенцээр зөвшөөрсөн байдаг. Монгол Улсын иргэний хуулийн 549 дүгээр зүйлд хэрэглэгдэх хуулийг хожим сонгож болох заалт бий.

2. Нөхцөл байдлаас дүгнэсэн сонголтоор талууд тохирох эрх зүйг сонгоогүй тохиолдолд хэрэглэгдэх эрх зүйг тогтоох түвэгтэй байдал үүсдэг. Улмаар шүүх, арбитр талуудын нөхцөл байдлаас үүдэн гарсан буюу нөхцөл байдлаас эрх зүйн сонголт байсныг тогтоож чадах эсэхийг харгалзан үзнэ.<sup>15</sup> Тохирох эрх зүйг тогтоохын тулд талуудын санаа зорилгыг дүгнэж, шүүх, арбитр илүүд үздэг (чухалчилдаг) бусад хүчин зүйлүүд буюу гэрээг боловсруулах хууль зүйн нэр томьёо, хэлцлийн хэлбэр, төлбөр хийгдэх валют, хэрэглэгдэх хэл, жишиг болсон хэлцэлтэй холбоотой байдал, гэрээний зүйлийн шинж чанар болон байрлал (оршин байгаа газар), талуудын оршин суугаа газар, талуудын аль нэг нь төр байх тохиолдол орно.<sup>16</sup> Түүнчлэн уг ойлголт нь “Чимээгүй буюу төсөөлөгдөж буй сонголт”, “Арбитрыг сонгосон нь хуулийг сонгосонтой адил эсэх” гэсэн асуудлыг хамарна.

3. Хэлцэл хамгийн нягт болон хамгийн бодитой холбоо бүхий эрх зүйн тогтолцоог тодорхойлох асуудалд талууд хууль сонгосон тодорхой хүсэл зориг мэдэгдэхгүй тохиолдолд ийм хууль сонгож магадгүй байсан гэдгээр дүгнэлт хийхийг шүүх арбитрт зөвшөөрөөгүй байна. Ийм тохиолдолд шүүх, арбитр нь тухайн гэрээний харилцаатай хамгийн нягт холбоотой байгаа улсын хуулийг сонгодог зөрчилдөөний эрх зүйн үндсэн зарчмыг хэрэглэнэ.

<sup>15</sup> Ali Khaled Qtaishat, Dr. (2007). Web, Choice of Law in International Commercial Arbitration, India Law Journal , p.245-267

<sup>16</sup> Мөн тэнд.

Энэхүү орчин үеийн аргууд нь хэрэг тохиолдлын нягт холбоонд тулгуурладаг. Мөн түүнчлэн зөвхөн нэг шийдлээр хариуг нь олно гэж байхгүй. Хэрэглэгдэх хуулийг тодорхойлохын тулд 2 хүчин зүйлийг хамтад нь авч үзэх хэрэгтэй байдаг. үүнд эхнийх нь гэрээтэй холбогдох холболтууд байдаг бол хоёр дах нь ерөнхийд нь авч үзэх бодлогын асуудал байдаг.<sup>17</sup>

Гэрээний нягт холбоог тодорхойлох холболтууд нь:

- Гэрээг байгуулсан газар
- Хэлэлцээр хийсэн газар
- Гэрээний гүйцэтгэлийн газар
- Гэрээний зүйлийн байршиж буй газар
- Оршин байгаа газар, харьяалах улс, хуулийн этгээдийн харьяалах улс, талуудын үйл ажиллагаа явуулдаг газар.

Дээрх хүчин зүйлүүдийг харьцуулахдаа дараахыг мөн харгалзан үзэх хэрэгтэй:

- Улс хоорондын болон олон улсын тогтолцооны хэрэгцээ, шаардлага,
- Шүүхийн баримтлах бодлого,
- Бусад сонирхогч улсуудын баримтлах бодлого, болон тухайн хэрэг холбогдлыг тодорхойлох талаарх тухайн улсуудын ашиг сонирхол

Дээрхээс үзвэл гэрээт харилцаанд “илүү чухал үүрэг” (англи хэлээр characteristic performance) гүйцэтгэж буй талын оршин байгаа эсхүл үйл ажиллагаагаа явуулж буй улсын хууль тогтоомжийг авч үзэх хэрэгтэй. Гэхдээ энэ нь “илүү чухал үүрэг”-ийг тодорхойлох боломжгүй, эсхүл гэрээнд оролцогч өөр улстай илүү нягт холбоотой нь нотлогдвол зохимжгүй болно. Харин арбитрын бүрэлдэхүүн lex arbitri-г хэрэглэх талаар авч үзвэл-Аль нэг улсад байгаа шүүгч, арбитрч нь гэрээ байгуулсан газрын хуулийг эсхүл тухайн гэрээ илүү нягт холбоотой байгаа газрын хуулийг сонгон хэрэглэх боломжтой харагдаж байна. Энэ нь хэрэглэх хуулийг сонгох арга журам улс бүрт өөр өөр байдгаас шалтгаална. Тэгэхээр аль улсад байрлаж үйл ажиллагаа явуулж байгаагаас шалтгаалж арбитрын бүрэлдэхүүн зөрчилдөөний эрх зүйн өөр өөр журам мөрдөх үү гэсэн асуулт гарна.

Олон улсын худалдааны арбитрын практик болон арбитрын байгууллагуудын ажилд арбитрын бүрэлдэхүүн арбитрын үйл ажиллагааны газрын хууль сонгох журмыг заавал мөрдөх үүрэггүй гэдэг үзэл баримтлалыг баримтлах болжээ.<sup>18</sup> Товчоор

<sup>17</sup> Ibidem. P.72.

<sup>18</sup> Д.Алтанцэцэг нар. “Олон улсын арилжааны арбитр”,



хэлбэл, олон улсын арбитрын бүрэлдэхүүн хэрэглэх хуулийг сонгохдоо lex arbitri-г хэрэглэхгүй ба хэрэглэх хуулийг өөрсдөө шууд сонгох (direct choice or voie directe) эрхтэй. Харин үндэсний шүүхийн хувьд өөрийн улсын хууль сонгох журмыг заавал мөрдөх үүрэг хүлээнэ.

### Хоёр. Арбитрын хэлэлцээрт хэрэглэгдэх эрх зүйг сонгон хэрэглэсэн практик

Арбитрын хэлэлцээр, заалт хүчинтэй эсэх, түүнд хэрэглэгдэх эрх зүйг сонгон тодорхойлох талаар Олон улсын практикаас үзвэл:

1. Олон Улсын Худалдааны Танхимын 6162 дугаар (ICC Case №.6162) хэрэгт холбогдох үндсэн гэрээнд Олон Улсын Худалдааны танхимын арбитрын дүрмийн дагуу Женевийн арбитраар шийдвэрлүүлэх арбитрын заалт мөн “Египетийн хуулийг хэрэглэх” тухай хууль сонгосон заалт тус тус байв. Хариуцагчийн зүгээс Египетийн Иргэний болон худалдааны процессын хуулийн 502.3-д заасны дагуу арбитрын заалт хүчингүй гэсэн тайлбар гаргажээ. Энэ нь үндэслэлтэй сонсогдож байсан ба арбитрын ажиллагааг дуусгавар болгоход чиглэж байв. Гэвч арбитрын бүрэлдэхүүн арбитрын хэлэлцээрийн хэлбэр, хүчинтэй байдлын хувьд талуудын үндсэн гэрээнд хэрэглэхээр сонгосон хуулийг бус арбитрын байрлах газрын хууль буюу Швейцарын хуулийг хэрэглэх нь зүйтэй гэж үзэж шийдвэрлэжээ.<sup>19</sup>

2. Болгарын гадаад худалдааны банк (Bulbank) Австрийн банктэй гэрээ байгуулсан ба гэрээнд Австрийн хуулийг сонгосныг илэрхийлсэн арбитрын заалт орсон байна. Талуудын хооронд маргаан гарч арбитрын ажиллагаа Стоколмд эхэлжээ. Гэвч Bulbank-ны нэхэмжлэлийн дагуу арбитрын заалт хүчингүй гэдэг үндэслэлээр Шведийн дунд шатны шүүх арбитрын шийдвэрийг өөрчилсөн байна. Дараа нь Шведийн дээд шүүх арбитрын байрлах газрын хууль буюу Шведийн хуулийн дагуу арбитрын заалт хүчинтэй гэж дүгнэжээ.<sup>20</sup>

3. XL Insurance Ltd v Owens Corning хэргийн хувьд Нью-Йоркийн хууль хэрэглэх, 1996 оны Арбитрын тухай хуулийн дагуу

УБ., 2009. 237 дахь тал.

<sup>19</sup> Gary B.(2009) NY., International Commercial Arbitration. Volume 1. Published by: Kluwer law international. Pa.871.

<sup>20</sup> Trevor,C and Alejandro I,G. (2009)., N, Web. International Intellectual Property Arbitration. by: Kluwer law international. Pa.246.

Лондоны арбитрад хандах заалтууд бүхий даатгалын гэрээний асуудал хөндөгдсөн ба уг хэрэгт арбитрын харьяаллын асуудалд Английн хуулийг хэрэглэсэн байна. Өөрөөр хэлбэл, арбитрын заалт хэлбэрийн хувьд хүчинтэй эсэх арбитрын бүрэлдэхүүний хэрэг харьяалах эрх хэмжээний асуудлыг 1996 оны Арбитрын хуулийн дагуу шийдвэрлэнэ гэж Лондонгийн арбитрын шүүх дүгнэжээ.<sup>21</sup>

4. Matermaco v PPM Cranes-ийн хэргийг арбитраар харьяалан шийдвэрлэх боломжтой эсэх асуудалд арбитрын байрлах газар буюу Бельгийн хуулийг хэрэглэжээ. Хэдийгээр талууд гэрээндээ Висконсин мужийн хуулийг хэрэглэхээр тохиролцсон боловч Брюсселийн худалдааны шүүх Нью-Йоркийн конвенцийн 2.1, 5.2.a заалтыг үндэслэн ийм шийдвэр гаргажээ.<sup>22</sup>

Дээрх дөрвөн хэргийн эхний гурвын хувьд арбитрын хэлэлцээр хүчинтэй байгааг шүүх арбитраас тогтоосон байна. Бүх дөрвөн хэргийн хувьд хэрэв талууд илэрхий байдлаар арбитрын хэлэлцээрт хэрэглэх хуулиа тохиролцоогүй бол арбитрын байрлах газрын хуулийг арбитрын хэлэлцээрт илүү нягт холбоотой гэж үзжээ. Арбитрын хэлэлцээр ямар хуулийн дагуу хүчинтэй байх талаар Нью-Йоркийн конвенцийн 5.1.(a) заалтад тодорхойлжээ. Тодруулбал, “талуудын тохиролцож сонгосон хуулийн дагуу, хэрэв тийм сонголт хийгдээгүй бол арбитрын шийдвэр гарсан газрын хуулийн дагуу” арбитрын хэлэлцээрийн хүчинтэй эсэхийг тогтооно. Харин арбитрын шийдвэр гарсан газар нь ихэвчлэн арбитрын байрлах газартай давхцана. Ийм учраас Нью-Йоркийн конвенцийн дагуу талууд арбитрын хэлэлцээрт хэрэглэх хуулийг сонгоогүй бол уг хэлэлцээрт арбитрын байрлах газрын хуулийг хэрэглэнэ.

Арбитрын үйл ажиллагаанд хэрэглэгдэх эрх зүйг сонгон хэрэглэсэн практикаас түүвэрлэн харвал, МҮА-ын практикт 2009 онд арбитрын хэлэлцээрийн талаар нэг сонирхолтой тохиолдол бий болсон бөгөөд <sup>23</sup> Монгол Улсын хуулийн этгээд МҮА нэхэмжлэл гаргаж Бүгд Найрамдах Хятад Ард Улсын компанийг хариуцагчаар татсан

<sup>21</sup> Jean,E.P and Sebastien.B (2007)., Switzerland, Web. Comparative Law of International Arbitration. Published in 2007 by: Sweet and Maxwell Ltd. Schulthess Juristische Medien AG, Zurich, Pa.261.

<sup>22</sup> Alan,R and Martin,H. (2004), London, UK., Web. Law and Practice of International Commercial Arbitration. Published in 2004 by: Sweet and Maxwell Ltd. Pa.127.

<sup>23</sup> МҮХАУТ-ын дэргэдэх МҮА-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ч.Гүнждагватай хийсэн ярилцлагаас. 2012 оны 4 дүгээр сар 27-ны өдөр.



Хууль сахиулахуй

байна. Тухайн арбитрын хэлэлцээрт дараах заалтыг тусгажээ: “Уг гэрээнээс үүссэн аливаа маргааныг Монгол Улсад Улаанбаатар хотод шийдвэрлэнэ. Шийдвэрлэхдээ Олон улсын худалдааны танхимын(ICC) дэргэдэх Лондонгийн Арбитрын журмын дагуу явуулна” гэжээ.

- Нэхэмжлэгч Монгол Улсын талаас уг арбитрын заалтыг тайлбарлахдаа “Лондонгийн арбитрын журмын дагуу МҮА шийдвэрлэнэ” гэжээ.

- Хариуцагч БНХАУ-ын талаас уг заалтыг тайлбарлахдаа “Монгол Улс, Улаанбаатар хотод Олон улсын худалдааны танхимын(ICC) дэргэдэх Лондонгийн Арбитрын бүрэлдэхүүн өөрийн журмын дагуу шийдвэрлэнэ” гэжээ.

- Харин МҮА-ын байр суурь нь “Улаанбаатар хотод Лондонгийн Арбитрын журмын дагуу МҮА шийдвэрлэнэ” гэсэн тайлбар өгчээ.

Талууд арбитрын үйл ажиллагааны эрх зүйг сонгоогүй бол Арбитрын үйл ажиллагаанд хэрэглэгдэх эрх зүйг сонгохдоо Арбитрын байрлах газрын хууль буюу Lex arbitri-ийг тодорхойлно гэсэн зарчим бий. Дээрх МҮА-ын тайлбар нь үндэслэлтэй гэж үзэх ба талууд арбитрын үйл ажиллагааны эрх зүйг сонгон тодорхойлсон буюу Лондонгийн арбитрын журмыг сонгосон байсан тул Арбитрын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэсэн нь үндэслэлтэй байна.

Арбитрын үйл ажиллагаанд хэрэглэгдэх эрх зүйг сонгохдоо арбитрын байрлах газар буюу арбитрын шийдвэр гарсан газрын хуулийн дагуу Олон улсын практикт тодорхойлдог талаар өмнө өгүүлсэн. Арбитр үйл ажиллагааг зохицуулах эрх зүйг сонгохдоо тухай арбитртай бодит холбоо (real connection) бүхий арбитрт холбогдох газрын хуулийг сонгох хэрэгтэй.<sup>24</sup> Тухайлбал, Олон улсын худалдааны танхимын дэргэдэх Арбитрын шийдвэрлэсэн 10623 дугаар шийдвэр байна.<sup>25</sup>

### Эх сурвалжийн жагсаалт

1. Д.Алтанцэцэг нар. “Олон улсын арилжааны арбитр”. УБ., 2009.

2. Э.Байгал. “Олон улсын хувийн эрх зүй”. УБ., 2012.

3. Т.Мэндсайхан. “Олон улсын хувийн эрх зүй”. УБ., 2008.

4. М.М.Богуславский. “Олон улсын хувийн эрх зүй”. (Орч. Ред: Ж.Амарсанаа, Т.Мэндсайхан). УБ., 2008.

5. Т.Мэндсайхан. “Монголын үндэсний арбитрын шийдвэрлэсэн маргаан: Олон улсын худалдааны эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх асуудал”. //Арбитр ба бизнесийн эрх зүй сэтгүүл. 2005 оны 2 дугаар улирал, №02 (07).

6. МҮХАҮТ-ын дэргэдэх МҮА-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ч.Гүнжагватай хийсэн ярилцлагаас. 2012 оны 4 дүгээр сар 27-ны өдөр.

Ali Khaled Qtaishat,Dr. (2007). Web, Choice of Law in International Commercial Arbitration, India Law Journal, p.245-267

7. Gary B.(2009) NY., International Commercial Arbitration. Volume 1. Published by: Kluwer law international. Pa.871.

8. Ibidem. P.72.

9. Trevor,C and Alejandro I,G. (2009)., N, Web. International Intellectual Property Arbitration. by: Kluwer law international. Pa.246.

10. Jean,E.P and Sebastien.B (2007)., Switzerland, Web. Comparative Law of International Arbitration. Published in 2007 by: Sweet and Maxwell Ltd. Schulthess Juristische Medien AG, Zurich, Pa.261.

11. Alan,R and Martin,H. (2004), London, UK., Web. Law and Practice of International Commercial Arbitration. Published in 2004 by: Sweet and Maxwell Ltd. Pa.127.

12. Aniekan,I (2008), Web. Determining the lex arbitri in international commercial arbitration for purposes of the validity of an arbitral award, P.1-7

13. See ICC Case No. 10623, as cited in Redfern and Hunter, (supra) p.102, footnote 45.

<sup>24</sup> Aniekan,I (2008), Web. Determining the lex arbitri in international commercial arbitration for purposes of the validity of an arbitral award, P.1-7

<sup>25</sup> See ICC Case No. 10623, as cited in Redfern and Hunter, (supra) p.102, footnote 45.

## УЛС ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН АСУУДАЛ

## ETHICAL ISSUES OF POLITICAL PUBLIC SERVANT

**М.ДОЛГОРСҮРЭН**

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрдэм шинжилгээний дэд ажилтан, хууль зүйн магистр

**DOLGORSUREN M. (LL.M)**

Researcher at the Department of Legal and Political studies, Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences

✉ [angelnice999888@gmail.com](mailto:angelnice999888@gmail.com)

**Товч агуулга:** Энэхүү өгүүлээр ёс зүйн онол, төрийн удирдлагын ёс зүй, улс төрийн албан хаагчийн ёс зүйн судалгаа, төрийн албан хаагчийн ёс зүйн олон улсын хэм хэмжээний зохицуулалтыг судалж, улс төрийн албан хаагчийн ёс зүйг үнэлэх үнэлэмж, шалгуурыг нарийвчлах, хэм хэмжээг зохицуулсан эрх зүйн орчин, төрийн албан хаагчдад хүлээлгэх хариуцлагын болон төрийн тогтвортой байдлыг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох талаар санал дэвшүүлэхийг зорьсон.

**Abstract:** This article discussed ethical theory, moral issues of state administration, ethical research of political public servant, international ethical norms of civil servant, to accurately assess the evaluating ethical issues of political public servant, the legal environment governing the rule of law, and the proposing to improve the system of accountability and state stability of civil servant.

**Түлхүүр үгс:** Ёс суртахуун, төрийн удирдлага, эрх зүйн зохицуулалт.

**Keywords:** moral, state administration, legal regulation.

**I. Удиртгал**

Ёс зүй бол тухайн орны ард түмний зан заншил, харилцаанд бичигдээгүй хуулийн шинэтгэлд тогтсон хариуцлагын хэм хэмжээ юм. Өөрөөр хэлбэл тодорхой ажил үйлс эрхэлж байгаа хүний зүгээс нийгэмтэйгээ харилцах, хариуцлага хүлээх, олны дунд биеэ авч явах, хүнтэй харилцах соёл, сайн сайхан зан үйлийн уламжлалт хэм хэмжээний нэгдмэл системийг ёс зүй гэж ойлгож болно.

Хүмүүсийн дундаас тун цөөхөн хүн л “Зөв хүний үйлдэл нүднээс далд ч зөв байдаг” гэдэг тодорхойлолтод нийцсэн өндөр ёс суртахууныг эзэмшсэн байдаг<sup>1</sup>. Бидэнд уламжлалдаа тулгуурласан хүчирхэг ёс суртахуун гаргаж ирэх хэрэгцээ шаардлага байна.

Хууль зүйн норматив хандлагаар авч үзвэл ёс зүй нь тодорхой мэргэжлийн, албан тушаалын онцлогоос урган гарах хэм хэмжээний тогтолцоо юм.

Эртний Грекийн сэтгэгч Аристотель “Ёс зүй бол төр улсын бүрэлдэхүүн хэсэг юм. Олон нийтийн болон төр улсын амьдралд

оролцох этгээд сайн үйлийн суртахуунтай хүн байвал зохино”. АНУ-ын эрдэмтэн Ноам Чомский “Ёс суртахуун төрд биш, харин хүнд л байдаг” хэмээн үзжээ.

Хаана ёс суртахуун өндөр байна, тэр улс оронд ард түмэн нь аз жаргалтай амьдардаг. Бүшидо<sup>2</sup> ёсонд суурилсан японы ард түмний ёс суртахуун буюу шударга ёс, туйлын ажилсаг, хөдөлмөрч чанар, хатуужил тэвчээр, нинжин, өрөвч сэтгэл, эелдэг чанар, нэр төрөө эрхэмлэх, сэтгэлийн хөөрлөө нууж, ил гаргадаггүй чанар.. энэ бүхэн нь Япон улсыг дэлхийн шинжлэх ухаан, технологийн тэргүүлэгч гүрэн болгон хувиргажээ<sup>3</sup>.

Аристотелийн хэлсэнчлэн “аливаа хүнийг шударга үйлийг бүтээсэн үе нь л шударга байна” байдаг ажээ.

Эртний хятадын их сэтгэгч Лаоз “Дээд сайн үйл ус лугаа адил. Ус бүх юмсад бялхсан ашиг тусаа өгдөг боловч юуг ч сөрж эсэргүүцдэггүй”. “Ард түмний дотор маргаан шуугиан гаргахгүйн тулд мэргэдийг

<sup>1</sup> Ж.Бор, Д.Баатар. Монголын ёс суртахуун. УБ., 2017. 20 дахь тал.

<sup>2</sup> Нитоёз Иназо Бушидо япон үндэстний ёс зүйн цогц... “Ниппон ньос” сонин газар. УБ., 2007.

<sup>3</sup> С.Нарангэрэл. Чингис хааны сүр хүч. УБ., 2013. 239 дэх тал.

хүндэтгэх хэрэгтэй”<sup>4</sup>.

“И.Кант “Бид уу хийх ёстой вэ?” гэсэн ёс суртахууны асуултыг бид өөрсдөөсөө асуудаггүй нь хүмүүсийн үйлдлийг залж чиглүүлэх ёс суртахууны хэм хэмжээ алдагдсантай холбоотой байж болох юм<sup>5</sup>. Түүнчлэн “Та өөртөө хүсээгүйг бусдад бүү хий. Өөртөө хүсч байгааг бусдад хүс” гэсэн ёс суртахууны алтан зарчим алдагдсанаас ёс суртахуун доройтож байна.

“Өө сэвгүй удирдагч хүн буянт үйлстэй байх ёстой. Ингэснээр түүний ёс суртахууны дээд чанар нь ард олныг захирах эрхийг олгох ёстой”. “Сайн санаат удирдагч алтан гадас од мэт олон оддын дунд гялалзаж байдаг. Ийм байхын тулд ёс журмыг бүү зөрч. Ёс бүү алд. Хаан нь хаан шиг, түшмэл нь түшмэл шиг, эцэг нь эцэг шиг, хүү нь хүү шиг байх ёстой”<sup>6</sup> гэж нийгэмд хүлээсэн үүрэг хариуцлагаа хүн бүр, дээдэс доодосгүй сахин биелүүлэх нь нийгэмд шударга ёс, хэв журам тогтоохын үндэс сургаж байжээ.

Шилдэг удирдагч бол улс төрийн төлөө байх, түүнийхээ төлөө ёс суртахуунлаг байх явдлыг улс, төрийн хишгээр амьдарч, аялдан дагалдаж буй хэсэгтэйгээ зүй зохистой хослуулж чадсан хүмүүс юм. Ёс суртахуунтай байх гэдэг нь тодорхой албанд түүнд тохирсон хүн байх гэсэн үндсэн шалгуурыг ямагт тавьж байдаг.

Ёс суртахуунлаг, сайн засаглалтай байхын тулд иргэд нь засгийн газраа хянаж чаддаг байх ёстой бөгөөд тэд улс төрийн үйл явцад оролцох ижил боломжтой, засгийн газрын үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй байх тэд өөрсдийн үйлдлийг хариуцах чадвартай байх ёстой. Ингэснээр улс төрийн амьдралд тэгш оролцоо, ил тод байдал буюу хариуцлагатай байх, түүнийг дэмжих институцийг хөгжүүлэх боломжтой.

## II. Төрийн удирдлагын ёс зүй

Удирдлагын ёс зүй бол “Улс төрчид төрийн албан тушаалтнуудын үйлдэл, үйл ажиллагаа, шийдвэр гаргалтад ёс зүйн хэмжүүрийн хамаарах байдал”<sup>7</sup> гэсэн байна.

Г.Алмонд, Д.Пауэл, К.Стром, Р.Дальтон нарын эрдэмтэд аль ч нийгмийн үед төрийн удирдлага 3 үндсэн шалгуурт тохирсон байх ёстой. Энэ нь:

1. Шударга ёсыг төр засаг түүнийг хангаж

<sup>4</sup> Б.Даш-Ёндон. Лаозын гүн ухаан /эх сурвалж, тайлбар/. УБ., 2014. 19 дэх тал.

<sup>5</sup> М.Золзаяа. Монголын бизнесийн ёс зүйн төлөвшил, хандлага. УБ., 2016. 45 дахь тал.

<sup>6</sup> Большой энциклопедический словарь. Мифология. Ред. Е.М.Мелятинский. М. 1998. с99-100.

<sup>7</sup> Alian Noghiu and Tibor Toth. Public officials ethics- an international survey.

чаддаг байх ёстой.

2. Төрийн бодлого нь үр дүнтэй, үр ашигтай байх ёстой.

3. Хүний эрх чөлөөг хадгалж хамгаалж чаддаг байх ёстой гэжээ<sup>8</sup>. Эндээс харахад улс төр нь өөрөө ёс зүйтэй байх гэдэг асуудал төрийн оршин тогтнохтой холбоотой байсан болох нь харагдаж байна.

“Дарга болох чадвар хэн бүхэнд байдаггүй. Хэрэв хэн нэгэн хүн эрх мэдэл олгосонгүй гэх юм уу, эсхүл удирдан жолоодох боломж өгсөнгүй гэж унтууцан догшоорд байвал, түүнд: даргалж, удирдан жолоодох тус дэм болдог тэр зүйл сэтгэл оюунд байхгүй байна шүү дээ гэдгийг нь хэлэх хэрэгтэй”<sup>9</sup>

Өнөөгийн нийгэмд төрийн албан хаагч шударга зарчимч, нийгмийн ашиг сонирхлын төлөө анхаарал тавьдаг, албан ажил үүргээ гүйцэтгэхдээ авлига авах учиргүй гэсэн энэ зарчим өнөөдөр ихэд алдагдсан байна. Өнөөдөр бидэнд хамгийн ихээр ажиглагдан төрийн албаны ёс зүйн асуудалд хөндөгдөж байгаа зүйлийн нэг бол авлигын асуудал юм. Өөрөөр хэлбэл төрийн албан хаагчид төрийн албан хаагчийн зарчим, ёс зүйгээ зөрчиж байгаа явдал юм. Монголын ихэнх хүмүүс ходоодоороо саналаа өгдөг. Яг энэ зүйлийг дулдуйдан санал авч буй төрийн албан хаагчдын ёс суртахуун ямар байгааг харуулж байна.

Төрийн албан хаагч хүн шударга, цэцэн мэргэн, хүлээцтэй байхаас гадна уран илтгэх чадварыг эзэмшсэн байх учиртай. Мөн төр, эрх зүйн үндсүүдийн талаар мэдлэгтэй байх ёстой ба ийм мэдлэггүйгээр хэн ч шударга үнэнч байж чадахгүй. Ер нь төрийн албан хаагч бол албан ажлынхаа үйл ажиллагааныхаа зарчмыг ягштал биелүүлдэг бусдыг үлгэрлэж чадахуйц ёс зүйтэй байх нь маш чухал юм.

Төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг сахихын тулд хуулийн соалт, ёс зүйн дүрмээс гадна байгууллагын соёл, удирдлагын арга барил, үлгэрлэл зэргийг багтаасан ёс зүйн менежмент шаардлагатай байдаг. Ёс зүйн зарим бүрдэл хэсэг нь тухайн улс төрийн албаны ерөнхий орчин, соёл уламжлалаас хамааралтай байдаг.

Ер нь улс төрийн албан хаагч бол албан ажлынхаа үйл ажиллагааныхаа зарчмыг ягштал биелүүлдэг, бусдыг үлгэрлэж чадахуйц ёс зүйтэй байх нь онцгой чухал юм.

### Намын эрх ашгаас ард түмний эрх ашгийг

<sup>8</sup> Г.Алмонд, Д.Пауэл, К.Стром, Р.Дальтон. Харьцуулсан улс төр. Онолын хүрээ. УБ., 2005. 202 дахь тал.

<sup>9</sup> Аристотель. Дээд суртахуун. УБ., 2006. 8 дахь тал.

дээгүүр тавих нь парламентын гишүүн хүний баримтлах ёс суртахууны зарчим юм.

Энэ нь сонгуульд нэр дэвшигчид өөрсдийгөө шилдэг тэргүүний хүн, улс төрийн сайн зүтгэлтэн гэх мэтээр худал хуурмаг мэдээлэл өгч, УИХ-ын гишүүнээр сонгогдсон хойноо мэдлэг боловсрол, оюуны чадавх, хүний мөс чанар, ёс суртахууныхаа байр сууриа ажил амьдрал дээр таниулаад сонгогчдын илтгэлийг хөсөрдүүлэн дахин сонгогдох боломжгүй болж байгаагаар тайлбарлагдана.

Төр засгийн өндөр албан тушаалд очихын тулд улс орон болон өөрийнхөө хэр хэмжээнээс хэтэрсэн амлалтаар хуурч сонгогдож томилогдсон хойноо уг амлалтаа биелүүлээгүйн төлөө хуулийн хариуцлага хүлээхгүй байгаа ч харин сонгогчдын өмнө ёс суртахууны хариуцлага хүлээж байгаа нь илүү бодитой болов. Дж Мур "Ёс суртахууны хүрээ хуулийн хүрээнээс илүү өргөн байдаг. Манай орны хуулиар хориглоогүй, заагаагүй үйлдлийг бид ёс суртахууны хувьд хийж гүйцэтгэх эсвэл хийхгүй ч байх үүрэгтэй"<sup>10</sup> гэж эрх зүйн зохицуулалтаас ёс суртахууны зохицуулалт хавьгүй илүү өргөн хүрээний зан үйлдлийг хамарч зохицуулдаг болохыг заажээ.

Сонгогч олон түмэн сонгож томилсон албан тушаалтнуудад ёс суртахууны хариуцлага хүлээлгэж, албан тушаалтнууд ч гэсэн өөрсдөө итгэл найдварыг нь хангалтгүй биелүүлснийхээ төлөө ёс суртахууны хариуцлага хүлээж огцрох, үйл ажиллагаагаа бодитойгоор тайлагнах зэрэг үйлдэл хийж сураагүй буюу эрх мэдэлтнүүдэд тийм ёс суртахууны соёл төлөвшөөгүй байгаа тохиолдолд Монголд албан тушаал, эрх мэдэл нь хүмүүсийн дээдлэх үнэт зүйл болсоор байх юм.

Нийгмийн ёс суртахууны хүмүүжил, соёл бол төр засгийг элдэв эрсдэл, авлига зэрэг бүтэлгүй тохиолдлуудаас аврах чухал хүчин зүйл болж чадах юм<sup>11</sup>.

Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны ёс зүйн дүрмийг гаргах гэж олон жилийн нүүр үзэж одоо нэлээд зүгшрэх тийшээгээ болж байна. Энэ нь тодорхой учир шалтгаантай. Тухайлбал,

-Бичмэл бус хуулийг бичгийн хуульд хөрвүүлэх нь арга зүйн хувьд амар биш. Ялангуяа ёс зүй нь олон зуун жилийн турш

хүмүүсийн аж амьдрал, зан заншлаар дархлагдсан, түүний хууль, категори, хорио цээр, шийтгэл нь эрх зүйгээс ч илүү хүчтэй үйлчилдэг.

-Манай оронд зарим мэргэжлийн байгууллагад ёс зүйн жижиг дүрэм, журам, мөрдөгдөж байгаагаас биш ёс зүйн ийм өргөн зэрэг зиндааны дүрэм байхгүйгээс нийгмийн зан суртахуунд будилаантай асуудал үүсэж байна. Төрийн зарим өндөр албан тушаалтны үйлдсэн хэргийг ёс зүйд нялзаагаад шийтгэлгүй орхих, ёс суртахууны доголдол гаргасан төрийн албан хаагчид ямар ч зэмлэл үзүүлэхгүй байгаа зэрэг дутагдал нь олон түмний дургүйцлийг төрүүлж, нийгмийн ухамсрыг булингартуулж байна. Үүнээс улбаалаад авлига, хээл хахууль бусад ёс бус үйлдлүүд газар авч байна.

Аливаа хүн өөрийнх нь эрх мэдэл, боломжийг тодорхой байдлаар хязгаарласан хууль, дүрэм, горим батлан гаргахыг сайшаадаггүй нь амьдралын үнэн билээ.

Одоогийн төсөлд "Төрийн өндөр албан тушаалтны зэрэглэлд хамаарах төрийн албан тушаалтнаас үйл ажиллагаагаа төрийн албаны зарчим, түүнд тавих шаардлагын дагуу гүйцэтгэхэд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоож хэвшүүлэхэд энэ дүрмийн зорилго оршино"<sup>12</sup> гэж заасан байна.

Хүмүүс төрийн албан хаагчдад өндөр шаардлага тавьдаг бөгөөд хэрэв түүнийг нь биелүүлэхгүй буюу хангалтгүй биелүүлэх нь олон нийтийн анхаарлыг татсан хурц асуудал болж нийгмийг цочирдуулах, засаг, төрдөө үл итгэх байдал бий болно. Үүнээс болоод улс орны эрүүгийн нөхцөл байдал хүндэрч зохион байгуулалттай хэрэг өсөж, түүнд хяналт тавихын тулд улс орны эдийн засгийн чадавх ба санхүүгийн нөөцийн нэлээд хэсгийг зарцуулах, бүх шатны түшмэлүүдийн дунд авлига ба хээл хахууль бий болох, харгислал ба терроризм, гэмт явдал, нийгмийн гол гол салбаруудад газар авч байна<sup>13</sup> хэмээн эрдэмтэн, судлаачид тэмдэглэжээ.

Төрийн албан хаагч бие хүний мэргэжил-зан суртахууны хөгжлийг ерөнхийд нь хэдэн төвшинд ангилж болох юм. Үүнд:

- Энэрэнгүй үзэл, ардчилал, ёс суртахууны өндөр шалгууртай, нягт нямбай, тогтвортой хүмүүсийн давхраа
- Төрийн албан хаагч өөртөө ноогдсон ажлаа зайлшгүй гүйцэтгэхийг хичээж, албан

<sup>10</sup> Джордж Эдвард Мур. Природа моральной философии. М., 328 дахь тал.

<sup>11</sup> Б.Галиндэв. Монголын нийгмийн өөрчлөлтийн үе дэх ёс суртахууны асуудлууд. УБ., 2010. 78 дахь тал.

<sup>12</sup> Р.Вандангомбо. Төрийн албаны ёс зүй. УБ., 2007. 45 дахь тал.

<sup>13</sup> Д.Будников. Кризис в России: Криминальный аспект // Российская газета. 1999.







үүрэг, эрхээ “ариун үйлс” хэмээн ухаардаг.

- Удирдах ажилтан хариуцлагатай, санаачилгатай зан суртахууны хэмжүүрээр үлгэр жишээ ч байдаг.

- Гүйцэтгэх чадвар, сэтгэл хөдлөлийн шинж, дүрэм заавар болон буулт хийхээс татгалздаггүй.

- Эрх мэдлээрээ түрий барьдаг, хэрэглэгчийн сэтгэл зүй болон бусдаар тэжээлгэх санаа давамгайлсан бэртэгчин ухамсартай ажилтнууд цөөнгүй байдаг.

- Доод түвшин нь хүнд сурталтан ба дасан зохицогчид юм. Ийм бүтэлгүй араншинт түшмэлийг “Эрдэнийн сан Субашидад”:

“Үнэн санаандаа өөр нэгнийг бодоод  
Үгэндээ өөр нэгнийг хэлэгч хүнийг  
Үлэмж бичиг хуурамч гэж хэлдэг бөгөөд  
Үтэл муу хүн, сайн мэхэлсэн нь билээ”  
хэмээн тэмдэглэжээ<sup>14</sup>.

Төрийн удирдах албан тушаалтнуудад ёс суртахуун бол ажил дээр сэтгэл зүйн тааламжтай уур амьсгалыг бүрэлдүүлэх, ажилтны хооронд хамтач харилцааг бий болгох, материалын ба зан суртахууны урамшлыг зохистой хослуулах, сэдлийн тогтолцоог боловсронгуй болгох, албан тушаал болон тэтгэврийн асуудлыг зөв шийдвэрлэхтэй салшгүй холбоотой хэмээн ойлгодог хүн бүхэнд тус болно.

Төрийн албан хаагчийн шийдвэр гаргахад нөлөөлдөг хүчин зүйлийн дотор үнэн сэтгэлээсээ ажиллаж, өөрийгөө илэрхийлэх гэсэн дотоод сэдэл давамгайлах нь үр бүтээлтэй чин шударга хөдөлмөрлөхөд хамгийн чухал зүйл юм.

Ёс суртахууны талаар өөрийгөө танина гэдэг бол өөрийнхөө нинжин сэтгэлийн харилцааг нээнэ гэсэн үг юм.

1. Нинжин сэтгэлийн байдал, төлөвийн оношилгоо

2. Нинжин сэтгэл болон хувийн зан төлөвийн харилцааны шинж чанарыг илрүүлэх

3. Нинжин сэтгэл болон авьяасаа ёс суртахууны өндөр шаардлагыг хангаж чадахуйц төвшинд хүргэх арга замыг хайж олох, түүнийг ухамсарлах зэрэг болно.

Эдүгээгийн манай нийгэмд ноёрхож байгаа зан суртахууны байдал, хэм хэмжээнд өөрчлөлт орлоо. Аль ч түвшинд зохицуулалт хийх гол үндэс нь бие хүний ёс суртахууны сонголт байдаг.

Ёс суртахууны зохицуулалт хариуцлагын болон хяналтын шударга тогтолцоон дээр суурилдаг. Засгийг бүхэлд нь ард түмний

<sup>14</sup> Р.Вандангомбо. Төрийн албаны ёс зүй. УБ., 2007. 87 дэх тал.

өмнө ил тод болгож, хяналтад оруулах нь өндөр үр дүнтэй. Үүний тулд төрийн албаны ёс зүй ба зан суртахууны нарийн мэдрэмжтэй байх хэрэгтэй<sup>15</sup>.

Төрд алба хашиж буй хүмүүс шударга, үнэнч байх ёстой талаар ч эрт дээр үеэс хүмүүс ярьж байсан. Демократ “Төр бол бүх нийтийн эрх ашиг, сайн сайхан байдал, шударга ёсыг төлөөлдөг учир төрийн эрх ашиг бүхнээс дээр байна”. Нийгэм, төрийг бүх нийтээрээ бус цөөн хэдэн ухаантан, эрхэм дээдэс удирдах ёстой. Эрхэм дээдэс бол зөвхөн язгууртан бус оюун ухаан, ёс суртахууны эрхэм чанаруудыг эзэмшсэн хүн байна.

М.Т.Цицерон “Төрийн тухай” зохиолдоо “Төрийн албан хаагч гэдэг бол цэцэн мэргэн, шударга, хүлээцтэй байхаас гадна уран илтгэх чадварыг эзэмшсэн байх учиртай. Мөн төр, эрх зүйн үндсүүдийн талаар мэдлэгтэй байх ёстой ба ийм мэдлэггүйгээр хэн ч шударга, үнэнч байж чадахгүй”. Д.Ж.Локк “Төрийн албан тушаалтнууд гагцхүү хуулиар олгогдсон эрх мэдлийг хэрэгжүүлэх ёстой<sup>16</sup>”.

Ф.Ницшегийн хэлсэнчлэн “Төрийн албан хаагч айх, эмээх, ичих зүйлгүйгээр ажиллаа л гэвэл өөрийнхөө төлөө бус төрийн төлөө ажиллах ёстой<sup>17</sup>”.

Төрийн алба хашна гэдэг бол их нэр хүндтэй, хариуцлагатай үйл учраас төрийн түшээ нь ажил үүрэгтээ бүхий л авьяас билиг, оюуны чадавхаа шавхан дайчлах шаардлагатай билээ.

Доктор, профессор Б.Чимид: Төрийн мэргэшсэн алба бол “явуулын” улс төрчдийг хуулиар зэвсэглэж, хуульд захирагдаж ажилладаг болгох “отчийн газар” мөн гэжээ<sup>18</sup>. Төр нь хууль тогтоох, хууль биелүүлэх, хууль хамгаалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг ард түмний төлөөллийн байгууллага бөгөөд төрийн албанд ажиллаж буй этгээдийн ёс зүйн зан үйлээр тухайн байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ дүгнэгдэж байдаг.

Аристотель: “Албан тушаал хүнийг илчлэн харуулдаг” гээд, албан тушаал авсан этгээд ойр дотнынхон болон нийт нийгэмтэйгээ харьцана. Ийм үеийн ганц шударга ёс нь бусад хүнд ашид тусыг үзүүлсэн сайн сайханд оршино” гэжээ. Ёс суртахуунтай хүн гэдэг бол сайн үйлд нийцсэн оюун ухааныг удирдлага болгодог этгээд гэж албан тушаалын талаар философиин ойлголтыг өгсөн нь нийгмийн хөгжлийн ямар ч үе шатанд ард түмний нэг хэсэг эрх мэдлийг

<sup>15</sup> Д.Дэмбэрэл. Ёс зүйт төр. УБ., 2011. 216 дахь тал.

<sup>16</sup> Ц.Батбаяр. Ёс зүй. УБ., 2007. 162 дахь тал.

<sup>17</sup> Мөн тэнд. 166 дахь тал.

<sup>18</sup> Б.Чимид. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс. УБ., 2006.



төр хэрэгжүүлдгийн хувьд ард түмэнгүй төр гэж байхгүйн адил төлөөлөлгүй эрх мэдэл хэрэгжүүлэх төлөөлөлгүй ард түмэн гэж үгүй тул албатан буюу албан тушаалтан байх нь ойлгомжтой.

Төр анх бий болсноос эхлээд сэтгэгчид төр, түүний албан хаагчид нь ямар хүн байвал илүү зохистой талаар олон арван үзэл санаа дэвшүүлжээ. Тухайлбал Демократ (МЭӨ 470-365) “Төр бол бүх нийтийн эрх ашиг, сайн сайхан байдал, шударга ёсыг төлөөлдөг учир төрийн эрх ашиг бүхнээс дээр байна. Зохион байгуулалт сайтай ухаалаг удирдагчтай төр бол ард түмний түшиг тулгуур юм” гэж үзжээ<sup>19</sup>.

Дээрхийн гэгээн XIV Далай лам: “Өөрийн сөрөг бодол, мэдрэхүйг дарахын тулд тэднийг өдөөж буй үйлдэл болоод тухайн нөхцөл байдлаас тойрч явах нь зүйтэй ажээ”<sup>20</sup> гэснийг бодуштай.

Аливаа ажил, албан тушаал нь ёс зүйн өвөрмөц шаардлагыг бий болгодог. Төрийн албан хаагчийн ёс зүйн тусгай хэм хэмжээ нь ёс зүйн ерөнхий зарчмаас ангид шаардлага биш бөгөөд харин түүний хүрээнд төрийн албан хаагч заавал сахин биелүүлбэл зохих хуульд заагдсан ёс зүйн шаардлагууд юм.

Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ хуульд төдийгүй хуулийн хүрээнд тогтоогдсон ёс зүйн болон сахилгын дүрмүүдэд илүү нарийвчлан тусгагдсан байдаг бөгөөд тэдгээр нь төрийн албан хаагчийн ёс зүйн нэмэлт хэм хэмжээг бүрдүүлдэг.

Ёс суртахууны эрхэм чанар, улс төрийн мэргэн ухаан 2-ыг нэгэн биедээ тээж, хүн ардаа эрхэмлэн хайрлах сэтгэлтэй хүн л төрийн эрх барих дээдсийн суудалд суух учиртай. Улс төрч хүний гаргасан шийдвэр, үйл хэрэг ямагт улс нийгмийн шинжтэй, өргөн цар хүрээтэй асуудлыг шийдэж байх ёстой болохоос бус хувийнхаа амьдрал, ахуйг дээшлүүлсэн, ах дүү, төрөл садан төрлийнхөн, нам бүлгийнхнээ төрийн албанд шургуулсан, эрх мэдлээ ашиглаж ард түмний татварын мөнгө гувчуулсан зэрэг ёс суртахуунгүй үйлдлүүдээр хэмжигдэх ёсгүй<sup>21</sup>.

Төрийн албыг мэргэжлийн үйл ажиллагаагаараа хангаж байдаг онцгой төрөл болох төрийн алба өөрийн гэсэн мэргэжлийн ёс зүйтэй байх ёстойг нарийн үндэслэх хэрэгтэй байна. Үүнд:

- Засаглалын нэр хүнд түшмэдийн зан суртахууны шинж, тэдгээрийн эмх цэгц, шударга байдал, төр засагтаа чин сэтгэлээсээ

үнэнч ажиллахаас шууд шалтгаална.

- Төрийн албан хаагчийн ёс суртахуунгүй ноцтой үйлдэл нь нийгмийг тогтворгүй байдалд оруулдаг хүчтэй зүйл болж, хүмүүсийн анхаарлыг үлэмж татдаг.

- Энэ мэргэжлийн онцлог нь төрийн санаа зоригийг илэрхийлэхийн хувьд үргэлж олон түмний анхаарлын төвд байж, хүн ардтай тогтмол ажилладаг учраас иргэдийнхээ эрх ашиг болон бусад зүйлийг тодорхой хэмжээгээр харгалзан үзсэн зан төлөвийн өвөрмөц хэм хэмжээг боловсруулахыг шаардаж байдагтай холбоотой<sup>22</sup>.

Өнөөгийн түшмэдүүд амьдрал дээр хариуцлагын ёс зүйг зонхилох болжээ. Өдгөө олон улс орон түшмэдийн хариуцлагын ёс зүйн тухай тусгай хуультай болж “Арга хэрэгслэлийг зөвтгөх зорилго бүхий” зарчмыг хэн ч хаана ч сурталчлах болжээ.

Ёс суртахууны амин сүнснийг бүрэлдүүлж байж албан ажлын хүрээнд дэх хүний оюун ухааны чиглэл болдог. Тухайлбал,

- Засаглалын бүх салаа мөчир, сонгогчдын санаа зориг, төрийн байгууллага, албан газар, сөрөг хүч ба үйлчлүүлэгчидтэй эвсэг, төвийг сахиж харилцах;

- Хууль ёс, хуулийн хэм хэмжээ, үзэл баримтлал болон албан заавар, журмын шаардлагыг хатуу чанд сахих;

- Албан хаагч өөрийн иргэний эрх, эрх чөлөөгөө сайн дураараа буюу ухамсартайгаар хязгаарлах;

- Албан үүргээ чин сэтгэлээсээ хариуцлагатай гүйцэтгэж, түүний өнөөгийн байдал, цаашдын хандлага ямар байх ёстойг сайтар мэдэх;

- Нигүүлсэнгүй үзэл, нийгмийн шударга ёс, эрх мэдлийн байгууллага дахь албаны ёс журмыг хэлбэрийн төдий гүйцэтгэх бус хүний тусын тулд үйл ажиллагаа явуулах, иргэн, хүн бүрийн ашиг сонирхол, хүсэл эрмэлзэл, авьяас чадвараа амжилттай хэрэгжүүлэх хамгийн таатай нөхцөлийг бий болгохын төлөө зүтгэхээ ухамсарлах ёстой. Түүний гол үндэслэл нь хүнээс илүү эрх мэдэлтэй байх бус харин хүмүүст эрх мэдлийг олгох;

- Албан хаагчаас эх орныхоо өмнө хүлээсэн хариуцлагаа гүнзгий ухамсарлах, түүнд бие сэтгэлээ зориулах, түүнийг хамгаалах, батжуулах, хөгжүүлэхтэй уялдан зан суртахууны хэм хэмжээг чанд сахих явдал. Иймээс нэлээд улсын хуульд төрийн албан хаагч бол 2 улсын иргэн байж болохгүй гэж заасан байдаг;

<sup>19</sup> Ц.Батбаяр. Ёс зүй. УБ., 2007. 162 дахь тал.

<sup>20</sup> Аристотель. Дээд суртахуун. УБ., 2006. 9 дэх тал.

<sup>21</sup> Б.Галиндэв. Хүн байх ухаан.УБ.,2016.119 дэх тал.

<sup>22</sup> Р.Вандангомбо. Төрийн албаны ёс зүй. УБ., 2007. 54 дэх тал.





• Бүх улс үндэстнүүдийг арьс, өнгө, үндэс угсаа ялгаварлахгүйгээр тэдний эрх чөлөө ба тэгш эрхийг хүлээн зөвшөөрөх зэрэг болно.

Манай улсад төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой зарим асуудлыг Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Ерөнхийлөгчийн тухай хууль, Монгол Улсын Их хурлын тухай хууль, Монгол Улсын Их хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Авлигын эсрэг хууль, УИХ-ын хуралдааны дэгийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 95-р зарлигаар баталсан “Төрийн албан хаагчийн тангараг өргөх ёслол”, МУ-ын Засгийн газрын 2010 оны 288-р тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм” зэрэг хууль тогтоомжоор зохицуулж байна. Эндээс харахад улс төрчдийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжор хангалттай сайн зохицуулж өгөөгүй юм. Манайд сонгогчдын зүгээс өөрийн тойргийн гишүүдэд ёс зүйн хариуцлага тооцох ямар ч тогтолцоо байхгүй бөгөөд парламентын гишүүний онцгой бүрэн эрхэд хэн ч халдашгүйгээр хуульчилсан байдаг. Улс төрч гэмт хэрэг үйлдсэн гэдэг нь шүүхээр тогтоогдсон нөхцөлд л бүрэн эрх нь цуцлагдахаар зохицуулсан. Төрийн албан хаагчийн ёс суртахууны үнэлэмж, шалгуур нөхцөлүүд хуулиудад хангалттай тусгагдаж чадаагүйгээс төрийн албаны ёс зүй зөрчигдөх явдал цөөнгүй гарах болов.

Английн улс төрч Эдмунд Берк сонгогчдынхоо өмнө хэлсэн үгэндээ “өөрсдийн сонгогчид, сонгогдсон тойргийнхоо үзэл санаа, ашиг сонирхлыг илэрхийлэхээр өөрийн улс төрийн байр сууриндаа барьцаалагдсан зүгээр нэг төлөөлөгч төдий байх уу, эсвэл сонгуулийнхаа тойргийн эрх ашиг, хүсэл эрмэлзэлд харшилсан ч нийт улс орныхоо эрх ашгийн төлөө өөрийн боловсрол чадвар, туршлага гэгээрлээ зориулж чадах итгэмжлэгдсэн төлөөлөгч байх уу. Би хувьдаа 2 дахь хувилбарыг сонгоно. Энэ бол миний өөрөө өөртөө үүрэг болгож авах ёстой ёс зүйн тэр шаардлага” гэж хэлсэн байдаг<sup>23</sup>. Эдгээр сонирхлыг хувь улс

<sup>23</sup> ШУА-ийн ФСЭЗХүрээлэн. Эрдмийн ертөнц. /Academe/ 2012/1 /6/. УБ., 2012.91 дэх тал.

төрчдийн өөрийнх нь хувийн сонирхлоос хэрхэн яаж зааглах вэ? гэсэн асуудлыг харж байна.

Уйнстон Черчилль: “Улс төрчид дараагийн сонгууль хүртэл өөрийгөө аргацаахыг боддог бол, төрийн зүтгэлтэн дараагийн үе хүртэл тэмцдэг” гэж хэлсэн байдаг<sup>24</sup>. Манай улс төрчид ирэх сонгууль хүртэл амиа яаж аргацаах вэ? гэж бодож ажилдаг. Улс төрийн албан хаагч нь үйл ажиллагаандаа шударга ёсны зарчим, хууль дээдлэл зарчим, тэгш байдлын зарчим, хариуцлага хүлээх зарчим, олон нийтэд үйлчлэх ёс зүйн зарчмыг баримтлах ёстой.

Төрийн гол зорилтыг нийгмийн амьдралын шударга ёсыг хангах, хүн бүхэн өөрт оногдсон ажил үүргээ ягштал биелүүлэх, бусдын эрхийг боогдуулж дотоод хэрэгт нь үл оролцох явдал хэмээжээ. Н.Макиавелли дээрх санааг цааш үргэлжлүүлэн хүчтэй төрийн засаглалын тусламжтай гагцхүү эрх чөлөө, шударга ёсны ноёрхлыг тогтоож чадна<sup>25</sup>.

Төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн дүрмийг батлах асуудал нэлээд сунжирч дөрвөн парламентын нүүр үзэж байна. Нэг талаар ёс зүй гэдэг төвөгтэй асуудал. Хүмүүсийн болгоомжлол ч байдаг болов уу. Ёс зүйг заавал ингэж журамлах хэрэгцээ, шаардлага байна уу? гэдэгт УИХ-ын гишүүд эргэлзээтэй ханддаг нь ч бий. Нөгөөтээгүүр их сайн бодож албаны ёс зүй, хувийн ёс зүйгээс хэрхэн ялгагдах ёстой гэдгийг салгаж зааглах хэрэгтэй. Иймэрхүү нөхцөл шалтгаануудаас болоод удсан тал бий. Гэхдээ Төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн дүрмийг даруйхан баталж мөрдүүлэх нь зүйтэй.

### III. Улс төрийн албан хаагчийн ёс зүйн судалгаа

Төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргаж иргэд яагаад таагүй хандах болов гэдэг хариулт дараах судалгаанаас харагдаж байна. Төрийн удирдах албан хаагчдын өөр нэг онцлох шинж чанар бол албан ажил, хувийн ашиг сонирхлоо хольж хутгахгүй байх, нийтийн эрх ашгийг ямагт өөрийнхөөс дээгүүр тавьж ажиллах явдал юм. Сонин хэвлэлд төрийн удирдах албан тушаалтан, төрийн албан хаагчдын талаар таагүй, сөрөг мэдээлэл нийтлэх нь нийтлэг болсон хэдий ч үүнийгээ төрийн албан хаагч бүрт хавтгайруулан хамаатуулах бус, харин тодорхой хүний жишээн дээр төрийн албан хаагчдын бусдаас ялгарах онцлог шинж чанарын талаар тодруулан бичдэг нь

<sup>24</sup> Мөн тэнд. 92 дахь тал.

<sup>25</sup> Ц.Батбаяр. Ёс зүй. УБ., 2007. 162 дахь тал.



сайшаалтай юм. Ингэхдээ төрийн удирдах албан тушаалтан болон албан хаагчдад тавигдах гол шалгуурыг ажлын хариуцлага, шударга байх зарчим, нийтийн эрх ашгийн төлөө тэмцэх чадвар, мэдрэмж гэдгийг онцлон авч үзсэн байна.

Ялангуяа төрийн удирдах албан тушаалтанд бусдыг үлгэрлэх, биеэ авч явах соёл, ёс зүйн хэм хэмжээ нь тэдгээрийн эзэмшвэл зохих онцлог шинж чанаруудад хамаарна. Улс төрийн эрх мэдэлтэн гэдэг бол бидний /бусдын/ улс төрийн эрх мэдлийг ацаглаж авсан этгээд юм. Иймд иргэд, улс төрийн эрх мэдэлтнүүд ёс суртахууны хариуцлагаа хэрхэн сахиж байгааг хянадаг байх ёстой. Чухам ингэж байж улс орондоо цэвэр нандин улс төрийг төлөвшүүлж чадна.

“Төрийн албан хаагч, ялангуяа төрийн өндөр албан тушаалтнууд хариуцлага хүлээдэг байх” нь тэдний хувьд онцгой шинж чанар. Нийтлэлүүдэд төрийн байгууллагын удирдах албан тушаалтнуудын дунд өөрсдийн албан тушаал, эрх мэдлээ хувьдаа ашиг хонжоо олох, өмч хөрөнгө идэж шамшигдуулах, авлига, хээл хахууль авах, танил тал, арын хаалгаар асуудлыг шийдэх, өөрийн хүнийг ажил алба, албан тушаалд томилох зэрэг зөрчил доголдол газар авч хавтгайрсан тухай голлон бичиж байна.

Монголын төрийн үйл ажиллагаанд албан тушаалаа урвуулан ашиглах ёс зүйн хийгээд гэмт хэргийн чанартай зөрчил жилээс жилд буурах биш харин “өсөн нэмэгдэх” хандлагатай байна. Үүнийг зарим сонины жишээ, үзүүлэлтээр нотлон харуулж болно. Тухайлбал, төрийн албан хаагчдын ёс зүйн асуудлыг нэлээд их хөндөн бичдэг Зууны мэдээ сонины нийтлэлд төрийн албан хаагч албан тушаал ашиглах нь хамгийн түгээмэл шинжтэй ёс зүйн асуудлын сэдэв болсон хэвээр байна. Зөвхөн 2008 онд нийтлэгдсэн байдлаас харахад:

- Тендер будлиантуулдаг дарга нарын далд эрх ашиг /Зууны мэдээ, 2008.2.19, 40 (2800)/

- Засаг дарга хувийнхаа байшинг тамгын газартаа 100 саяар “шахжээ”, /Зууны мэдээ, 2008.6.23, 151 (2911)/,

- “Төрийн албаны төгөлдөршил гэж үүнийг хэлээд байна уу”, /Зууны мэдээ, 2008.10.15, 247 (3007)/ гэх зэрэг 67 материал нийтлэгджээ<sup>26</sup>. Энэ нь өмнөх 2007 оныхоос бараг 2 дахин их үзүүлэлттэй байгаа юм. Ер нь тус сонины аль ч оныг авч

үзсэн түүнд хөндөгдсөн сэдвүүдээс төрийн албан хаагчдын албан тушаалаа ашигласан тохиолдлууд хамгийн өндөр үзүүлэлттэй гарч байна.

Төрийн өндөр албан тушаалтан нь эрхэлсэн ажлаасаа гадуур төлбөртэй үйлчилгээ явуулдаг, банк, төрийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн өртэй байдаг эсэх талаар төдийлөн анхаарч бичдэггүй байдал ажиглагдав. УИХ-ын гишүүдийн хувьд ашиг сонирхлын зөрчилтэй асуудлыг хэлэлцэхэд оролцохгүйгээ албан ёсоор мэдэгдэж санал хураалтад оролцохгүй байх, гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссаны дараа тодорхой хугацаагаар тухайн асуудлаар бусад УИХ-ын гишүүдэд лобби хийхгүй байх талаар эрх зүйн зохих зохицуулалт чухал юм.

Төрийн албан хаагчид цэвэр ариун ёс суртахуунтай, нийтийн болон албан тушаал, ажил мэргэжлийнхээ ёс зүйн хэм хэмжээг чанд баримтлан ажилладаг болоход төрийн албаны үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал чухал ач холбогдолтой. Учир нь төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд иргэдийн хяналтыг буй болгож чадсан төр илүү цэвэршдэг тухай судлаачид авч үзсэн байдаг. Тэгвэл монголын төрийн албан хаагчдаас төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг зөрчдөг тухай иргэдийн гомдол, саналыг сонин хэвлэлд бага боловч нийтэлдэг байдал ажиглагдсан нь цаашид нэмэгдүүлж, тогтмолжуулах шаардлагатай харуулж байна.

Төрийн гүйцэтгэх албан тушаалтнууд өөрийн удирдах албан тушаалтны ёс зүйн байдлыг үнэлсэн байдлыг дүгнэхэд 44% сэтгэл ханамж маш муу, 28% сэтгэл ханамж муу, 16% сэтгэл ханамж дунд, үлдсэн 12% нь сэтгэл ханамж сайн гэсэн үр дүн гарсан байна. 70-аас илүү хувь нь сэтгэл ханамж муу байгаа нь удирдлагууддаа сэтгэл хангалуун бус байдаг гэж хэлж болохоор байна<sup>27</sup>.

Төрийн албаны зөвлөлөөс 2014 онд нийт 347 ёс зүйн зөрчил бүртгэгдсэнээс төрийн удирдах албан тушаалтантай холбоотой 31 зөрчил, 2015 онд нийт 212 ёс зүйн зөрчил бүртгэгдсэнээс төрийн удирдах албан тушаалтантай холбоотой 28 зөрчил, 2016 онд нийт 193 ёс зүйн зөрчил бүртгэгдсэнээс төрийн удирдах албан тушаалтантай

<sup>26</sup> УИХ-ын Тамгын газрын судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв. ТАХ-ийн ёс зүйн асуудалд дахь хэвлэл нийтлэлийн контент-анализ. УБ., 2008. 18 дахь тал.

<sup>27</sup> МУИС, МУБИС, ШУТИС, ШУА-ийн Философийн хүрээлэн. МУИС-ийн философийн салбар төгсөгчдийн холбоо. Хэрэглээний ёс зүйн асуудлууд: эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2017. 118 дахь тал.



холбоотой 19 зөрчил бүртгэгдсэн байна<sup>28</sup>. Үүнээс харахад төрийн удирдах албан тушаалтны ёс зүйн зөрчил сүүлийн 3 жилийн дунджаар 10.6 хувьтай байгаа нь өмнөх онуудтай харьцуулахад өссөн дүнг илэрхийлсэн байна. 60 тэрбумын хэрэг, Оюутолгой болон Дубайн гэрээ, обшор данс зэрэг олон нийтийн дунд болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй төрийн удирдах албан тушаалтны ёс зүйтэй холбоотой асуудлууд иргэдийн төрд болон төрийн удирдах албан хаагчдад илтгэх итгэлийг алдагдуулах сөрөг үр дагавартай өнөөгийн нийгмийн асуудал болоод байна.

Төрийн удирдах албан тушаалтан өөрсдийнхөө ажилд хэрэг болох ёс зүйн үндсэн зарчим, стандартын талаар болон зохистой биеэ авч явах байдлын хил хязгаар хаагуур байгаа талаар мэддэг байх ёстой. Эрх барих байгууллагад сонгогдон ажиллаж буй лидерүүд ёс суртахууны хэм хэмжээгээ тангараг өргөх байдлаар илэрхийлдэг.

#### **IV. Төрийн албан хаагчийн ёс зүйн олон улсын хэм хэмжээний зохицуулалт**

Азербайжан Улсад төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг тусдаа хуулиар зохицуулдаг бөгөөд Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн тухай хуулийг 2007 онд батлан гаргажээ. Энэ хууль нь ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх баталгаа юм. Хуульд тодорхойлсноор төрийн албан хаагч бүр хууль дээдлэх, хүний эрхийг эрхэмлэх, ардчилсан зарчим, ёс зүйн өндөр хэм хэмжээ болон энэ хуулийг баримтлан ажиллах ёстой.

##### **Хуулийн зорилт:**

- ❖ Төрийн алба болон төрийн байгууллагын нэр хүндийг нэмэгдүүлэх;
- ❖ Төрийн байгууллага, төрийн албан хаагчид хандах иргэдийн итгэлийг бэхжүүлэх;
- ❖ Төрийн байгууллага, төрийн албан хаагчийг авлига, ашиг сонирхлын зөрчилд орохоос урьдчилан сэргийлэх;
- ❖ Төрийн байгууллага, төрийн албан хаагчийн ажлын үр ашиг, ил тод байдлыг нэмэгдүүлэх;
- ❖ Төрийн албан хаагчийн мөрдөх ёс зүйн талаар иргэдэд мэдээлэл, ойлголт өгөх;
- ❖ Төрийн байгууллага, төрийн албан хаагчийн ажлыг үнэлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

Энэ хууль нь дараах харилцааг зохицуулдаг. Үүнд:

- Төрийн албан хаагч болон төрийн

байгууллага хоорондын харилцаа;

- Удирдлага болон ажилтан хоорондын харилцаа (Захирах, захирагдах ёс);

➤ Төрийн албан хаагчдын өөр хоорондын харилцаа;

- Төрийн албан хаагчийн бусадтай харилцах харилцааг зохицуулна<sup>29</sup>.

ХБНГУлсад Ёс зүйн зөвлөлийн хууль, (Ethics Council Act)<sup>30</sup> 2007 баталж мөрдүүлсэн байна. Тус хуулиар Германы ёс зүйн зөвлөлийн чиг үүрэг, гишүүдийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа зэргийг зохицуулсан байна. Ёс зүйн зөвлөл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, технологи, философи, ёс зүйн, нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн асуудалд мэргэшсэн 26 гишүүнээс бүрдэнэ. Ёс зүйн зөвлөл нь төрийн албаны ёс зүйн асуудлаар олон нийтийн байгууллагуудын дунд хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, бусад улс орнуудын ижил төстэй байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх чиг үүрэгтэй.

АНУ-д төрийн түшмэдийн ёс суртахууны сөрөг үзэгдэлтэй тэмцэхдээ цаашдаа хуулийг мөрдүүлэх арга замыг үндэс болгожээ. 1978 онд Конгресс Засгийн газрын ёс зүйн тухай хуулийг батлав. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны зан суртахууны асуудалд нь хяналт тавих үүргийг холбогдох хууль хамгаалалтын байгууллага ба тусгайлан байгуулсан засгийн газрын ёс зүйн алба хариуцдаг. Өнөө хүртэл АНУ-д дээрх хуулийн үйлчлэх хүрээ улам бүр өргөжиж, зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага нарийссаар байна. 1989 онд Конгресс ёс зүйн хэм хэмжээнд шинэчлэл хийж хуулийг гаргасан.

Эдүгээ АНУ-д ёс зүйтэй холбоотой асуудлаар тухайлбал, банкнаас хүүгүй зээл авах, цалинтай амралт буюу амралтын үеэр зорчсон онгоцны тийзийн үнэ авах зэрэг асуудлаар ямар нэгэн хөнгөлөлт байхгүй болсон. Хэрэв ийм үйлдэл хийвэл хуулиар шийтгэгдэнэ. Мөн түүнчлэн номоо хэвлүүлэх, урамшилтай лекц унших буюу зөвлөгөө өгөх болбол холбогдох төрийн байгууллагаас тусгай зөвшөөрөл авна. Ийм маягаар олсон нэмэгдэл орлого нь төрийн албан хаагчийн жилийн албан ёсны цалингийн 15%-аас илүү байх ёсгүй байна. Хуулийн эдгээр заалтыг зөрчсөн албан хаагчид 1 жил хүртэл хорих ял буюу 50 мянган долларын торгууль ногдуулах, хүндрүүлэх нөхцөлтэй бол 5

<sup>29</sup> Улсын Их Хурлын Тамгын газрын судалгаа, шинжилгээний хэлтэс. Төрийн албаны эрх зүйн зарим асуудлаарх бусад орны туршлага. харьцуулсан судалгаа. УБ., 2014. 15 дахь тал.

<sup>30</sup> 7 <http://www.ethikrat.org/about-us/ethics-council-act>

<sup>28</sup> Төрийн албаны зөвлөл. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн мэдээ. УБ., 2017.

хүртэл жилээр хорьдог байна<sup>31</sup>.

Бусад улс орнууд ёс зүйн дүрэмдээ төрийн өндөр албан тушаалтны эрх ашгийн зөрчлийн ёс зүйг гол асуудлаа болгон тусгасан нь анзаарагдсан. Мөн тухайн өндөр албан тушаалтан өөрийн эрх мэдлийг хувийн эрх ашигтаа зохицуулж ашиглах, авлигаас сэргийлэхийг онцгойлж тодорхой заадаг юм билээ. Мэдээж хэрэг улс орон бүрт ёс заншлаас үүдээд асуудал өөр өөр байна. Бид өөрийн орны онцлог нөхцөл байдлыг харгалзан асуудлыг зохицуулахаар төлөвлөсөн. Бидэнд гадны туршлагатай зөвлөхүүд ёс зүйн дүрмийг баталж гаргаснаар бүх хүнийг ёс зүйтэй болгох асуудал эцсийн зорилго биш. Ер нь төрийн өндөр албан тушаалтны хувьд албан ажлаа гүйцэтгэж явахдаа би энэ хэмжээнээс хальж болохгүй, иймэрхүү зүйлд баригдаж ажиллах ёстой гэсэн ухамсрыг төрүүлж дадлага хэвшил болгох нь чухал гэдгийг зөвлөсөн. Хэдийгээр төрийн өндөр албан тушаалтан ч гэсэн хүн л юм болохоор хувийн амьдралдаа алдаа гаргана. Түүнийгээ албан ажлынхаа хүрээнд гаргаж болохгүй байхаар зохицуулах нь чухал гэж үзэж байгаа.

Гадаад орны туршлагаас харахад төрийн албан хаагчийн биеэ хэрхэн авч явах тухай кодекс гаргаж мөрдүүлэх, түүнийгээ хууль тогтоомжоор баталгаажуулах, ёс зүйн зөвлөгөө, хяналт шалгалт эрхэлсэн зөвлөл хороо байгуулах зэргийг голчилсон байна.

Олон улсын практикт төрийн албанд ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлэх, ёс зүйгүй үйлдлээс урьдчилан сэргийлэхийн тулд үндсэн 2 төрлийн хандлага, менежментийн арга барилыг ашигладаг бөгөөд ихэвчлэн эдгээрийг хослуулан хэрэглэдэг.

- Дэг журмын дагаж мөрдөх буюу хууль дүрэмд суурилсан ёс зүйн хандлага. Ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлэхэд ёс зүйгүй үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

- Зарчимд суурилсан ёс зүйн хандлага. Энэ хандлагын элементүүдэд үнэт зүйлс, сургалт, зөв зүйлийг хийх сэдэл урамшуулал, идэвх, эерэг өрсөлдөөн зэрэг ордог. Энэ хандлага нь сайн, ёс зүйтэй, үнэнч зан суртахуунд буюу хувь хүний шийдвэрт ач холбогдол өгдөг<sup>32</sup>.

Ёс зүйгүй үйлдэл нь соёлын хүчин зүйлээс хамааралтай тул түүнтэй тэмцэх уламжлал, арга механизм харилцан адилгүй ч үндсэн 2 төрлийн хандлага зонхилдог. Тухайлбал,

<sup>31</sup> Р.Вандангомбо. Төрийн албаны ёс зүй. УБ., 2007. 59 дэх тал.

<sup>32</sup> Donald C. Menzel. 2010. Ethics moments in Government; Cases and Controversies. CRC Press. p 5-7.

Их британи, Шинэ Зеланд, Австрали зэрэг улсад ёс зүйн зөрчилтэй тохиолдол бүрийг тухайлан авч хэлэлцэж, шийдэл гарц хайх хандлагатай байдаг бол Герман, Франц зэрэг Европын орнуудад ерөнхий хуулийн хүрээнд шууд бус хэлбэрээр шийддэг. Төрийн албаны ёс зүйн харилцаанд хяналт тавих, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тогтолцоог хосолмол хэлбэрээр ашиглах замаар зохицуулалт хийх нь чухал<sup>33</sup>.

Төрийн албаны ёс зүйн стандарт маш тодорхой байх ёстой. Төрийн албан хаагчид өөрсдийнхөө ажилд хэрэглэх үндсэн зарчим стандартын талаар болон зохистой биеэ авч явах байдлын хил зааг хаагуур байгаа талаар мэддэг байх ёстой. Төрийн захиргааны үйл ажиллагааны үндсэн ёс зүйн стандарт болон зарчмыг илэрхийлсэн товч тодорхой бөгөөд сурталчилгаа сайн хийгдсэн тухайлбал ёс зүйн кодекс зэргээр үүнийг тодорхойлж болох бөгөөд ингэснээр нэг талаас төр засгийн байгууллага нөгөө талаас олон түмний дунд ийм стандарт зарчмын талаар нэгдмэл ойлголттой болно.

## V. Дүгнэлт

Улс төрийн ертөнцийг ёс зүйтэй болгоход иргэний нийгмийг хөгжүүлэх, улс төр дэх сөрөг хүчин өөрийн үүргээ гүйцэтгэх, төрийн үйл ажиллагааг нээлттэй ил тод, тунгалаг, ариун байлгахыг шаардах, өөрийн улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн гол бодлого, нийгэмд тулгамдсан асуудлыг олон нийтээр хэлэлцүүлэх нь чухал юм.

Ардчилсан орны аливаа улс төрийн үйл ажиллагаа нь харьцангуй ил тод байх шаардлагатайгаас гадна улс орны болон ард түмний эрх ашгийн асуудлыг тэргүүн зэрэгт тавих юм. Иймд хариуцлагатай төрийг төлөвшүүлэх үйл явцад хамтран ажиллаж олон нийтийн хяналтыг бий болгох асуудалд анхаарах нь үр нөлөөтэй болно.

Улс төрийн удирдагчид өөрсдийн албан үүргээ гүйцэтгэхдээ ёс зүйн өндөр стандартыг баримтлах үүрэгтэй. Тэд хүсэл зоригоо бодит жишээгээр болон чухам улс төрийн түвшинд хүртээлтэй арга хэмжээгээр жишээ болгон харуулдаг. Ард түмнээс сонгогдсон төрийн түшээд ёс зүйн хэм хэмжээг чанд баримтлан ажиллавал нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ.

Платоны үзэж байснаар хүн байгалиас заяасан авьяасаараа чадах бүхнээ хийх явдал нь шударга ёс юм. Нинжин сэтгэл, ард түмний ашиг тусыг эрхэмлэн бодох өгөөмөр зан чанар нэгэнт үгүй хүмүүс улс төрд хүчин зүтгэх гэж эрмэлзэхээ болох тэр цагт улс төр зүтгэх гэж эрмэлзэхээ болох тэр цагт улс төр <sup>33</sup> Г.Мягмар. Төрийн албанд ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлэх арга замууд. УБ., 2016. 156 дахь тал.



МОНГОЛ  
УЛСЫН  
ХУУЛЬ  
САХИУЛАХ  
УНИВЕРСИТЕТ



өөрөө ёс зүйтэй болно.

Улс төрийн албан хаагчийн ёс зүйг үнэлэх үнэлэмж, шалгуурыг нарийвчлах, хэм хэмжээг зохицуулсан эрх зүйн орчин, төрийн албан хаагчдад хүлээлгэх хариуцлагын болон төрийн тогтвортой байдлыг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох нь зүйтэй байна.

### Санал

1. Төрийн албаны боловсон хүчнийг чадавхжуулах, нийгмийн давхарга хэсгийг төлөөлөх шударга хүмүүсийн итгэлийг хүлээсэн хүмүүсээр сэлбэх;

2. Улс төрийн намуудын эрүүл өрсөлдөөн, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн зөв хандлагын идэвхжил нь эерэг үр дүн гаргах үндэс суурь болох;

3. Парламентын дотоод хяналт шийдвэр гаргах олонхот цөөнхийн зохистой, эрүүл саруул хэт улс төржилтөөс ангид хяналт тогтоох;

4. Ил тод байдал, засаглалын ажлыг нээлттэй явуулах;

5. Төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэх;

6. Төрийн удирдах албан тушаалтны манлайлах арга барил, ёс зүйг сайжруулах хяналтын тогтолцоог бий болгох;

7. Удирдах албан тушаалтны ёс зүйн байдлыг улирал бүр үнэлэх судалгаа авч, судалгаанд шинжилгээ хийх;

8. Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой хууль тогтоомжийг шинэчлэх боловсронгуй болгох.

### Эх сурвалжийн жагсаалт

#### I. Монгол эх сурвалж

1. Г.Алмонд, Д.Пауэл, К.Стром, Р.Дальтон. Харьцуулсан улс төр. Онолын хүрээ. УБ., 2005.

2. Ц.Батбаяр. Ёс зүй. УБ., 2007.

3. Ж.Бор, Д.Баатар. Монголын ёс суртахуун. УБ., 2017.

4. Р.Вандангомбо. Төрийн албаны ёс зүй. УБ., 2007.

5. Б.Галиндэв. Монголын нийгмийн өөрчлөлтийн үе дэх ёс суртахууны асуудлууд. УБ., 2010.

6. Б.Галиндэв. Хүн байх ухаан. УБ., 2016.

7. Б.Даш-Ёндон. Никомадын ёс зүй. УБ., 2007.

8. Б.Даш-Ёндон. Аристотель. Улс төр. УБ., 2006.

9. Б.Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. II боть.

УБ., 2011.

10. Б.Даш-Ёндон. Лаозын гүн ухаан /эх сурвалж, тайлбар/. УБ., 2014.

11. Д.Дэмбэрэл. Ёс зүйт төр. УБ., 2011.

12. А.В.Иванов, И.В.Фотиева, М.Ю.Шишин. Ёс суртахуун-оюун ухаант мандлын соёл иргэншил: үндэслэл, хэтийн төлөв. УБ., 2011.

13. М.Золзаяа. Ёс зүй. УБ., 2014.

14. М.Золзаяа. XIII-XIV зууны Монголчуудын ёс суртахууны үнэлэмжийн онцлог. УБ., 2016.

15. М.Золзаяа. Монголын бизнесийн ёс зүйн төлөвшил, хандлага. УБ., 2016.

16. Г.Мягмар. Төрийн албанд ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлэх арга замууд. УБ., 2016.

17. МУИС, МУБИС, ШУТИС, ШУА-ийн Философийн хүрээлэн. МУИС-ийн философийн салбар төгсөгчдийн холбоо. Хэрэглээний ёс зүйн асуудлууд: эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. УБ., 2017.

18. С.Нарангэрэл. Монголчуудын зан суртахууны гарвал. УБ., 2010.

19. С.Нарангэрэл. Чингис хааны сүр хүч. УБ., 2013.

20. С.Нарангэрэл. Чингис хааны ёс суртахууны шаштир. УБ., 2014.

21. С.Нарангэрэл. Хуулийн амин сүнс /Чингис хааны гэрээслэл/. УБ., 2017.

22. Нитобэ Иназо Бушидо япон үндэстний ёс зүйн цогц... "Ниппон ньос" сонин газар. УБ., 2007.

23. Д.Отгонтуяа. Платон. Төр улс. УБ., 2005.

24. Д.Тунгалаг. Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй. УБ., 2012.

25. Төрийн албаны зөвлөл. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн мэдээ. УБ., 2017.

26. Улсын Их Хурлын Тамгын газрын судалгаа, шинжилгээний хэлтэс. Төрийн албаны эрх зүйн зарим асуудлаарх бусад орны туршлага. Харьцуулсан судалгаа. УБ., 2014.

27. УИХ-ын Тамгын газрын судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв. ТАХ-ийн ёс зүйн асуудалд дахь хэвлэл нийтлэлийн контент-анализ. УБ., 2008.

28. Б.Чимид. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс. УБ., 2006.

29. Фредерик Бастиа. Хууль. УБ., 2007.

30. ШУА-ийн ФСЭХ. Дээд суртахуун. УБ., 2006.

31. ШУА-ийн ФСЭХ. Аристотель. Евдемын ёс зүй. УБ., 2008.



32. ШУА-ийн ФСЭЗХүрээлэн. Эрдмийн ертөнц. /Academiae/ 2012/1 /6/. УБ., 2012.

33. Б.Энхбаяр. Төрийн албан хаагчийн ёс зүй. УБ., 2000.

## II. Гадаад эх сурвалж

34. Alian Noghiu and Tibor Toth.Public officials ethics-an international survey.

35. Будников.Д.Кризис в России: Криминальный аспект //Российская газета. 1999.

36. Большой энциклопедический словарь. Мифология.Ред. Е.М.Мелятинский. М., 1998.

37. Джордж Эдвард Мур. Природа моральной философи. М., с328.

38. Donald C. Menzel. 2010. Ethics moments in Government; Cases and Controversies.CRC Press.

39. Michael Gallagher, Michael Laver, Peter Mair. Representative Government in Western Europe.NY.1992.

## III. Бусад эх сурвалж

40. <http://www.ethikrat.org/about-us/ethics-council-act>

41. [www.forum.mn](http://www.forum.mn)

42. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)



Хууль сахиулахуй

## СЭТГҮҮЛД НИЙТЛҮҮЛЭХ ӨГҮҮЛЛЭЭ ИРҮҮЛНЭ ҮҮ



Хууль сахиулах үйл ажиллагааны нэгдмэл байдлыг илэрхийлсэн **“Хууль сахиулахуй”** онол, арга зүйн сэтгүүл улирал бүр хэвлэгдэн гарна.

Иймд эрдэмтэн, судлаач, багш, ажилтан, практик байгууллагын албан хаагч Та уг сэтгүүлд нийтлүүлэх өгүүллээ журамд заасан шаардлагын дагуу бэлтгэн, Сэтгүүлийн Редакцийн зөвлөлд цаасаар болон цахимаар (journal@leu.gov.mn) ирүүлнэ үү.<sup>1</sup>

Утас: 7015-5034

### СЭТГҮҮЛИЙН ЗАХИАЛГА

Сэтгүүлийг Монгол Шуудан, Түгээмэл, Улаанбаатар шуудангаар захиалан авах боломжтой.<sup>2</sup>

Захиалга	Гарах дугаар	Хэвлэл захиалга
Улирлаар	1	9900 төгрөг
Хагас жилээр	2	19800 төгрөг
Жилээр	3	39600 төгрөг

#### Захиалгын индекс:

Монгол шуудан:	204073	Утас: 7007-8977
Түгээмэл шуурхай шуудан:	250007	Утас: 7011-5015
Улаанбаатар шуудан:	2001027	Утас: 7012-7027

#### Худалдаалдаг цэг:

- о “Интерном” их дэлгүүр
- о Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Номын худалдаа

#### Дугаар эрхлэн гаргасан:

О.Уулзахжаргал

#### Дизайнер:

Х.Баднаажонон

#### Сэтгүүлийн редакцийн зөвлөл

<sup>1</sup> Өгүүлэлд тавигдах шаардлагыг <http://www.leu.gov.mn/page/2407.shtml?link=1596>-ээс үзнэ үү.

<sup>2</sup> <http://www.leu.gov.mn/page/2407.shtml?link=1596>